

Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль

Монгол улс

Хүний эрхийн тайлан

Хүний Эрхийг Хамгаалагчид
АНУ, Миннесота

Хүчирхийллийн Эсрэг Үндэсний Төв
Улаанбаатар хот, Монгол улс

2014 оны 1 дүгээр сар

Хүний Эрхийг Хамгаалагчид

АНУ Миннесота дахь Хүний эрхийг хамгаалагчид байгууллага нь олон улсын хүний эрхийн стандартыг хэрэгжүүлэхэд иргэний нийгмийн байгууллагуудад дэмжлэг үзүүлж, хууль ёсыг бэхжүүлэх зорилттой. Хүний эрхийг хамгаалагчид нь АНУ-д сайн дурынхан, судлаачид, боловсрол олгогчид, хүний эрхийг хамгаалагчидийн оролцоотой олон улсад хүрч ажиллах үлс орноо сонгож ажилладаг. Хүний эрхийг хамгаалагчид нь хүний эрхийг хангах, хамгаалах зорилгоор олон улсын болон АНУдахь түншлэгч нартайгаа хамтран 25 гаруй үлс орны хүний эрхийн хэрэгжилтийг баримтжуулсан ба нийт 75 гаруй тайлан гаргасан.

Хүний эрхийг хамгаалагчид Нэгдсэн Үндэсний Байгууллагад тусгай зөвлөх статустай байгууллага юм.

Хүчирхийллийн Эсрэг Үндэсний Төв

Хүчирхийллийн эсрэг үндэсний төв нь 1995 оноос хойш Монгол улсад анх удаа гэр бүлийн болон бэлгийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэх, хохирогч хүүхэд эмэгтэйчүүдийг хамгаалах чиглэлээр ажиллаж эхэлсэн анхны төрийн бус байгууллага юм. ХЭҮТ нь гэр бүлийн болон бэлгийн хүчирхийлэлтэй тэмцэхэд үндэсний хэмжээний урьдчилан сэргийлэх, хамгаалах систем бий болгох зорилготой. ХЭҮТ нь хамт олныг хөгжүүлж, тэдний оролцоог хангах замаар гэр бүлийн болон бэлгийн хүчирхийллийн хохирогчийн аюулгүй байдлыг хангах, дэмжих үйлчилгээ үзүүлэх төрийн үүргийг бий болгоход идэвхийлэн ажилладаг. ХЭҮТ дараах арга замаар зорилгоо хэрэгжүүлэхээр ажиллаж байна.

- ❖ Хүүхэд, эмэгтэйчүүдийн эсрэг гэр бүлийн хүчирхийллийн асуудлаар олон нийтийн ойлголтыг нэмэгдүүлэх
- ❖ Хүчирхийллээс урьдчилан сэргийлэх сургалтын хөтөлбөрт жендэрт суурилсан хүчирхийллийн агуулгыг системтэйгээр албан болон албан бус боловсролын системд өөрчлөлт хийх замаар багтаах нөлөөлөл
- ❖ Хүчирхийллээс урьдчилан сэргийлэх, таслан зогсоох хууль, эрхзүйн орчныг бий болгох, онцгойлон гэр бүлийн хүчирхийллийг гэмт хэрэгт тооцох
- ❖ Хүчирхийллийг даван туулахад эмэгтэйчүүдэд дэмжлэг үзүүлэх нийгмийн хамгааллын системийг хөгжүүлэхэд хувь нэмэр оруулах (хуулийн туслалцаа, сэтгэл зүйн зөвлөгөө, хамгаалах байр гм)
- ❖ Олон улс болон үндэсний хэмжээнд эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийллийн асуудлаар сүлжээгээ өргөжүүлэх, хөгжүүлэх

Хүний Эрхийг Хамгаалагчид

330 Second Avenue South, Suite 800

Minneapolis, MN 55401 USA

612-341-3302

Имэйл: hrights@advrights.org

Цахим хуудас: www.theadvocatesforhumanrights.org

Хүчирхийллийн Эсрэг Үндэсний Төв

Утас: 976-70119949

Имэйл: mongolcav@mongol.net

Цахим хуудас: <http://www.safefuture.mn/>

© 2013 The Advocates for Human Rights

All rights reserved. Published 2013.

ISBN: 0-929293-73-8

ТАЛАРХАЛ

Хүний Эрхийн Хамгаалагчид байгууллага (The Advocates for Human Rights) болон Хүчирхийллийн Эсрэг Үндэсний Төвийн (ХЭҮТ) хамтарсан тайланг Та бүхэнд толилуулж байгаадаа баяртай байна.

Мониторинг хийж, тайланг хэвлүүлэхэд санхүүгийн дэмжлэг үзүүлсэн Нээлттэй Нийгэм Хүрээлэн, Сигрид Раусин Итгэл байгууллагад болон АНУ-ын элчин сайдын яаманд тусгайлан талархал илэрхийлье.

Түүнчлэн, мониторинг хийхэд хувь нэмрээ оруулсан дараах хувь хүмүүс, байгууллагууд: Д.Энхжаргал, М.Мөнхсаруул, Н.Арвинтариа, Kate Bruce, Suzanne Turner, Calleigh McRaith, Reshad Amini, Robin Phillips, Cheryl Thomas, Helen Rubenstein, Rosalyn Park, Dechert LLP, Trans Perfect Legal Solutions болон зохион байгуулалтаар хангаж тусалсан Хүчирхийллийн эсрэг үндэсний төвийн хамт олон, орон нутаг дахь салбарын зохицуулагчдад гүн талархал илэрхийлье.

Судлаачдын зүгээс мониторинг хийхэд дэмжлэг үзүүлсэн дараах сайн дурын ажилтан, дадлагын оюутан, бусад хувь хүмүүст: А.Энхтүвшин, Б.Тунгалаг, Д.Урангуа, Д.Амаржаргал, Ганбаатар, В. Marion Greene, Х.Чимгээ, Kent Harbison, Р.Өнөржаргал, Claire Kelly, Khukhuu, Megan Kirkland, Diana Menanteau, Нургуль, Aurelija Olendraite, Amy Perna, Thea Reilkoff, Kris Simondet, Linnea VanPilsom-Bloom, Anna Veit-Carter, Kaitrin Vohs, Jack Weatherford болон Eron Woods нарт талархал илэрхийлье.

ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ

ХЭҮТ- Хүчирхийллийн эсрэг үндэсний төв
НҮБ-Нэгдсэн үндэсний байгууллага
ГБХТТХ-Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль
ТББ-Төрийн бүс байгууллага
УБ- Улаанбаатар хот
ШШГГ-Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар

АГУУЛГА

ХУРААНГУЙ	7
ТАНИЛЦУУЛГА	13

ГЭР БҮЛИЙН ХҮЧИРХИЙЛЭЛТЭЙ ТЭМЦЭХ ТУХАЙ ХУУЛЬ БА ЭРХ ХЯЗГААРЛАХ ШИЙДВЭР

Эрх хязгаарлах шийдвэр гаргуулахад учирдаг саад бэрхшээлүүд	18
Олон нийт болон хохирогчдын ойлголт, мэдлэг хангалтгүй байдал	19
Төрийн албан хаагчдын хангалтгүй мэдлэг, хэвшмэл хандлага болон бүрэн бус, системчлэгдээгүй сургалт	20
Нотолгоонд учирдаг саад бэрхшээл	26
Эрх зүйн түслалцааны хүртээмжгүй байдал	29
Эдийн засгийн хараат байдал	29
Нууцлалыг хамгаалахад тулгарч буй бэрхшээл	30
Эрх хязгаарлах шийдвэр гаргуулахаад тулгарч буй бэрхшээл	32
Эрх хязгаарлах шийдвэрийн гүйцэтгэлд тавих хяналт, албадан биелүүлэх механизм байхгүй	34
Эрх хязгаарлах шийдвэр огт хэрэгждэггүй	35
Эрх хязгаарлах шийдвэрийн гүйцэтгэлд тавих хяналт байдаггүй	37
Эрх хязгаарлах шийдвэрийн зөрчилд анхаарал хандуулдаггүй	38

ЗАХИРГААНЫ ЗӨРЧИЛ БОЛОН ЭРҮҮГИЙН ХЭРГИЙГ ХЯНАН ШИЙДВЭРЛЭХ ҮЙЛ

АЖИЛЛАГААНД ТУЛГАРЧ БҮЙ БЭРХШЭЭЛ	41
Захиргааны хариуцлагын тухай хууль	43
Захиргааны хариуцлагын тухай хууль:Архидан согтуурал	44
Захиргааны хариуцлагын тухай хууль: Танхайрах	45
Захиргааны хариуцлагын үр нөлөөгүй байдал	46

ЭРҮҮГИЙН ХУУЛЬ

Шүүх эмнэлгийн дүгнэлт	48
Хариуцлага хүлээлгэх шийдвэр: Захиргааны хариуцлага, эрүүгийн ял эсвэл шийтгэхгүй орхих	49
Прокурор эрүүгийн хэрэг үүсгэх, хариуцлага хүлээлгэхээс татгалзах нь	52
Эвлэрүүлэх, гомдлыг хэрэгсэхгүй болгох	54
Хохирогчоос мэдүүлэг авах шаардлага	56
Эрүүгийн эрх зүйн зохицуулалт	57
Эрүүгийн ял	59
Амиа хорлох оролдлого ба аргагүй хамгаалалт	60

ГЭРЛЭЛТ ЦУЦЛАЛТ

Гэрлэлтээ цуцлуулахад учирдаг саад бэрхшээлүүд	62
Эвлэрүүлэх хугацаа ба эрсдэлт нөхцөл байдал	63
Гэрлэлт цуцлах үед болон гэрлэлт цуцалсны дараа үйлдэгдэх хүчирхийлэл	65

ХАМГААЛАХ БАЙР, ДЭМЖИХ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ХҮРЭЛЦЭЭГҮЙ БАЙДАЛ	
Хамгаалах байруудын хэрэгцээ	67
Санхүүжилт, нөөц хүрэлцээгүй	67
Санхүүжилт хүрэлцээгүйн улмаас хамгаалах байрууд хаагдаж байна	68
Орон нутаг дахь хамгаалах байрны хэрэгцээ	69
Хамгаалах байр: аюулгүйн баталгааг хангах нь	70
Нийгмийн үйлчилгээнүүд	71
Хохирогчийг дэмжих үйлчилгээнүүд	71
Зан үйлд нөлөөлөх хөтөлбөр ба саад бэрхшээл	72
Засаг захиргааны анхан шатны нэгж дээр ажилладаг мэргэжилтнүүдийн хуулиар хүлээсэн үүргээ хэрэгжүүлж байгаа байдал	73
Нийгмийн ажилтан	73
Сум, багийн Засаг дарга	74
ДҮГНЭЛТ	76
ЗӨВЛӨМЖ	
Улсын Их Хурал	78
Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн шинэчлэлийн хүрээнд:	78
Гэрлэлт цуцлах эрх зүйн зохицуулалтын хүрээнд:	79
Гэмт хэргийн эрх зүйн зохицуулалтын хүрээнд:	80
Хууль зүйн яаманд	80
Боловсрол, сургалтын хүрээнд:	81
Шүүх, шүүгчдэд	81
Цагдаагийн ерөнхий газарт	83
Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газарт	84
Прокурорт	84
Эрүүл мэндийн яаманд	85
Хүн ам, хөгжил, нийгмийн хамгааллын яаманд	85
Сум, баг, хорооны Засаг даргад	86
Нийгмийн ажилтанд	86
Эрүүл мэндийн ажилтанд	86
Олон нийтийн боловсролын хүрээнд:	87
ХАВСРАЛТ	88

ХУРААНГУЙ

Дэлхий дахинд сая сая эмэгтэйчүүд гэр бүлийн хүчирхийллийн улмаас тарчлан зовж байна. Тэдний хамгийн ойр дотно хүмүүс болох нөхөр, найз залуу, өмнөх буюу одоогийн хамтран амьдрагчийн зүгээс хүчирхийлэл үйлдэж, хамт олон, гэр бүл, үр хүүхэд нь бие махбод, сэтгэл санаа, нийгэм, эдийн засгийн ноцтой үр дагаврыг амссаар байна. Хүчирхийлэл нь эмэгтэйчүүдийн амьд явах, ялгаварлан гадуурхалт, айдас, дарамт, хүчирхийлэл, эрүүдэн шүүлтээс ангид, эрх чөлөөтэй амьдрах эрхийг зөрчдөг. Дээр дурдсан эрх, эрх чөлөө нь олон улсын хэм хэмжээгээр хамгаалагдсан ч¹ гэр бүлийн хүчирхийлэл нь дэлхий нийтэд тулгамдсан, түгээмэл асуудал болсоор байна. Эмэгтэйчүүдийн 70% нь амьдралынхаа явцад ямар нэг төрлийн хүчирхийлэлд өртөж байгааг НҮБ-ын судалгаагаар тогтоожээ.²

Сэтгэл түгшээсэн дэлхийн хэмжээний дээрх тоон мэдээлэлтэй төстэй дүр зураг Монгол улсад ч бас байна. “Нөхөн үржихүйн эрүүл мэндийн судалгаа”-нд оролцсон 9106 хүний 73.6% нь хүчирхийллийн ямар нэг харилцаатай гэр бүлийг мэдэхээ илэрхийлжээ. Уг судалгаанд хамрагдсан 6894 эмэгтэйн 19% буюу 5 эмэгтэй тутмын 1 нь нөхөр, хамтран амьдрагчийн зүгээс үйлдсэн бие махбодын хүчирхийлэлд өртсөн байна.³

Монгол улсад гэр бүлийн хүчирхийллийн талаар албан ёсны статистик мэдээлэл дутмаг. Гурван жилийн өмнөөс л гэр бүлийн хүчирхийллийн улмаас үйлдэгдсэн гэмт хэргийн тухай статистик мэдээлэл гарах болсон. Цагдаагийн байгууллагад бүртгэгдсэн гэмт хэргийн тоон мэдээллээс үзэхэд 2010 оноос хойш нийт 49 хүн гэр бүлийн хүчирхийллийн улмаас амиа алдаж, 1180 хүн гэмтсэн байна. 2013 оны эхний 8 сард л гэхэд 267 гэмт хэрэг бүртгэгдэж, 6 хүн нас барж, 198 хүн гэмтжээ.⁴

Засаг захиргааны анхан шатны нэгж дээр байрладаг цагдаагийн байгууллагад ирж буй дуудлагын ихэнх хувийг гэр бүлийн хүчирхийллийн дуудлага эзэлдэг. Тухайлбал, судалгаанд хамрагдсан цагдаагийн ажилтан нь долоо хоногт гэр бүлийн хүчирхийллийн 63 дуудлага хүлээж авдаг байна.⁵

2007 онд баривчлагдсан хүмүүсийн тал хувь нь гэр бүлийн хүчирхийлэл үйлдсэний улмаас захиргааны хариуцлагын арга хэмжээ авагдсан байна.⁶ Гэр бүлийн хүчирхийллийн дээрх тоон мэдээллүүд нь энэ асуудалд хойшлуулшгүй арга хэмжээ авах шаардлагатайг нотолж байна.

¹ Хүний Эрхийн Түгээмэл Тунхаглал, Иргэний болон Улс төрийн эрхийн тухай олон улсын Пакт, Эдийн засаг, нийгэм, соёлын эрхийн тухай олон улсын Пакт, Эмэгтэйчүүдийг ялгаварлан гадуурхах бүх хэлбэрийг устгах тухай Конвенци, Эрүүдэн Шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг доромжлон харьцаж шийтгэхийн эсрэг Конвенци

² Нэгдсэн үндэстний байгууллага, “Эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийлэл” мэдээллийн хуудас, 2011 он
http://www.un.org/en/women/endviolence/pdf/pressmaterials/unite_the_situation_en.pdf

³ МУ-ын Үндэсний статистикийн хорооноос НҮБ-ын Хүн амын сангийн санхүүгийн дэмжлэгтэйгээр үндэсний хэмжээнд хийсэн “Нөхөн үржихүйн эрүүл мэндийн судалгаа”, 2009 он

⁴ Цагдаагийн ерөнхий газрын статистик тоон мэдээлэл

⁵ Цагдаагийн ажилтантай хийсэн ярилцлага, Д хот, 2013.1. 23, 1500.

⁶ ХЭҮТ-ийн тайлан, “Гэр бүлийн хүчирхийллийн өнөөгийн байдал” (судлаачдийн файлаас)

Монгол улсын Засгийн газраас Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийг хэрхэн хэрэгжүүлж байгаад хөндлөнгийн хяналт, үнэлгээ хийх, нотолгоо цуглуулах зорилгоор Хүчирхийллийн эсрэг үндэсний төв (цаашид энэ тайланд “ХЭҮТ” гэж товчилно), Миннесотагийн Хүний Эрхийг Хамгаалагчид Төрийн бус байгууллага хамтран 2013 оны нэг, гуравдугаар саруудад мониторинг хийлээ. Судалгааны баг нь 7 аймагт ажиллаж, хохирогч, нийгмийн ажилтан, цагдаагийн ажилтан, эрүүл мэндийн ажилтан, Засаг дарга, ТББ-ын ажилтан, яамдын мэргэжилтэн, шүүгч, прокурор, бусад хуульчдыг хамруулан нийт 137 хүнтэй ярилцлага хийлээ. Энэ тайланд танилцуулагдаж буй дүгнэлт, зөвлөмж нь эдгээр ярилцлага, судлаачийн ажиглалт, хоёрдогч эх сурвалжид үндэслэсэн болно.

2004 онд Монгол улсын УИХ-аас Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийг (цаашид энэ тайланд “ГБХТТХууль” гэж товчилно) баталсан нь гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх чухал алхам болсон. Энэ хууль батлагдсанаар хуулийн хүрээнд гэр бүлийн хүчирхийллийн хохирогчийг хамгаалах, хүчирхийлэл үйлдэгчид хариуцлага тооцох эрх зүйн үндэслэл бүрдсэн. Монгол Улсын төр энэ хуулийг баталснаар гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх улс төрийн хүсэл эрмэлзлэлээ илэрхийлсэн.

Засгийн газар ГБХТТХуулийг үр дүнтэй хэрэгжүүлбэл цаашид бүсийнхээ хэмжээнд загвар болж хэрэглэгдэх бүрэн боломжтой юм.

ГБХТТХууль нь эрх хязгаарлах шийдвэр зэрэг гэр бүлийн хүчирхийллээс эмэгтэйчүүдийг хамгаалах олон чухал заалтыг багтаасан. Эрх хязгаарлах шийдвэрийн зохицуулалт нь хохирогчийн аюулгүй байдлыг хангах чухал арга хэмжээ болсон бөгөөд хүчирхийлэл үйлдэгчийг тусдаа амьдрахыг даалгах, хохирогчтой уулзах болон уулзахаар оролдохыг хориглох, хамтран өмчлөх дундын эд хөрөнгөө эзэмших, ашиглах, захиран зарцуулахыг хориглох, асрамжиндаа байгаа насанд хүрээгүй хүнтэй харилцахыг шүүхээс түр хориглож хязгаарладаг. Уг хуулиар цагдаа, нийгмийн ажилтан, сум багийн Засаг дарга⁷ болон бусад мэргэжилтнүүдийн гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх үүрэг, хариуцлагыг хуульчилж өгсөн. Мөн зан үйлд нөлөөлөх хөтөлбөрт болон архины хамаарлаас гаргах эмчилгээнд хүчирхийлэл үйлдэгчийг хамруулах шийдвэр гаргах эрхийг шүүгчид олгосон. Шүүгч нь эрх хязгаарлах шийдвэрийг нэг жил хүртэл хугацаатай авах боломжтой болсон.

Гэвч ГБХТТХууль, холбогдох хууль тогтоомжууд нь хоорондоо уялдаагүй, хуулийн тодорхой заалтуудыг хэрэглэх чиглэл, удирдамж дутмаг, хэрэгжүүлэх нөөц хангалтгүй, хуулийн талаарх мэдлэг, ойлголт сүл зэрэг нь хуулийг үр дүнтэй хэрэгжих боломжийг хязгаарласан. Энэ хууль батлагдсанаас хойш өнөөг хүртэлх хугацаанд эрх хязгаарлах шийдвэрийг шүүхээс цөөхөн гаргасан байгаа нь дээрх саад бэрхшээлүүдээс шалтгаалжээ. ХЭҮТ-ийн мэдээлснээр, ГБХТТХууль 2005 онд хүчин төгөлдөр болж хэрэгжиж эхэлснээс хойш шүүхээс цөөн тооны эрх хязгаарлах шийдвэр гарсны ихэнх хувь нь нийслэл Улаанбаатар хотод байна. Хөдөө, орон нутгийн зарим ярилцлага өгөгчийн зүгээс “эрх хязгаарлах шийдвэрийг тухайн орон нутагтаа хэзээ ч гаргуулж байгаагүй” гэж хариулжээ.

⁷ Монгол улс нь 21 аймаг, нийслэл хотоос бүрдэнэ. Аймаг тус бүр “Сүм”-д хуваагдана, Сүм нь захиргааны хамгийн бага нэгж болох “Баг”-т хуваагдана.” Ц. Одгэрэл болон Ганболд Батцэцэг, Монгол улсын хууль эрх зүйн тогтолцоо, хуулиуд: Товч агуулга, GLOBALEX (2006.01 cap), <http://www.nyulawglobal.org/globalex/mongolia.htm>.

Монгол улсад, эрх хязгаарлах шийдвэр шүүхээс гаргахгүй байх, гаргасан ч хэрэгжихгүй байхад хэд хэдэн саад бэрхшээл нөлөөлсөн. Нэгдүгээрт, гэр бүлийн хүчирхийллийн талаарх ойлголт, мэдлэг хангалтгүй, ГБХТТХуулийн дагуу хүчирхийлэл үйлдэгчийн эрхийг хязгаарлуулах хүсэлтээ шүүхэд гаргаснаар хүчирхийллийн болзошгүй эрсдлүүдээс урьдчилан сэргийлэх боломжтойг эмэгтэйчүүд сайн мэдэхгүй байна. Олон хохирогч гэр бүлийн хүчирхийллийг түүлж байгаа амьдралаа хэвийн зүйл гэж ойлгож байгаагаас гадна ГБХТТХуулийн хамгаалалтыг авах боломжтой гэдгээ ухамсарлахгүй байна. Төрийн албан хаагчдын ихэнх нь дээрх хандлагыг улам түгээж, бэхжүүлж байна. Зарим цагдаа, нийгмийн ажилтан, прокурор нь ГБХТТХуулийг мэддэггүйн улмаас гэр бүлийн хүчирхийллийн хохирогчийг хамгаалах гэхээсээ гэр бүлийн бүрэн бүтэн байдлыг хадгалж үлдэх хандлага гаргаж байна. Иймд, ГБХТТХуульд тусгагдсан хамгаалалтын аргуудыг ашиглахын оронд олон эмэгтэйчүүд хамгаалах байранд буцаж очих эсвэл хүчирхийллээс дайжиж гэрлэлтээ цуцлуулах сонголт хийж байна. Түүнчлэн, гэр бүлийн хүчирхийллийн суурь шалтгааныг архины хамааралт байдал гэж үзэх буруу ойлголт түгээмэл байна. Засгийн газар нь хүчирхийлэлтэй биш архидан согтууралтай тэмцэхийг илүүд үзэж байгаа нь дээр дурдсан ойлголт, ухамсрын илэрхийлэл юм.

Хэдийгээр эмэгтэйчүүд ГБХТТХуулийн хамгаалалтыг хэрхэн авах талаар мэдлэгтэй байлаа ч хуулийн хязгаарлалт, процедурын саад бэрхшээлээс шалтгаалан уг үйл явц нь улам төвөгтэй, эсвэл боломжгүй болдог байна. Хуулиар тусгайлан шаардаагүй байхад ихэнх шүүх эрх хязгаарлах шийдвэр гаргахаасаа өмнө аюулын зэрэг өндөр байгааг нотлох үнэлгээг шаарддаг. Эрсдлийн үнэлгээ хийлгэх үйл явц төвөгтэй, цагдаагийн ажилтан, нийгмийн ажилтан хоёр заавал уг үнэлгээг хамтдаа хийсэн байхыг шаарддаг ч ихэнх тохиолдолд тэд хамтдаа хийж чаддаггүй. Эрх хязгаарлах шийдвэр гаргуулахын тулд гэмтэл бэртлээ шүүх эмнэлгийн дүгнэлтээр баталгаажуулах шаардлагыг хохирогчоос шүүх нэмж шаарддаг.

Гэмтэл бэртлээ шинэ байгаа үед нь эрх хязгаарлах шийдвэр гаргуулахын тулд шинжээчийн дүгнэлттэй холбогдох төлбөр, ажлын хязгаарлагдмал цаг, холбон зуучлах шаардлагуудтай холбоотой урт замыг хохирогч туулах болдог. Монгол улсад ихэнх хэргийн хувьд үнэ төлбөргүй эсвэл бага хөлстэй эрх зүйн туслалцаа авах боломжгүй байдаг тул хохирогч энэ хүнд, бэрх процессыг өөрсдөө зохицуулах болдог. Энэ бүхний эцэст хохирогч эрх хязгаарлах шийдвэр шүүхээс гаргуулж чадлаа ч харамсалтай нь огт хэрэгждэггүй. Орон нутагт, ялангуяа төрийн үйлчилгээнээс хол газар амьдардаг эмэгтэйчүүдийн хувьд эрх хязгаарлах шийдвэр гаргуулахын тулд шаардагдах бичиг баримтуудыг бүрдүүлэх нь тэдний хувьд том сорилт болдог байна.

ГБХТТХууль нь бусад холбогдох хуулиудтайгаа нийцээгүй, уялдаа холбоо муутайгаас шалтгаалан шүүхээс гаргасан эрх хязгаарлах шийдвэрийг хэрэгжүүлэх, албадан гүйцэтгэхэд асар их бэрхшээл тулгардаг. ГБХТТХуулиар “эрх хязгаарлах шүүхийн шийдвэрийг хэрэгжүүлэх, хүчирхийлэл үйлдэгчид хүргэх, зөрчигдсөн тохиолдолд орон гэрээс нь албадан гаргах, холдуулах зэрэг эрхийг Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага эдэлнэ” хэмээн хоёрдмол утгагүйгээр, тодорхой зааж өгөөгүй.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага нь шүүхийн шийдвэрийг хэрэгжүүлэх үүрэг хүлээдэг ч түүний хэрэгжилтийг хангахад чиглэсэн заавар, удирдамж байдаггүй. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын ажилтны зүгээс санаачилга гарсан тохиолдолд л эрх хязгаарлах

шийдвэрийг биелүүлэх үүрэг хариуцлагаа тухайн байгууллага хэрэгжүүлдэг. Ийм тохиолдол маш цөөн, дийлэнх ажилтнууд нь уг ажиллагааг хэзээ ч хэрэгжүүлж байгаагүй.

ГБХТТХуулиар эрх хязгаарлах шийдвэрийг биелүүлэх хариуцлагыг тусгаагүй, шийдвэрийг зөрчсөнөөс үүсэх үр дагаврыг тусгайлан тогтоогоогүйгээс болж уг шийдвэр нь хүчгүйдсэн. Эрх хязгаарлах шийдвэрийг зөрчсөн тохиолдолд эрүүгийн ял шийтгэх талаар тусгаагүй, зөвхөн хуулийн дагуу хариуцлага хүлээлгэнэ гэж ерөнхий хуульчилсан. Шүүхийн шийдвэрийг биелүүлээгүй тохиолдолд Эрүүгийн хуулийн дагуу ял хүлээх нийтлэг зохицуулалт байдаг ч төрийн байгууллагын ажилтнуудын ихэнх нь эрх хязгаарлах шийдвэрийг зөрчсөн тохиолдолд энэ зохицуулалтыг ашиглан хариуцлага хүлээлгэх ёстойг олж хардаггүй. ГБХТТХуулийн үг хэллэг тодорхой бус байгаагаас Эрүүгийн хуулийн заалтуудыг хэрэглэх боломжийг олж харахгүй байхад хүргэж, хууль хэрэгжүүлэгч нар хуулиар хүлээлгэсэн үүрэг хариуцлагаа биелүүлээгүйгээс ихэнх эрх хязгаарлах шийдвэр хэрэгжээгүй байна. Хүчирхийлэл үйлдэгч эрх хязгаарлах шийдвэрийг зөрчсөнийхөө төлөө ямар ч хариуцлага хүлээхгүй байна. Хүчин төгөлдөр эрх хязгаарлах шийдвэрийн биелэгдэх баталгаа сул, зөрчигдсөн тохиолдолд ял түлгахгүй байгаа нь Засгийн газрын зүгээс гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх үүрэг хариуцлагаа хэрэгжүүлэхэд гол бэрхшээл үүсгэж байна. Хүчирхийлэл үйлдэгч эрх хязгаарлах шийдвэрийг зөрчсөн тохиолдолд цагдаагийн ажилтны зүгээс сануулах эсвэл зүгээр л өнгөрөөх хандлагатай байна. Албадан биелүүлэлт болон оновчтой ял байхгүйгээс хохирогч улам л аюултай нөхцөл байдалд орж, шүүхийн шийдвэр зөвхөн цаас болон үлдэж, хүчирхийлэл үйлдэгч түүнийг үл ойшоож байна.

Үүнээс гадна Монгол улсын Эрүүгийн хуульд гэр бүлийн хүчирхийллийг гэмт хэрэг гэж хуульчлаагүйгээс гэр бүл, ахуйн хүрээнд үйлдэгдсэн хэргийг мөрдөн шалгахад тэргүүлэх ач холбогдол өгдөггүй тул хүчирхийлэл үйлдэгч ял завшиж, хариуцлагаас мултардаг. Гэр бүлийн хүчирхийлэл үйлдэгчид хариуцлага хүлээлгэхдээ Эрүүгийн хуулиас илүүтэй Захиргааны хариуцлагын тухай хуулийг хэрэглэдэг. Эрүүгийн хууль, Захиргааны хариуцлагын хуулийн аль алинд нь гэр бүлийн хүчирхийллийн талаар тусгай заалт байдаггүйгээс хууль хэрэглэгчид оновчгүй хариуцлага хүлээлгэхээс гадна нотлохыг шаардсан, процедурын хувьд бэрхшээлтэй хууль, практикийг мөрддөг. Цагдаагийн ажилтнууд Захиргааны хариуцлагын тухай хуулийн архидан согтуурах болон бусдын амгалан тайван байдлыг алдагдуулж танхайрахтай холбоотой зохицуулалтын хүрээнд л хэргийг шийдвэрлэдэг. Эдгээр хариуцлага нь богино хугацаагаар баривчлах, эсвэл мөнгөн торгууль оногдуулах байдаг учраас энэ нь эргээд хохирогчдыг шийтгэдэг. Тэр ч байтугай цагдаагийн ажилтан нь хүчирхийлэл үйлдэгчид ял шийтгүүлэхийг хүсэхгүй байгаа хохирогчийн хүсэлтийг харгалзан хариуцлага тооцохгүй орших, эсвэл хөнгөн шийтгэл оноож байна.

Эрүүгийн хуульд гэр бүлийн хүчирхийлэлтэй холбоотой заалт байдаггүй учраас цагдаагийн ажилтан, прокурорын зүгээс гэмтэл учруулах, тарчлаах зэрэг гэмт хэргийн зүйлчлэлийн хүрээнд хэргийг шийдвэрлэдэг. Цагдаагийн ажилтан гэр бүлийн хүчирхийллийн үйлдэл дээр эрүүгийн хэрэг үүсгэхээр прокурорт шилжүүлэхээс өмнө хохирогчийн авсан гэмтэл бэртлийг эрүүгийн хэрэг үүсгэхүйц ноцтой болохыг шүүх эмнэлгийн дүгнэлтээр батлах шаардлагатай болдог. Гэвч шүүх эмнэлгийн дүгнэлт гаргуулах нь хохирогчийн хувьд төвөгтэй, хүнд сорилт болдог.

Эрүүгийн хэрэг үүсгэн, шүүх эмнэлгийн дүгнэлт гаргаж, хүчирхийлэл үйлдэгчид хариуцлага тооцсон ч хүчирхийлэл үйлдэгч хохирогч хоёр “эвлэрсэн” гэдэг үндэслэлээр, эсвэл хохирогч гомдлоосоо татгалзсанаар прокурорын зүгээс хэргийг хааж болно. Хүчирхийлэл үйлдэгчээс эдийн засгийн хувьд хараат тохиолдолд хохирогчийн эмзэг байдал нь хэвээр байдгаас эрүүгийн хэргийг цаашид үргэлжлүүлэхээс татгалздаг. Прокурор ял шийтгэлийг хөнгөлөх, хэрэгсэхгүй болгох зэргээр хэт зөөлөн хандах үед хүчирхийллийг тэр даруйд нь зогсоох боломжгүй болж, хүчирхийлэл үйлдэгч суллагддаг.

Эрх хязгаарлах шийдвэрийг анхаарч үздэггүй болон эрүүгийн эрх зүйн тогтолцооны үр дүнгүй байдлаас болж хохирогч аюулгүй байдлаа хамгаалах өөр арга замыг хайдаг. Олон эмэгтэй гэр бүлийн хүчирхийллээс ангижрахын тулд нэн тэргүүнд гэрлэлтээ цуцлуулах арга замыг сонгодог. Монгол улсын Гэр бүлийн тухай хуулиар гэрлэлт цуцлах нь чөлөөтэй ч эмэгтэйчүүд гэрлэлтээ цуцлуулахад хэд хэдэн бэрхшээл туулах болдог. Нэгдүгээрт, хэрвээ эмэгтэй жирэмсэн эсвэл нэг хүртэлх насны хүүхэдтэй бол гэрлэлтээ цуцлуулах боломжгүй. Хоёрдугаарт, гэрлэлт цуцлуулахтай холбоотой зардал нь олон эмэгтэйд хязгаарлалт болдог. Эцэст нь, Гэр бүлийн тухай хуулийн дагуу шүүгч гэрлэлтээ цуцлах хүсэлт гаргасан хосуудад 3 сарын эвлэрэх хугацаа өгөх эрхтэй. Нэхэмжлэл гаргагчийн амь нас, эрүүл мэндэд аюул занал учрах эрсдэл байгаа тохиолдолд эвлэрүүлэх хугацаа өгөхгүй гэрлэлтийг шүүд цуцлах хуулийн боломж байдаг ч шүүгч тэр бүр гэр бүлийн хүчирхийлэлтэй харилцааны нөхцөл байдлыг анхаарч үздэггүй. Гэр бүлийн хүчирхийлэлд өртөж байгаа нь нотлогдсон ч зарим шүүгч эвлэрүүлэх хугацааг хосуудад өгсөөр байна. Эвлэрүүлэх хугацаа өгснөөр хүчирхийллийн харилцаатай нөхцөл байдалд байгаа хохирогчийн амь нас, эрүүл мэнд, аюулгүй байдлыг эрсдэлд оруулдаг, ялангуяа эрх хязгаарлах арга хэмжээг шүүхээс аваагүй тохиолдолд эрсдэл улам нэмэгддэг. Шүүхээс өгсөн эвлэрэх хугацаанд эмэгтэйчүүд заналхийлэл, хүчирхийлэлд өртөж улмаар амь насаа алдсан тохиолдол гарсан. Гэрлэлтээ цуцлуулах нэхэмжлэлтэй эрх хязгаарлах арга хэмжээ авахуулах хүсэлтийг давхар гаргах боломжтой ч олон хохирогч энэ талаар мэддэггүй. Энэ хамгаалалтыг эдлэхээр хүсэлт гаргасан ч шүүх нөхцөл байдлыг харгалзан үзэж, хэргийг хамтатган шийддэггүй.

ГБХТТХуульд хамгаалах байрны үйлчилгээний зохицуулалт тусгагдсан, Нийгмийн халамжийн тухай хуульд түр хамгаалан байрлуулах үйлчилгээг олон нийтийн оролцоонд тулгуурласан халамжийн үйлчилгээний нэг төрөл гэж хуульчилсан ч хохирогчийг хамгаалахад онцгой шаардлагатай энэ үйлчилгээний хүртээмж үнэхээр хангалтгүй байна. Өнөөдөр нийслэлд ганцхан хамгаалах байр 20 ортойгоор үйл ажиллагаа явуулж байна. Бусад дөрвөн хамгаалах байр нь санхүүжилт байхгүйн улмаас хаалгаа барьсан. Орон нутагтаа хүчирхийлэлд өртсөн эмэгтэйчүүд аюулгүй байдлаа хамгаалуулах гэж нийслэл хүртэлх урт замыг туулахаас аргагүй байдалд ордог тул хамгаалах байрны хэрэгцээ нэн түлгамдсан асуудал болсоор байна. Хамгаалах байрны хүрэлцээ хангалтгүйн улмаас хүчирхийллээс зугтахаар оролдсон хохирогчийг хүчирхийлэл үйлдэгчийн зүгээс дагаж мөшгих, айлган сүрдүүлэх, заналхийлэх, амь насанд нь хүрэх тохиолдлууд гарсаар байна.

Хамгаалах байр хүрэлцээгүйн улмаас хохирогч хямралд өртсөн үедээ зайлшгүй шаардагдах бусад нийгмийн үйлчилгээ, дэмжлэгт хамрагдаж чаддаггүй, нөгөө талаас эдгээр үйлчилгээнд зориулсан санхүүжилт байдаггүй. Ачаалал ихтэйн улмаас гэр бүлийн хүчирхийллийн хохирогчийн хэрэгцээнд нийцсэн үйлчилгээ үзүүлэх боломж олгогддоггүй гэж цагдаа, нийгмийн ажилтан болон хуулийн зөвлөгч нар ярилцлагадаа дурдаж байсан.

Ялангуяа хөдөө, орон нутагт эдгээр хэрэгцээг хангах нэн шаардлагатай. Төрийн албан хаагчид ГБХТТХуулиар хүлээсэн үүргээ биелүүлэхэд тэр бүр онцгой ач холбогдол өгдөггүй. Тухайлбал: ГБХТТХуулиар нийгмийн ажилтан гэр бүлийн хүчирхийллийн хохирогчийн эрсдлийн түвшинг үнэлж, нөхцөл байдлын үнэлгээ хийх үүргийг хуульчилж өгсөн. Нийгмийн ажилтны ажил үүргийн тодорхойлолтонд гэр бүлийн хүчирхийллийн асуудлаар ажиллах талаар тусгагдаагүй учраас хуульд тусгагдсан үүрэгт ажлаа ажлын бус цагаар хийх болдог. Дүүрэг, аймаг, сумдын Засаг дарга нар хуулиар гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх үүрэг хүлээсэн ч тэд энэ асуудалд тэргүүлэх ач холбогдол өгдөггүй. Тэдэнд энэ чиглэлээр ажиллах нөөц, чадавх байдаггүй. ХЭҮТ-ийн орон нутгийн салбарын зохицуулагч нар хэрэгцээтэй байгаа үйлчилгээ, дэмжлэгийг орон нутаг дахь хохирогчид хүргэж ажилладаг.

Эцэст нь дүгнэхэд хохирогчийн аюулгүй байдлыг хангах, хүчирхийлэл үйлдэгчид хариуцлага тооцоход чиглэсэн хуулийн шинэчлэлийг цаг алдалгүй хийх шаардлагатай байна. Эдгээр нэн тэргүүнд анхаарал хандуулах, яаралтай авах арга хэмжээг тайлангийн зөвлөмж хэсэгт тусгасан. Засгийн газрын зүгээс тайлангийн тэргүүлэх зөвлөмжид илүү анхаарах шаардлагатай. Судалгааны багийн зүгээс хохирогч хамгаалал, хүчирхийлэл үйлдэгчид хариуцлага тооцох асуудалд төр болон ТББ-тай хамтран ажиллахыг зөвлөж байна. Судалгааны баг нь Монгол улсын Засгийн Газрыг энэ тайлангийн зөвлөмжид анхаарал хандуулж, онцгойлон ажил хэрэг болгохыг шаардаж байна.

ТАНИЛЦУУЛГА

“Надад тохиолдсон хамгийн хэцүү үе бол түүнд зодуулж, дарамтлуулж, хүчирхийлүүлж байсан мөчүүд юм. Үнэндээ энэ бүхэн яг л амьтан зодож байгаа юм шиг байдаг байсан. Гэхдээ амьтныг ч гэсэн тийм аймшигтайгаар зодож тамладаггүй биз дээ, харин ч эсрэгээр асарч халамжилдаг. Энэ бүхэн аймшигтай зэрлэг байсан. Тэр миний үснээс зулгааж, хоолойг минь багалзуурдсанаас болж, би амьсгал авч чадахгүй болж байсан. 2007 онд тэр намайг бүтэн хоёр өдрийн турш орноосоо босч чадахгүй болтол зодсон. Миний толгойгоор хана мөргүүлсэн. . . . Би өөрийгөө хамгаалах гэж оролдсон ч тэр том биетэй учраас би юу ч хийж чадаагүй. Тэр намайг зэрлэгээр зодож, тарчлаасаар байсан. Тэр миний үсийг туг тугаар зулгааж, цохиж, зодно гэдгийг бүх төрлөөр үзүүлсэн. Эцэст нь би цагдаа дуудсан”⁸

Монгол улсад ГБХТТХууль хэрэгжиж эхлээд 8 жил өнгөрсөн ч хохирогч хамгаалагдаж чадахгүй байна. ГБХТТХуулиар иргэний журмаар хамгаалалтын арга хэмжээ авах боломжийг хуульчилсан ч өнөөг хүртэл цөөн тооны эрх хязгаарлах шийдвэрийг шүүхээс гаргажээ.⁹ Гэтэл цагдаагийн байгууллагад ирж буй дуудлагын ихэнх хувь нь гэр бүлийн хүчирхийлэлтэй холбоотой байна. Нэгэн хорооны¹⁰ цагдаагийн хэсэг долоо хоногт дунджаар гэр бүлийн хүчирхийллийн 63 дуудлага хүлээж авдаг байна.¹¹ НҮБ-ын Эмэгтэйчүүдийн асуудал хариуцсан хороо болон Монгол улсын Хүн амын хөгжил, нийгмийн хамгааллын яамны мэдэгдлээр улсын хэмжээнд гарч буй нийт гэмт хэргийн 6 хувь нь гэр бүлийн хүчирхийлэлтэй холбоотой гэжээ.¹² Монгол улсад гурван эмэгтэй тутмын нэг нь гэр бүлийн хүчирхийллийн хохирогч болж байна гэж ХЭҮТ мэдээлсэн.¹³

Монгол улсад ГБХТТХууль батлагдсан нь гэр бүлийн хүчирхийллийг нийгмийн асуудал гэж хүлээн зөвшөөрөх анхны алхам болсон. Нөгөө талаар энэ алхам нь олон улсын эрх зүйн хүрээнд эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийллийг бууруулах амлалт, үүрэг болж чадсан.¹⁴

⁸ Хохирогчийн ярилцлага, Э хот, 2013.3.22, 14:00. Энэ эмэгтэйн түүхийг 9, 14, 3, 53 болон 58-р хуудсанд иш татсан.

⁹ Судлаач Хэлэн Рубенстейнд ТББ-аас ирсэн цахим шуудан (2013.07.6) (судлаачийн файлаас). Эрх хязгаарлах арга хэмжээний албан ёсны тоон мэдээлэл байхгүй.

¹⁰ “Нийслэл УБ хот нь 9 дүүрэгт, дүүрэг тус бүр”хороо”-нд хуваагддаг. Ц.Одгэрэл болон Ганболд Батцэцэг, Монгол улсын хууль эрх зүйн тогтолцоо, хуулиуд: Товч агуулга, GLOBALEX (2006.01 cap), <http://www.nyulawglobal.org/globalex/mongolia.htm>

¹¹ Цагдаагийн ажилтны ярилцлага, Д хот, 2013.01 .23, 1500.

¹² Монгол улс, Хүн ам хөгжил, нийгмийн хамгааллын яамны сайд С.Эрдэнийн НҮБ, Эмэгтэйчүүдийн аж байдлын хорооны 57 дугаар хуралдаан дээр хэлсэн үгнээс <http://www.un.org/womenwatch/daw/csw/csw57/generaldiscussion/memberstates/mongolia.pdf>

¹³ ХЭҮТ, Монгол улс дахь Гэр бүлийн хүчирхийллийн эрх зүйн орчин http://www.stopvaw.org/sites/3f6d15f4-c12d-4515-8544-26b7a3a5a41e/uploads/dvfactsheetenglish__2_.pdf

¹⁴ Монгол улс нь НҮБ-ын гишүүн орны хувьд НҮБ-аас батлагдсан Хүний эрхийн түгээмэл тунхаглалд тусгагдсаны дагуу бүх хүнийг хүнийг шашин шүтлэг, хэл, арьс өнгө, нас, хүйс зэргээр ялгаварлан гадуурхалтаас ангид байлгах, хүний эрх, эрх чөлөөг хамгаалах, хүндэтгэх, ханган хэрэгжүүлэх, сурталчлах үүрэг хүлээсэн. НҮБ-аас баталсан бусад хүний эрхийн гэрээ, конвенц зэрэг баримт бичгүүд, тухайлбал Эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийллийг устгах тунхаглал, Венийн тунхаглалд зааснаар Монгол улс нь хүний эрхийг хамгаалж, хүндэтгэх үүрэгтэй. Монгол улс нь Эмэгтэйчүүдийг ялгаварлан гадуурхах бүх хэлбэрийг устгах тухай Конвенц, Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын Пакт, Эдийн зэсэг, нийгэм, соёлын эрхийн тухай олон улсын Пакт, Эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг доромжлон харьцаж, шийтгэхийн эсрэг Конвенцид тус тус нэгдэн орсон. Дээрх олон улсын гэрээ, конвенцид тусгагдсан эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийлэлтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх, эмэгтэйчүүдийг хамгаалах, хүчирхийлэл үйлдэгчид хариуцлага оногдуулах, хохирогчид нөхөн төлбөр олгох амлалтаа Монгол улсын төр, Засгийн газар биелүүлэх ёстой. Монгол улс 1992 онд батлагдсан Үндсэн Хуульдаа “Монгол Улсын олон улсын гэрээ нь соёрхон баталсан буюу нэгдэн орсон тухай хууль хүчин төгөлдөр болмогч дотоодын хууль тогтоомжийн нэгэн адил үйлчилнэ” гэж заасан.

Энэ талаар Хууль Зүйн Яамны Төрийн нарийн бичгийн дарга “Тухайн үедээ энэ алхам нь маш том амжилт болсон. Энэ өөрчлөлт нь хүмүүсийг гэгээрүүлж, хууль хэрэгжүүлэгчдийн нүдийг нээхэд тусалсан. Гэр бүлийн хүчирхийлэлд анхаарал хандуулахад чухал хувь нэмэр болсон. Хууль батлагдсан нь энэ асуудлыг хэзээ ч хүлээн зөвшөөрөгддөггүй, хэн ч анхаарал хандуулдаггүй байсан тэр цаг үед ялалт болж эрх зүйн тогтолцоонд цоо шинэ агуулга, механизмыг оруулж ирсэн” гэж хэлсэн.¹⁵

Гэр бүлийн хүчирхийллийн хохирогчийг хамгаалах зорилгоор хүчирхийлэл үйлдэгчийн эрхийг хязгаарлах шийдвэрийг шүүхээс гаргахаар хуульчилсан нь чухал алхам болсон.¹⁶ Гэр бүлийн хүчирхийллийн хэргийг шийдвэрлэхэд цагдаа, нийгмийн ажилтан, сум багийн Засаг дарга болон бусад мэргэжилтнүүдийн хүлээх үүрэг, хариуцлагыг тусгайлан хуульчилсан. Цагдаагийн ажилтан нь гэр бүлийн хүчирхийллийн талаарх гомдол, мэдээллийг хүлээн авч шийдвэрлэх, үйлдэгдсэн газар дээр нь очиж ажиллах, хүчирхийлэл үйлдэгч болон гэрчээс мэдүүлэг авах, хохирогчийн аюулгүй байдлыг хамгаалах, хүчирхийлэл үйлдэгчид хариуцлага хүлээлгэх, эрхийг нь хязгаарлуулах хүсэлтийг хохирогчийг төлөөлж шүүхэд гаргах зэрэг үүрэг хүлээсэн.¹⁷ Нийгмийн ажилтан нь нөхцөл байдлын үнэлгээ хийх, хүчирхийлэл үйлдэгчийн зан үйлд нөлөөлөх албадан сургалтыг зохион байгуулах, хохирогчид шаардлагатай үйлчилгээг үзүүлэх, олон нийтийн ойлголт, хандлагыг нэмэгдүүлэх сургалт, бусад үйл ажиллагааг зохион байгуулах зэрэг үүрэг хүлээсэн.¹⁸ Сум, багийн Засаг дарга хохирогчийг шаардлагатай хамгаалалтаар хангах үүрэгтэй.¹⁹

ГБХТТХуулийг хэрэгжүүлэх бүтэц, механизм, процедур хангалтгүй байгаа нь хуулийн хэрэгжилтэнд саад учруулж байна. Энэ талаар Монгол улсын Хүний Эрхийн Үндэсний Комиссын сургалтын албаны дарга “Хуулийг хэтэрхий ерөнхий байдлаар баталсан, батлахдаа ихэнх чухал заалтуудыг хассан” гэж тайлбарласан.²⁰ Шүүмжлэл дагуулсан заалтуудыг хуулиас хассанаар түүний үр дүнтэй хэрэгжилтэд сөргөөр нөлөөлсөн. Нөгөө талаар, холбогдох хуулиудад чухал, нэн шаардлагатай нэмэлт өөрчлөлтүүд ороогүй, ялангуяа зарим нэг хуулийг тухайн хуулиас нэр зааж ишлэл хийсэн ч нэмэлт өөрчлөлт хийгдээгүй.”²¹

Эрүүгийн тогтолцоонд хохирогчийг хамгаалах, хүчирхийлэл үйлдэгчид хариуцлага тооцох зохицуулалт хангалтгүй. Эрүүгийн хуульд гэр бүлийн хүчирхийллийг гэмт хэрэг гэж хуульчлаагүй нь хүчирхийлэл үйлдэгчид хөнгөн хариуцлага тооцох нөхцлийг бүрдүүлсэн. Эрх хязгаарлах арга хэмжээ авсан иргэний эрх зүйн хамгаалалтын хүрээнд эсвэл эрүүгийн эрх зүйн системээр хангалттай хамгаалагдаж чадахгүйн улмаас эмэгтэйчүүд гэрлэлтээ цуцлуулах сонголт хийж байна. Хүчирхийллээс ангижирахын тулд зарим эмэгтэйчүүд амиа хорлох оролдлого хийх эсвэл хүчирхийлэл үйлдэгчийн амь насыг хөнөөхөд хүрч байна.

¹⁵ Хууль зүйн яамны төрийн нарийн бичгийн даргын ярилцлага, УБ хот, 2013. 01.29, 14:00

¹⁶ Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль, 17 дугаар зүйл

¹⁷ Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль, 09 дүгээр зүйл

¹⁸ Дээрх хуулийн 10 дугаар зүйл

¹⁹ Дээрх хуулийн 14 дүгээр зүйл.

²⁰ Хүний эрхийн үндэсний комисстой хийсэн ярилцлага, 2013.01. 22, 10:00

²¹ Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн 2-р зүйлийн 2.1дэх хэсэг: Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль тогтоомж нь Монгол Улсын Үндсэн хууль, Иргэний хууль, Эрүүгийн хууль, Гэр бүлийн тухай, Хүүхдийн эрхийг хамгаалах тухай хууль, энэ хууль болон тэдгээртэй нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийн бусад актаас бүрдэнэ.

ГБХТТХууль, Эрүүгийн хууль, Захиргааны хариуцлагын тухай хууль болон Гэр бүлийн тухай хуулиудад гэр бүлийн хүчирхийллийн хохирогчийг хамгаалах зорилгоор хэрэглэж болох олон зохицуулалт байдаг ч бүрэн хэрэгждэггүй. Эдгээр хуулийн цоорхой, хийдэл нь олон эмэгтэйг гэр бүлийн хүчирхийллийг тэвчих, улмаар амь насаа алдах эрсдэлд хүргэсээр байна.

Хохирогч Дулмаа²² аюулгүй байдлаа хамгаалуулахаар хуулийн болон нийгмийн үйлчилгээний байгууллагуудад хандсан. Үүнд: хүчирхийлэл үйлдэгчид эрх хязгаарлах арга хэмжээ авах шүүхийн шийдвэр гаргуулсан, эрүүгийн хэрэг үүсгүүлсэн, захиргааны хариуцлагын арга хэмжээ авахуулсан, гэрлэлтээ цуцлуулсан, хамгаалах байрны үйлчилгээг авсан боловч хамгаалалт үр дүнгүй болсон. Түүний түүхээс олон олон эмэгтэй гэр бүлийн хүчирхийллийн улмаас хэрхэн зовж зүдэрч байгааг харж болно.

Дулмаа нөхөртэйгээ хамтран амьдарснаас хойш 30 жилийн турш хүчирхийллийн харилцаатай амьдарсан. Түүний нөхөр “хүчирхийллийн талаар хэн нэгэнд хэлэх л юм бол таван хүүхдийнх нь хамт хүйс тэмтэрнэ” гэж айлган сүрдүүлдэг байсан. Тэрээр эхнэр, хүүхдээ өвлийн хүйтэн шөнө өмсөх гутал, хувцасгүй нүцгэн хөөж гаргадаг байжээ. Хүчирхийллийн улмаас Дулмаагийн хэд хэдэн хавирга, эгэм, мөр, гар нь хугарч байсан. Нөхөр нь охиныхоо биед хайч зоож, өөр нэг охиноо алхаар цохиж гэмтээсэн. Энэ бүгд ойр ойрхон давтагддаг.

Эрүүгийн хуулийн хамгаалалт энэ эмэгтэйд туслаагүй. Дулмаа цагдаагийн байгууллагад гомдол гаргасан ч тэд ямар нэг хариу өгөөгүй. Хүчирхийлэл ноцтой байсан ч түүнээс, бас хүүхдүүдээс нь цагдаагийн ажилтан юу болов гэж асуугаагүй, хэн ч түүний байдалд анхаарал хандуулдаггүй байсан. Зөвхөн сануулаад орхих, эсвэл нэг шөнө баривчлаад сулладаг учраас хариуцлага тооцох арга хэмжээ маш сул байсан. Баривчлагдаад гарч ирэхдээ нөхөр нь улам ууртай болж, цагдаад барьж өглөө гэж өширхөж эхэлсэн.

Гэсэн ч цагдаа намайг хамгаална гэж Дулмаа итгэсээр байсан. Хороонд нь шинээр ирсэн цагдаагийн ажилтан тэдний гэрээр эргэж тойрч, нөхцөл байдал ямар байгааг шалгаж байсан нь хамгийн аз жаргалтай мөч байсан. Харамсалтай нь тэр цагдаагийн ажилтан солигдож, шинээр ирсэн цагдаагийн ажилтан түүний нөхцөл байдлыг үл тоомсорлосон. Түүгээр ч зогсохгүй хүчирхийлэлд Дулмааг буруутгасан, тиймээс тэрээр дахин хэзээ ч цагдаагийн байгууллагаас тусламж хүсээгүй.

Дулмаа нөхөртөө эрх хязгаарлах арга хэмжээ авах шийдвэрийг шүүхээс гаргуулахыг хүсч байсан ч энэ арга хэмжээ нь хэрэгждэггүй гэдгийг сонсоод татгалзсан. Нөхөр нь “Хэрвээ надаас салахыг хүсэх юм бол чи үхэх болно. Чи хэзээ ч шүүхээр гэрлэлтээ цуцлуулж чадахгүй” гэж хэлдэг. Эцсийн найдвар болгож, гэрлэлтээ цуцлуулахаар тэр шийдсэн.

²² “Дулмаа” гэж хохирогчийн нэрийг өөрчилсөн болно.

Дулмаа хамгаалах байранд очихыг хамгийн их хүсэж, тэнд илүү аюулгүй байж чадна гэж итгэдэг байсан ч амьдарч байсан орон нутагт нь тийм байр байгаагүй. Одоо Дулмаа хүүхдүүдийнхээ хамт гэрт амьдарч байгаа ч нөхөр нь олоод очих боломжтой. Тэр “Нөхөр маань намайг дахиад л олоод ирнэ” гэж хэлсэн. “ГБХТТХуульд нэмэлт өөрчлөлт оруулах гэж байгааг сонссон ч батлагдах хүртлээ зөндөө удах байх, тэр хүртэл нь би амьд байж чадах эсэхийг мэдэхгүй. Миний хувьд энэ чигээрээ л дуусах байх, харин хууль өөрчлөгдсөнөөр бусад эмэгтэйчүүдэд туслах байх гэж би бодож байна” гэж хэлсэн юм.²³

Эрүүгийн хэрэг үүсгэлээ ч, эсвэл захиргааны хариуцлагын арга хэмжээ авлаа ч ялгаагүй. Хариуцлага нь хэтэрхий хөнгөн учраас аль аль нь ямар ч үр дүнгүй гэж эмэгтэйчүүд үздэг. Нөгөө талаас хуулийн байгууллагын ажилтнууд нь эмэгтэйчүүдээс хэзээ ч барагдуулах боломжгүй нотолгоо, баримтуудыг шаарддаг, процедурын энэ мэт хүнд суртал нь тэдэнд олон олон саад бэрхшээлийг авчирдаг. Эдгээр саад бэрхшээлээс шалтгаалан эмэгтэйчүүд шүүхэд хандан эрх хязгаарлах шийдвэрийг гаргуулж чаддаггүй. Зарим эмэгтэй эрх хязгаарлах шийдвэрийг гаргуулж чадсан ч тэр нь огт хэрэгждэггүй учраас эрсдэл нь улам нэмэгддэг. Хуулийн байгууллагад хандсанд нь өширхсөн хүчирхийлэл үйлдэгчийн зүгээс илүү харгис, аймшигтай дарамт, хүчирхийллийг амсах болдог. Ихэнх эмэгтэйн хувьд аюулгүй газар, тухайлбал хамгаалах байранд байрлах нь бүтэшгүй зүйл. Өнөөдрийн байдлаар 20 ортой ганцхан хамгаалах байр нийслэл Улаанбаатар хотод ажиллаж байна. Нийт 2,8 сая хүн амын дунд зөвхөн нэг л хамгаалах байр төрийн бус байгууллагын харьяанд ажиллаж байна. Гэрлэлтээ цуцлуулснаар хүчирхийллээс ангижирч чаддаггүй. Аюулгүй байдлыг нь хамгаалах үр дүнтэй хамгаалалт байхгүйгээс хүчирхийлэлтэй харилцаа даамжирсаар зарим эмэгтэйг амиа хорлох эсвэл хүчирхийлэл үйлдэгчид ноцтой гэмтэл учруулж, амь насыг нь хөнөөхөд хүргэдэг.

Гэр бүлийн хүчирхийллээс хамгаалах эрх зүйн орчин ийнхүү хангалтгүй байгаа ч бас хуулийг шинэчлэхээр ажиллаж байгаа нь сайшаалтай. Монгол улсын Хууль Зүйн Яамны Төрийн нарийн бичгийн дарга “Бид үнэхээр сайн, бас цогц эрх зүйн суурийг бий болгохоор ажиллаж байна. Одоо хэрэгжиж буй хууль нь анх боловсруулагдсан үеийнхээ л үзэл баримтлалын хүрээнд үйлчилж байна. Харин хуулийн шинэчилсэн найруулгаар бид шинэ тогтолцоог бэхжүүлэх, инститчлахад анхаарал хандуулж байна. Илүү тодорхой бас хохирогчийг бодитоор хамгаалж чадахуйц хэм хэмжээг бий болгоно” гэж хэллээ.²⁴

2011 оны 6 сард ГБХТТХуулийн шинэчилсэн найруулгыг боловсруулах ажлын хэсгийг Хууль Зүйн сайдын тушаалаар байгуулсан.²⁵ Засгийн газрын ажлын хэсэг нь төр, төрийн бус байгууллага болон академик төлөөллөөс бүрдсэн. Энэ ажлын хэсэг зөвхөн ГБХТТХуулийн шинэчилсэн найруулгыг төдийгүй холбогдох хууль тогтоомжуудад орох шаардлагатай нэмэлт өөрчлөлтийг давхар боловсруулах үүрэг гүйцэтгэж байгаа. Тухайлбал: Эрүүгийн хууль, Эрүүгийн байцаан шийтгэх тухай хууль, Гэр бүлийн тухай хууль зэрэг²⁶

²³ Хохирогчийн ярилцлага, Б хот, 2013. 01.31, 15:00

²⁴ Хууль зүйн яам, Төрийн нарийн бичгийн даргын ярилцлага, УБ хот, 2013.1. 29, 14:00.

²⁵ Ажлын хэсэг байгуулах тухай Хуульзүйн сайдын тушаал № 102

²⁶ Хууль зүйн яам, Төрийн нарийн бичгийн даргын ярилцлага, УБ хот, 2013.1.29, 14:00; Дээд шүүхийн шүүгчтэй хийсэн ярилцлагаас, Д хот, 2013. 1.30, 14:00; Жендэрийн үндэсний хорооны ажлын албаны даргатай хийсэн ярилцлагаас, УБ хот, 2013. 1.21, 14:00 (“хэрэгжиж буй хуулиудад уялдаа, зохицуулалт шаардлагатай”)

Минесота дахь “Хүний эрхийн төлөөх өмгөөлөгчид” байгууллага нь Монгол улсын ГБХТТХууль, холбогдох хууль тогтоомжийн хэрэгжилт болон Засгийн газрын зүгээс гэр бүлийн хүчирхийллийн асуудалд хэрхэн хандаж байгаад мониторинг хийх зорилгоор нотолгоонд суурилсан судалгааг 2013 оны нэг болон гуравдугаар саруудад зохион байгуулсан. Судлаачид Монгол улсын нийслэл Улаанбаатар, Дархан, Эрдэнэт хот болон орон нутагт нийт 137 асуулга, ярилцлагыг төр, төрийн бус байгууллага, хохирогчдоос авсан. Энэ тайлан нь хохирогчийн аюулгүй байдлыг хангах, хүчирхийлэл үйлдэгчдэд хариуцлага хүлээлгэхэд чиглэсэн олон улсын хүний эрхийн хуулийн стандартад нийцүүлэн мониторингийн дүгнэлт, зөвлөмжийг гаргасан. Ялангуяа, хохирогчийг хамгаалах, хүчирхийлэл үйлдэгчид хариуцлага хүлээлгэх зорилгоор хуульчлагдсан доорх механизмүүдын хэрэгжилтэнд мониторинг хийсэн:

- ГБХТТХууль болон эрх хязгаарлах арга хэмжээ;
- Эрүүгийн хариуцлага болон захиргааны арга хэмжээ;
- Гэрлэлт цуцлалт;
- Хамгаалах байр болон нийгмийн үйлчилгээ.

Эдгээр механизм бүр нь хохирогчийг зарим талаар хамгаалж, хүчирхийлэл үйлдэгчид ямар нэг байдлаар хариуцлага оногдуулж байгаа хэдий ч цаашид өөрчлөх, хийх зүйл их үлдсэнийг тайланд онцолсон. Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх эрх зүйн бүтэц бий болгох, хэрэгжилтийг нь сайжруулах зөвлөмж, дүгнэлт гаргасан.

ГБХТТХУУЛЬ БА ЭРХ ХЯЗГААРЛАХ ШИЙДВЭР

Эмэгтэйчүүдийг хүчирхийллээс хамгаалах хамгаалалтын чухал аргуудын нэг нь иргэний журмаар шүүхээс эрх хязгаарлах шийдвэр гаргах явдал юм. ГБХТТХуулиар шүүгч эрх хязгаарлах шийдвэр гаргах эрхтэйг хуульчилсан ч 2005 онд хууль хэрэгжиж эхэлснээс хойш Монгол улсын хэмжээнд цөөн тооны л шийдвэр шүүхээс гарсан байдаг.²⁷ Шүүхээс гаргасан цөөхөн тооны эрх хязгаарлах шийдвэр нь цагдаагийн байгууллагад ирдэг гэр бүлийн хүчирхийллийн дуудлагатай харьцуулахад хол зөрүүтэй, эсрэг тэсрэг байдлыг харуулж байна.²⁸ Нэгэн тохиолдол: Нөхцөл байдлын үнэлгээг цагдаагийн ажилтан биш нийгмийн ажилтан хийсэн гэсэн шалтгаанаар шүүх эрх хязгаарлах шийдвэр гаргуулах хүсэлтийг хангаагүй.²⁹ Шүүхийн дээрх шийдвэр гараад удаагүй байхад хүчирхийлэл үйлдэгч хохирогчийг гэрийнх нь гадаа хүлээж байгаад 10 гаруй удаа хутгалж амь насыг нь хөнөөжээ.³⁰

Ихэнх эрх хязгаарлах шийдвэрийг нийслэл УБ хотод гаргасан ч гэр бүлийн хүчирхийллийн дуудлага орон нутагт илүү бүртгэгдсэн байдаг.³¹ Орон нутагт хийсэн ярилцлагын үеэр зарим оролцогчид “орон нутагт нь эрх хязгаарлах арга хэмжээг шүүхээс авч байсан тохиолдол хэзээ ч гараагүй” гэдгийг дурдсан байна.³²

Эрх хязгаарлах шийдвэр ба саад бэрхшээл

Гэр бүлийн хүчирхийллийн хохирогчид эрх хязгаарлах шийдвэр гаргуулахын тулд олон бэрхшээл, үрт замыг туулдаг. Зарим хохирогч эрх хязгаарлах шийдвэрийг шүүхээс гаргуулснаар хуулийн хамгаалалтад орох боломжтойгоо мэддэггүй, хамгийн эхэлж уулзсан үйлчилгээний ажилтны хандлага, нотлох баримтуудын бүрдүүлбэр, тавигдах шаардлагаас шалтгаалан зарим нь залхдаг. Эдийн засгийн хараат байдлаасаа шалтгаалах, нууцлал алдагдахаас болгоомжлох, эсвэл хүчирхийлэл үйлдэгчийн амлалт, ятгалганд итгэсний улмаас эрх хязгаарлах шийдвэрийг гаргуулах хүсэлтийг шүүхэд тэр бүр гаргадаггүй байна. Эрх хязгаарлах шийдвэр үр дүнтэй хамгаалалт болж чаддаггүй учраас зарим эмэгтэйчүүд учирч болзошгүй эрсдлээс айсандаа хүсэлт гаргахаас татгалздаг.

²⁷ Судлаач Хэлэн Рубенстэйнд ТББ-аас ирсэн цахим шуудан (2013.7.16) (судлаачийн файл).

²⁸ “Дунджаар 7 хоногт гэр бүлийн хүчирхийллийн 63 дуудлага хүлээж авдаг” гэж цагдаагийн ажилтан мэдээлсэн, Д хот, 2013.1.23, 15:00. “Долоо хоногт гэр бүлийн хүчирхийллийн дуудлага хэд хэдэн удаа ирдэг” гэж цагдаагийн ажилтан хуваалцсан. Б хот, 2013.1.30, 15:00; Цагдаагийн ажилтны ярилцлага, Г хот, 2013.3. 22, 15:00; Цагдаагийн ажилтны ярилцлага А хот, 2013.3. 22, 14:30.

²⁹ Нийгмийн ажилтны ярилцлага, Д хот, 2013.1. 21, 10:00. Нөхцөл байдлын үнэлгээний маягт нь гэр бүлийн хүчирхийллийн эрсдлийн түвшинг тогтоох асуултуудаас бүрдэнэ. (зэвсэг хэрэглэсэн эсэх, амь насанд нь халдах заналхийлэл, дагаж мөрдөх, бэлгийн хүчирхийлэл байгаа гм) Асуулт бүр оноотой, оноог нэгтгэж эрсдлийн түвшинг тогтоох боломжтой. Хавсралт Д-г харна уу.

³⁰ Хуульчийн ярилцлага, Д хот, 2013.1.30,10:00. Сэтгэл зүйчийн ярилцлага, Д хот, 2013.3. 26, 11:30: Эрх хязгаарлах шийдвэр гаргуулах хүсэлтийг хохирогч гаргахдаа эрсдлийн үнэлгээг нийгмийн ажилтан, цагдаагийн ажилтнаар хийлгэх ба бусад мэргэжилтнээр хийлгэсэн маягтыг хавсаргаж баримт болгоно. Нэгэн эмэгтэй өөрийгөө төлөөлүүлэн эрх хязгаарлах шийдвэр гаргуулахаар шүүхэд хүсэлт гаргахыг цагдаагийн ажилтнаас хүсэхэд тэрээр хамтарсан багийн гишүүдтэйгээ зөвлөлдөөгүй гэсэн шалтгаанаар хүсэлтийг нь хангаагүй. Удалгүй нөхөр нь ирээд, түүнийг хүүхэдтэй нь хамт зодож, гэрээс нь хөөж гаргасан.

³¹ Хүний эрхийн үндэсний комисс, сургалт хариуцсан мэргэжилтэн, 2013.1. 22, 10:00; Хуульчийн ярилцлага, Д хот, 2013. 1.23, 12:00.

³² Сургуулийн нийгмийн ажилтан, Б хот, 2013.1.29, 10:45; ТББ-ын ярилцлага, Э хот, 2013.3.18, 11:00; ТББ-ын ярилцлага, Б хот, 2013. 2.1, 9:00.

Хохирогчид болон олон нийтийн ойлголт, мэдлэг хангалтгүй

Ихэнх хохирогч гэр бүлийн хүчирхийллийн талаарх ойлголт болон эрх хязгаарлах шийдвэрийг шүүхэд хандан гаргуулж болох талаар мэдээлэлгүйн улмаас хэзээ ч энэ хамгаалалтыг хүсч байгаагүй гэж хариулжээ.

ГБХТТХуулиар нийгмийн ажилтан нь гэр бүлийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэх, олон нийтэд ойлголт, мэдлэг нэмэгдүүлэх сургалт, бусад үйл ажиллагааг зохион байгуулах үүрэгтэй.³³ Гэвч, олон хохирогч хамгаалалтын ямар арга хэмжээ байдаг, түүний хэрхэн хүсэх талаар мэддэггүй учраас түслалцаа авч чаддаггүй байна. Зарим хохирогч хэзээ ч эрх хязгаарлах арга хэмжээний талаар сонсож байгаагүй гэж хариулсан.³⁴ Нөхөртөө хүүхдийнхээ хамт зодуулсан 30 настай эмэгтэй “Үнэндээ эрх хязгаарлах арга хэмжээний талаар ХЭҮТ-д үйлчлүүлэхээр очоод л олж мэдсэн”, “Цагдаагийн ажилтан, хуульч энэ талаар надад хэлж өгч байгаагүй” гэж хариулсан.³⁵ Энэ эмэгтэйн нөхөр түүний гар, эгэм, мөрийг нь хугалж, хүүхдийнхээ биед хайч зоож байхад эрх хязгаарлах шийдвэр шүүхээс гаргуулах замаар хамгаалагдаж болно гэдгийг мэдээгүйн улмаас нөхрөө орхиж явж чадаагүй, нөхөр нь түүнээс явбал ална гэж заналхийлж байсан учраас хүчирхийлэлтэй амьдралдаа үлдсэн байдаг.³⁶

Олон жил маш хэрцгий хүчирхийлэл, дарамт дор амьдарч байсан эмэгтэй:

“Тэр намайг бүтэн 7 хоногийн турш зодсон. Миний толгойг хананд мөргүүлж, дараа нь суран бүсээрээ ташуурдаж, үсийг минь зулгаасан. Би ухаан алдсан ч, тэр ус цацан сэрээж, зодуур тамлалаа үргэлжлүүлсээр байсан. Би дахиад л ухаан алдсан, намайг угаалгын өрөөнд чирч оруулж, миний толгойг угаалтууранд чихсэн. Тийшээ аваачихдаа миний үснээс чирч явж байсан. Тэр үед би хүүхдүүдээ аюулгүй байлгах зорилгоор ахынхаа гэр лүү явуулсан байсан. Иймээс, би гэртээ зөвхөн түүнтэй хамт байсан. Би цагдаа, эмнэлэг эсвэл хамаатнаа дуудах ямар ч боломжгүй байсан, учир нь тэр намайг өрөөнд түгжсэн, бас би зодуулснаас болоод хөдөлж ч чадахгүй болсон байсан”³⁷

Энэ хүчирхийлэлтэй харилцаа нь олон жил үргэлжилж, эмэгтэй амь насаа алдах шахсаны дараа л цагдаагийн ажилтан хүчирхийлэл үйлдэгчийг баривчилж эрүүгийн хариуцлага оногдуулсан. Энэ эмэгтэй хүчирхийлэлтэй харилцаанд олон жил амьдрахдаа эрх хязгаарлах арга хэмжээ авахуулах хүсэлт гаргаж байгаагүй, учир нь хуулийн ийм хамгаалалт байдаг талаар мэдээгүй.³⁸

³³ Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль, 10 дугаар зүйлийн 10.1.3 дахь хэсэг

³⁴ Хохирогчийн ярилцлага, А хот, 2013.3. 21, 1400 (“Тухайн үед хуулийн талаар би мэддэггүй байсан. Яг юу хийхээ мэдээгүй.”). Хохирогчийн ярилцлага, Д хот, 2013.1.21, 16:00.

³⁵ Хохирогчийн ярилцлага, Б хот, 2013.1.31, 15:30. Энэ түүхийг 14, 25, 26, 35, 37 болон 63 хуудсанд иш татсан.

³⁶ Хуульчийн яриа, Д хот, 2013. 1.28, 10:00 (“8 жилийн турш хүчирхийллийн харилцаатай амьдарсан, учир нь эрх хязгаарлах арга хэмжээгээр хамгаалалт авах боломжтой гэж мэдээгүй”)

³⁷ Хохирогчийн ярилцлага, Э хот, 2013. 3. 22, 14:00. Энэ түүхийг 9, 14, 3, 53 болон 58 хуудсанд иш татсан

³⁸ Дээр дурдагдсан.

Зарим эмэгтэй эрх хязгаарлах арга хэмжээний талаар мэдэхгүй байхаас гадна өөртөө тулгарч буй гэр бүлийн хүчирхийллийг эрхийг нь зөрчсөн зөрчил, хариуцлага хүлээх ёстой гэмт хэрэг гэж мэддэггүй.³⁹ Нэгэн хохирогч “Би бүх л гэр бүлд, хосуудад ийм асуудал байдаг гэж ойлгодог байсан. Тэр намайг маш олон удаа алгадаж....цохиж...өвтгөж байсан ч энэ бүхнийг би хэвийн зүйл гэж бодож байсан.”⁴⁰ Хүчирхийлэл үйлдэгчид ерөнхийдөө л өөрсдийгөө өмөөрдөг, ийм зүйл байж л байдаг гэж үздэг.⁴¹ Гэр бүл цуцлах шүүх хурал дээр нэг нөхөр мэдүүлэхдээ “ би гэр бүлийн хүчирхийлэл үйлддэггүй....би түүнийг арваадхан удаа л зодсон. . . . тэр өөрөө согтуу байсан. Хамгийн сүүлд эхнэрээ зодсон шалтгаан нь энэ байсан” гэж тайлбарласан.”⁴²

Хохирогч өөрийн эрх болон эрх хязгаарлах хамгаалалтын арга хэмжээний талаар мэдэхгүй байгаа нь гэр бүлийн хүчирхийллийн мөн чанар, түүнд хэрхэн хандах, хэрхэн шийдвэрлэх талаар олон нийтийн мэдлэг сул байгааг харуулж байна.

Төрийн албан хаагчдын хангалтгүй мэдлэг, хэвшмэл хандлага болон бүрэн бус, системчлэгдээгүй сургалт

ГБХТТХуулиар эрх хязгаарлах арга хэмжээтэй холбоотой төрийн албан хаагчдын үүрэг хариуцлагыг хуульчилж өгсөн ч⁴³ тэд хохирогчийг хамгаалах хуулийн хамгаалалтын талаар мэдлэг сул, хуулиар хүлээсэн үүргээ биелүүлэх хүсэл эрмэлзэл хангалтгүй байдаг. Гэр бүлийн хүчирхийллийн мөн чанар, ГБХТТХуулийн хэрэглээ, ялангуяа эрх хязгаарлах арга хэмжээг хэрхэн хэрэгжүүлэх талаар холбогдох төрийн байгууллагын бүх шатны албан тушаалтнууд сургагдах шаардлагатайг судалгаанд оролцогчдын зүгээс дахин давтан илэрхийлж байсан.⁴⁴

Хохирогчид үр ашгийг нь шууд хүртэх үр дүнтэй нэг арга зам нь Хамтарсан багаар ажиллах юм. Эмнэлэгт түшиглэсэн Нэг цэгийн үйлчилгээний төв дээр Хамтарсан багаар ажиллах аргачлалыг зарим орон нутгийн засаг захиргаа ТББ-тай хамтран түршиж байна.⁴⁵ Эдгээр төв нь хохирогчийг 72 цаг хүртэлх хугацаагаар байрлуулж, нийгмийн ажилтан болон сувилагч хохирогчтой уулзаж нөхцөл байдлын үнэлгээ хийдэг.⁴⁶ Багийн засаг дарга Хамтарсан багийн ажиллагааны талаар ярихдаа:

³⁹ ТББ-ын ярилцлага, Э хот, 2013. 3.18, 11:00; Хохирогчийн ярилцлага, Б хот, 2013, 1 сар 29,15:00 [Энэ түүхийг 15, 22, 24, 26, 60, 64 болон 65 хуудсанд иш татсан. Хохирогчийн ярилцлага, А хот, 2013. 3.21, 14:00

⁴⁰ Хохирогчийн ярилцлага, Б хот, 2013. 1. 29, 15:00. Энэ түүхийг 15, 22, 24, 26, 60, 64 болон 65 хуудсанд иш татсан.

⁴¹ Гэрлэлт цуцлах шүүх хурал, Д хот, 2013. 3.29,10:00

⁴² Дээр дурдагдсан.

⁴³ Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль, 9 дүгээр зүйлийн 9.1.2 дахь хэсэг (Эрх хязгаарлах арга хэмжээ авах хүсэлт гаргахад шаардлагатай бүх мэдээллийг хохирогчид цагдаа өгөх ёстой), 9.1.9 дахь хэсэг (Цагдаагийн ажилтан эрх хязгаарлах арга хэмжээ авах хүсэлт гаргах)

⁴⁴ Жендэрийн үндэсний хорооны ажлын албаны дарга, УБ, 2013. 1. 21,14:00; ТББ-ын ярилцлага, Б хот, 2013. 2.1, 9:00; Сургуулийн нийгмийн ажилтан, А хот, 2013. 3.21, 10:00 ТББ-ын ярилцлага, А хот, 2013. 3.22, 10:00; Прокурорын ярилцлага, Д хот, 2013.3.28, 14:00; Нийгмийн ажилтны яриа, Д хот, 2013.1. 21,10:00; Хүний эрхийн үндэсний комисс, УБ, 2013.1.22, 10:00; Цагдаагийн сэтгэл зүйч, Э хот, 2013.3.18, 12:00.

⁴⁵ Цагдаагийн ажилтны яриа 1, Д хот, 2013.3.25, 10:00 (Багийн гишүүдэд сургуулийн нийгмийн ажилтан, өрхийн эмч, хорооны Засаг дарга, хэсгийн байцаагч)

⁴⁶ Сувилагчийн яриа, Д хот, 2013.1. 21, 10:00.

“Бид, багийн түвшинд хамтарсан багтай ижил төстэй баг байгуулсан, гэхдээ сайн дурын үндсэн дээр нэгдсэн.. . . Хамтарсан баг нь одоо 10 орчим гишүүдтэй, багийн хэсгийн байцаагч, нийгмийн ажилтан болон орон нутгийн хамт олны зарим төлөөлөл багтдаг.. . . Энэхүү багийн үйл ажиллагаа үр дүнтэй байгааг бид харж байгаа. Одоогоор нийт 3 хэрэг дээр хамтран ажиллаж үр дүнд хүрсэн. Түүнчлэн, хэд хэдэн хүчирхийлэл үйлдэгчийг архины хамаарлаас гаргах эмчилгээнд хамруулсан, бүгд л сайн байгаа. Нийтдээ 5 гэр бүлд туслаад байна.”⁴⁷

Багийн хамтын ажиллагаа үр дүнтэй байгаа ч зарим гишүүд уулзалт, хамтын ажиллагаандаа тэргүүлэх ач холбогдол өгдөггүй. Багийн тогтмол уулзалтын талаар хүүхэд хамгааллын ажилтан хуваалцахдаа:

“Хамтарсан баг амжилтгүй байгаа шалтгаан нь: төрийн байгууллагын ажилтнууд, цагдаа, сургуулийн ажилтнууд нь байнга солигдож байдаг учраас хамтарсан баг тогтворгүй байдаг. Иймээс багийн өдөр тутмын үйл ажиллагааг гардан зохион байгуулах хүн байхгүй. Бид нийгмийн хариуцлагаа ухамсарлах хүрээнд л багаар ажиллаж байна даа”⁴⁸

Мэргэжилтнүүдийн сургагдаагүй, бэлтгэгдээгүй байдал

Цагдаагийн ажилтан, нийгмийн ажилтан, шүүгчдийн ихэнх нь хохирогчийн хүсэлтийн дагуу түүнийг хамгаалах зорилгоор эрх хязгаарлах арга хэмжээг авах талаарх ойлголт байдаггүй.⁴⁹ Нэгэн цагдаагийн ажилтан тайлбарлахдаа, “Үнэндээ, маш олон хүмүүс гэр бүлийн хүчирхийллийн хуулийн заалтуудыг мэддэггүй. Жишээ нь: миний хувьд эрх хязгаарлах арга хэмжээний талаар өнөөдөр л сонсож байна.”⁵⁰ Нэгэн нийгмийн ажилтан хамт ажилладаг хүнээсээ эрх хязгаарлах арга хэмжээний талаар олж мэдсэнээ хуваалцсан, гэхдээ тухайн үед хамт ажиллаж байсан 15 нийгмийн ажилтнаас нэг нь ч энэ арга хэмжээг авахуулах талаар алхам хийж үзээгүй байна.⁵¹ Өөр нэг нийгмийн ажилтан тайлбарлахдаа, “Эрх хязгаарлах арга хэмжээ авахуулахад шүүх дээр л бэрхшээл учирдаг. Шүүх уг арга хэмжээг авах үндэслэл алга гэсэн шалтгаанаар хохирогчоос илүү нотлох баримт шаардаж буцаадаг”⁵²

Дараах жишээ нь төрийн албан хаагч мэдлэг, мэдээлэлгүйн улмаас хохирогчид туслах гэсэн алхам нь хэрхэн бүтэлгүйтсэнийг харуулж байна: Өмгөөлөгч хохирогчийг эрх хязгаарлах арга хэмжээ авахуулах хүсэлт гаргахад нь тусалсан, харин цагдаа, нийгмийн ажилтан болон шүүгчийн зүгээс ямар ч ойлголтгүйн улмаас эмэгтэйг мухардалд оруулсан:

⁴⁷ Багийн Засаг даргын яриа, Б хот, 2013.1.30, 14:00.

⁴⁸ Хүүхдийн төлөө газар, Э хот, 2013. 3.18, 12:30.

⁴⁹ Нийгмийн ажилтны яриа, Д хот, 2013. 1. 21, 10:00;ТББ-ын ярилцлага, Э хот, 2013. 3.19, 11:00; Нийгмийн ажилтны яриа, Д хот, 2013. 1. 24, 16:00; ТББ-ын ярилцлага, Е хот, 2013. 3.21, 9:00; Цагдаагийн ажилтны яриа, Г хот, 2013. 3.22, 15:00; Нийгмийн ажилтны яриа, Д хот, 2013.3. 26, 1000; Цагдаагийн ажилтны яриа 2, Д хот, 2013. 3.25, 12:00; Шүүхийн нарийн бичиг, Э хот, 2013. 3.19,17:30 (“Эрх хязгаарлах арга хэмжээг шүүхээс авсан тухай сонсож байгаагүй. Шүүх эцэг эх байх эрхийг хасах тухай мэдэх ч харин насанд хүрсэн хүмүүсийн хооронд ийм арга хэмжээ авдаг тухай мэдэхгүй”); Багийн засаг дарга 2, Э хот, 2013. 3.19, 9:30; Багийн Засаг дарга 1, Э хот, 2013.3.19, 9:30; Хуульчийн яриа, Д хот, 2013. 1. 23, 12:00.

⁵⁰ Цагдаагийн ажилтны яриа 2, Д хот, 2013. 3.25, 12:00.

⁵¹ Нийгмийн ажилтны яриа, Д хот, 2013.1 сар.24, 16:00.

⁵² Нийгмийн ажилтны яриа, Д хот, 2013. 1.21, 10:00.

“Би эмэгтэйд хуулийн дагуу хүсэлт гаргахад нь тусалсан, тэр бүх бичиг баримтаа бүрдүүлж, хүсэлтээ бичиж дуусгаад шүүхэд өгсөн. Цагдаа, нийгмийн ажилтан болон шүүгчийн зүгээс юу хийхээ мэдэхгүй байсан. Эмэгтэйн гэрт очиж нотлох баримт олж ир гэж шүүгч, цагдаа, нийгмийн ажилтанд хэлсэн. Цагдаа, нийгмийн ажилтнууд сургалтанд хамрагдаагүй учраас нөхцөл байдлыг хэрхэн үнэлэхээ ч мэдэхгүй байсан”⁵³

Өмгөөлөгчийн зүгээс шүүгчийн ойлголтгүй байдлыг давж, эрх хязгаарлах арга хэмжээ авахуулах үйлчлүүлэгчийнхээ хүсэлтийг хангуулахын тулд хэрхэн хүчин чармайлт гаргаж ажилласан тухайгаа хуваалцсан:

“Шүүхийн практикт, эрх хязгаарлах арга хэмжээ оногдуулж байсан туршлага ховор, шинэ тутам. Зарим хэргүүдийг шийдвэрлүүлэхийн тулд бид Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийг барьж очиж, тэдэнд үзүүлж байж, эрх хязгаарлах арга хэмжээг шүүхээр гаргуулж байсан. Учир нь тэд ийм хууль байдаг талаар ч мэдэхгүй байсан. Хуулийг шүүхийн танхимд авчирч өгч байсан.”⁵⁴

Төрийн байгууллагын зарим ажилтнууд, гэр бүлийн хүчирхийллийн зарим ноцтой хэлбэрүүдийг ГБХТТХуулийн хүрээнд ойлгож, хүлээн зөвшөөрч чаддаггүй.⁵⁵ Тухайлбал, дагаж мөшгих, тарчлаах зэрэг хэлбэрүүдийг. “Хүчирхийлэл үйлдэгч дагаж мөшгихөөс хохирогчийг хамгаалах зорилгоор эрх хязгаарлах арга хэмжээг шүүхээс авч байгаагүй” гэж нэгэн шүүгч хэлсэн.⁵⁶ Нөхрийн зүгээс заналхийлэх, дагаж мөшгих, тарчлаах үйлдлээс хамгаалагдахын тулд нэгэн эмэгтэй эрх хязгаарлах шийдвэр гаргуулахыг хүссэн ч шүүх түүний хүсэлтийг хангахаас татгалзсан. Удалгүй тэрээр нөхрийнхөө гарт амь насаа алдсан.⁵⁷ Харин өөр нэг эмэгтэй эрх хязгаарлах шийдвэрийг шүүхээс гаргуулж чадвал дараагийн удаа цагдаагийн ажилтан “эхнэр, нөхрийн асуудал” гэж хандахаас илүү хурдан шийдвэрлэх байх гэж найдаж байсан.⁵⁸ Ийм хамгаалалт байхгүй байхад өдөр тутам нөхөр нь түүнийг ална гэсэн мессэж илгээж, байнга айдас түгшүүрт оруулж байсан тухай:

“Би өдөр бүр айдастай байдаг. Дөнгөж уржигдар тэр манай гэрт ирээд хаалга нүдээд байсан ч би хаалгаа нээгээгүй. Тэр миний гар утас руу залгаад л байсан, би бас л хариу өгөөгүй, намайг заавал олж авна гэж мессэж ирүүлсээр байсан. Дараа нь биднийг цагдаа дуудсан байх гэж бодоод тэр яваад өгсөн. Өнөөдөр, эсвэл маргааш юу болох бол гэж би үргэлж айдаг. Сэтгэл санааны хувьд байнга түгшүүртэй байснаас эм их хэрэглэдэг болсон. Үүнээс болж миний толгой байнга өвдөж, их турсан. Одоо би, хуулийн сургуулийн

⁵³ ТББ-ын ярилцлага, У хот, 2013. 3.21, 9:00.

⁵⁴ Хуульчийн ярилцлага, Д хот, 2013.1. 23, 12:00.

⁵⁵ Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль, 6 дугаар зүйлийн 6.1 дэх хэсэг

⁵⁶ Шүүгчийн яриа, Д хот, 2013. 1.29, 11:00.

⁵⁷ Хуульчийн ярилцлага, Д хот, 2013.1. 30, 11:00. Нийгмийн ажилтны яриа, Д хот, 2013.1.21,10:00 (дагаж мөрдөхөөс хамгаалагдах боломжууд байдаг талаар итгэлгүй байгаа)

⁵⁸ Хохирогчийн яриа, У хот, 2013,3 сар 22, 9:00. Энэ түүхийг 12, 13, 17, 28, 35, 36 болон 54. хуудсанд иш татсан

магистрийн ангид сурч байгаа ч, сургууль руугаа явахаас айдаг. Ажил дээрээ байсан ч, миний бодол санаа ажил дээрээ төвлөрч чаддаггүй, учир нь тэр байнга мессэж бичиж дарамталдаг “ би чамайг алах болно, би чиний хаана байгааг мэдэж байгаа.. алах болно...” Ажлаас гэр хүрэхэд ганцхан зам байдаг учир орой харихдаа байнга айж түгшдэг, явган явдаггүй. Магадгүй тэр машинтай ирээд намайг аваад явчих байх, бас тэр намайг алчих байх гэж байнга айдаг”⁵⁹

Дагаж мөшгисөн тохиолдолд эрх хязгаарлах шийдвэр гаргах үндэслэл болдоггүй, гэмт хэрэг гэж зүйлчлээгүй байгаагаас гэр бүлийн хүчирхийллийн хохирогч хүүлийн хамгаалалт авах боломжгүйг судалгааны тайлангийн Эрүүгийн ял болон Захиргааны хариуцлага хүлээлгэхэд тулгарч буй бэрхшээл хэсэгт багтаасан.⁶⁰

Мэргэжилтнүүдийн хэвшмэл хандлага

Мэргэжилтнүүд гэр бүлийн хүчирхийллийн талаарх хэвшмэл, буруу хандлагатай байгаа нь эрх хязгаарлах шийдвэрийг шүүхээс гаргах, хохирогч хамгаалагдах боломжийг хязгаарлаж, хүндрэл учруулж байна.⁶¹ Энэ хандлага нь “гэр бүлийн хүчирхийлэл нь хувийн асуудал”, “гэр бүл дотроо шийдвэрлэх ёстой” гэсэн тэдний итгэл үнэмшилтэй холбоотой юм. Нөхөр нь алахаар заналхийлсэн тохиолдолд, цагдаагийн ажилтан эрүүгийн хэрэг үүсгүүлэх, эрх хязгаарлах шийдвэр гаргуулах нэхэмжлэл гаргахаас илүү иргэний журмаар⁶² гомдол гаргахыг эхнэрт нь санал болгодог. Учир нь нөхөр нь гэр бүл дотроо заналхийлсэн учраас гэж тэд тайлбарладаг.⁶³

Цагдаагийн ажилтан, нийгмийн ажилтны ихэнх нь гэр бүлийн хүчирхийлэл нь онцгойлон анхаарал хандуулах хэрэг биш гэж үздэг. Нийгмийн ажилтан хэлэхдээ:

“Хороонд ажиллаж буй мэргэжилтнүүдийн хандлагыг өөрчлөх хэрэгтэй, гэр бүлийн асуудлаа өөрсдөө л шийдэх ёстой гэж тэд үздэг. Харин хуулиар цагдаагийн ажилтан, нийгмийн ажилтны нөхцөл байдлын үнэлгээ хийх үүргийг хуульчилж өгсөн. Гэхдээ тэдэнтэй ярилцахаар очиход хорооны ажилтнуудын ажлын ачаалал үнэндээ их байдаг. Гэр бүлийн хүчирхийллийн хэргүүдээс илүү хүнд, шийдвэрлэх асуудал зөндөө байдаг гэж тэд хэлдэг. Эндээс тэд бусад хэргүүдээ илүү анхаарал хандуулдаг нь харагддаг. Хорооны нийгмийн ажилтнуудын хувьд бас л адилхан байдаг”⁶⁴

⁵⁹ Дээр дурдагдсан.

⁶⁰ Захиргааны хариуцлага, эрүүгийн ял онооход тулгарч буй бэрхшээл хэсгээс үзнэ үү.

⁶¹ Хохирогчийн ярилцлага, У хот, 2013.3.22, 9:00 [энэ түүх 12, 13, 17, 28, 35, 36 болон 54 хуудсанд дурдагдсаныг харна үү; Нийгмийн ажилтны яриа, Д хот, 2013.1.21, 10:00; ТББ-ын ярилцлага, Б хот, 2013.2. 1, 9:00; ТББ-ын ярилцлага, Э хот, 2013.3.18,11:00.

⁶² Иргэний хуулиар, хохирогч эд хөрөнгийн маргаан, хүүхдийн тэтгэмж, эд хөрөнгө нөхөн төлүүлэх, гэмтэл бэртэл нөхөн төлбөрийн асуудлаар хувийн гомдол гаргаж болно. Хэрвээ хохирогч гомдлоос гадна эрх хязгаарлах шийдвэр гаргуулах нэхэмжлэл гаргавал, шүүх шийдвэр гаргах боломжтой. Судлаач Хэлэн Рубенстэйнд ирсэн цахим шуудан (2013. 7.16) (судлаачийн файл).

⁶³ Хохирогчийн ярилцлага, У хот, 2013.3.22, 9:00 (энэ түүх 12, 13, 17, 28, 35, 36 болон 54 хуудсанд дурдагдсаныг харна үү)

⁶⁴ Нийгмийн ажилтны яриа, Д хот, 2013.1.21, 10:00. ТББ-ын ярилцлага, Б хот, 2013.2.1, 9:00 “Цагдаад хандахад тэд өөр чухал хэрэг дээр ажиллаж байна гэж хариулдаг. Тэд үргэлж л ажил ихтэй байна гэж уцаарладаг.Гэр бүлийнхээ асуудлыг өөрсдөө л шийд гэж хэлдэг”

Эдгээр хэвшмэл хандлага нь цагдаагийн ажилтны зүгээс авах арга хэмжээнд саад учруулж, тээг болсоор байна. Эрх хязгаарлах шийдвэрийг шүүхээр гаргуулахыг хүссэн эмэгтэйн хүсэлтийг цагдаагийн ажилтан буцаасны дараа хүчирхийлэл үйлдэгч хохирогчийг хүнд гэмтээсэн талаар ярьсан:

“Хагарах, хэмхрэх, том, жижиг нь хамаагүй гартаа тааралдсан бүх зүйлээр эмэгтэйг зодсон. Энэ эмэгтэй суманд амьдардаг учраас морио унаад зөвлөгөө авахаар ирсэн Нэгэн удаа нөхөр нь том хэмжээний модон саваагаар түүнийг зодсон Эмэгтэй зодуулж, цохиулсны улмаас ухаан алдаж унасан. Түүнийг “Зүгээр л үхээд өг” гэж хэлээд цохиж байсан. Нөхөр нь олон удаа хутга, хүйтэн зэвсэг хэрэглэж байснаас эмэгтэй оёдол тавиулж байсан. Эмч гайхаад: Та яаж ийм нөхцөлд амьдарч байна вэ? Та яаж даван туулдаг вэ? Хэрвээ би, таны оронд байсан бол, аль хэдийн амь тавьсан байх байсан.” гэж хэлж байсан. Эмэгтэйн биед шарх, сорвигүй газар гэж байхгүй. Шарх, шалбархай өдөр бүр нэмэгдэж, нэг өдөр түүний гарыг хугалсан”⁶⁵

Энэ бүх баримт байхад цагдаагийн ажилтан нөхрөөс нь мэдүүлэг авчихаад л, эрх хязгаарлах шийдвэрийг шүүхээс гаргуулах хүсэлтийг хохирогчийг төлөөлөн шүүхэд гаргалгүй хэдхэн өдөр баривчлаад сулласан. Аргагүйн эрхэнд хохирогч хүчирхийлэл үйлдэгчээс зугтаж өөр хот руу нүүх шаардлагатай болсон.⁶⁶

Гэр бүлийн хүчирхийллийн хэргийг шийдвэрлэх явцад салбарын мэргэжилтнүүд хамтран ажиллаж чаддаггүй, харилцан дэмжлэг үзүүлэхээс татгалздаг. Нэгэн тохиолдол: шүүгч эрх хязгаарлах шийдвэрийг шүүхээс гаргуулахад нь хохирогчид тусалсан нийгмийн ажилтныг буруутгаж, зөвхөн гэр бүл цуцлахад л шүүх оролцоно, харин гэр бүлийн асуудалд оролцохгүй гэж нийгмийн ажилтныг буруутгасан.⁶⁷ Нэгэн цагдаагийн ажилтан хохирогчийг эрх хязгаарлах шийдвэр шүүхээс гаргуулах нэхэмжлэлээ буруу гаргасан гэж буруутгасан тухай өмгөөлөгч мэдээлсэн. Түүнчлэн, хохирогчийг төлөөлөн эрх хязгаарлах шийдвэрийг гаргуулах хүсэлтийг шүүхэд өгөхийг хүссэн нийгмийн ажилтны чармайлт талаар болсон. Учир нь цагдаагийн ажилтан “эр хүн эр хүнээ хамгаалах ёстой” гэж тайлбарлаад татгалзсан.⁶⁸ Цагдаагийн ажилтны энэ шийдвэрт хамтран ажиллагсдын хандлага нөлөөлсөн.⁶⁹ Үүнтэй төстэй тохиолдол: хорооны цагдаагийн ажилтан, нийгмийн ажилтан нар эрх хязгаарлах шийдвэрийг шүүхээс гаргуулахын тулд нөхцөл байдлын үнэлгээ хийх, нотлох баримт бүрдүүлэхээс татгалзсан. Үүнтэй адил жишээг нэгэн өмгөөлөгч хуваалцсан ба хорооны цагдаагийн ажилтан, нийгмийн ажилтан нар “энэ бол гадаадын хууль” гэж тайлбарлаад хамтран ажиллахаас татгалзсан.⁷⁰

⁶⁵ ТББ-ын ярилцлага, Э хот, 2013. 3.18, 11:00

⁶⁶ Дээр дурдагдсан.

⁶⁷ Нийгмийн ажилтны ярилцлага, Д хот, 2013.1. 24,16:00

⁶⁸ ТББ-ын ярилцлага, А хот, 2013.3. 22, 10:00

⁶⁹ Дээр дурдагдсан.

⁷⁰ ТББ-ын хамгаалах байр, ярилцлага, Д хот, 2013, 1.31, 9:00

Давтан сургалт, арга зүйн дэмжлэг хязгаарлагдмал

Системтэй, тогтвортой сургалт байхгүйгээс төрийн албан хаагчдын гэр бүлийн хүчирхийллийн мөн чанар, хэргийн онцлогийг ойлгохгүй байх, ялангуяа эрх хязгаарлах шийдвэрийг хэрхэн авах, хуулийг хэрхэн хэрэглэх талаар мэдлэггүй байхад нөлөөлж байна.⁷¹ Төрийн албан хаагчдад нэн тулгамдсан асуудал нь энэ төрлийн сургалтанд хамрагдах шаардлага юм. Төрийн нийт албан хаагчдын 90% нь албан тушаал дээрээ шинээр томилогдсон гэж Хүн амын хөгжил, нийгмийн хамгааллын яамны төлөөлөгч мэдээлсэн.⁷² Жендэрийн үндэсний хорооны төлөөлөгч “Дөрвөн жил тутам тохиох сонгуулийн дараа төрийн албан хаагчид олноор өөрчлөгддөг. Иймд сургалтыг тогтмол зохион байгуулах шаардлагатай.” гэж онцолсон.⁷³

Нийгмийн ажилтан,⁷⁴ цагдаа,⁷⁵ шүүгч,⁷⁶ прокурор,⁷⁷ эрүүл мэндийн ажилтан,⁷⁸ өмгөөлөгч, хуульч,⁷⁹ болон Засаг дарга нарт тогтмол сургалт шаардлагатай байна.⁸⁰ Шүүгч, прокурор нар ч тогтмол сургалтанд хамрагдах шаардлагатай байгаагаа илэрхийлсэн.⁸¹ Нэгэн шүүгч “Энэ төрлийн сургалт нь шүүгч нарт гэр бүлийн хүчирхийллийн хэргийг хэрхэн шийдвэрлэх мэдлэг, арга зүйг олгож, эмэгтэйчүүдэд туслах боломж олгоно” гэж тайлбарласан⁸²

Хүний Эрхийн Үндэсний Комисс болон ХЭҮТ хамтран төрийн албан хаагчид болон үйлчилгээний ажилтнуудад зориулж хэд хэдэн сургалт зохион байгуулсан. Эндээс харахад ийм төрлийн сургалт зохион байгуулахад хүний нөөц болон санхүүгийн хязгаарлагдмал байдлыг шийдвэрлэх шаардлагатайг онцолсон.⁸³ Манай сургалтын хэлтэс нь дөрөвхөн ажилтантай учраас орон нутаг дахь алслагдсан аймгуудад хүрч ажиллахад хүрэлцдэггүй гэж Хүний Эрхийн Үндэсний Комиссын мэргэжилтэн тайлбарласан.⁸⁴

⁷¹ Жендэрийн үндэсний хороотой хийсэн ярилцлага, Улаанбаатар, 2013.1.21, 14:00; ТББ-тай хийсэн ярилцлага, Б хот, 2013.2.1, 9:00; Сургуулийн нийгмийн ажилтантай хийсэн ярилцлага, А хот, 2013. 3.21, 10:00

⁷² Хүн амын хөгжил нийгмийн хамгааллын яамтай хийсэн ярилцлага, Улаанбаатар, 2013.1.22, 14:30

⁷³ Жендэрийн үндэсний хороотой хийсэн ярилцлага, Улаанбаатар, 2013.1.21, 14:00

⁷⁴ Прокурорын ярилцлага, Д хот, 2013. 3. 28,14:00; Нийгмийн ажилтны ярилцлага, Д хот, 2013. 1. 21, 10:00; Жендэрийн үндэсний хороотой хийсэн ярилцлага,Улаанбаатар, 2013. 1. 21,14:00

⁷⁵ Хүний Эрхийн Үндэсний Комисстай хийсэн ярилцлага, Улаанбаатар, 2013. 1.22,10:00; Цагдаагийн байгууллагын сэтгэл зүйчтэй хийсэн ярилцлага, Э хот, 2013. 3.18,12:00; Прокурортой хийсэн ярилцлага, Д хот, 2013. 3.28, 14:00; Нийгмийн ажилтны ярилцлага, Д хот, 2013. 1. 21,10:00; Жендэрийн үндэсний хороотой хийсэн ярилцлага,Улаанбаатар, 2013. 1. 21, 14:00

⁷⁶ Хүний Эрхийн Үндэсний Комисстай хийсэн ярилцлага,Улаанбаатар, 2013. 1.22,10:00; Жендэрийн үндэсний хороотой хийсэн ярилцлага,Улаанбаатар, 2013. 1. 21, 14:00

⁷⁷ Хүний Эрхийн Үндэсний Комисстай хийсэн ярилцлага, Улаанбаатар, 2013. 1.22,10:00; Цагдаагийн байгууллагын сэтгэл зүйчтэй хийсэн ярилцлага, Э хот, 2013. .8, 12:00

⁷⁸ Жендэрийн үндэсний хороотой хийсэн ярилцлага,Улаанбаатар, 2013. 1.21, 14:00

⁷⁹ Дээр дурдагдсан.

⁸⁰ Хүний Эрхийн Үндэсний Комисстай хийсэн ярилцлага, Улаанбаатар, 2013.1.22, 10:00

⁸¹ Шүүгчтэй хийсэн ярилцлага, Б хот, 2013.1.28, 9:00; Прокурорын ярилцлага 1, Э хот, 2013.3.18, 9:30

⁸² Шүүгч нартай хийсэн ярилцлага, Б хот, 2013. 1.28, 9:00

⁸³ Жендэрийн үндэсний хороотой хийсэн ярилцлага,Улаанбаатар, 2013. 1.21,14:00; Хүний Эрхийн Үндэсний Комисстай хийсэн ярилцлага, Улаанбаатар, 2013.1.22, 10:00

⁸⁴ Хүний Эрхийн Үндэсний Комисстай хийсэн ярилцлага,Улаанбаатар, 2013.1.122,10:00

Дээрх сургалтанд хамрагдсан оролцогч нар сургалт үр дүнтэй байгааг онцолсон.⁸⁵ Нийгмийн ажилтан:

“Эдгээр сургалт нь зөвхөн хохирогчид үйлчлэх төдийгүй мөн хүчирхийлэл үйлдэгчтэй хэрхэн ажиллах, хуулийг хэрхэн хэрэглэх зэрэг чухал мэдээллүүдийг өгдөг учраас хэрэгтэй сургалт болдог. Учир нь их, дээд сургуульд суралцахдаа тухайн мэргэжлээрээ онолын мэдлэг хуримтлуулснаас хохирогчтой хэрхэн ажиллах гэх мэт практик туршлага эзэмшиж төгсдөггүй.”⁸⁶

ГБХТТХуулиар цагдаагийн ажилтан, нийгмийн ажилтан ямар үүрэг хариуцлага хүлээсэн тухай сургалтаар олж мэдсэний үр дүнд гэр бүлийн хүчирхийллийн хэргийг бусад мэргэжилтнүүд рүү холбон зуучлах, хамтран ажиллах нь нэмэгдсэн гэж өөр нэг нийгмийн ажилтан мэдээлсэн. Ийм төрлийн сургалтанд хамрагдсаны дараа гэр бүлийн хүчирхийллийг хувийн асуудал гэж үздэг хандлага нь өөрчлөгдсөн гэж эрүүл мэндийн нийгмийн ажилтан онцолсон.⁸⁷ Сургалтанд хамрагдсан цагдаагийн ажилтны ихэнх нь ГБХТТХуулийг анх удаа сонсож байгаагаа хэлж байсан, нөгөө талаар ийм сургалт нь эдгээр мэргэжилтний хандлага, мэдлэгийг нэмэгдүүлэхэд үр нөлөөтэй гэж сургагчаар ажилласан өмгөөлөгч сэтгэгдлээ хуваалцсан.⁸⁸

Нотолгоонд учирдаг саад бэрхшээл

Эрх хязгаарлах шийдвэрийг шүүхээс гаргахдаа нотлох баримт заавал бүрдүүлэхийг ГБХТТХуулиар шаарддаггүй ч мэргэжилтнүүд бүрдүүлэх боломжгүй нотлох баримтуудыг хохирогчоос шаарддаг.⁸⁹ Хохирогчийн мэдүүлэг дангаараа хангалтгүй гэж үзэх хандлага нийтлэг байдаг. Эрх хязгаарлах шийдвэрийг шүүхээс гаргуулах зорилгоор нотлох баримт бүрдүүлэх бэрхшээлт замыг туулах шаардлагатай.⁹⁰ Энэ нөхцөл байдал нь шүүхээс шийдвэрлэсэн эрх хязгаарлах арга хэмжээний тоо цөөхөн байхад нөлөөлж байна. Хохирогч шаардлагатай нотлох баримтыг бүрдүүлж авахын тулд эрүүл мэнд, цагдаа, нийгмийн ажилтан, өмгөөлөгчтэй уулзах зэрэг олон шат дамжлагуудыг туулах хэрэгтэй болдог.⁹¹

Эрх хязгаарлах шийдвэр гаргахын тулд шүүх болгон янз бүрийн баримт бичиг, нотлох баримтыг өөрсдийн үзэмжээр шаарддаг нь хохирогчдод эргэлзээ, тодорхойгүй байдлыг бий болгож байна. Зарим шүүх нөхцөл байдлын үнэлгээгээр⁹² аюулын зэрэг, эрсдлийн түвшин өндөр гарсан бол хангалттай нотлох баримт гэж үздэг. Аюулын зэрэг, эрсдлийн түвшин өндөр биш гэж нөхцөл байдлын үнэлгээгээр гарсан тохиолдолд бол шүүхээс

⁸⁵ Нийгмийн ажилтны ярилцлага, Д хот, 2013.1.24 ,16:00; Нийгмийн ажилтны ярилцлага , Д хот, 2013.1.21,10:00

⁸⁶ Нийгмийн ажилтны ярилцлага, Д хот, 2013.1.24, 16:00

⁸⁷ Нийгмийн ажилтны ярилцлага, Д хот, 2013.1.21,10:00

⁸⁸ ТББ-тай хийсэн ярилцлага, Б хот, 2013.2.1, 9:00

⁸⁹ Хуульчийн ярилцлага, Д хот, 2013.1.23, 12:00; Шүүгчтэй хийсэн ярилцлага, С хот, 2013.3.18, 14:00; ТББ-тай хийсэн ярилцлага, У хот, 2013.3.21, 9:00

⁹⁰ Сувилагчийн ярилцлага, Д хот, 2013.1.21, 10:00; ТББ-тай хийсэн ярилцлага, Д хот, 2013.2.1, 10:00

⁹¹ Хуульчийн ярилцлага, Д хот, 2013.1.23, 12:00. Сэтгэл зүйчтэй хийсэн ярилцлага, Д хот, 2013.3.26, Хуульчийн ярилцлага, Д хот, 2013.1.28,10:00

⁹² Эрсдлийн үнэлгээний маягт ишлэл 28- аас харна үү.

шүүх эмнэлгийн дүгнэлт шаарддаг.⁹³ Өөр нэг шүүх нь цагдаагийн байгууллагын, эмчийн тодорхойлолт эсвэл Хамтарсан багийн үнэлгээг шаарддаг.⁹⁴

Орон нутагт амьдардаг хохирогчид хэзээ ч бүрдүүлэх боломжгүй нотлох баримтыг цуглуулах шаардлагатай тулгардаг.⁹⁵ Энэ талаар өмгөөлөгч тайлбарлахдаа:

“Орон нутагт амьдарч буй хохирогч эрх хязгаарлах шийдвэр шүүхээс гаргуулах нэхэмжлэл өгөхийн тулд аймгийн төвд биеэр ирэх шаардлагатай. Ингэхийн тулд доод тал нь 200 км замыг туулж ирэх болдог. Заримдаа хэд хэдэн удаа ирж, буцах шаардлага тулгардаг. Аймгийн төвд ирээд эрх зүйн туслалцаа авахаар цагдаад ханддаг. Цагдаа боломжгүй гэвэл дараагийн хуульч рүү явах хэрэг гарна. Эсвэл хохирогч өмгөөлөгчид хандана, гэвч ихэнх өмгөөлөгч суманд биш, аймгийн⁹⁶ төв дээр л ажилладаг”⁹⁷

Нөхцөл байдлын үнэлгээ

Эрх хязгаарлах шийдвэр гаргуулахаар шүүхэд нэхэмжлэл гаргахад нөхцөл байдлын үнэлгээ заавал хийлгэсэн байх тухай ГБХТТХуульд тусгаагүй ч ихэнх шүүх үүнийг шаарддаг. ГБХТТХуулиар цагдаагийн ажилтан, нийгмийн ажилтан нар хамтдаа нөхцөл байдлын үнэлгээ хийхийг үүрэг болгосон.⁹⁸ Тухайн мэргэжилтнүүд хамтран хийсэн нөхцөл байдлын үнэлгээг олж авах нь хохирогчийн хувьд бэрхшээлтэй байдаг.⁹⁹ Дээр дурдсанчлан, зарим цагдаагийн ажилтан, нийгмийн ажилтан нар гэр бүлийн хүчирхийллийн хэргүүдэд анхаарал хандуулдаггүй учраас¹⁰⁰ эрх хязгаарлах шийдвэрийг шүүхээр гаргуулж, хуулийн хамгаалалтанд орох боломжийг хохирогчийн хувьд байхгүй болгож байна.

Шүүх эмнэлгийн дүгнэлт

Хуулиар шаарддаггүй ч ихэнх шүүх эрх хязгаарлах шийдвэр гаргахдаа шүүх эмнэлгийн дүгнэлтийг хохирогчдоос шаарддаг.¹⁰¹ Хохирогч гэр бүлийн хүчирхийллийн улмаас гэмтсэн бэртэл, гэмтлээ шүүх эмнэлгийн мэргэжилтний дүгнэлтээр баталгаажуулж, нотлох баримт болгон шүүхэд өгөх шаардлагатай болдог.¹⁰² Хэрвээ хохирогчид нүдэнд үзэгдэхүйц бэртэл гэмтэл байхгүй бол эрх хязгаарлах шийдвэр гаргуулах үндэслэл болох нотлох баримтыг

⁹³ Сэтгэл зүйчийн ярилцлага, Д хот, 2013.3.26, 11:30

⁹⁴ Хуульчийн ярилцага, Д хот, 2013.1.28,10:00; Судлаач Хэлэн Рубенстэйнд ТББ-аас ирсэн цахим шуудан (2013. 7- 23) (судлаачын файл).Зарим шүүх шаарддаг ч, ГБХТТХуулиар эрх хязгаарлах арга хэмжээ авахад эмнэлэгийн магадлагаа шаардахаар заагаагүй. Харин цагдаагийн ажилтан эсвэл нийгмийн ажилтан хохирогчийн өмнөөс энэ хүсэлтийг гаргахад шүүх дээрх шаардлагыг тавьдаггүй. Нотлох баримт бүрдүүлэлт ба саад бэрхшээл хэсгээс үзнэ үү.

⁹⁵ Шүүгчийн ярилцлага, С хот, 2013.3.18, 14:00; ТББ-ын ярилцлага, У хот, 2013. 3.21, 9:00

⁹⁶ Монгол улс нь нийт 21 аймагт хуваагддаг. Түмэн Дашцэрэв, “Монголын хүн амын хэл,соёл, бичиг үсгийн онцлог” Senri Ethnological Studies 66: 309–324 (2004) –өөс олж харах боломжтой. http://ir.minpaku.ac.jp/dspace/bitstream/10502/1052/1/SES66_023.pdf

⁹⁷ Хууль зүйн хэлтэс, Г хот, 2013. 3.21, 10:00

⁹⁸ Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1.1 дэх хэсэг

⁹⁹ Дээрх заалт: нийгмийн ажилтан нь цагдаагийн ажилтантай хамтран эрсдлийн үнэлгээг хийх үүрэгтэй.

¹⁰⁰ Мэргэжилтнүүдийн хэвшмэл хандлага хэсгээс үзнэ үү.

¹⁰¹ Судлаач Хэлэн Рубенстэйнд ТББ-аас ирсэн цахим шуудан (2013. 7-23) (судлаачын файл)

¹⁰² Хуульчийн ярилцлага, Д хот, 2013.1.23, 12:00; Судлаач Хэлэн Рубенстэйнд ТББ -аас ирсэн цахим шуудан (2013.7. 23) (судлаачийн файл)

бүрдүүлээгүйд тооцогдоно. Учир нь энэ бүх замыг түүлах явцад хохирогчийн биед байгаа хөхрөлт, бяцралтын үл мөр бүдгэрсэн эсвэл арилсан байдаг.¹⁰³ Хөхөрч бяцарсан үл мөр арилсан гэсэн шалтгаанаар шүүх эмнэлгийн эмч түүнд дүгнэлт гаргаж өгөхөөс татгалзсан, ингээд эрх хязгаарлах шийдвэрийг шүүхээс гаргуулах ямар ч боломжгүй болсон гэж нэг хохирогч хэлсэн.¹⁰⁴ Гэр бүлийн хүчирхийллийн улмаас үүссэн гэмтэл, шархыг баримтжуулах ямар ч боломжгүй байсаар цаг хугацаа алдсан өөр нэгэн тохиолдол байна. Учир нь эмэгтэй хэд хэдэн удаа зорьж очсон ч шүүх эмнэлгийн эмч үргэлж л завгүй таарч, түүнд цаг гаргах боломжгүй байсан.¹⁰⁵

Хохирогчийг шүүх эмнэлгийн эмчид холбон зүүчлэхэд Нэг цэгийн үйлчилгээний төвүүд дэмжлэг үзүүлж ажилладаг.¹⁰⁶ Нийслэл дэх Нэг цэгийн үйлчилгээний төвүүд нь хохирогчид хялбар байдлаар шүүх эмнэлгийн дүгнэлт гаргаж ажиллах ёстой ч санхүүжилт хомс, мэргэшсэн хүний нөөц бэлтгэгдээгүйгээс энэ үүргээ биелүүлж чаддаггүй.

Шүүх эмнэлгийн байршил хол, зардал мөнгөний гачаал болон ажлын цагийн тохиромжгүй байдлаас шалтгаалан шүүх эмнэлгийн дүгнэлт олж авах нь хохирогчийн хувьд бэрхшээлтэй байна.¹⁰⁷ Хөдөө, орон нутгийн эмэгтэйчүүд илүү хол замыг туулахаас гадна унааны зардал зэрэг бэрхшээлтэй тулгарч байна.¹⁰⁸ Явган алхах эсвэл олон нийтийн унаагаар явах нь тэдний эрсдлийг улам нэмэгдүүлдэг.¹⁰⁹ Орон нутагт шүүх эмнэлгийн эмч ажилладаг ч, хохирогч хувийн нууцлалаа хадгалахын тулд хот газар хүрч очих болдог.¹¹⁰

Шүүх эмнэлгийн дүгнэлт олж авахын тулд олон дахин очихын зэрэгцээ шүүх эмнэлэгт үзүүлэхэд 5000 төгрөг¹¹¹ төлөх шаардлагатай болдог.¹¹² Хэдийгээр хохирогчийг өөрийн бэртэл гэмтэл, шархны үл мөрөө фото зургаар баримтжуулж, гэрч байгаа бол шүүх хурал дээр авчрахыг зөвлөдөг ч, шүүх эмнэлгийн дүгнэлтийг шүүх шаардсан хэвээр байна.¹¹³ Шүүх эмнэлгийн дүгнэлт гаргахад тулгарч буй бэрхшээлийн талаар Захиргааны хариуцлага болон Эрүүгийн ял оногдуулахад тулгарч буй саад бэрхшээлийн тухай өгүүлсэн хэсгээс дэлгэрүүлж харна уу.

¹⁰³ Хуульчийн ярилцлага, Д хот, 2013. 1. 23, 12:00; Сэтгэл зүйчийн ярилцлага, Д хот, 2013. 3. 26, 11:30

¹⁰⁴ Хохирогчийн ярилцлага, Б хот, 2013. 1.29, 15:00. Энэ түүхийг 15, 22, 24, 26, 60, 64 болон 65 хуудсанд иш татсан.

¹⁰⁵ Сувилагчийн ярилцлага, Д хот, 2013. 1.21, 10:00

¹⁰⁶ Нийгмийн ажилтны ярилцлага, Д хот, 2013. 1.21,10:00; Сувилагчийн ярилцлага, Д хот, 2013.1. 21, 10:00 (тэдэнд сэтгэл зүйн болон хуулийн зөвлөгөө, үйлчилгээг нэг цэгээс хүргэх хэрэгтэй)

¹⁰⁷ Судалгаанд ярилцлага өгөгчдийн зарим нь үнэлгээний чанарт сэтгэл дундуур байгаагаа илэрхийлсэн. Гэр бүлийн хүчирхийллийн гэмтлийг хэрхэн баримтжуулах стандарт шүүх эмнэлэгт байдаггүй. Тэд тусгай маягт ашиглаж эхэлсэн тухай нэгэн эмч дурдсан. Шүүх эмнэлгийн эмчийн яриа, А хот, 2013.3.22, 11:30. Шүүх эмнэлгийн дүгнэлт нь бэртэл гэмтлийг үнэн зөв тодорхойлохгүй байх магадлалтай. Нөхөр нь ах дүү нартайгаа хамт түүнийг зодож, толгойд нь гэмтэл учруулсан үед эхэндээ хүнд гэмтэл гэж оншилсон ч сүүлд нь дүгнэлтээ өөрчилж хөнгөн гэмтэл гэсэн дүгнэлт гаргасан тухай хохирогч хуваалцсан. Хохирогчийн яриа, Э хот, 2013.3.19,15:30

¹⁰⁸ Нийгмийн ажилтны ярилцлага, Д хот, 2013.3.27,14:00

¹⁰⁹ Сувилагчийн ярилцлага, Д хот, 2013.1.21,10:00

¹¹⁰ ТББ -ын ярилцлага, А хот, 2013.3. 22,10:00

¹¹¹ Сарын цалингийн доод хэмжээ 104,400 төгрөг (ойролцоогоор 100 ам доллар) АНУ-ын төрийн департамент, 2012 Хүний эрхийн илтгэл тайлан: Монгол улс (2013. 4.19,) үзэх боломжтой линк: <http://www.state.gov/j/drl/rls/hrrpt/humanrightsreport/index.htm?year=2012&dliid=204222>

¹¹² Шүүх эмнэлгийн эмчийн ярилцлага, А хот, 2013. 3.22, 11:30 (хэрвээ хохирогч ямар нэг орлогогүй нь нотлогдвол төлбөрөөс чөлөөлж болно гэж тайлбарласан)

¹¹³ Прокурорын ярилцлага, Г хот, 2013. 3.21,14:30. Шүүгчийн яриа 2, Д хот, 2013. 3. 28,10:00 (Шүүх эмнэлэг рүү очих боломжгүй хохирогч зургаа өөрсдөө авч баримтжуулдаг гэж тайлбар хийсэн).

Эрх зүйн туслалцааны хангалтгүй байдал

Эрх хязгаарлах шийдвэр шүүхээс гаргуулахад тулгарах шат дараалсан олон саад бэрхшээлийг туулахын тулд хохирогчид эрх зүйн туслалцаа маш чухал. Өмгөөлөгчид хэлэхдээ хохирогч ганцаараа яваад эрх хязгаарлах шийдвэр гаргуулж чадсан нэг ч тохиолдол байхгүй, учир нь эрх зүйн туслалцаагүйгээр хохирогч өөрөө ийм хамгаалалт олж авах нь бүтэшгүй юм.¹¹⁴

Хуулийн сургуульд сурч буй нэгэн хохирогч тайлбарлахдаа, “Надтай адилхан хуулийн мэдлэгтэй хүн байгаад ч юу хийхээ мэддэггүй.”¹¹⁵ Ихэнх аймаг, сумдад эрх зүйн туслалцаа авах боломж хязгаарлагдмал.¹¹⁶ Ялангуяа суманд эрх зүйн туслалцаа авах боломжгүй байдгийг орон нутагт хийсэн ярилцлагаар тодруулсан.¹¹⁷ Мөн ХЭҮТ-тэй төстэй зарим ТББ-үүд хуулийн зөвлөгөө, эрх зүйн туслалцаа үзүүлдэг ч орон нутгийн засаг захиргааны зүгээс санхүүгийн дэмжлэг байдаггүй учраас хүртээмжгүй. Иймээс гэр бүлийн хүчирхийллийн хохирогч эрх зүйн туслалцаа авах боломжгүй байдаг.¹¹⁸ Нэгэн өмгөөлөгч “Суманд хуулийн зөвлөгөө, эрх зүйн туслалцаа авах ямар ч боломжгүй, бас ХЭҮТ-ийн салбар байдаггүй” гэж тайлбарласан.¹¹⁹ Түүний ихэнх үйлчлүүлэгч нь унаагүй учраас эрх зүйн туслалцаа авахын тулд явган алхах эсвэл замын унаанд дайгдах хэрэгтэй болдог, нэг үйлчлүүлэгч нь хуульч дээр хүрч очихын тулд замдаа долоон цаг зарцуулж байсан тухай аймагт ажилладаг нэгэн өмгөөлөгч мэдээлсэн.¹²⁰

Эдийн засгийн хараат байдал

Хохирогч хүчирхийлэл үйлдэгчээс эдийн засгийн хараат байдалд байх нь эрх хязгаарлах арга хэмжээ авахуулахаар шүүхэд гаргах хүсэлтээ хойшлуулах шалтгаан нь болдог.¹²¹ Монгол улсад гэр бүлийн хүчирхийллийн олон хохирогч ажилгүй, нөгөө талаар хүчирхийлэл үйлдэгчээс шүүд хамааралтай, тэдний эдийн засгийн дэмжлэгээр амьдарч байдаг.¹²² Нийгмийн халамж хариуцсан мэргэжилтэн “Миний бодлоор, Монгол улсын хувьд ажилгүйдэл том асуудал. Энэ нь хохирогч эдийн засгийн хувьд хүчирхийлэл үйлдэгчээс хамааралтай байх нөхцлийг бүрдүүлдэг. Нөгөө талаар, эдийн засгийн хараат байдал нь эмэгтэй хүнийг эмзэг байдалд оруулдаг.”¹²³ гэж тайлбарласан. Ялангуяа хүүхэдтэй, мөн дэмжиж туслах төрөл

¹¹⁴ Хуульчийн ярилцлага, Д хот, 2013.1.24, 10:00; Хуульчийн ярилцлага, Д хот, 2013. 1.23,12:00; Хуульчийн ярилцлага, Д хот, 2013. 1. 24, 10:00

¹¹⁵ Хохирогчийн ярилцлага, У хот, 2013.3. 22, 9:00. Энэ түүхийг 12, 13, 17, 28, 35, 36 болон 54 хуудсанд иш татсан.

¹¹⁶ Нийгмийн ажилтны яриа, Д хот, 2013.1.21, 10:00

¹¹⁷ Дээр дурдсан; Прокурорын яриа, А хот, 2013. 3.21, 17:00; Хууль зүйн хэлтэс, Г хот, 2013.3. 21, 10:00; Хуульчийн яриа, С хот, 2013. 3.18, 9:00

¹¹⁸ Хохирогчид чиглэсэн үйлчилгээ хэсгээс үзнэ үү.

¹¹⁹ Хуульчийн яриа, С хот, 2013. 3.18, 9:00

¹²⁰ Дээр дурдагдсан: Шүүгчийн яриа, У хот, 2013. 3. 22, 11:00 (цагдаа олон удаа дуудаад ирээгүй учраас нөхөр нь түүний нүүр, толгой руу цохиж, зодсоны дараа хохирогч 200 км газрыг хэрхэн алхаж түүлсан тухай)

¹²¹ Нийгмийн ажилтны яриа, Д хот, 2013.1. 21, 10:00; Хуульчийн яриа, Д хот, 2013.1.24,10:00; Нийгмийн ажилтны яриа, Д хот, 2013.1. 21, 10:00; ТББ-ын ярилцлага, Б хот, 2013. 2.1, 9:00 (зургаагаас долоон кейс хуваалцсан)

¹²² Нийгмийн ажилтны яриа, Д хот, 2013.1.21, 10:00

¹²³ Нийгмийн халамжийн газрын мэргэжилтэн, Д хот, 2013. 1. 24, 14:00. Нийгмийн ажилтны яриа, Б хот, 2013. 1. 31, 10:00

төрөгсөд байхгүй бол эдийн засгийн хараат байдал нь эмэгтэйчүүдэд илүү хүнд тусдаг.¹²⁴ Өөрийн гэсэн мөнгөн хуримтлал байхгүй эсвэл ажилгүй бол хүчирхийлэл үйлдэгч нөхрөөсөө холдох боломжгүй, бас хүүхдүүддээ дэмжлэг үзүүлж чадахгүй гэж нэгэн хохирогч нийгмийн ажилтанд хэлсэн байна.¹²⁵

Нөгөө талаар, эдийн засгийн хараат байдал нь хохирогч эрх хязгаарлах шийдвэр гаргуулахаар шүүхэд хүсэлт гаргахад шаардагдах төлбөр, хураамжийг төлөх боломжгүй болгодог. Үүнд: архивын лавлагаа нэг хуудас нь 2000 төгрөг байдаг.¹²⁶ Эрх хязгаарлах шийдвэр шүүхээс гаргасан бол хохирогч уг шийдвэрийг гүйцэтгүүлэхийн зардалд 50,000 төгрөг Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газарт төлөх шаардлагатай болдог. Энэ төлбөр нь тухайн шүүхийн шийдвэрийг гүйцэтгэхэд гарах унааны мөнгө зэрэг зардалд зарцуулагдана.¹²⁷

Хохирогч эрх хязгаарлах арга хэмжээ авахуулах хүсэлт гаргахаас эхлээд л санхүүгийн бэрхшээлтэй тулгардаг, эдийн засгийн тусламж дэмжлэг энэ үед л хэрэгтэй байдаг талаар судалгаанд ярилцлага өгсөн хэд хэдэн оролцогчид хуваалцаж байсан.¹²⁸ Гэхдээ, Монгол улсын хувьд халамж, мөнгөн тэтгэмжийг тодорхой бүлгүүдэд өгдөг ч гэр бүлийн хүчирхийллийн хохирогчдод тусгайлан санхүүгийн дэмжлэг үзүүлэх хөтөлбөр байдаггүй.¹²⁹ Хэрвээ санхүүгийн ийм хөтөлбөр байдаг бол нөхрөөсөө тусдаа бие даан амьдрах, бас ажил олж хийхэд нь дэмжлэг болно гэж нэгэн хохирогч хэлсэн.¹³⁰

Нууцлал хадгалахад тулгарч буй бэрхшээл

Хохирогчийн хувийн нууцлалыг хадгалахад тулгарч буй бэрхшээл нь заримдаа эрх хязгаарлах арга хэмжээ авахуулах хүсэлт гаргахад саад болдог. Гэр бүлийн хүчирхийлэлд өртсөнийг нь хүмүүст мэдвэл улам эрсдэлд орж, хүчирхийлэл давтагдана гэж тэд айдаг.¹³¹

Гэр бүлийн хүчирхийллийн улмаас хуулийн зөвлөгөө, эрх зүйн туслалцаа авахад хэд хэдэн удаа ирж очих шаардлага тулгардаг ч эмэгтэйчүүд хуулийн байгууллагаар явж байгаагаа хүмүүст мэдэгдэхийг хүсдэггүй гэж орон нутагт эрх зүйн туслалцаа үнэ төлбөргүй үзүүлдэг өмгөөлөгч тайлбарласан.¹³² Үүнтэй нэгэн адил цагдаагийн байгууллагад дахин дахин ирж очихыг хохирогч хүсдэггүй.¹³³ Хэрвээ хохирогчийн нөхөр энэ тухай мэдвэл эмэгтэйн аюулгүй байдал эрсдэлд орно. Нэгэн хохирогч тайлбарлахдаа:

¹²⁴ Нийгмийн ажилтны яриа, Д хот, 2013.1. 21, 10:00; Хуульчийн яриа, Д хот, 2013. 1. 24, 10:00. Хохирогчийн яриа, Д хот, 2013. 3.25, 14:30 (“Намайг бага байхад эцэг эх маань нас барсан. Миний төрөл төрөгсөд бүгд хөдөө байдаг учраас намайг хамгаалах хэн ч байдаггүй. Би ажилгүй болоод л түүний цалингаар амьдарч, яг л боол шиг болсон.”)

¹²⁵ Нийгмийн ажилтны яриа, Д хот, 2013.1. 21, 10:00

¹²⁶ Хуульчийн ярилцлага, Д хот, 2013.1.28, 10:00.

¹²⁷ Дээр дурдагдсан: Эрх хязгаарлах арга хэмжээний хэрэгжилт хангалтгүй байгаа талаар, Шүүхийн шийдвэр биелүүлэх газрын үүргийг ярилцсан хэсгийг үзнэ үү.

¹²⁸ Хохирогчийн ярилцлага, Б хот, 2013. 1.29, 15:00 [Энэ түүхийг 10, 16, 18, 20, 51, 54 болон 55 хуудсанд иш татсан]; Нийгмийн ажилтны ярилцлага, Д хот, 2013. 1. 24,16:00

¹²⁹ Нийгмийн халамжийн газар, Д хот, 2013. 1.24,14:00 (жишээ нь: нийгмийн халамжийн тэтгэмж нь хөгжлийн бэрхшээлтэй, тэтгэвэрийн болон ажилгүй хүмүүст боломжгүй)

¹³⁰ Хохирогчийн ярилцлага, Б хот, 2013.1. 29, 15:00. Энэ түүхийг 10, 16, 18, 20, 51, 54 болон 55 хуудсанд иш татсан.

¹³¹ Хуульчийн ярилцлага, С хот, 2013. 3.18, 9:00; Прокурорын ярилцлага, С хот, 2013. 3.19,14:00; Хохирогчийн ярилцлага, С хот, 2013. 3.19,16:00; ТББ -ын ярилцлага, А хот, 2013.3. 22, 10:00; ТББ, хамгаалах байрны ярилцлага, Д хот, 2013. 1. 31, 9:00; Хохирогчийн ярилцлага, Д хот, 2013. 3. 25, 14:30

¹³² Хуульчийн ярилцлага, С хот, 2013. 3. 18, 9:00

¹³³ ТББ-ын ярилцлага, А хот, 2013. 3. 22, 10:00

“Асуудал, бэрхшээлээ итгэж болох найдвартай хүнд, аюулгүй газар сэтгэлээ хуваалцаж ярилцах хэрэгцээ надад байдаг. Мэдээж, надтай уулзаж ярилцаад, дараа нь өөр бусад хүмүүст миний асуудлыг ярихыг би хүсэхгүй. Ийм хүн бол нийгмийн ажилтан, ХЭҮТ, эсвэл надтай сайн ярилцах боломжтой хүн байж болно”¹³⁴

Ихэнх үйлчилгээний ажилтнуудад үйлчлүүлэгчтэй уулзах нууцлал бүхий орон зай, тусгай өрөө байдаггүй.¹³⁵ Саяхан ТББ-д хэрэгжиж байгаа төслийн дэмжлэгтэй ганцаарчлан уулзаж ярилцах өрөөтэй болсон талаараа нийгмийн ажилтан ярьсан.¹³⁶ Нэгэн хохирогч нийгмийн ажилтнаас зөвлөгөө авахаар хандсан тохиолдлын талаар өмгөөлөгч хуваалцахдаа:

“Тэнд маш урт дараалал байсан. Үйлчлүүлэгч нар уйлж байсан. . . Ганцаарчлан уулзах тусгай өрөө байгаагүй, нууцлал хадгалах ямар ч боломж байхгүй. Тухайн нийгмийн ажилтан тэдгээр эмэгтэйн түүхийг сонсож, явсных нь дараа түүний талаар хорооны бусад ажилтнуудад ярьж байсан. Үүнээс болж эмэгтэйн эрсдэл нэмэгдсэн. Гэвч эрх хязгаарлах шийдвэр гаргуулах хүсэлт өгөхөд шаардагдах нөхцөл байдлын үнэлгээний маягтыг бөглөхөөс нийгмийн ажилтан татгалзсан учраас эмэгтэй хамгаалалт авах боломжгүй болсон. Одоо хохирогч дахин хэзээ ч хороонд хандаж чадахгүй.... тэр итгэлээ алдсан. Учир нь түүний хувийн мэдээлэл, нууцлал алдагдсан. Тэрээр дахин хэзээ ч, хэнд ч итгэхгүй.”¹³⁷

Нэг хороо “Нээлттэй цонхны үйлчилгээ” нэвтрүүлэх зорилгоор нийгмийн ажилтны ганцаарчилсан уулзалтын өрөөг өөрчилсөн. Ингэснээр гэр бүлийн хүчирхийллийн хохирогч нар хандаж ирэх нь 75% буурсан гэж нийгмийн ажилтан мэдээлсэн.¹³⁸ Судалгааны багийн ажигласнаар “Нээлттэй цонхны үйлчилгээ” гэдэг нь нийгмийн ажилтан үйлчлүүлэгчтэй өрөөнөөсөө зөвхөн цонхны хоёр талаас харьцана гэдгийг олж мэдсэн. Энэ нөхцөл байдал нь тухайн үйлчлүүлэгчийн хувийн нууцыг хадгалах боломжгүй, хажууд нь дараалал хүлээж буй хүмүүс сонсох бүрэн боломжтой юм.¹³⁹

Багийн засаг дарга хохирогчтой уулзаж ярилцахад хүмүүс байнга орж гарч байдаг нь ярилцах ямар ч боломж олгодоггүй, бэрхшээлтэй байдаг талаар хуваалцсан.¹⁴⁰ Судалгаанд хамрагдаж ярилцлага өгсөн ихэнх Засаг дарга болон цагдаагийн ажилтны зүгээс тусгай өрөө байхгүй, ажиллах орчин, нөхцөл байдал нь хүндрэлтэй тухай хуваалцаж байсан. Судлаачдын баг нэг хороонд очсон уулзалтаар ярилцлага орчуулгатай явагдаж байхад ч

¹³⁴ Хохирогчийн ярилцлага, С хот, 2013. 3.19, 16:00. Хохирогчийн ярилцлага, Б хот, 2013. 1. 31, 15:30 (“ганцаарчлан уулзах ямар ч өрөө байхгүй, иймээс бусад хүмүүсийн өмнө ичгэвтэр байдалд орсон”) [Энэ түүхийг 10, 19, 20, 28, 29 болон 53 хуудсанд иш татсан].

¹³⁵ Цагдаагийн байгууллагын сэтгэл зүйчийн ярилцлага, Э хот, 2013. 3.18, 12:00; Нийгмийн ажилтны ярилцлага, Д хот, 2013. 1.24, 16:00; Багийн Засаг даргын ярилцлага 2, Э хот, 2013.3.19, 9:30; Олон нийттэй харилцах алба, Г хот, 2013. 3. 21, 15:30; Нийгмийн ажилтны ярилцлага, Д хот, 2013. 3.27, 12:00

¹³⁶ Цагдаагийн байгууллагын сэтгэл зүйчийн ярилцлага, Э хот, 2013. 3.18, 12:00

¹³⁷ ТББ -ын хамгаалах байрны ажилтан, Д хот, 2013. 1.31, 9:00

¹³⁸ Нийгмийн ажилтны ярилцлага, Д хот, 2013. 1. 24, 16:00

¹³⁹ Дээр дурдагдсан.

¹⁴⁰ Багийн засаг даргын ярилцлага 2, Э хот, 2013. 3. 29, 9:30

¹⁴¹ Багийн нийгмийн ажилтан, Б хот, 2013.1. 31, 14:00 (нийгмийн ажилтан бусад ажилтнуудтай хамт нэг өрөөнд ажилладаг учраас хохирогчийн нууцлалыг хадгалах боломжгүй)

хорооны ажилтнууд, бас бусад хүмүүс байнга орж гарах нь бэрхшээлтэй байсан.¹⁴¹ Заавал мэдээлэх үүрэг нь¹⁴² эмч, нийгмийн ажилтан болон бусад үйлчилгээний ажилтнуудаас хохирогч туслалцаа авахаар хандахад хүндрэлтэй болгох магадлалтай. Судалгаанд хамрагдаж ярилцлага өгсөн ихэнх мэргэжилтэн гэр бүлийн хүчирхийллийн тохиолдлыг заавал мэдээлэх үүрэг нь зарим талаар хохирогчид эрсдэл учруулж болох талаар хуваалцсан.¹⁴³ Хүчирхийллийг заавал мэдээлснээр хохирогчийн эрсдэл улам нэмэгдэх магадлалтай.¹⁴⁴ Цагдаад хүчирхийллийг мэдээлснээр цагдаагийн ажилтан хамгаалах нэрийн дор эмэгтэйн бэртэл гэмтлийг эмчлүүлэх боломжгүй болгохоос айдаг гэж тайлбарласан.¹⁴⁵

ГБХТТХуулиар эмч, сургууль, цэцэрлэгийн багш нарыг гэр бүлийн хүчирхийллийн хэрэг болон хүчирхийллийн болзошгүй эрсдлийг цагдаагийн ажилтан болон орон нутгийн удирдлагад заавал мэдээлэх үүргийг хуульчилсан.¹⁴⁶ Хуулиар заавал биелүүлэх үүрэг болгож шаардаагүй ч үйлчилгээний бусад ажилтнууд гэр бүлийн хүчирхийллийг цагдаад мэдээлдэг.¹⁴⁷ Хохирогчийн зөвшөөрөлгүйгээр гэр бүлийн хүчирхийллийн тохиолдлыг цагдаад мэдээлэх нь эрсдлийг улам нэмэгдүүлж, бусад шаардлагатай үйлчилгээ авах боломжийг хязгаарладаг.¹⁴⁸ Жишээ нь, эхнэрээ нийгмийн ажилтантай уулзсаны дараахан цагдаагийн ажилтан дуудсаныг олж мэдсэн нөхөр нь эхнэр, хүүхдээ ална гэж айлган сүрдүүлсэн талаар хохирогч мэдээлсэн.¹⁴⁹

Эрх хязгаарлах шийдвэр гаргуулахад тулгарч буй бэрхшээл

Эрх хязгаарлах арга хэмжээ шүүхээс гаргуулах хүсэлт гаргасны дараа эрсдэл нь улам нэмэгдэнэ гэж зарим хохирогчид айдаг.¹⁵⁰ Нийгмийн ажилтан “Эрх хязгаарлах шийдвэр гарах нь цаашид ямар нэг хүчирхийлэл үйлдэгдэхгүй гэсэн баталгаа биш юм. Хэдийгээр шүүхийн шийдвэрт үүнийг хориглосон байдаг ч хүчирхийлэл үйлдэгч хохирогчийг айлган сүрдүүлэх, зодож цохих, уулзахгүй байх, хүчирхийлэл үйлдэхгүй гэсэн баталгаа болдоггүй”¹⁵¹ гэж мэдээлсэн. Үйлчлүүлэгч нь цагдаагийн ажилтан хангалттай хамгаалж чадахгүй гэсэн айдастай байсан тухай өөр нэг нийгмийн ажилтан ярьсан:

¹⁴² Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль, 13 дугаар зүйл

¹⁴³ Хууль зүйн яам, Улаанбаатар, 2013.1. 31, 14:00; Хууль зүйн яам, Улаанбаатар, 2013.1. 29,14:00; Хуульчийн ярилцлага, Д хот, 2013. 1. 24,10:00; Шүүгчийн ярилцлага, Д хот, 2013. 1. 30, 16:00; Нийгмийн ажилтны ярилцлага, Б хот, 2013.1.30,10:00; Сургуулийн нийгмийн ажилтны ярилцлага, Б хот, 2013. 1. 29, 10:45

¹⁴⁴ Баримтжуулалт ба тайлан, Хүний эрхийг хамгаалагчид 2006.2.1 http://stopvaw.org/Documentation_and_Reporting.html

¹⁴⁵ Нийгмийн ажилтан, эмчийн ярилцлага, С хот, 2013. 3.18, 16:00

¹⁴⁶ Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1 дэх хэсэг

¹⁴⁷ Эрүүл мэндийн ажилтны ярилцлага, Г хот, 2013. 3. 21,16:30;Сургуулийн нийгмийн ажилтан, Б хот, 2013. 1. 29, 10:45; Хүүхдийн төлөө хэлтэс, Э хот, 2013. 3.18, 12:30; Судалгаанд оролцогчдын зарим нь хүчирхийлэлд өртсөн хүүхэдтэй ажилладаг ба хүчирхийллийн тохиолдлыг заавал мэдээлэх үүрэгтэй.

¹⁴⁸ Заавал мэдээлэх үүрэгтэй: хөгжлийн бэрхшээлтэй зэрэг эмзэг бүлэг болон хүүхдийн эсрэг хүчирхийллийг хэрэг.

¹⁴⁹ Сургуулийн нийгмийн ажилтан, Б хот, 2013.1.29, 10:45. Хохирогчийн ярилцлага, Б хот, 2013.1.29, 15:00 Энэ түүхийг 10, 16, 18, 20, 51, 54 болон 55 хуудсанд иш татсан]; Хохирогчийн ярилцлага, Б хот, 2013. 1.31,15:30 (хүчирхийллийн талаар өөр хэн нэгэн мэдсэнийг хүчирхийлэгч мэдвэл хохирогчийн амь насыг хөнөөх болно) [Энэ түүхийг 10, 16, 18, 20, 51, 54 болон 55 хуудсанд иш татсан].

¹⁵⁰ Өмгөөлөгчийн ярилцлага, Б хот, 2013.1. 28, 14:00 (эрх хязгаарлах арга хэмжээний талаар олж мэдээд нөхрийг нь шүүхээс гэрээ орхин явахыг даалгах юм байна гэж ойлгоод хүсэлт гаргасан. Тэр шүүхийн шийдвэрийг мэдэх л юм бол түүнийг зовоох болно); Хууль зүйн хэлтэс, Г хот, 2013.3.21 1:000 (нөхөрт нь эрх хязгаарлах арга хэмжээ авсаныг мэдээд айсан хохирогчийн тухай, “нөхөр нь маш хэрцгийгээр зоддог учраас тэр цаашид болох явдлаас айсан”); Хуульчийн ярилцлага, Д хот, 2013.1.23, 12:00 (эрх хязгаарлах шийдвэр хэрэгждэггүй учраас хохирогчийн нөхцөл байдлыг улам дордуулдаг)

¹⁵¹ Нийгмийн ажилтны ярилцлага, Д хот, 2013.3.27,14:00

*Миний хийсэн нөхцөл байдлын үнэлгээгээр хохирогч бие махбод, сэтгэл санааны хүчирхийлэлд өртсөнийг нотлох тодорхой баримтууд гарч ирсэн. Мөн бэлгийн хүчирхийлэл, гэрлэлтийн хүчин байгааг ч илрүүлсэн. Энэ хэрэг их тодорхой байсан, тэр эмэгтэйн хөл хугарсан, өмнөх хүчирхийллийн улмаас гар дээр нь урагдсан сорви үлдсэн байсан. Тэр надтай ярилцаж байхдаа үйлж, маш их шаналж айдастай байсан. . . Хэдийгээр бид эрх хязгаарлах арга хэмжээний талаар мэдээлэл өгсөн ч тэр эмэгтэй нөхрөөсөө айгаад уг боломжийг ашиглахаас татгалзсан. ГБХТТХуулиар хорооны цагдаагийн ажилтан хохирогчийг төлөөлөн шүүхэд эрх хязгаарлах шийдвэр гаргуулахаар хүсэлт гаргах үүрэгтэй ч түүнийгээ хэрэгжүүлдэггүй, оролцдоггүй. Энэ эмэгтэйн хувьд цагдаагийн ажилтан түүнд тусалж чадахгүй гэж бодсондоо, хуулийн байгууллагад хандсанд учрах эрсдлээс айсандаа татгалзсан.*¹⁵²

Хэрвээ эрх хязгаарлах шийдвэрийг гаргах шүүх хурлыг хойшлуулбал хүсэлт гаргасан эмэгтэйн эрсдэл улам нэмэгддэг. ГБХТТХуулиар эрх хязгаарлах шийдвэрийг шүүхээс 24 цагийн¹⁵³ дотор гаргахаар хуульчилсан ч зарим онцгой эрсдэлт нөхцөлд хүртэл шүүх хурлыг бүтэн долоо хоног хүртэл хүлээх тохиолдол байдаг талаар өмгөөлөгч мэдээлсэн.¹⁵⁴

Хохирогчид эрх хязгаарлах арга хэмжээг санал болгосны дараа “эрсдэл нэмэгдэх үү” гэж тэд эргүүлэн асуудаг талаар өмгөөлөгч ярьсан. Энэ шийдвэр гарсны дараа ч хүчирхийлэл үйлдэгч хохирогчийг гэмтээх, заналхийлэх аюултай учраас “хүчирхийлэл үйлдэгчийг шүүхийн шийдвэрээр гэрээс нь гаргасан ч түүштэй хэрэгжихгүй, энэ тохиолдолд цагдаагийн ажилтан хохирогчийг хамгаалж чадахгүй байснаас эмэгтэйн амь нас аюулд учрах вий гэж би санаа зовж байсан” гэж өмгөөлөгч мэдээлсэн.¹⁵⁵

Эрх хязгаарлах шийдвэр хангалттай хэрэгжихгүй бол яана гэсэн айдас нь хохирогчдыг хүсэлтээ татаж авахад хүргэдэг.¹⁵⁶ Дээрх нөхцөл байдлын улмаас шүүхээс хүсэлтээ татсан 6-7 эмэгтэйг мэднэ гэдгээ өмгөөлөгч хэлсэн. Эрх хязгаарлах шийдвэрийг шүүхээс гаргалаа ч нөхцөл байдал нь өмнөхөөсөө илүү дордож магадгүй гэсэн айдас тэдгээр эмэгтэйчүүдэд байсан.¹⁵⁷ Эрх хязгаарлах шийдвэрийг гаргуулах хүсэлтээсээ татгалзсан хохирогч эмэгтэйн тухай нийгмийн ажилтан ярьсан:

*“Хүчирхийлэл үйлдэгчийн зүгээс эмэгтэйд шүүхээс өргөдлөө буцааж ав гэж шахалт үзүүлж, дарамталсныг би мэднэ.... Түүнийг байнга зодож, цохиж, сүүлдээ ална гэж хутга шидэж айлгаж эхэлсэн”*¹⁵⁸

¹⁵² Нийгмийн ажилтны ярилцлага, Д хот, 2013.1.21,10:00

¹⁵³ Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.2 дахь хэсэг.

¹⁵⁴ Хуульчийн ярилцлага, Д хот, 2013.1.23, 12:00

¹⁵⁵ ТББ-ын ярилцлага, Э хот, 2013. 1.18, 10:00

¹⁵⁶ Хуульчийн ярилцлага, Д хот, 2013. 1.28, 10:00; Нийгмийн ажилтны ярилцлага, Д хот, 2013. 1. 21,10:00. Эрх хязгаарлах шийдвэрийг зөрчихөд анхаарал хандуулдаггүй хэсгээс үзнэ үү.

¹⁵⁷ ТББ-ын ярилцлага, Б хот, 2013. 2.1, 9:00

¹⁵⁸ Сургуулийн нийгмийн ажилтны ярилцлага, Б хот, 2013.1. 29, 10:45

Ийм төрлийн хүчирхийлэл нь заримдаа шүүхийн ажилтан, өмгөөлөгчийн хажууд тохиолддог. Хүчирхийлэл үйлдэгч шүүгчийн өрөөнд, шүүхийн хүлээлгийн тэнхимд хохирогчийг цохиж зодохыг завдаж байсан талаар өмгөөлөгч дүрслэн ярьсан. Дараа нь хүчирхийлэл үйлдэгч өмгөөлөгчийн ажил дээр ирж, “эхнэр, та хоёрыг ална” гэж заналхийлсэн. Энэ үед хүртэл цагдаагийн ажилтан хамгаалалт үзүүлэхдээ дурамжхан байсан.¹⁵⁹

Эрх хязгаарлах шийдвэрийн гүйцэтгэлд тавих хяналт, албадан биелүүлэх механизм байхгүй

Хэдийгээр хохирогч эрх хязгаарлах шийдвэр гаргуулах хүсэлт гаргаж олон саад бэрхшээлийг туулдаг ч, шүүхийн шийдвэр цаасан дээр үлдэж, бодит хамгаалалт болж чаддаггүй. ГБХТТХуулиар эрх хязгаарлах шийдвэрийг шүүх гаргахыг хуульчилсан ч¹⁶⁰ тухайн шийдвэрийг хэрхэн хэрэгжүүлэх, хяналт тавих талаар, ямар байгууллага хариуцах тухай тусгаагүй¹⁶¹ нь хэрэгжих боломжгүй болгосон. Хүний эрхийн үндэсний комиссын төлөөлөгч тайлбарлахдаа:

“Хохирогч эрх хязгаарлах шийдвэр гаргуулж чадлаа ч нэмэргүй, шүүхийн шийдвэрийн хэрэгжилтэнд хэн хяналт тавих тодорхойгүй, бас хэрэгжүүлэх зохицуулалт нь орхигддог. . . . Иймээс олон эмэгтэйчүүд хамгаалалт авч чадаагүй талаар сонсож байсан. “Шүүхийн шийдвэр зөвхөн цаасан дээр л үлддэг” гэж эмэгтэйчүүд хэлж байсан. Учир нь эрх хязгаарлах шийдвэр амьдрал дээр хэрэгждэггүй, тэднийг хүчирхийлэл үйлдэгчээс хамгаалж чаддаггүй.”¹⁶²

Бусад хүмүүс ч бас дээрхийн адил хэлж, амьдрал дээр эрх хязгаарлах арга хэмжээ хэрэгждэггүй,¹⁶³ хамгаалалт болж чаддаггүй¹⁶⁴ гэж ярьсан. Нийгмийн ажилтан тайлбарлахдаа:

“Би эрх хязгаарлах шийдвэрийг гаргуулахын тулд юу хийх шаардлагатай талаар судалж үзсэн. Би мэргэжил нэгтэнтэйгээ уулзаж ярилцахад тэр эрх хязгаарлах шийдвэр ямар ч хэрэггүй байдаг талаар хэлсэн. Энэ бол миний олж авсан хариулт. . . . Хуульчтай уулзахад “ямар ч ашиггүй, ямар ч үр дүнгүй учраас ийм зүйлийн араас хөөцөлдөж цагаа алдах хэрэггүй” гэж хэлсэн.”¹⁶⁵

¹⁵⁹ Хуульчийн ярилцлага, Д хот, 2013.1.28, 10:00

¹⁶⁰ Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн 17 дугаар зүйл.

¹⁶¹ Дээр дурдагдсан. Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн 16 дугаар зүйл.

¹⁶² Хүний эрхийн үндэсний комисс, Улаанбаатар, 2013.1. 22,10:00;Сувилагчийн ярилцлага, Д хот, 2013.1. 21,10:00

¹⁶³ Хуульчийн ярилцлага, Д хот, 2013.1. 23,12:00; Нийгмийн ажилтны ярилцлага, Д хот, 2013.1. 24,16:00; Өмгөөлөгчийн ярилцлага, Б хот, 2013. 1. 28,14:00; Хуульчийн ярилцлага, У хот, 2013. 3. 21,18:00

¹⁶⁴ Хуульчийн ярилцлага, Д хот, 2013. 1.23,12:00; Хуульчийн ярилцлага, Д хот, 2013. 1.24,10:00;Шүүгчийн ярилцлага, Г хот, 2013. 3.22,11:00

¹⁶⁵ Нийгмийн ажилтны ярилцлага, Д хот, 2013.1. 24, 16:00

Эрх хязгаарлах шийдвэр огт хэрэгждэггүй

Хохирогчийг хамгаалах зорилгоор гаргасан эрх хязгаарлах шийдвэр хэрэгждэггүй нь уг шийдвэрийг хүчирхийлэл үйлдэгчид мэдээлдэггүй, биелүүлээгүй тохиолдолд ямар үр дагавартай талаар сануулдаггүй явдал юм. Шүүхийн шийдвэрт хүчирхийлэл үйлдэгчийг гэрээ орхин явахыг даалгасан л бол хэрэгжих ёстой. Гэвч шүүхийн шийдвэрийг хүчирхийлэл үйлдэгчид хэзээ ч мэдээлээгүй, тэднийг хэзээ ч гэрээс нь явуулах арга хэмжээ аваагүй гэж хэд хэдэн хохирогч хэлсэн.¹⁶⁶ Хүний эрхийн үндэсний комиссын төлөөлөгч “Миний хувьд хэн нэгнийг гэрээс нь явуулаад, нөгөө нэг нь гэртээ үлдэж байсан тохиолдлыг хэзээ ч харж байгаагүй” гэж хэлсэн.¹⁶⁷

Нэгэн тохиолдол: хүчирхийлэл үйлдэгчид эрх хязгаарлах арга хэмжээ авсан ч гэрээс нь явуулах алхам хийгдээгүй. Хүчирхийлэл маш ноцтой болж хохирогчийн яс хугарч бүтэн жил гэртээ хэвтэх шаардлагатай болсон тухай эмэгтэй дурсан ярьсан:

“Тэр үед нөхөр уурлаад, намайг зодож толгой руу цохиж эхэлсэн. Тэр эрэгтэй хүний чанга хатуу гараар миний толгой руу цохиж гурав, дөрвөн цагийн турш зодсон учраас миний гавлын яс янгинан өвдөж хавдсан байсан. Дараа нь миний нуруу руу олон удаа өшиглөсөн. Миний хөл, гар бүгд хөхөрч, шалбарч бүх бие маань маш их өвдөж байсан ч би шүүх эмнэлэгт хандаагүй. Долоо хоног бүр эсвэл хоёр долоо хоног тутам энэ бүхэн надад тохиолддог байсан. . . Манайх гэр хороололд байдаг, намайг нөхөртөө зодуулж байх тэр үед хадам ээж миний талаар маш олон муу зүйл хэлсэн нь түүнийг улам уурлуулж намайг гэрээс хөөж гаргахад хүргэсэн.”¹⁶⁸ Тэр шөнө гадаа маш хүйтэн байсан учраас би хашаандаа байдаг 00 дотор шөнийг өнгөрүүлсэн. Миний хувьд хамгийн хэцүү мөч байсан. Би хүүхдээ бодоод хэзээ ч цагдаад хандаж байгаагүй. Би өөрийн нэр төрөө бодоод хэзээ ч эмч эсвэл эмнэлэгт очиж байгаагүй, бэртэл эмтлээ үргэлж нууж явсан”¹⁶⁹

Эрх хязгаарлах шийдвэрийг шүүхээс гаргуулсан хохирогч, “Нөхөр маань хэзээ ч гэрээ орхиж яваагүй. Хуулиар эрх хязгаарлах шийдвэр гарснаас хойш 3 өдрийн дотор хүчирхийлэл үйлдэгч гэрээ орхин явах ёстой, гэхдээ тэр хэзээ ч яваагүй.”¹⁷⁰ гэж ярьсан.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар (цаашид энэ тайланд ШШГГ гэж товчлоно) нь эрүүгийн болон иргэний журмаар шүүхээс гаргасан бүх захирамж, шийдвэрийн хэрэгжилтийг хангах үүрэгтэй¹⁷¹ учраас гэр бүлийн хүчирхийлэлтэй холбоотой эрх хязгаарлах шийдвэрийн

¹⁶⁶ Хохирогчийн ярилцлага, Д хот, 2013. 3.25, 14:30; Дүүргийн шүүгчийн ярилцлага, Г хот, 2013. 3. 22, 11:00 (хүчирхийлэл үйлдэгч хохирогчийг олж уулзах гэж олон удаа ирсэн)

¹⁶⁷ Хүний эрхийн үндэсний комисс, Улаанбаатар, 2013.1.22, 10:00

¹⁶⁸ Гэр нь Монголын уламжлалт амьдрах гэр юм. A House to Go, МОНГОЛЫН ЮУРТ (2011), <http://www.mongolyurt.com>

¹⁶⁹ Хохирогчийн ярилцлага, Д хот, 2013. 3. 25, 14:30. Гэр нь тойрог хэлбэртэй, гол хэсэгтээ зайтай. Эвхэж хурааж, нүүхэд хамгийн тохиромжтой унь болон бүрээс зэрэг зүйлсээс бүрдэнэ. “Гэр гэж юу вэ?” About.com Азийн түүх, <http://asianhistory.about.com/od/glossaryfj/g/GlosGer.htm>.

¹⁷⁰ Дээр дурдагдсан. Хуульчийн ярилцлага, Д хот, 2013.1.23, 12:00 (“Хүчирхийлэл үйлдэгч эрх хязгаарлах шийдвэрийн хувийг хүлээн авсан ч хүчирхийлэл үйлдэгч гэртээ үлдэж, харин хохирогч хамгаалах байр луу явдаг”)

¹⁷¹ ШШГГ-ын ажилтны ярилцлага, Д хот, 2013.1.28, 16:00

хэрэгжилтийг ч бас хангах үүрэг хүлээнэ. Гэвч ГБХТТХууль болон Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуульд энэ талаар тодорхой зүйл заалт ороогүй учраас энэ утгаар нь ойлгож хэрэглэдэггүй.¹⁷² ШШГГ-ын дарга хүчирхийлэл үйлдэгчид эрх хязгаарлах шийдвэрийн хувийг хүргүүлэх тухай заалтыг хуульд оруулж тодорхой болгох хэрэгтэй гэж ярьсан.¹⁷³

Хуульд тодорхой зохицуулалт байхгүй учраас ШШГГ-ын ихэнх ажилтнууд эрх хязгаарлах шийдвэрийг хэрэгжүүлэхээр ажиллаж байгаагүй. ШШГГ-ын дарга албан үүргийнхээ хүрээнд гэр бүлийн хүчирхийлэлтэй холбоотой шийдвэр харж байгаагүй гэж хэлсэн.¹⁷⁴ ШШГГ-ын өөр нэг ажилтан “Олон хэргүүд дээр ажиллаж байсан, аль нь ч ийм төрлийн шүүхийн шийдвэртэй холбоотой байгаагүй”¹⁷⁵ гэж хэлээд “Миний хувьд энэ хууль болон эрх хязгаарлах шийдвэрийн талаар сайн ойлголт байхгүй”¹⁷⁶ гэж нэмж хэлсэн.

Хуульд шүүхийн шийдвэрийг хэрэгжүүлэх тухай тодорхой чиглэл байхгүй учраас хохирогч эрх хязгаарлах арга хэмжээний хэрэгжилтийг хүлээн зовж байдаг.¹⁷⁷ Нэгэн өмгөөлөгч мэдээлэхдээ:

*“Заримдаа шүүх эрх хязгаарлах шийдвэрийн хувийг хохирогчид өгч, ШШГГ өөрөө хүргэж хэрэгжилтийг ханга гэж хэлсэн байдаг. . . . Уул нь шүүх өөрөө хүргэх ёстой ч энэ асуудлыг иргэний хэрэг гэж үзээд хохирогчоор өөрөөр нь хүргүүлдэг.”*¹⁷⁸

Зарим тохиолдолд хохирогч шүүхийн шийдвэрийг гүйцэтгүүлэх, хүчирхийлэл үйлдэгчийг гэрээс нь явуулахад зориулж, ШШГГ-т 50,000 мянган төгрөг төлөх хэрэгтэй болдог. (30 ам доллар ойролцоогоор 10 өдрийн цалинтай тэнцэнэ).¹⁷⁹

ШШГГ-ын ажилтан эрх хязгаарлах шийдвэрийг хэрэгжүүлсэн нэг л тохиолдол гарсан. Энэ жишээ нь цаашдын хэрэгжилтэнд загвар болж болох юм. Тухайн ажилтан тайлбарлахдаа, эрх хязгаарлах шүүхийн шийдвэрийг хэрэгжүүлж, эмэгтэйн аюулгүй байдлыг хүүхэдтэй нь хамт хангах шаардлагатай болсон. Тэднийг түр зуур аюулгүй байрлуулах газар хайсан. Түүнээс гадна цагдаагийн байгууллагад хандаж нөхрийг нь дуудан ирүүлж, эрх хязгаарлах

¹⁷² Дээд шүүхийн шүүгчийн ярилцлага, У хот, 2013.1.30,14:00 (“ШШГГ аливаа шийдвэрийг гүйцэтгэх үүрэгтэй ч тэд энэ үүргээ биелүүлдэггүй. Энэ шийдвэрийн хэрэгжүүлэх тусгай бүлэг Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуульд байх хэрэгтэй байна. Тэгж байж л шүүхийн шийдвэр хэрэгжинэ.”)

¹⁷³ ШШГГ-ын ажилтны ярилцлага, Д хот, 2013.1.28, 16:00. Дээд шүүхийн шүүгчийн ярилцлага, У хот, 2013.1.30,14:00 (Цагдаагийн байгууллага болон ШШГГ-ын аль нь ч ялгаагүй шүүхийн шийдвэрийг гүйцэтгэх нь үр дүнтэй.“ ШШГГ байсан ч давхар цагдаагийн нэмэлт үүрэг байж л гэмт хэрэг давтагдахаас урьдчилан сэргийлнэ. Хуульд үүнийг багтаах хэрэгтэй.”); Хүүхэд гэр бүл, хөгжлийн төв, Б хот, 2013. 1.30, 9:00 (“ШШГГ нь ажиллаж байна, тэгэхээр тэд хэрэгжүүлэх ёстой. Шүүхийн шийдвэрийг гүйцэтгэх тэдний үүрэг оролцоог нэмэгдүүлэх хэрэгтэй гэж бодож байна”)

¹⁷⁴ ШШГГ-ын ажилтны ярилцлага, Д хот, 2013. 1.28, 16:00

¹⁷⁵ ШШГГ-ын ажилтны ярилцлага, Г хот, 2013.3. 22, 12:00

¹⁷⁶ Дээр дурдагдсан.

¹⁷⁷ Зарим хохирогч шүүхийн шийдвэрийг өөрөө хэрэгжүүлдэг. Хуульчийн ярилцлага, Д хот, 2013.1.23, 12:00 (“ хэрэгжилт бол хамгийн чухал алхам. Шийдвэрийг хэрэгжүүлэхгүй байх маш олон нөхцөл байна. Нөхөр нь эхнэртээ мөнгө төлөх ёстой ч хэзээ ч өгөөгүй. Хохирогч өөрөө хэд хэдэн удаа шүүхийн шийдвэрийг гарт нь өгч, мөнгөө авах гэж очсон байдаг.”)

¹⁷⁸ Хуульчийн ярилцлага, Д хот, 2013.1.23, 12:00

¹⁷⁹ Хуульчийн ярилцлага, Д хот, 2013.1.28, 10:00

шийдвэрийг зөрчихгүй, эхнэр, хүүхэд болон ШШГГ-ын ажилтанд заналхийлэл учруулахгүй байх талаар сануулж, гарын үсгээр баталгаажуулсан. Хүчирхийлэл үйлдэгч эрх хязгаарлах шийдвэрийг зөрчихөд, тухайн ажилтан цагдаагийн ажилтныг дуудаж түүнийг баривчлуулсан байна.¹⁸⁰

Мөн, зарим нэг цагдаагийн ажилтан эрх хязгаарлах шийдвэрийг хэрэгжүүлэх санаачлага гаргаж ажилласан байдаг.¹⁸¹ Эрх хязгаарлах шийдвэрийг цагдаагийн ажилтан танилцуулахад хүчирхийлэл үйлдэгч хэрхэн хүлээж авсан талаар хохирогч тайлбарласан:

“Энэ тухай сонсоод тэр гайхаад, бас айж түүний бие чичирч байсан. Тэр үед нөхөр, бас хадам ээж хамт байхад цагдаагийн ажилтан, нийгмийн ажилтантай ирж эрх хязгаарлах шүүхийн шийдвэрийг гардуулж, түүнд гурван сарын хугацаатай авсан хязгаарлалтыг тайлбарлаж өгсөн”¹⁸²

Эрх хязгаарлах шийдвэрийн гүйцэтгэлд хяналт байдаггүй

Эрх хязгаарлах шийдвэрийг ямар байгууллага гүйцэтгэх талаар хуульд тодорхой заагаагүй нь хэрэгжилт мүү байхад нөлөөлсөн. Өмгөөлөгчийн тайлбарласнаар “Зарим тохиолдолд шийдвэр гүйцэтгэгч хүчирхийлэл үйлдэгчийн гэрт нь очиж шүүхийн шийдвэрийн дагуу гэрээсээ явахыг шаарддаг ч юу ч өөрчлөгддөггүй. Хүчирхийлэл үйлдэгч гэртээ эргэж ирсэн үгүйд хэн ч хяналт тавьдаггүй. Шүүхийн шийдвэр зөвхөн түнхаглал төдий л зүйл болдог”¹⁸³ Хүчирхийлэл үйлдэгчийн эрхийг хязгаарласан шийдвэр хэрэгжсэн туршлага практикт байхгүй байгаа нь төрийн албан хаагчид энэ шийдвэрийг хэрэгжүүлэх мэдлэг хомс байгаатай бас холбоотой. Эрх хязгаарлах шийдвэрийг ямар нөхцөлд зөрчсөн гэж үзэх талаар хүчирхийлэл үйлдэгч ч бас мэддэг байх ёстой.

Эрх хязгаарлах шийдвэрт тавих хяналтын нэг чухал хэсэг бол холбогдох байгууллагууд хоорондоо хэрхэн мэдээлэл солилцох тухай зохицуулалт тодорхой байх явдал юм. Шүүх эрх хязгаарлах шийдвэр гаргасан талаар цагдаагийн ажилтан ямар ч мэдээлэлгүй байдаг.¹⁸⁴ Цагдаагийн ажилтан “Бид шүүхийн шийдвэрийн хувийг хэзээ ч хүлээж авч байгаагүй. Энэ талаар зөвхөн хохирогчоос л мэдэж авдаг”¹⁸⁵ Хэрвээ цагдаагийн ажилтан шүүхийн шийдвэрийн талаар ямар ч мэдээлэлгүй байх юм бол тухайн шийдвэр зөрчигдөж байгаа эсэхэд хяналт тавих боломжгүй. Зарим Засаг дарга нар хүчирхийлэл үйлдэгчид шаардлага тавих ёстой ч¹⁸⁶ тэдний хувьд эрх хязгаарлах шийдвэр гарсан талаар мэдээлэл аваагүй тохиолдолд энэ нь боломжгүй юм. Жишээ нь багийн Засаг дарга шүүх эрх хязгаарлах шийдвэр гаргасан эсэхийг мэдэх боломжгүй юм¹⁸⁷

¹⁸⁰ ШШГГ-ын ажилтны ярилцлага 1, Д хот, 2013.3.27,10:00

¹⁸¹ ШШГГ-ын төлөөлөгч: Засгийн газраас Тахарын алба байгуулахаар бэлтгэл ажил хийж байна. Энэ алба нь эрх хязгаарлах шийдвэрт анхаарал хандуулж, хохирогч, шүүгчийн аюулгүй байдлыг хангаж ажиллана. Энэ тогтолцоогоор шүүх захирамж гаргаж, алба нь хэрэгжүүлэх үүрэг хүлээнэ. Хуульчийн ярилцлага, Д хот, 2013.1.28, 10:00

¹⁸² Хохирогчийн ярилцлага, Д хот, 2013. 3. 25, 14:30

¹⁸³ Хуульчийн ярилцлага, Д хот, 2013.1. 23, 12:00

¹⁸⁴ Хүүхдийн байцаагч, У хот, 2013.3. 21, 12:30

¹⁸⁵ Хорооны цагдаагийн ажилтны ярилцлага, Д хот, 2013. 1. 23, 15:00

¹⁸⁶ Багийн Засаг даргын ярилцлага, Б хот, 2013.1.30, 14:00

¹⁸⁷ Багийн Засаг даргын ярилцлага 2, Эхот, 2013. 3.19, 9:30

Монгол улсад шүүхийн шийдвэрийн гүйцэтгэлд хяналт тавих зорилгоор цахим хяналт хэрэглэх талаар анхаарч эхэлж байгаа.¹⁸⁸ Ийм төрлийн технологи нь хохирогчийн аюулгүй байдлыг дээд зэргээр хангаж, хүчирхийлэл үйлдэгч шүүхийн шийдвэрийг зөрчих нөхцлийг бууруулна. Цахим хяналтыг үр дүнтэй ашиглан, эрх хязгаарлах шийдвэрийг хэрэгжүүлэхдээ олон талаас нь анхаарах шаардлагатай. Цахим хэрэгсэл нэвтрүүлсэн тохиолдолд хангалттай хянаж, дохиолол ирсэн үед цагдаагийн зүгээс нэн даруй хариу арга хэмжээ авах нь хамгийн чухал. Орон нутагт байршил хол газруудад цагдаагийн ажилтан цахим хяналтын дохиоллын дагуу очиход цаг алдах магадлалтай.¹⁸⁹ Дохиолол ирсэн даруй арга хэмжээ авахгүй тохиолдолд цахим хэрэгсэл нь хохирогчийн аюулгүй байдлыг хамгаалах бус харин ч эрсдлийг нэмэгдүүлнэ.

Эрх хязгаарлах шийдвэрийн зөрчилд анхаарал хандуулдаггүй

ГБХТТХуулиар эрх хязгаарлах шийдвэрийг ямар тохиолдолд зөрчсөн гэж үзэх талаар тодорхой тусгаагүй. Хүчирхийлэл үйлдэгч эрх хязгаарлах шийдвэрийг зөрчсөн тохиолдолд ямар хариуцлага хүлээлгэх тухай хуульчлаагүй. Ингэснээр хүчирхийлэл үйлдэгч тухайн шийдвэрийг зөрчсөн тохиолдолд ямар ч хариуцлага хүлээхгүй байхад хүргэсэн.

ГБХТТХуулиар тодорхой нөхцлийг харгалзан хууль тогтоомжид заасан хариуцлага хүлээлгэхээр заасан ч¹⁹⁰ эрх хязгаарлах шийдвэрийг зөрчсөн бол гэж тодорхой зааж өгөөгүй. Эрүүгийн хуулийн 258 дугаар зүйлд шүүхийн шийдвэрийг хэрэгжүүлээгүй бол гэмт хэрэг гэж хуульчлагдсан байдаг учраас¹⁹¹ тусгайлан заагаагүй ч эрх хязгаарлах шийдвэр зөрчигдсөн тохиолдолд адил авч үзэх боломжтой. Судалгаанд хамрагдагсдын зарим нь эрх хязгаарлах шийдвэрийг зөрчих нь Эрүүгийн хуулийн 258 дугаар заалтыг зөрчсөнтэй адил гэж үзнэ,¹⁹² зарим хуульчид эрх хязгаарлах шийдвэрийг зөрчихөд хариуцлага хүлээлгэх хуулийн үндэслэл байхгүй гэж үзэж байсан.¹⁹³

Хэдийгээр зарим хуульчид Эрүүгийн хуулийн 258 дугаар заалтаар¹⁹⁴ эрх хязгаарлах шийдвэрийг зөрчсөн этгээдэд хариуцлага хүлээлгэх боломжтой гэж үздэг ч энэ заалтыг хэрэглэн ямар ч хариуцлага хүлээлгэж байгаагүй гэж судалгааны багийн зүгээс дүгнэсэн. ШШГГ-ын ажилтан эрх хязгаарлах шийдвэр зөрчигдсөн тохиолдолд Эрүүгийн хуулийн 258 дугаар заалтыг хэрэглэх боломжийн талаар тайлбарласан:

¹⁸⁸ ШШГГ-ын ажилтны ярилцлага 1, Д хот, 2013. 3.27,10:00

¹⁸⁹ Хууль зүйн яам, Улаанбаатар хот, 2013.1.31, 14:00 (цахим хяналт нь зөвхөн хот суурин газар үр дүнтэй, харин хөдөө, орон нутагт боломжгүй)

¹⁹⁰ Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль, 19 дугаар зүйлийн 19.1 дэх хэсэг: “Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль тогтоомжийг зөрчсөн этгээдэд түүний үйлдэл, эс үйлдэхүйн нийгмийн аюулын шинж чанар, зөрчлийн байдал, учруулсан хохиролын хэмжээг харгалзан хууль тогтоомжид заасан хариуцлага хүлээлгэнэ”

¹⁹¹ Эрүүгийн хууль, 258 дугаар зүйлийн 258.1 дахь хэсэг: Хуулийн хүчин төгөлдөр болсон шүүхийн шийтгэх тогтоол, шийдвэр, магадлал, шүүхийн тогтоол, шүүгчийн захирамжийг санаатай биелүүлээгүй, эсхүл биелүүлэхэд нь зориуд саад учруулсан бол хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг таваас тавь дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, нэг зуугаас хоёр зуун тавин цаг хүртэл хугацаагаар албадан ажил хийлгэх, нэгээс гурван сар хүртэл хугацаагаар баривчлах ял шийтгэнэ.

¹⁹² ШШГГ-ын ажилтны ярилцлага 1, Д хот, 2013.3.27,10:00; Цагдаагийн ярилцлага, Д хот, 2013.1.23,15:00

¹⁹³ Дүүргийн шүүхийн шүүгч, Г хот, 2013.3.22, 11:00; Цагдаагийн ажилтны ярилцлага, Э хот, 2013.3.19, 15:30

¹⁹⁴ Цагдаагийн ажилтны ярилцлага, Д хот, 2013.1.23, 15:00; ШШГГ-ын ажилтны ярилцлага 1, Д хот, 2013.3.27,10:00

“Шүүхийн шийдвэрийг гүйцэтгээгүй этгээдийг баривчилна гэж хуульчилсан учраас тэр баривчлагдах ёстой. Бид цагдаад мэдээлэх ёстой, түүнийг баривчлах эсэх нь цагдаагаас шалтгаална. . . . ШШГТХуулиар бид хүчирхийлэл үйлдэгчийг баривчлах эрх байхгүй. Түүнийг алдахгүйн тулд шийдвэр гарсан даруйд цагдаад мэдэгдэж, цагдаа түүнийг хүргэх газар нь аваачиж ажиллах ёстой”¹⁹⁵

Байнга хүчирхийлэлд өртдөг байсан нэгэн хохирогч эрх хязгаарлах шийдвэр шүүхээс гаргуулж чадсан тухай хуульч ярьсан. Сэтгэл санааны дарамтаас болж тэр дотор эрхтэний хагалгаанд орох шаардлагатай болсон, учир нь түүний хоол боловсруулах эрхтэн шархалсан байсан:

“Хүчирхийлэл үйлдэгч 6 сартай хүүхдээ гал дээрх тогоондоо хийх оролдлого хийж байсан. Хохирогч байнгын хүчирхийлэл дарамтанд байж, олон ч удаа цагдаад дуудлага өгсөн. Нэг удаа нөхөр нь гэр дээрээ бензин цацаж байгаагаа утсаар эхнэртээ хэлж дарамталж байсан. . . .эмэгтэй цагдаагийн байгууллагад тэдний үүргийг нь сануулж байж дуудлага өгдөг. Дуудлагын дагуу цагдаагийн ажилтан ирж, түүнийг гэрээ шатаахыг зогсоосон. . . . тэр дахиад л хүчирхийлж эхэлсэн. . . . хэд хэдэн дуудлагын дараа цагдаагийн ажилтан залхаж, дахин ирэхээ больсон. Цагдаагийн хэсэг рүү тусламж хүсэн зугтаж байхдаа эмэгтэй ойчиж, хөлөө хугалсан.”¹⁹⁶ Эрх хязгаарлах шийдвэрийг шүүхээс гаргасан ч, ШШГГ нөхрийг нь гэрээс нь явуулсан ч тэр хүчирхийлэл үйлдсээр л байсан. Тэр дахин дахин ирж байсан. Орой болсон хойно дахиад л хүрээд ирдэг байсан. Хэд хоногийн дараа тэр уучихсан ирсэн. . .эмэгтэй дахиад л цагдаа дуудсан”¹⁹⁷

Цагдаагийн ажилтан дуудлагаар ирсэн ч эрх хязгаарлах шийдвэрийг зөрчсөн хүчирхийлэл үйлдэгчийг баривчлахын оронд зөвхөн аман сануулга өгдөг, эсвэл тэр шөнөдөө л баривчилдаг. Хүчирхийлэл үйлдэгч хохирогчийг айлган сүрдүүлж, эд хөрөнгөө сүйтгэсээр байдаг.¹⁹⁸

Эрх хязгаарлах шийдвэрийг шүүхээс гаргасан даруй хохирогч баярладаг ч удалгүй шүүхийн шийдвэрийг зөрчсөн хүчирхийлэл үйлдэгч ямар ч хариуцлага хүлээхгүй байгааг хараад дахин айдаст автдаг гэж өөр нэг хуульч тайлбарласан. Юу ч өөрчлөгддөггүй учраас хохирогч дахин хэзээ ч эрх хязгаарлах арга хэмжээ авахуулах хүсэлт шүүхэд гаргахгүй.¹⁹⁹ Тухайн аймгийн хувьд энэ нь эхний болоод хамгийн сүүлчийн эрх хязгаарлах шийдвэр байсан гэж хуульч тайлбарласан. Учир нь эрх хязгаарлах анхны шийдвэр хэрэгжээгүй тул дараагийн удаа хэн ч энэ хүсэлтийг гаргахыг хүсээгүй.²⁰⁰

¹⁹⁵ ШШГГ-ын ажилтны ярилцлага 1, Д хот, 2013.3. 27,10:00

¹⁹⁶ Хуульчийн ярилцлага, Д хот, 2013. 1. 28, 10:00

¹⁹⁷ Дээр дурдагдсан.

¹⁹⁸ Дээр дурдагдсан. Өөр нэг тохиолдол: ШШГГ хүчирхийлэл үйлдэгчийг гэрээс нь тусгаарласан ч тэр дараа нь буцаж ирээд хохирогчийг заналхийлсэн. Тэр үед цагдаагийн ажилтан түүнийг баривчилж, эрх хязгаарлах шийдвэрийг сануулсан ч заналхийлэл, хүчирхийлэл үргэлжилсэн.

¹⁹⁹ Шүүгчтэй хийсэн ярилцлага, У хот, 2013.3.12, 18:00

²⁰⁰ Дээр дурдагдсан.

Цагдаагийн ажилтан яг ямар тохиолдлыг эрх хязгаарлах шийдвэр зөрчсөн гэж үзэх талаар мэддэггүй. Хохирогчийн амь нас, эрүүл мэнд аюултай байдалд орохоос бусад тохиолдолд цагдаагийн ажилтан ГБХТТХуулийг хэрэглэн ямар нэг арга хэмжээ авах эрх байхгүй гэж нэгэн цагдаагийн ажилтан ярьсан.²⁰¹ Өөр нэг тохиолдол: цагдаагийн ажилтан эрх хязгаарлах шийдвэрийг хүчирхийлэл үйлдэгчид гардуулсан ч тэрээр гэрээ орхиж явахаас татгалзсан учир хохирогчид тусалж чадаагүй:

“Нөхөр маань гэрээ хэзээ ч орхиж яваагүй. . . . Би хорооны цагдаад энэ талаар хэлсэн, гэвч ямар ч алхам хийгээгүй. Цагдаагийн ажилтан надад туслана, түүнийг тусгаарлана гэж итгэж байсан ч анхаарч үзээгүй орхисон”²⁰²

Хүчирхийлэл үйлдэгчийг холдуулж өгөхийг хохирогч цагдаагийн ажилтнаас хүсэхэд тэрээр цааргалсан. Энэ тухай хохирогч мэдээлэхдээ:

“Үнэндээ, цагдаа шууд намайг үгүйсгэсэн. . . Би нийгмийн ажилтанд хандсан ч цагдаатай яг адилхан “гэр бүлийн асуудалд оролцох зав алга” гэж хэлсэн”²⁰³

Ихэнх тохиолдолд цагдаагийн ажилтан хүчирхийлэл үйлдэгчийн араас сайтар хөөцөлдөхгүй, зүгээр л орхичихдог. Нэгэн хохирогч хэрхэн хоёроос гурван удаа эрх хязгаарлах шийдвэрийг шүүхээс гаргуулах гэж оролдсон талаар ТББ-ын ажилтан тайлбарласан:

“Байнгын хүчирхийлэл, дарамт үргэлжилж байсан. Хохирогч хоёр гурван удаа хагалгаанд орох хүртэл хүчирхийлэл хурцадмал байдалд хүрсэн. Нэг удаа хүчирхийлэл үйлдэгч түүний бие рүү буцалсан ус цацсан. . . . Эрх хязгаарлах шийдвэрт хяналт байгаагүй. . . . нөхрийг нь баривчилдаг ч ямар ч өөрчлөлт гардаггүй. Нөхөр нь суллагдахад асуудал дахиад л өрнөдөг. Эрх хязгаарлах шийдвэрийн биелэлтийг хянах гэж тэднийд хэн ч, хэзээ ч ирж байгаагүй. Хүчирхийлэл гарах бүрт л эмэгтэй цагдаад мэдээлж байсан. Цагдаа гомдлыг хүлээж авдаггүй эсвэл цагдаа ирмэгц нөхөр нь зугтаад явчихдаг. Тэр үед эмэгтэйд “та түүнийг олох л юм бол бид түүнийг баривчлах болно” гэж цагдаа хэлдэг”²⁰⁴

Эрүүгийн хуулийн 258 дугаар зүйлийг ашиглах боломжтойг хүлээн зөвшөөрөхгүй хэрнээ эрх хязгаарлах шийдвэрийг хэрэгжүүлэх, хянах талаар тодорхой чиглэл, зохицуулалт хийгдэхгүй байгаагаас олон хохирогч хамгаалалт авч чадахгүйд хүргэж байна.

²⁰¹ Сумын цагдаагийн ажилтантай хийсэн ярилцлага, Э хот, 2013.3.19, 15:30

²⁰² Хохирогчтой хийсэн ярилцлага, Д хот, 2013.3.25, 14:30

²⁰³ Дээр дурдагдсан.

²⁰⁴ ТББ-тай хийсэн ярилцлага 1, Д хот, 2013.1.31, 9:00

ЗАХИРГААНЫ ЗӨРЧИЛ БОЛОН ЭРҮҮГИЙН ХЭРГИЙГ ХЯНАН ШИЙДВЭРЛЭХ ҮЙЛ АЖИЛЛАГААНД ТУЛГАРЧ БУЙ БЭРХШЭЭЛ

“Тэр намайг буруутгаж байсан. “Танай нөхрийн буруу гэж би бодохгүй байна, энэ бол чиний буруу. Та чинь настай л эмэгтэй байна шүү дээ, яагаад нөхөртэйгээ асуудал үүсгээд байгаа юм бэ” гэж цагдаа хэлсэн. Энэ бүхэн надад маш ичгэвтэр байсан учраас би дахин хэзээ ч цагдаад тусламж хүсч хандаагүй”²⁰⁵

Гэр бүлийн хүчирхийллийн хэргүүдэд захиргааны хариуцлага хүлээлгэх, эрүүгийн ял оногдуулахад олон тооны бэрхшээл тулгарч байна. Цагдаагийн ажилтан, шүүгч, прокурорууд гэр бүлийн хүчирхийллийн мөн чанар, онцлогийг хангалттай мэддэггүй. Эмэгтэйчүүдийг дарамт, хүчирхийллээс хамгаалахын тулд тэд зохих хууль, журам, зааврыг хангалттай ашигладаггүй.

Хүчирхийлэл үйлдэгчид захиргааны хариуцлага хүлээлгэх, эрүүгийн ял оногдуулахын тулд прокурор, шүүгч нараас илүүтэй цагдаагийн ажилтан чухал үүрэг гүйцэтгэх ёстой. Гэр бүлийн хүчирхийллийн хэргийг анхан шатанд таслан зогсоох, эхний шатны хариуцлага хүлээлгэх үүрэг цагдаагийн ажилтанд оногддог.²⁰⁶ Хэргийн дуудлагаар хамгийн түрүүнд очиж, эрүүгийн хэрэг үүсгэх эсэхийг шийдвэрлэх үүрэгтэй цагдаагийн ажилтан үл тоомсорлож хандвал гэр бүлийн хүчирхийллийн хэргүүд прокурор, шүүхийн шатанд тэр бүр шилждэггүй.²⁰⁷ Иймд цагдаагийн ажилтны мэдлэг, хандлага маш чухал. Цагдаагийн ажилтны зүгээс хэргийг шилжүүлсэн тохиолдолд л прокурор оролцдог. Үүний дараа л тухайн хэрэгт эрүүгийн хариуцлага хүлээлгэх эсэхэд хяналт тавьж ажилладаг.

Прокурор тухайн хэргийг шүүхэд хянан шийдвэрлүүлэхээр шийдсэн үед шүүгчийн оролцоо бий болно. Тэдний үүрэг бол тухайн хэрэгт эрүүгийн ял эсвэл захиргааны хариуцлага хүлээлгэх эсэх шийдвэр гаргана. Ихэнх хэрэг олон нөхцөл, шалтгааны улмаас шүүхийн шатанд хүрч очдоггүй. Тухайлбал, хохирогч өргөдлөө буцаах, хүчирхийлэл үйлдэгч буруугаа хүлээх эсвэл архины албадан эмчилгээнд явах, цагдаагийн ажилтан сануулаад өнгөрөөх, эсвэл прокурор эрүүгийн хэрэг үүсгэхгүйгээр захиргааны хариуцлага оногдуулдаг зэрэг.²⁰⁸

Иргэний журмаар эрх хязгаарлах шийдвэр гаргасан эсэхээс үл хамааран хүчирхийлэл үйлдэгчийг захиргааны журмаар баривчлах, эрүүгийн хэрэг үүсгэх эсэх нь цагдаагийн хандлагаас шалтгаалж байна.²⁰⁹ Цагдаагийн ажилтнууд буруу ойлголт, сөрөг хандлагатай

²⁰⁵ Хохирогчийн ярилцлага, Б хот, 2013.1.31, 15:30. Энэ хохирогчийн түүхийг 10, 19, 20, 28, 29 болон 53 хуудсанд иш татсан.

²⁰⁶ Цагдаагийн ажилтан асуудал болсон газар ч очдог, өргөдөл гомдлыг ч цагдаагийн газар л хүлээж авдаг. Тэд хэргийг баримтжуулахад, шийдвэрлэхэд, захиргааны хариуцлага оногдуулах, торгох шийдвэр гаргахад оролцдог.

²⁰⁷ Хариуцлага хүлээлгэх шийдвэр; Эвлэрүүлэх гомдлыг хэрэгсэхгүй болгох хэсгийг үзнэ үү.

²⁰⁸ Улсын яллагчийн ярилцлага, Б хот, 2013.1.21, 15:40

²⁰⁹ Цагдаагийн ийм шийдвэр гаргасан өөр нэг шалтгаан нь “гэр бүлийн хүчирхийллийн хэрэгт юу хийхээ мэддэггүй,” “эмэгтэй хүнтэй ярилцах үр чадвар байхгүй,” эсвэл гэр бүлийн хүчирхийлэл бол гэр бүлийн, эхнэр нөхрийн хоорондын асуудал гэж боддог.” Хохирогчтой хийсэн ярилцлага, У хот, 2013.3.22, 9:00 [Энэ хохирогчийн түүхийг 12, 13, 17, 28, 35, 36 болон 54 хуудсанд иш татсан] Гэр бүлийн хүчирхийллийг цагдаагийн ажилтан заримдаа өөрийн үзэмжээр шийдвэрлэдэг. Ахимаг насны, нэр төртэй байдал, эсвэл гаднах байдлаас нь дүгнэлт хийж шийдвэр гаргадаг. Эмч, нийгмийн ажилтантай хийсэн ярилцлага, С хот, 2013.3.18, 16:00; ТББ-тай хийсэн ярилцлага, А хот, 2013. 3.22, 10:00; Цагдаагийн ажилтны ярилцлага1, Д хот, 2013. 3.25, 12:00 Зарим цагдаагийн ажилтан гэр бүлд тайван байдал бий болгоход эмэгтэй хүн гол үүрэг хүлээх ёстой гэж үздэг. Тэд “ нөхөр чинь согтуу ирвэл уурлаж, хэрүүл битгий өд, зүгээр л тайван байх хэрэгтэй” гэж хэлдэг. Эрүүл мэндийн ажилтантай хийсэн ярилцлага, Э хот, 2013. 3.18, 13:30. Төрийн албан хаагчдад зориулсан сургалт хангалтгүй хэсгээс үзнэ үү.

байдгаас хүчирхийлэл үйлдэгчид арга хэмжээ авах, эсвэл баривчлах алхам хийдэггүй талаар олон тохиолдлыг судалгааны баг сонссон.²¹⁰ Зарим тохиолдолд хүчирхийлэл үйлдэгч олон жилийн турш эхнэрээ хүчирхийлэлтэй харилцаанд байлгасан байдаг. Эд хогшлоо эвдэж, нүүрийг нь үрж шалбалсан зэрэг асуудлаар хандаж байсан гэр бүлийг сүм, хороо бүрт ажиллаж буй цагдаагийн ажилтнууд мэдэж байдаг.”²¹¹ Цагдаагийн ажилтан хохирогчоос хүчирхийлэл үйлдэгчийг үнэхээр баривчлуулахыг хүсэж байгаа эсэхийг асуудаг. Нөхөрт нь захиргааны хариуцлага хүлээлгэж богино хугацаагаар баривчилсан талаар цагдаагийн ажилтан ярихдаа:

“Тэр биеэр жижигхэн, туранхай, хэн ч түүнийг зэрлэг хүн гэж хэлэхгүй. . . Тиймээс би “Яагаад түүнийг баривчлуулах гээд байгаа юм бэ? Яагаад түүнийг гэртээ аваачихгүй гээд байгаа юм бэ?” гэж хохирогчид хэлсэн. Миний зүрх сэтгэл дотор түүнийг баривчлах хүсэл төрөхгүй байсан, учир нь тэр маш дорой, туранхай жижигхэн, яаж ийм хүн гэр бүлийн хүчирхийлэл үйлдэж чадах вэ” гэж бодогдож байсан.”²¹²

Заримдаа хохирогчийн хүсэлтээр, эсвэл хүчирхийлэл үйлдэгч эрүүл, архи уусан ч амгалан тайван байдал алдагдуулаагүй байна гэсэн шалтгаанаар цагдаа баривчлахгүй орхидог. Мөн хохирогч мөнгөн торгууль төлөхөөс татгалздаг учраас баривчилдаггүй. Хүчирхийлэл үйлдэгчийг баривчлахын оронд зөвхөн эхнэрээ зодохгүй байхыг сануулж, “амралтын өдөр байна” гэх мэтээр зүгээр өнгөрөөдөг.²¹³

Ер нь ихэнхдээ хохирогчийг хамгаалж, хүчирхийлэл үйлдэгчид хариуцлага тооцох гэхээсээ илүү гэр бүлийн бүрэн бүтэн байдалд цагдаагийн ажилтан анхаарал хандуулдаг.²¹⁴ Хурим нь болох гэж байгаа ч нүд нь хөхөрсөн эмэгтэйг хараад “Би нөхрийг нь баривчилж, шоронд хийх үү эсвэл зүгээр л орхих үү гэж өөрөөсөө асуусан. Хосууд гэрлэхээр хуримаа товлочихсон, хүүхэд нь төрөх гэж байсан учир хэргийг шууд орхисон”²¹⁵ гэж цагдаагийн ажилтан дурсан ярьсан.

Гэр бүлийн хүчирхийллийн хэргийг үр дүнтэй шийдвэрлэхэд Цагдаагийн ажилтанд ч бас саад бэрхшээл тулгардаг. Орон нутагт ажилладаг ажилтнууд алс хол байдаг айл өрхүүдэд хүрч ажиллахад унаа хэрэгтэй байдаг тухай мэдээлсэн.²¹⁶ Цагдаагийн ажилтан хэлэхдээ:

“Сум, багийн түвшинд ажилладаг цагдаагийн ажилтанд унаа байдаггүй учраас Засаг даргын унааг ашигладаг. Хэрвээ Засаг даргын унаа завгүй

²¹⁰ Цагдаагийн ажилтан нотолгоонд суурилсан баривчилгаа хийх сайн туршлага нь цагдаагийн ажилтан газар дээр нь байгаа нотолгоонд суурилах (тухайлбал гэмтсэн эд хогшил, ил харагдах гэмтэл бэртэл, эсвэл тэмцсэн эмэгтэй). Цагдаа хэргийг заавал гэрч шаардахгүй баривчлах ёстой. Хууль хэрэгжүүлэх шинэчлэл, Хүний эрхийн төлөөх нөлөөлөл (2009 2 сар 3), http://www.stopvaw.org/Law_Enforcement_Reform_Efforts.

²¹¹ Цагдаагийн ажилтны ярилцлага 1, Д хот, 2013.3-25, 12:00.

²¹² Дээр дурдагдсан

²¹³ Хохирогчийн ярилцлага, Ф хот, 2013.3-22, 14:00. Энэ хохирогчийн түүх 5, 10, 29, 44, 49 дугаар хуудсанд иш татсан.

²¹⁴ Цагдаагийн ажилтны ярилцлага, Э хот, 2013, 3 -19, 14:30

²¹⁵ Дээр дурдагдсан.

²¹⁶ Багийн засаг даргын ярилцлага 1, Э хот, 2013.3 -19, 9:30

*бол ойрхон байгаа хэн нэгний унааг зээлж ажлаа амжуулдаг. Унаа байгаа тохиолдолд бид хүрэх газраа 30- 40 минут зарцуулж хүрдэг.*²¹⁷

Алслагдсан орон нутагт цагдаагийн ажилтан ажлаа гүйцэтгэх унаагүй байгаа нь хүчирхийллийг шуурхай таслан зогсоож чадахгүй, цаг алдахад хүргэдэг.²¹⁸ “Хохирогч эмэгтэй цагдаад дахин хандахаа больсон. Учир нь дуудлага өглөө ч цагдаагийн ажилтан унаа байхгүй гэсэн шалтгаанаар ирж туслалцаа үзүүлж чаддаггүй” гэж нэгэн өмгөөлөгч тайлбарласан:

“Сум, багийн цагдаа нар унаагүй, байгаа ганц мотоцикл нь заримдаа бензингүйн улмаас ашиглах боломжгүй байдаг. Орон нутагт түргэн тусламж эсвэл цагдаагийн дуудлага өгөх үйчилгээ байдаггүй. Эмэгтэйчүүд сум, багийн цагдаад хүрч очихын тулд явган алхах, эсвэл замын унаанд дайгдахад хүрдэг.²¹⁹ Ихэнх тохиолдолд аймаг руу дунджаар 200 км, сумын төв рүү 50 км замыг туулах хэрэгцээ тулгардаг. Хүчирхийллийн улмаас бэртэл, гэмтэл авсан хохирогч хүчирхийллээс зуны улиралд голдуу зугтаж хөдөө хээр хоног төөрүүлж, төв газар барааддаг”²²⁰

Захиргааны хариуцлагын тухай хууль болон Эрүүгийн тухай хуулиар хариуцлага оногдуулах боломжтой ч хүчирхийлэл үйлдэгчид үр дүнтэй хариуцлага болж чаддаггүй. Тиймээс цагдаагийн ажилтан хүчирхийлэл үйлдэгчийг тэр бүр баривчилдаггүй, ихэнхдээ торгодог. Захиргааны хариуцлагын тухай хуулийн дагуу хүчирхийлэл үйлдэгчийг торголоо ч хохирогчид эдийн засгийн давхар хохирол учирдаг. Хүчирхийлэл нь ноцтой биш л бол гэр бүлийн хүчирхийллийн хэргүүдэд хорих ял оногдуулдаггүй, ялласан ч богино хугацаагаар шийтгэдэг.

Захиргааны хариуцлагын тухай хууль

Гэр бүлийн хүчирхийллийн ихэнх хэргүүдэд хүчирхийлэл үйлдэгч хариуцлага хүлээдэггүй. Хүчирхийлэл үйлдэгчид хуулийн хариуцлага хүлээлгэхдээ ихэнхдээ Захиргааны хариуцлагын тухай хуулийг ашигладаг. Захиргааны хариуцлагын тухай хуулиар гэр бүлийн хүчирхийллийн хэрэгт хариуцлага хүлээлгэхдээ хүчирхийлэл үйлдэгч архидан согтуурч²²¹, бусдын амгалан тайван байдлыг алдагдуулсан гэсэн хуулийн заалтыг үндэслэл болгон ашигладаг.²²² Энэ хариуцлага нь Эрүүгийн хуулиар хүлээлгэх хариуцлагатай харьцуулахад хөнгөн. Цагдаагийн

²¹⁷ Цагдаагийн ажилтны ярилцлага, С хот, 2013 .3 -20, 10:00

²¹⁸ Эдгээр асуудал нь хохирогч бусад үйлчилгээ хүртэхэд саад болдог. Эрх хязгаарлах арга хэмжээнд тулгарч буй бэрхшээл хэсгээс харна үү

²¹⁹ Аймгийн төв.

²²⁰ ТББ –ын ярилцлага, Ф хот, 2013. 3 -21, 9:00. Эрүүл мэндийн үйлчилгээ авах, бэртэл гэмтэл хугарсан хавиргаа эмчлүүлэхэд маш хэцүү байдаг тухай нэгэн хохирогч тайлбарласан. Хууль болон цагдаагийн туслалцаа авах тухай асуухад “Чи хэнд ч хэрэггүй, чи зүгээр л гэртээ л хэвтэж бай” гэж хэлдэг. Хохирогчийн ярилцлага, Б хот, 2013. 1 -31, 15:30. Энэ хохирогчийн түүх 10, 19, 20, 28, 29 болон 53 хуудсанд иш татсан

²²¹ Захиргааны хариуцлагын тухай хууль, 22 дугаар зүйл (архидан согтруусан): Удаа дараа согтуурсан тохиолдолд 7 хоноогоос 30 хоног хүртэл баривчилна.

²²² Захиргааны хариуцлагын тухай хууль, 21 дүгээр зүйл (танхайрах): Гудамж, талбай, орон сууц, нийтийн тээвэр, үзвэр, үйлчилгээний болон олон нийтийн бусад газар хэрүүл маргаан, зодоон үүсгэсэн, бусдыг өдөөн хоргоосон, айлган сүрдүүлсэн, иргэдийн амгалан тайван байдал алдагдуулсан, олон нийтийг үл хүндэтгэсэн, үйлчилгээний болон дарааллын журам зөрчсөн бол 15000 хүртэл төгрөгөөр торгох, эсхүл 7-30 хоногийн хугацаагаар баривчлах шийтгэл ноогдуулна

ажилтан хүчирхийлэл үйлдэгчийг архидан согтуурсан гэсэн шалтгаанаар л баривчлан эрүүлжүүлдэг.²²³ Түүнчлэн хүчирхийлэл үйлдэгчийг архидан согтуурч, бүсдын амгалан тайван байдлыг алдагдуулсан гэсэн үндэслэлээр торгууль оногдуулдаг.²²⁴ Гэр бүлийн хүчирхийллийг зогсооход дээрх хуулийн аль ч заалт үр дүнтэй байдаггүй.

Захиргааны хариуцлагын тухай хууль: Архидан согтуурал

“Гэр бүлийн хүчирхийллийн ихэнх хэргүүд нь архидалт эсвэл согтуурсан хүмүүстэй холбоотой байдаг.”²²⁵

Монгол улсад гэр бүлийн хүчирхийллийн гол шалтгааны нэг нь архидан согтуурал гэж судалгаанд оролцогчид дурдсан байсан. Энэ байдал нь “архидалттай тэмцэхэд л гэр бүлийн хүчирхийлэл зогсоно” гэж үзэх хандлагыг бэхжүүлж байна. Гэр бүлийн хүчирхийллийн гол шалтгаан нь архидалт гэсэн домогт итгэсэн хэвээр байгаа учраас Засгийн газар хохирогчийг хамгаалах, хүчирхийлэл үйлдэгчид хариуцлага хүлээлгэх, зан үйлд нь нөлөөлөх хөтөлбөрт хамруулах асуудалд анхаарал хандуулж чадахгүй байна. Зарим хүчирхийлэл үйлдэгч хүчирхийлэл үйлдсэн гэм буруугаа архи руу түлхэж хариуцлагаас мултардаг.

Эрүүлжүүлэх байранд ирж байгаа ихэнх хүмүүс бараг бүгд л гэр бүлийн хүчирхийлэлтэй холбоотой байдаг тухай эрүүлжүүлэх байрны ажилтан тайлбарласан.²²⁶ Өөр нэг ажилтан эрүүлжүүлэх байрны нэг өдрийг дүрсэлсэн:

“Дуудлагаар очоод нөхөр нь согтуу байвал түүнийг эрүүлжүүлэх байранд аваачдаг. Маргааш өглөө нь эрүүлжүүлэгдсэн нөхрийг Захиргааны хариуцлагын тухай хуулиар торгох болдог. Хохирогчоос эсвэл гэр бүлийн гишүүдийн хэн нэгнээс өргөдөл гомдол хүлээж авдаг, шүүх рүү шилжүүлэхэд долоо хоногоос 10 хоног хүртэл баривчлах хариуцлага хүлээлгэдэг”²²⁷

Эрх зүйн систем нь ийм байдлаар архидалт руу анхаарал хандуулж байгаа нь хүчирхийлэл үйлдэгчийн аюултай байдлыг нэмэгдүүлэх сөрөг жишиг тогтооход нөлөөлж байна. Хуулийн байгууллагын ажилтнууд архидан согтуурсан хэр хэмжээнээс хамаарч аюул, эрсдлийг тогтоодог. Нөхөр нь эхнэрийнхээ ясыг хугалж, зодож нүдсэн байвал яах вэ гэж асуухад “согтуу байвал баривчлаад, эрүүлжүүлэх газар хүргэнэ, гэхдээ нөхөр нь эрүүл байвал хэрэг бүртгэх хүртэл хүчирхийлэл үйлдэгч чөлөөтэй л явна²²⁸ гэж прокурор хариулсан.

“Цагдаагийн байгууллагад дуудлага өг” гэж найздаа зөвлөсөн ТББ-н ажилтан энэ талаар дурсан ярьсан:

²²³ Багийн цагдаагийн ажилтны ярилцлага, Б хот, 2013. 1-30, 15:00; Улсын яллагчын ярилцлага, Б хот, 2013.1 -28, 15:40

²²⁴ Шүүгчийн ярилцлага, Ф хот, 2013.3 -22, 1100; Цагдаагийн ажилтны ярилцлага, С хот, 2013. 3-18, 11:00.

²²⁵ Сумын шүүгчийн ярилцлага, Э хот, 2013. 3 -18, 15:30.

²²⁶ Эрүүлжүүлэх газрын ажилтан, Ф хот, 2013. 3- 21, 11:00.

²²⁷ Цагдаагийн ажилтны ярилцлага 1, Д хот, 2013. 3 -25, 10:00.

²²⁸ Прокурорын ярилцлага, А хот, 2013. 3 -21, 17:00.

“Эмэгтэй зугтах гэсэн боловч нөхөр нь хутга барин дайрч, 2 хүүхдийнх нь өмнө ална гэж айлган сүрдүүлсэн. Тэрээр цагдаа руу утасдахад, нөхөр нь чинь архи уусан юм уу? гэж асуугаад “өө, эрүүл юм бол нөхөртэйгээ эвлэрээд унтуул” гэж хариу өгсөн.”²²⁹

Цагдаагийн байгууллагын дээрх хандлага нь, хүчирхийлэл үйлдэгчийг өөгшүүлэхээс гадна хохирогч дахин түслэмж дэмжлэг хүсэх хүсэл эрмэлзэлийг нь үгүй хийж байна. Сүүлд нь ТББ-ын ажилтанд найз нь энэ талаар хэлэхдээ “Цагдаагийн утас руу залгасан ч ажиллахгүй, буруу дугаар байсан учраас хамгаалалт авч чадаагүй”²³⁰ гэж ярьсан.

Хүчирхийлэл үйлдэгчийг зөвхөн “архидан согтуурсан” гэдэг шалтгаанаар баривчлах нь эрүүлжүүлэх газар дүүрсэн тохиолдолд хохирогчийн эрсдлийг улам нэмэгдүүлж байна.²³¹ Хамгаалах байрны сэтгэл зүйч үйлчлүүлэгчийнхээ тухай хуваалцсан:

“Тэр эмэгтэй хамгийн сүүлд ирэхдээ биедээ маш олон шарх сорвитой, яс нь хугарсан байсан. Нөхөр нь гэртээ согтуу ирэхээр нь тэр зугтахыг оролдсон ч чадаагүй, түүний гар, хөлийг хүлж, гадаа муу усны нүхэнд хэд хонуулсан.... Түүний биеийг хурц эд зүйлээр зүсэж гэмтээсэн. Хөлдөө маш олон шархтай байсан”²³²

Энэ хүчирхийллээс гадна “ална” гэсэн заналхийлэл байнга үргэлжилж байсан, тэр эмэгтэй цагдаад дуудлага өгсөн ч “эрүүлжүүлэх байр дүүрсэн” гэдэг шалтгаанаар ямар ч арга хэмжээ авалгүй орхисон байсан.²³³

Архидан согтуурсан үедээ л гэр бүлийн хүчирхийлэл үйлдэж байна гэж үзэж, архидалт руу гол анхаарал хандуулснаар энэ төрлийн хэргийг шийдвэрлэж чадахгүй юм.²³⁴

Захиргааны хариуцлагын тухай хууль: Танхайрах

Гэр бүлийн хүчирхийллийн хэрэгт хариуцлага оногдуулахдаа Захиргааны хариуцлагын тухай²³⁵ “хуулийн олон нийтийн амгалан тайван байдлыг алдагдуулах” гэсэн заалтыг үндэслэн шийдвэрлэдэг.²³⁶ Энэ арга хэмжээ нь хохирогчийг эрсдэлтэй байдалд нь үлдээж,

²²⁹ ТББ-тай хийсэн ярилцлага, Э хот, 2013 .3 -18, 11:00

²³⁰ Дээр дурдагдсан

²³¹ ТББ-тай хийсэн ярилцлага, Ф хот, 2013 .3 -21, 9:00 (Ихэнх сүмдэд эрүүлжүүлэх газар байдаггүй, иймд сумын цагдаагийн газрын хаа нэг газар хүчирхийлэл үйлдэгчийг баривчилдаг); Шүүгчтэй хийсэн ярилцлага, Ф хот, 2013. 3 -22, 11:00.

²³² Хамгаалах байрны сэтгэл зүйчийн ярилцлага, Д хот, 2013. 3 -23, 11:30.

²³³ Дээр дурдагдсан

²³⁴ Хүчирхийллийн онол, түүний эволюци, Хүний эрхийг хамгаалагчид (2006.2 .1), http://www.stopvaw.org/Evolution_of_Theories_of_Violence.

²³⁵ 21 дүгээр зүйл.

²³⁶ Шүүгчийн ярилцлага, С хот, 2013 .3 -18, 14:00; I Шүүгчтэй хийсэн ярилцлага, Э хот, 2013. 3-18, 11:00; Цагдаагийн жижүүрийн ярилцлага, Ф хот, 2013. 3- 21, 13:30; Хуульчийн ярилцлага, Э хот, 2013.3 -19, 14:30. гэхдээ, талууд эвлэрсэн тохиолдолд эрүүгийн хуулиар хөнгөн гэмтэл учруулсанд үзүүлэх хариуцлага эсвэл захиргааны хариуцлагыг цуцалдаг. Захиргааны хариуцлагын тухай хууль 43.1 дугаар зүйл: “, хариуцагч харилцан буулт хийж, нэхэмжлэлийн шаардлагыг өөрчлөх, шаардлагыг биелүүлэх арга замаа тодорхойлох зэргээр хоорондоо тохиролцож эвлэрлийн гэрээ байгуулж, маргаанаа дуусгавар болгож болно. Талууд албан ёсоор эвлэрсэн тохиолдолд хэргийг дахин шалгахыг зогсоодог. Захиргааны хариуцлагын тухай хууль, 43.4 дугаар зүйл.

хүчирхийлэл үйлдэгчийг өөгшүүлж байна. Хохирогчид давхар хариуцлага хүлээлгэж, хүчирхийлэл үйлдэгч мултарч үлддэг учраас энэ арга хэмжээг дахин дахин хүлээлгэсэн ч ямар ч үр дүнгүй байна.

“Олон нийтийн амгалан тайван байдлыг алдагдуулсан” үндэслэлд нийцэх хангалттай баримт байлаа ч хохирогчийн зүгээс гомдол гаргахыг хуулиар шаарддаггүй.²³⁷ Хохирогч ихэнх тохиолдолд хүчирхийлэл үйлдэгчээ баривчлуулах, эсвэл хуулийн тогтолцоогоор дамжуулан зан үйлд нь нөлөөлөхийг хүсдэг. Хүчирхийлэл үйлдэгчийн дарамт шахалт, айдас эсвэл хүчирхийлэл үйлдэгчийг шоронд явуулахыг хүсэхгүй байх зэрэг олон шалтгааны улмаас хохирогч өргөдлөө буцаадаг.²³⁸ Хохирогчийг хангалттай хамгаалахын тулд түүний хүслийг үл харгалзан хүчирхийлэл үйлдэгчид чанга хариуцлага хүлээлгэх шаардлагатай.

Хэрвээ хохирогч хүчирхийлэл үйлдэгчид хариуцлага хүлээлгэх эсвэл яллахыг хүсэхгүй бол цагдаагийн ажилтан зөвхөн сануулдаг, эсвэл ямар нэг ажиллагаа хийхгүй орхидог.²³⁹ Өөр нэг тохиолдол: нөхөр нь эхнэрээ сард нэгээс хоёр удаа зодож, хөнгөн гэмтэл учруулдаг. Маргалдаж, хэрэлдсэний дараа нөхөр нь эхнэрээ 5 настай хүүхдийн хамт машиндаа чихэж оруулаад зодож, хөнгөн гэмтэл учруулсан. Түүний биед шарх сорви ил байсан ч хохирогч өөрөө торгуулахыг хүсээгүй учраас цагдаагийн ажилтан сануулаад өнгөрсөн. Энэ талаар цагдаагийн ажилтан тайлбарлахдаа “Энэ айлд хүчирхийлэл байнга давтагддаг. Эхэндээ би хөнгөн сануулаад өнгөрөх нь асуудлыг шийдвэрлэхэд туслана гэж бодсон.”²⁴⁰ Ингэж сануулах нь ямар ч үр дүнгүйг цагдаагийн ажилтан эцэстээ хүлээн зөвшөөрсөн. Тэрээр энэ талаар харамсан ярихдаа:

“Хүчирхийлэл үйлдэгчид сануулга өгөхөд тэд “дахин хэзээ ч хүчирхийлэл үйлдэхгүй” гэдэг. Гэвч энэ бүхэн худлаа байдаг, дахиад л давтагддаг. Би маш олон удаа сануулж байсан, тэд хэзээ ч өөрчлөгддөггүй, энэ бүхэнд үнэхээр сэтгэлээр унасан”²⁴¹

Захиргааны хариуцлагын үр нөлөөгүй байдал

Захиргааны хариуцлагын тухай хуулийн хэрэгжилт ямар ч үр дүнгүй байгаад цагдаагийн ажилтан, шүүгч нар сэтгэл дундуур байдгаа илэрхийлсэн.²⁴² Захиргааны хариуцлагын тухай хуулиар хүчирхийлэл үйлдэгчийг богино хугацаагаар баривчлах эсвэл мөнгөн торгууль оногдуулснаар гэр бүлийн хүчирхийллийг зогсоож, дахин давтагдахаас урьдчилан сэргийлж чадахгүй.

²³⁷ Цагдаагийн ажилтны ярилцлага, Б хот, 2013. 1 -30, 15:00.

²³⁸ Цагдаагийн ажилтны ярилцлага, Д хот, 2013 .1 -18, 8:00; Хууль зүйн яамтай хийсэн ярилцлага, Б хот, 2013.1 -31, 10:00

²³⁹ Цагдаагийн ажилтны ярилцлага, Э хот, 2013. 3 -19, 14:30; Сумын цагдаагийн ажилтны ярилцлага, Э хот, 2013. 3-19 15:30; Улсын яллагчийн ярилцлага, Б хот, 2013. 1 -28, 15:40.

²⁴⁰ Цагдаагийн ажилтны ярилцлага2, Д хот, 2013. 3 - 25, 10:00

²⁴¹ Цагдаагийн ажилтны ярилцлага , Э хот, 2013. 3 -9, 14:30..

²⁴² жишээг хар... Цагдаагийн ажилтны ярилцлага, F хот, 2013.3- 21, 12:30; Шүүгчтэй хийсэн ярилцлага, Ф хот, 2013. 3 -22, 11:00; Цагдаагийн жижүүртэй хийсэн ярилцлага, Ф хот, 2013 .3 -21, 13:30. харна уу Цагдаагийн ажилтны ярилцлага Г хот, 2013. 3-21, 12:00

Захиргааны хариуцлага оногдуулахад долоогоос гуч хоног хүртэлх²⁴³ хугацаагаар баривчилдаг ч гэр бүлийн хүчирхийлэл давтагдан даамжирсаар байдаг. Нэгэн хохирогч тайлбарлахдаа “Нөхөр согтуу ирж, орилж чарлаад, намайг зодоход, хөрш маань цагдаа дууддаг. Цагдаа зөвхөн эрүүлжүүлээд явуулдаг. Эрүүлжүүлэх байрнаас гаргахын тулд би мөнгө төлөх хэрэгтэй болдог. Тэр гарч ирээд архиа илүү их ууж, хүчирхийлэл дахин давтагддаг.”²⁴⁴ “Нөхөр нь эхнэрээ үргэлж хүчирхийлдэг, эхнэрийнх нь нүд байнга хөхөрсөн явдаг, хавирга, сүүж нь хугарч байсан.”²⁴⁵ Цагдаагийн ажилтан энэ хүчирхийлэл үйлдэгч танхайрсан, согтуурсан гэж бараг хорь гаруй удаа баривчлагдаж байсан тухай ярьсан.²⁴⁶ “Хүчирхийлэл үйлдэгчийг богино хугацаагаар баривчлах нь ямар ч ач холбогдолгүй, тэднийг 30 хоног баривчлахаас аль болох татгалздаг учир нь тэд гарч ирээд дахиад л нөгөө үйлдлээ давтдаг” гэж шүүгч тодруулж хэлсэн.²⁴⁷

Захиргааны хариуцлагын тухай хуулиар гэр бүлийн хүчирхийлэл үйлдэгчид 2 төрлийн мөнгөн торгууль оногдуулдаг: Согтуурч танхайрсан үйлдэлдээ торгууль, эрүүлжүүлэх байранд хоносны төлбөр төлдөг. Нийтлэг нэгэн хэргийн талаар цагдаагийн ажилтан товч хуваалцсан:

“Хүчирхийлэл үйлдэгч согтуу гэртээ ирээд эхнэрээсээ архины мөнгө нэхэж, эсвэл хардаж зовоодог, сүүлдээ зодож эхэлнэ. Энэ хүчирхийлэл үргэлж давтагддаг.Эхнэрээ үргэлж зодно, цагдаад баригдана, торгуулийн мөнгө төлөөд л суллагдана. Хүчирхийлэл дахиад л давтагдана, баривчлагдана, суллагдана. дахиад л... дахиад”²⁴⁸

Торгуулийн мөнгө болон эрүүлжүүлэх байрны төлбөрийг хохирогч төлөхөөс аргагүй байдалд ордог. Энэ нь тухайн өрхийн орлогоос л гарна.²⁴⁹ “Ямар хүн эрүүлжүүлэх байранд хүргэгдсэн, ямар хүнд торгуулийн шийтгэл хүлээлгэснийг хэлэхэд хэцүү” гэж хуульч хэлсэн.²⁵⁰ Торгууль, төлбөртэй холбоотой хариуцлага хүлээлгэх механизм нь хохирогчийг давхар хохироодгоос тэд цагдаагийн байгууллагад дуудлага өгөхөөс татгалзахад хүргэдэг. Нэгэн нийгмийн ажилтан “эмэгтэйчүүд эрүүлжүүлэх байрны төлбөрийг төлөх ёстой болдог. Ийм учраас л тэд цагдаа дууддаггүй. Иймээс хүчирхийлэл үргэлжилсээр л байна. Хүчирхийллийн хэрэг хэзээ ч хаагддаггүй, үргэлжилсээр л байдаг.”²⁵¹

²⁴³ 222-223 хуудасны эх сурвалжыг харна уу.

²⁴⁴ Эрүүл мэндийн ажилтны ярилцлага, Э хот, 2013.3 -18, 13:30..

²⁴⁵ Цагдаагийн ажилтны ярилцлага, Ф хот, 2013.3 -21, 12:30. Нэгэн цагдаа хүчирхийлэл үйлдэгчийн хэрхэн 12 удаа баривчилсанаа тайлбарласан. Нөхрөө 12 удаа баривчлуусан эхнэр нь 7 хоноод л гаргаад авсан. Цагдаагийн ажилтны ярилцлага 1, Д хот, 2013 .3 -25, 12:00.

²⁴⁶ Цагдаагийн ажилтны ярилцлага, Ф хот, 2013. 3-21, 12:30

²⁴⁷ Шүүгчийн ярилцлага, Ф хот, 2013. 3 -22, 11:00

²⁴⁸ Цагдаагийн ажилтны ярилцлага, С хот, 2013. 3 -18, 11:00. Цагдаагийн ажилтны ярилцлага, Г хот, 2013. 3 -21, 12:00 (өнөөдөр архи уугаад, торгуульд 5000 төгрөг төлөөд чөлөөтэй болно гэж хууль хэлж байна).

²⁴⁹ Цагдаагийн ажилтны хийсэн ярилцлага, Э хот, 2013.3- 19, 14:30; Цагдаагийн жижүүрийн ярилцлага, Ф хот, 2013.3 - 12, 13:30;Хуульчийн ярилцлага, С хот, 2013.3-19, 9:00; Цагдаагийн ажилтны ярилцлага, Г хот, 2013. 3 -21, 12:00; Хуульчийн ярилцлага, С хот, 2013 .3-18, 9:00; Нийгмийн ажилтны ярилцлага, Э хот, 2013 .3-18, 12:00; Нийгмийн ажилтны ярилцлага, Д хот, 2013 .3 -27, 12:00; Эмч, нийгмийн ажилтны ярилцлага, С хот, 2013 .3 - 18, 1600; Хуулийн зөвлөхийн ярилцлага, Э хот, 2013 .3 -21, 10:00; Эрүүлжүүлэх байрны ажилтны ярилцлага, Ф хот, 2013 .3 - 21, 11:00.

²⁵⁰ Хуульчийн ярилцлага, С хот, 2013. 3 -18, 9:00.

²⁵¹ Нийгмийн ажилтны ярилцлага, Д хот, 2013. 3 -27, 12:00.

ЭРҮҮГИЙН ХУУЛЬ

Гэр бүлийн хүчирхийллийн хэрэгт эрүүгийн хэрэг үүсгэх, хариуцлага хүлээлгэхэд саад бэрхшээл дэндүү их. Засгийн газрын зүгээс энэ төрлийн хэрэгт анхаарал хандуулдаггүй, чимээгүй өнгөрдөг, шүүх хэзээ ч цуглуулж барамгүй нотолгоо шаарддаг, эвлэрүүлэх нэрээр хаацайлж өнгөрүүлдэг. Гэр бүлийн хүчирхийллийн хэргийг Эрүүгийн хуулиар шийдвэрлэхийн тулд маш олон шалгуурт нийцүүлэх ёстой болдог. Хамгийн түрүүнд, хохирогч хүчирхийллийн улмаас бэртэл гэмтэл авснаа шүүх эмнэлгийн дүгнэлтээр баталгаажуулах ёстой.²⁵² Хоёрдугаарт, эрүүгийн хэрэг үүсгэх эсэх цагдаагийн ажилтан шийдвэрлэнэ. Гуравдугаарт, уг шийдвэрийг прокурор батална.²⁵³ Ихэнх тохиолдолд хохирогчийн гомдол эрүүгийн журмаар шийдэгдэх шаардлагатай нь нотлогддог.²⁵⁴ Эцэст нь, хохирогч хүчирхийлэл үйлдэгчийн дарамт шахалтын улмаас гомдлоосоо буцаж, хэрэг хаагддаг. Дээрх бүх шаардлага, дарамт хохирогчийг залхахад хүргэж, эрүүгийн хариуцлага хүлээлгэх ажиллагаа үр дүнгүй болдог.

Шүүх эмнэлгийн дүгнэлт

Монгол улсын эрх зүйн тогтолцоонд хохирогч шүүх эмнэлгийн дүгнэлт олж авахад олон саад бэрхшээл туулдаг.²⁵⁵ Эрүүгийн байцаан шийтгэх хуулиар хохирогчийн биед учирсан гэмтлийн зэргийг тодорхойлохыг шаарддаг. Судалгаанд оролцогчид шүүх эмнэлгийн дүгнэлтгүй тохиолдолд эрүүгийн журмаар хэргийг шийдвэрлэх боломжгүйг баталсан.²⁵⁶ Шүүх эмнэлгийн мэргэжилтэн гэмтлийн зэргийг тодорхойлоход гол үүрэг гүйцэтгэдэг.²⁵⁷ Энэ практикийн талаар “Эхлээд хохирогч гомдол гаргах ёстой. Дараа нь хохирогчийг эмчийн дүгнэлт гаргуулахаар явуулдаг. Бүх төрлийн гэмтэл бэртэл, эрүүл мэндэд заналхийлсэн хэргүүдэд заавал шүүх эмнэлгийн дүгнэлт гаргуулах ёстой” гэж цагдаагийн ажилтан тайлбарласан”²⁵⁸

Дээр дурдсанчлан, шүүхээс иргэний журмаар эрх хязгаарлах шийдвэр гаргуулахын тулд шүүх эмнэлгийн дүгнэлт хэрэгтэй учраас хохирогч бэрхшээлтэй учирдаг.²⁵⁹ Хууль хэрэгжүүлэгчид хохирогчид шүүх эмнэлгийн дүгнэлтийг хэрхэн авах талаар чиглүүлж, мэдээлэл өгдөггүй нь хүндрэл болдог. Эхлээд хохирогч цагдаагийн байгууллагаас тогтоол эсвэл Нэг цэгийн үйлчилгээний төвөөс “шүүх эмнэлгийн дүгнэлт гаргуул” гэсэн холбон зуучлах бичиг авах

²⁵² Эрүүгийн байцаан шийтгэх тухай хууль, 156, 165.1.2 дугаар зүйл, Улсын яллагчийн ярилцлага, Б хот, 2013 .1 - 28, 15:40.

²⁵³ Улсын яллагчийн ярилцлага, Б хот, 2013 .1 -28, 15:40

²⁵⁴ Дээр дурдагдсан

²⁵⁵ Эрх хязгаарлах арга хэмжээнд тулгарч буй бэрхшээл – хэсгээс үзнэ үү.

²⁵⁶ Эрүүгийн байцаан шийтгэх тухай хууль, 156.1.2 дугаар зүйл, Цагдаагийн ажилтны ярилцлага, А хот, 2013 .3 -21, 11:30; Цагдаагийн ажилтны ярилцлага, Э хот, 2013 .3 -19, 12:30; Шүүгчийн ярилцлага, Э хот, 2013 .3 -18, 16:00; Цагдаагийн ажилтны ярилцлага 1, Д хот, 2013.3 -25, 12:00 (шүүх эмнэлгийн дүгнэлт авахын тулд стрессдсэн); Цагдаагийн ажилтны ярилцлага 1, Д хот, 2013 .3 -25, 10:00; Улсын яллагч ярилцлага, Б хот, 2013 .1 -28, 15:40

(Хөнгөн гэмтлийг захиргааны журмаар, дунд болон хүнд гэмтлийг эрүүгийн журмаар шийдвэрлэнэ); Прокурортой хийсэн ярилцлага, Э хот, 2013 .3 -21, 14:30.

²⁵⁷ Эрүүгийн байцаан шийтгэх тухай хууль, 156.1.2.дугаар зүйл, Цагдаагийн ажилтны ярилцлага, А хот, 2013. 3- 21, 11:30; Шүүгчийн ярилцлага, Э хот, 2013.3 -18, 9:00; Цагдаагийн ажилтны ярилцлага1, Д хот, 2013.3 -25, 10:00.

²⁵⁸ Цагдаагийн ажилтны ярилцлага 1, Д хот, 2013 .3-25, 10:00.

²⁵⁹ Иргэний журмаар эрх хязгаарлах арга хэмжээ хэсгээс үзнэ үү

ёстой.²⁶⁰ Энэ тогтоол, холбон зуучлах бичгийг авахын тулд хохирогч цагдаагийн байгууллага эсвэл Нэг цэгийн үйлчилгээний төв рүү удаа дараа очих хэрэгтэй болно.²⁶¹ Цагдаагийн ажилтан эхлээд хохирогчийн гэмтэл, бэртэл нь шүүх эмнэлгийн дүгнэлт гаргуулах хэмжээнд байгаа эсэхийг тогтоосны дараа тогтоол гаргадаг. Нөхөр нь эхнэрийнхээ хамрыг хугалсан байхад цагдаагийн ажилтан эхнэрт нь шүүх эмнэлэгт хандах талаар хэлж өгөөгүй, “хамар чинь зүгээр, хөнгөн гэмтэл байна” гэж хэлсэн талаар хохирогч эмэгтэй дурссан.²⁶²

Хэдийгээр хохирогч тогтоол болон холбон зуучлах маягт авсан ч шүүх эмнэлэгт хандахад дахиад л бэрхшээлтэй тулгарна. Гэр бүлийн хүчирхийлэлтэй харилцаанд олон жил амьдарсан хохирогч эмэгтэй шүүх эмнэлэг рүү шилжүүлсэн маягтыг авч олон удаа очсон ч бүтээгүй, эцэст нь Нэг цэгийн үйлчилгээний төвийн ажилтан хамт явж байж дүгнэлт гаргуулсан байна.²⁶³

Шүүх эмнэлгийн эмч нарт гэр бүлийн хүчирхийллийн хэргүүд дээр ажиллах цаг байдаггүй. Ажлын өдрүүдэд өглөө 8:00 цагаас өдөр 2:00 цаг хүртэл ажилладаг. Хэрвээ шүүх эмнэлэг хаасан бол ерөнхий эмч үзлэг, шинжилгээ, дүгнэлт гаргах боломжгүй. Энэ тохиолдолд шүүх эмнэлэг ажиллах хүртэл хохирогч хүлээх хэрэгтэй болдог.²⁶⁴

Хэрвээ хохирогч дээр дурдсанаас бусад шалтгааны улмаас шүүх эмнэлгийн дүгнэлт авч чадаагүй бол эрүүгийн хариуцлагад хүчирхийлэл үйлдэгчийг татах процесс удааширна. “Хохирогч шүүх эмнэлэгт хандахыг хүсэхгүй бол яах вэ” гэсэн асуултанд цагдаагийн ажилтан “ийм тохиолдолд цагдаагийн ажилтан юу ч хийх боломжгүй”²⁶⁵ гэж хариулсан.

Хариуцага хүлээлгэх шийдвэр: Захиргааны хариуцлага, эрүүгийн ял эсвэл шийтгэхгүй орхих

Хариуцлага хүлээлгэх шийдвэр гаргахад цагдаагийн ажилтан гол үүрэг гүйцэтгэдэг. Нотлох баримт бүрдүүлэхийн тулд шүүх эмнэлгийн ажилтан хохирогчийн бэртэл, гэмтлийн зэргийг тодорхойлно, цагдаагийн ажилтан хохирогчийг шүүх эмнэлэг рүү явуулах, хэргийг прокурорт шилжүүлэх эсвэл захиргааны арга хэмжээ авах эсэх шийдвэр гаргахад гол гарц болдог. Голдуу нүдэнд харагдахуйц гэмтэл учирсан үед л цагдаагийн ажилтан гэр бүлийн хүчирхийллийн хэргийг Эрүүгийн эсвэл Захиргааны хариуцлагын тухай хуулиар шийдвэрлэх эсэхийг шийддэг. Хариуцлага хүлээлгэх энэ аргачлал нь хөнгөн эсвэл нуугдмал гэмтэлд ялангуяа бэлгийн хүчирхийллийн хэрэгт²⁶⁶ үйлчлэхгүй, улмаар хүчирхийлэл давтагдахад хүргэдэг.²⁶⁷ Заримдаа гэр бүлийн хүчирхийллийн хэрэгт “ямар нэг нотлох баримт байхгүй” гэсэн шалтгаанаар цагдаагийн ажилтан хариуцлага тооцдоггүй.

²⁶⁰ Цагдаагийн ажилтны ярилцлага, А хот, 2013 .3 -22, 1430; Шүүх эмнэлгийн эмчийн ярилцлага, А хот, 2013 .3-22, 11:30. Нэг цэгийн үйлчилгээний төв дээр шүүх эмнэлгийн эмч ирж үйлчлэх ёстой ч практик дээр хэзээ ч хэрэгждэггүй. Сүвилагчийн ярилцлага, Д хот, 2013.1 -21, 10:00. Олон нийт хохирогчид нэг цэгийн үйлчилгээний тухай мэдээлэл, ойлголтгүй хэсгийг харна уу.

²⁶¹ Сүвилагчийн ярилцлага, Д хот, 2013.1 -21, 10:00..

²⁶² Хохирогчийн ярилцлага, Э хот, 2013.3- 22, 15:30.

²⁶³ Сүвилагчийн ярилцлага, Д хот, 2013. 1 -21,10:00. Нотлох баримт бүрдүүлэхэд тулгарч буй бэрхшээл хэсгийг харна уу

²⁶⁴ Шүүх эмнэлгийн эмчийн ярилцлага, А хот, 2013.3 - 22, 11:30.

²⁶⁵ Цагдаагийн ажилтны ярилцлага, Б хот, 2013.1 -30, 15:00.

²⁶⁶ ТББ-тай хийсэн ярилцлага, Ф хот, 2013 .3 - 21, 9:00 (Эмэгтэйн гэмтэл нь цагдаагийн ажилтан оролцохоор хүнд биш, гэрлэлт дэхь хүчинд өртсөн гэдгээ хэлсэн ч хүлээж аваагүй). .

²⁶⁷ Хүчирхийллийн тохиолдолд, Эрүүгийн хуулийн 100 дугаар зүйл, Тарчлаан зовоосон гэсэн зүйл ангиар шийтгэх ёстой.

Эрүүгийн хариуцлага нь тухайн бэртэл гэмтлийн зэргээс шалтгаална,²⁶⁸ гэмтэл бэртэлтэй тохиолдолд эрүүгийн хэрэг үүсгэнэ.²⁶⁹ Гэсэн ч цагдаагийн ажилтан заримдаа хохирогчид учирсан гэмтэл бэртэл хөнгөн эсвэл харагдахгүй байна гэсэн шалтгаанаар хүчирхийлэл үйлдэгчид ямар ч хариуцлага хүлээлгэдэггүй. “Хэрвээ бэртэл гэмтэл нь хөнгөн бол талуудыг хооронд нь эвлэрэхийг сануулаад өнгөрдөг” гэж нэгэн цагдаагийн ажилтан хэлсэн.²⁷⁰ Цагдаагийн байгууллагад тусламж эрж очсон нэгэн хохирогч мэдээлэхдээ:

“Хэрвээ би хүнд гэмтэл авсан бол нөхөрт маань эрүүгийн хэрэг үүсгэх эсвэл захиргааны хариуцлага хүлээлгэнэ. Гэвч миний гэмтэл ноцтой хэмжээнд биш байгаа учраас ямар ч арга хэмжээ авахгүй. Учир нь гэмтэл байхгүй гэсэн шалтгаанаар цагдаа юу ч хийхгүй”²⁷¹

“Гэмтэл бэртлийн зэргийг үл харгалзан ноцтой хэргүүд дээр эрүүгийн хэрэг үүсгэх, захиргааны хариуцлага хүлээлгэх шийдвэр гаргадаг” гэж цагдаагийн ажилтан хэлсэн. Тэрээр ихэнх хэргүүд ямар дүр зурагтай байдаг талаар тайлбар өгсөн:

“Дуудлагаар очсон ч тэд гэр бүлийн асуудлаа олон нийтэд дэлгэхийг хүсдэггүй. . . Ихэнх тохиолдолд хохирогч өргөдөл, гомдлоо эргүүлэн авдаг. Харин тухайн хэрэг ноцтой бол хохирогч хуулийн байгууллагаар явдаг”²⁷²

“Энэ манай шийдэх асуудал биш, та нар гэртээ л шийдэх асуудал” гэж цагдаагийн ажилтан нэгэн эмэгтэйд хэлсэн талаар дор дурдсан байгаа.²⁷³

Гэр бүлийн хүчирхийллийн хэрэг ноцтой байдалд хүрч хохирогч хүнд бэртэл гэмтэл авсан ч Эрүүгийн хуулийн дагуу ял хүлээлгэхгүйгээр Захиргааны хариуцлагын тухай хуулиар хариуцлага тооцсоор байна.²⁷⁴ Өнгөрсөн 2 жилийн хугацаанд гэр бүлийн хүчирхийллийн 6-7 хэргийг л прокурорт шилжүүлсэн тухай цагдаагийн ажилтан мэдээлсэн.²⁷⁵

Хэдийгээр Захиргааны хариуцлагын тухай хуулиар зөрчлийн шинжтэй хэргийг шийдвэрлэдэг ч зарим хүнд гэмтэл учирсан хэргүүд дээр ч энэ хуулийг хэрэглэж байгааг судлаачид ярилцлагын үеэр олж мэдсэн. Олон нийтийн газар эхнэрээ зодсоны улмаас “танхайрсан” хэргээр 21 хоног баривчлагдаад гарсан хүчирхийлэл үйлдэгчийн тухай нийгмийн ажилтан тайлбарлахдаа:

“Нөхөр нь эхнэрийнхээ үснээс зулгааж, алгадаж, өшиглөж унагааж байгаад зодож нүдсэн. Тэр үед эхнэр нь 2 сартай жирэмсэн байсан. ...Эмэгтэйн хамар хугарч, нүд нь хөхөрч, доголсон байсан. Гудамжинд эхнэрээ зодож, зугтахаар нь араас нь хөөн очиж зодож байсан”²⁷⁶

²⁶⁸ Эрүүгийн байцаан шийтгэх тухай хууль, 156, 165.1.2. дугаар зүйл

²⁶⁹ Цагдаагийн жижүүрийн ярилцлага, Ф хот, 2013.3-21, 13:30

²⁷⁰ Цагдаагийн байцаагчийн ярилцлага, Э хот, 2013.3 -19, 12:30

²⁷¹ Хохирогчийн ярилцлага, Ф хот, 2013.3 -22, 9:00. Энэ хохирогчийн түүхийг 12, 13, 17, 28, 35, 36 болон 54 хуудсанд иш татсан.

²⁷² Цагдаагийн ажилтны ярилцлага, Э хот, 2013.3 -22, 14:00

²⁷³ Хохирогчийн ярилцлага, Ф хот, 2013.3 -22, 900. Энэ хохирогчийн түүх 12, 13, 17, 28, 35, 36 болон 54 хуудсанд иш татсан.

²⁷⁴ Цагдаагийн байцаагчтай хийсэн ярилцлага, Э хот, 2013.3 -19, 12:30.

²⁷⁵ Дээр дурдагдсан.

²⁷⁶ Нийгмийн ажилтны ярилцлага, Д хот, 2013.3 -27, 12:00.

Захиргааны хариуцлагын үр дүнгүй байдлаас шалтгаалан дуудлага өгч баривчлуулсан хүнийхээ амь насанд халдах, заналхийлэх явдал ихэсч байна. Нэгэн хохирогчтой хамт ажилладаг эмэгтэй “тэр эмэгтэйн гар, нүд нь байнга хөхөрсөн, түүнийгээ нуухаар нарны шил зүүж ирдэг. Түүний нөхөр нь байнга л утсаар залгаж “чи намайг хүнд байдалд оруулсан учраас, би чамайг ална, би чиний амьдралыг үгүй болгоно, чамайг шатаана...” гэж дарамталдаг байсан. Түүний биед хөхрөлт, шарх сорви үзэгдэх нь нэмэгдэх тэр мөчид цагдаа нөхөрт нь захиргааны арга хэмжээ авч 21 хоног баривчилдаг байсан” гэж хэлсэн.²⁷⁷

Заримдаа эрүүгийн хариуцлага хүлээлгэхэд хүчирхийлэлтэй харилцааны түүх хангалтгүй гэж үздэг.²⁷⁸ Нөхрийнхөө байнгын хүчирхийлэл, дарамтанд, “амь насыг чинь хөнөөнөө” гэсэн заналхийлэл дор 9 жилийн турш амьдарч байсан хохирогч эмэгтэй ярихдаа:

“Тэр ямар нэг зэвсэг хэрэглэдэггүй ч гар доор нь хамгийн ойрхон байгаа эд зүйлсийг над руу байнга л шидэлдэг байсан. Миний биед ихэнхдээ хөнгөн гэмтэл, шарх сорви үлдээдэг. . . . Тэр намайг үргэлж дагаж байдаг, хэзээ ч амь насыг чинь хороож чадна гэж дарамталдаг байсан. Тэр үргэлж л над руу утасдаж, үг хэлээр доромжилж, байнга айдас дарамтанд оруулдаг. Анх удаа цагдаа дуудахад, нөхөр маань согтуу байсан. Цагдаа ирээд түүнийг эрүүлжүүлэх байр луу авч явсан. Маргааш нь би өргөдлөө буцааж, түүнийг суллаж авсан, учир нь бид 2 хамт амьдардаг байсан, бас түүнийг өөрчлөгдөнөө гэж итгэдэг байсан. Энэ бүхэн их удаан үргэлжилсэн. Яг ийм тохиолдол хэдэн удаа болсныг би сайн санахгүй байна.”²⁷⁹

Бараг жилийн өмнө эрх хязгаарлах арга хэмжээ авахуулсан хүчирхийлэл үйлдэгч хүчирхийллээ үргэлжлүүлсээр, эхнэрээ гэртээ цоожилсон хэрэг бүртгэгдсэн. Энэ үйлдэлд нь зөвхөн захиргааны хариуцлагын хуулийн дагуу хүчирхийлэл үйлдэгчид арга хэмжээ авсан.²⁸⁰

Тухайн хэрэгт захиргааны хариуцлага хүлээлгэх, эсвэл Эрүүгийн хуулийн дагуу шийдвэрлэх эсэхэд хохирогч нөлөөлөх боломжтой.²⁸¹ Учир нь хохирогч эрүүгийн хэрэг үүсгэхийг зөвшөөрөхгүй, үргэлжлүүлэхийг татгалзсан.”²⁸²

Эрүүгийн хэрэг үүсгэсэн ч хохирогч хүссэн, бас хүчирхийлэл үйлдэгч буруугаа хүлээх, эсвэл талууд эвлэрсэн тохиолдолд захиргааны хариуцлагаар солих боломжтой.²⁸³ Тухайн хэрэг

²⁷⁷ Цагдаагийн ажилтны ярилцлага, А хот, 2013.3- 27, 14:30.

²⁷⁸ Эрүүгийн хуулийн 100 дугаар зүйл ангиар (эрүүдэн шүүх, тарчлаах).

²⁷⁹ Хохирогчийн ярилцлага, Ф хот, 2013. 3 -22, 9:00. Энэ түүхийг 5, 10, 29, 44, 49 хуудсанд иш татсан.

²⁸⁰ Дээр дурдагдсан.

²⁸¹ Шүүгчийн ярилцлага, С хот, 2013. 3 - 18, 14:00 (ямар хуулийн хариуцлага оногдуулахыг мэдэхгүй ч цагдаад ханддаг); Хохирогчийн ярилцлага, Ф хот, 2013. 3 -22, 9:00. Энэ түүхийг 5, 10, 29, 44, 49 хуудсанд иш татсан.

²⁸² Цагдаагийн ажилтны ярилцлага1, Д хот, 2013. 3 - 25, 10:00. Хүүхдийн байцаагч, Э хот, 2013. 3 - 21,11:00 (“шөнө бүр нөхөр нь согтуу ирж эхнэр хүүхдээ зодоод гудамжинд хөөж гаргадаг. Эхнэрийнх нь хүсэлтээр захиргааны хариуцлага оногдуулсан. Хэрвээ нөхөрт нь хохих ял оногдуулбал гэр бүл нь эдийн засгийн хувьд хүнд байдалд орно гэж хэлсэн.”). Захиргааны хариуцлагын тухай хуулийг харах танхайрах гэсэн хэсгийг харах

²⁸³ Улсын яллагчтай хийсэн ярилцлага, Б хот, 2013. 1 - 28, 15:40. Хохирогч хүчирхийлэл үйлдэгчийн шахалт, дарамт дор эвлэрэх ёсгүй.Прокурорын ярилцлага,Д хот, 2013. 2 - 1, 14:00.

ноцтой байсан ч хохирогч гомдлоос татгалзвал хэргийг шүүд хааж, захиргааны хариуцлагын арга хэмжээ авахуулахаар шүүх рүү шилжүүлнэ.”²⁸⁴

Прокурор эрүүгийн хэрэг үүсгэх, хариуцлага хүлээлгэхээс татгалзах нь

Цагдаагийн ажилтан гэр бүлийн хүчирхийллийн хэрэгт эрүүгийн хэрэг үүсгүүлэхээр прокурорт шилжүүлсэн ч прокурор ихэнхдээ татгалздаг.²⁸⁵ Прокурор хэд хэдэн шалтгааны улмаас хэргийг хэрэгсэхгүй болгодог. Хэрвээ хохирогчид учирсан гэмтэл, бэртэл нь хөнгөн бол прокурор хэргийг шүүд хаах боломжтой.²⁸⁶ Нэгэн тохиолдол: нөхөр нь эхнэрээ хутгалсан. Гэтэл шүүх эмнэлгийн дүгнэлтээр гэмтлийн зэрэг нь хөнгөн гарсан. Талууд эвлэрэх боломжгүй учраас цагдаагийн ажилтан хэргийг прокурорт шилжүүлсэн. Прокурор хөнгөн гэмт хэрэг гэж үзээд, хэргийг үргэлжлүүлэхээс татгалзсан. Эцэст нь тэд гэрлэлтээ цуцлуулсан.²⁸⁷

Эрүүгийн хуулиар бусдыг дагаж мөшгих нь гэмт хэрэг биш учраас ийм тохиолдолд ял шийтгэл хүлээдэггүй. Дагаж мөрдөхийг гэмт хэрэгт тооцох нь хохирогчдыг хамгаалахад төдийгүй тэдэнд үйлчилгээ үзүүлдэг ажилтнуудыг хамгаалах ач холбогдолтой.²⁸⁸ Нөхөр нь эхнэрийнхээ үснээс зулгааж, алгадаж, өшиглөж, унагааж байгаад зодож нүдсэн. Тэр үед эхнэр нь 2 сартай жирэмсэн байсан. ...Эмэгтэйн хамар хугарч, нүд нь хөхөрч, доголсон байсан. Гудамжинд эхнэрээ зодоод, зугтахаар нь араас нь хөөн очиж зодож байсан. Энэ талаар судалгаанд ярилцлага өгөгч дурсан ярьсан:

“Нөхөр нь эхнэрээ ажлаасаа гэр лүүгээ явах замд нь дагаж мөрддөг байсан, харин цагдаа түүнийг баривчилсан. Эмэгтэй автобусны буудлаас хамаатных руугаа явахад нарийн гудамжаар гардаг байсан, тэнд нөхөр нь байнга отоод байж байдаг”²⁸⁹

Нөхөр нь зодож, дагаж мөрддөг гэж хохирогч гомдол гаргасан. Цагдаагийн ажилтан нөхрийг нь Захиргааны хариуцлагын тухай хуулиар танхайрсан гэж 21 хоног баривчилсан, гэхдээ нөхөрт нь дагаж мөрдсөнийх нь төлөө шийтгэл хүлээлгэсэн эсэх нь тодорхойгүй.²⁹⁰

Дээрх цагдаа, прокурорын нэгэн адил хуулийн байгууллагын ажилтнуудын ихэнх нь гэр бүлийн хүчирхийллийн хэргийг шийдвэрлэхдээ гэмтэл бэртэл, эрсдэлд анхаарал хандуулахаас илүү гэр бүлийн бүрэн бүтэн байдлыг анхаарч байна. “Эмэгтэйчүүдийг нөхөртэйгээ битгий тэмцэлд, энэ бүхэн үргэлжлээд байвал талхны мөнгө олж ирдэг хүн чинь шоронд явах болно” гэж хэлдгээ нэгэн прокурор хүлээн зөвшөөрсөн.²⁹¹

²⁸⁴ Улсын яллагчтай хийсэн ярилцлага, Б хот, 2013. 1 -28, 15:40.

²⁸⁵ Прокурорын ярилцлага, Д хот, 2013. 2 - 22, 1400; Прокурорын ярилцлага 2, 2013.3-18. 9:00 (цагдаагийн ажилтны саналыг прокурор зөвшөөрөхгүй бол, хэргийг мөрдөн байцаалтанд буцаадаг).

²⁸⁶ Сумын шүүгчийн ярилцлага, Э хот, 2013. 3 -18, 15:30

²⁸⁷ Цагдаагийн ажилтны ярилцлага, Э хот, 2013. 3 -22, 15:00

²⁸⁸ ТББ -ын хоёр ажилтан хүчирхийлэл үйлдэгч дагаж мөшгисөн талаар мэдээлсэн ТББ-ын ярилцлага, Д хот, 2013. 2 -1,10:30.

²⁸⁹ Нийгмийн ажилтны ярилцлага, Д хот, 2013. 3 -27, 12:00

²⁹⁰ Дээр дурдагдсан.

²⁹¹ Прокурорын яриа, 1, Э хот, 3 -18, 2013. 9:30.

*“Хамгийн чухал нь эрчүүд гэр бүлээ тэжээж байдаг. . . . Хэргийг хэрэгсэхгүй болгож байгаа нь хохирогчид. Хэрвээ энэ асуудал олон удаа давтагдвал нөхөр чинь шоронд явах болно, тэгэхээр гэр бүлээ бүрэн бүтнээр нь авч үлд” гэж хэлдэг.*²⁹²

Өөр нэг прокурор хохирогч эмэгтэйчүүд хүчирхийллийг дэвэргэдэг гэж буруутгаж ярьсан:

*“Эхнэрүүд л асуудал, зөрчилдөөнийг бий болгодог. Яллагдагч этгээд тэдний эхнэрүүд үргэлж үг хэлээр дайрч давшилж байдаг тухай хэлдэг. Эхнэрүүд нөхрийгөө үргэлж өр ширэнд оруулж, шахалт үзүүлж байдаг. Миний ажиллаж байсан хэргийн яллагдагч нарын дунд ийм асуудал нийтлэг байсан”*²⁹³

“Маш хүнд хэлбэрийн хүчирхийлэл зөвхөн эрчүүдийн дунд л болдог” гэж прокурор хэлсэн. “Монгол улсад нөхөр нь эхнэрээ маш хүнд бэртээж гэмтээсэн хэрэг байдаггүй, энэ талаар би харж, сонсож байгаагүй” гэж мэдээлсэн. Гэвч нөхөртөө нүдээ цөм цохиулж, нүүр нь шарх сорвитой болсон эмэгтэйн тухай нэмж ярьсан. Харин төгсгөлд нь “энэ эмэгтэй тийм ч аюултай байдалд ороогүй, талууд согтуу байсан учраас зүгээр маргаан л байсан” гэж дүгнэж хэлсэн.²⁹⁴

Дээр дурдсанчлан нотлох баримт хангалтгүй, шүүх эмнэлгийн дүгнэлт байхгүй учраас прокурор шийтгэл оногдуулдаггүй. “Эмэгтэйчүүд хүчирхийлэл олон давтагддаг гэж мэдүүлдэг ч баримт байдаггүй. Иймд эрүүгийн хэрэг үүсгэх боломжгүй” гэж прокурор тайлбарласан.²⁹⁵

“Хохирогч хүчирхийлэл үйлдэгчийг шоронд явуулахыг хүсдэггүй нь прокурорын шийдвэрт нөлөөлдөг” гэж цагдаагийн ажилтан хэлсэн.²⁹⁶ Хохирогч хүчирхийлэл үйлдэгчээс айсан, дарамт шахалтанд орсон, эсвэл шоронгоос гарч ирснийхээ дараа өсөрхөхөөс айж байгаад нь анхаарал хандуулдаггүй байна. Хохирогч нөхөртөө зодуулсны дараа “гомдолгүй” гэж мэдүүлснээр прокурор хэргийг хэрхэн хэрэгсэхгүй болгосон тухай тайлбарлахдаа:

*“Хэрвээ би гомдолтой гэж хэлсэн бол хөнгөн гэмт хэрэг учраас түүнийг 6 сар хүртэл хорих байсан. Би маш их айсан учраас түүнийг шоронд явуулаагүй, гомдлоосоо татгалзсан. Учир нь тэр 6 сарын дараа суллагдахад, хэн намайг хамгаалах юм бэ?”*²⁹⁷

“Монголчууд нөхрөө шоронд явуулахыг хүсдэггүй учраас гэр бүлийн хүчирхийллийн маш цөөн хэрэгт эрүүгийн хариуцлага оногдуулдаг” гэж цагдаагийн ажилтан дүгнэж хэлсэн.²⁹⁸

²⁹² Дээр дурдагдсан

²⁹³ Улсын яллагчийн ярилцлага, Б хот, 2013.1 - 28, 15:40

²⁹⁴ Прокурорын ярилцлага 1, Э хот, 2013. 3 -18, 9:30.

²⁹⁵ Прокурорын ярилцлага, Э хот, 2013. 3 - 21, 14:30

²⁹⁶ Улсын яллагчийн ярилцлага, Б хот, 2013. 1- 28, 15:40

²⁹⁷ Хохирогчийн ярилцлага, А хот, 2013. 3 -22 15:30

²⁹⁸ Эрүүлжүүлэх байр, Ф хот, 2013.3 -21,11:00

Эвлэрүүлэх, гомдлыг хэрэгсэхгүй болгох

Монголын цагдаа, прокурор, шүүгч нарын зүгээс хохирогч, хүчирхийлэл үйлдэгчдийг хооронд нь эвлэрүүлэхийг дэмждэг, дараа нь хэргийг хаадаг. Энэ нөхцөл байдал нь олон нийт болон хохирогч, хүчирхийлэл үйлдэгч нарт “гэр бүлийн хүчирхийлэл бол ноцтой асуудал биш” гэсэн сөрөг ойлголт өгч байна. Судалгаанд ярилцлага өгөгчид “талуудыг эвлэрүүлэх нь төрийн албан хаагчдын хандлагаас үүссэн үр дүн” гэдэгтэй санал нэг байгаагаа илэрхийлсэн. “Манай аймагт гарсан нийт 8 хэрэгт талууд бүгд л эвлэрсэн, тэгэхээр ямар ч хэрэг над дээр шийдвэрлэгдээгүй” гэж прокурор хэлж байсан.²⁹⁹

Гэр бүлийн хүчирхийллийн хэрэгт талуудыг эвлэрүүлээд орхих нь нийтлэг үзэгдэл болсон.³⁰⁰ “Нийт арван хохирогчийн найм нь хүчирхийлэл үйлдэгчтэй эвлэрдэг” гэж цагдаагийн ажилтан хэлсэн³⁰¹. Өөр нэг цагдаагийн ажилтан хэлэхдээ:

“Үнэндээ тухайн хэрэг гарсан тохиолдол бүрт л хүчирхийлэл үйлдэгчид шийтгэл оногдуулах ёстой, гэвч маш цөөхөн хэрэгт л хариуцлага хүлээлгэдэг. Ихэнх тохиолдолд хохирогч хүчирхийлэл үйлдэгчтэй эвлэрдэг эсвэл гомдлоосоо татгалздаг”³⁰²

Төрийн албан хаагчдын шахалтаар хохирогч хүчирхийлэл үйлдэгчтэй эвлэрдэг. Үүний зэрэгцээ өөр бусад шалтгаан ч бас байдаг, тухайлбал эдийн засгийн хараат байдал³⁰³ үр хүүхдээ өнчрүүлэхгүй гэсэн хүсэл,³⁰⁴ нөхрөө шийтгэхээс халшрах,³⁰⁵ дарамт хүчирхийлэл давтагдахаас айх айдас³⁰⁶

Хөнгөн хэрэг дээр хохирогч болон гэмт хэрэгтэн хоорондоо эвлэрсэн, гэмт хэрэгтэн буруу зүйл хийснээ ухамсарласан тохиолдолд Эрүүгийн болон Эрүүгийн байцаан шийтгэх тухай хуулиар хэргийг хэрэгсэхгүй болгодог.³⁰⁷ Гэтэл, хуулийн энэ зүйл заалтыг гэр бүлийн

²⁹⁹ Прокурорын ярилцлага, Э хот, 2013. 3 -18, 9:30. Прокурорын ярилцлага, Э хот, 2013. 3 - 21, 14:30 (талууд эвлэрсэн бол хэргийг цааш нь шийдвэрлэхгүй); Прокурорын ярилцлага, Э хот, 2013. 3 -18, 9:30 (талууд эвлэрэхийг хүсвэл бид тэднийг хүсэлтээ гаргахыг шаарддаг).

³⁰⁰ Прокурорын ярилцлага, Э хот, 2013. 3 -18, 9:30; Цагдаагийн ажилтны ярилцлага, А хот, 2013. 3 -22, 14:30; Цагдаагийн ажилтны ярилцлага, А хот, 2013. 3 -25, 10:00; Цагдаагийн ажилтны ярилцлага, А хот, 2013. 3 - 22, 11:30; Цагдаагийн ярилцлага, А хот, 2013. 3 -25, 12:00; Цагдаагийн ажилтны ярилцлага, А хот, 2013. 3 -25, 10:00; Цагдаагийн ажилтны ярилцлага, А хот, 2013. 3 - 22, 15:00; Хүүхдийн байцаагч, Г хот, 2013. 3 - 21, 11:00; Цагдаагийн ажилтны ярилцлага, А хот, 2013. 3 -19, 12:30; Прокурорын ярилцлага, Д хот, 2013. 3 -28 14:00; Прокурорын ярилцлага, С хот, 2013. 3 -19,14:00; Шүүгчийн ярилцлага,С хот, 2013. 3 -18, 14:00; Сумын шүүгч, Э хот, 2013. 3 -18, 15:30; Прокурорын ярилцлага 2, Э хот, 2013. 3 -18, 9:30; Прокурорын ярилцлага, Э хот, 2013. 3 - 18, 9:00; Прокурорын ярилцлага, Г хот, 2013. 3 -21,14:30; Сумын цагдаагийн ажилтан, Э хот, 2013. 3 -19, 15:30.

³⁰¹ Цагдаагийн ярилцлага, А хот, 2013. 3 - 25, 2013. 12:00.

³⁰² Цагдаагийн ярилцлага, А хот, 2013. 3 -19, 12:30.

³⁰³ Дээр дурдагдсан; Прокурорын ярилцлага, Д хот, 2013. 3 - 28, 14:00; Хүүхдийн байцаагчийн ярилцлага, Г хот, 2013. 3 12, 11:00; Цагдаагийн ярилцлага, А хот, 2013. 3 -19, 2013. 15:00.

³⁰⁴ Прокурорын ярилцлага, С хот, 2013. 3 -19,14:00; Нийгмийн ажилтны ярилцлага, Д хот, 2013.3 -27, 14:00; Сургуулийн нийгмийн ажилтны ярилцлага, Э хот, 2013. 3 -18,11:00

³⁰⁵ Шүүгчийн ярилцлага, С хот, 2013. 3 -28, 14:00.

³⁰⁶ Хохирогчийн ярилцлага, А хот, 2013. 3 -22,15:30

³⁰⁷ Эрүүгийн байцаан шийтгэх тухай хууль 25.1 дугаар зүйл: Яллагдагч, шүүгдэгч нь Эрүүгийн хуульд заасан хөнгөн гэмт хэргийг анх удаа үйлдсэн бөгөөд учруулсан хохирлоо бүрэн төлсөн, гэм хорыг арилгасан нөхцөлд хохирогч нь яллагдагч, шүүгдэгчтэй сайн дураараа эвлэрсэн бол хэргийг хэрэгсэхгүй болгоно

хүчирхийллийн үлмаас хөнгөн гэмтэл учруулсан гэж хэргийг хаахад ашиглаж байна.³⁰⁸ Талууд эвлэрсэн гэсэн шалтгаанаар зарим нэг ноцтой хэргийг, хүнд хэлбэрийн гэмтэл учруулсан байсан ч хуулийн хариуцлага хүлээлгэхгүй орхигдуулсаар байна.

“Зөвхөн хөнгөн гэмтэл учруулсан хэрэгт л хохирогч хүчирхийлэл үйлдэгчтэй эвлэрснээр хаадаг, харин хүнд гэмтэл учруулсан хэргийг хохирогчтой зөвлөлдөхгүй, шууд л хуулийн дагуу арга хэмжээ авахаар шийддэг гэж цагдаагийн ажилтан хэлсэн.³⁰⁹ Судалгааны баг нь “эвлэрсэн” гэх хэргүүдийн талаар сонссон ба хүнд гэмтэл авсан, хүйтэн зэвсэг хэрэглэсэн эсвэл эрүүгийн гэмт хэрэгтэй холбоотой хэргүүдийг цагдаагийн ажилтан, прокуророос “эвлэрсэн” гэсэн шалтгаанаар хаасан байдаг. Нэгэн хохирогчийн нөхөр нь өөр нэг эрэгтэйд гэмтэл учруулж, бас эхнэрийнхээ хамрыг хугалсан байна. Гэвч прокурорт тэр эмэгтэй “ямар ч гомдолгүй” гэж хэлээд хэргийг хаалгасан байна.³¹⁰

Цагдаагийн ажилтан болон прокурор нь зэвсэг хэрэглэсэн хүчирхийлэл үйлдэгчийн хэргийг ч хааж байсан. Тухайлбал, нөхөр нь галын хайчаар эхнэрээ зодсон байна. Эрүүгийн хэрэг үүсч, шүүх эмнэлэг “гэмтлийн зэрэг нь хөнгөн” гэсэн дүгнэлт гаргасан. Хосууд эвлэрсэн л бол цагдаагийн ажилтан тухайн хэргийг хэрэгсэхгүй болгодог.³¹¹ Өөр нэг тохиолдол: найз эмэгтэйтэй гадуур зугаацсан гэж түүний найз залуу толгой руу нь модоор цохиж зодсон. Хохирогч цагдаад дуудлага өгсөн боловч хосууд өөрсдөө гомдлоосоо татгалзахыг хүсэж байгааг залуугийн ар гэрийнхэн ирж хэлсэн. Шүүгч хохирогчид “Ийм өчүүхэн зүйл дээр асуудал үүсгээд, бид ч энэ хэргийг цааш нь үргэлжлүүлэхийг хүсэхгүй байна” гэж хэлсэн.³¹²

Судалгаанд ярилцлага өгөгчид хэргийг “талууд эвлэрсэн” гэсэн үндэслэлээр хааж байгаад санаа зовж байгаагаа илэрхийлж байсан.³¹³

*“Миний эгч 18 настайдаа гэрлэж, 23 нас хүртлээ өдөр бүр гэр бүлийн хүчирхийлэлтэй харилцаанд амьдарсан. Манай гэр бүл 4 хүүтэй, эгч маань нөхөртөө зодуулах бүрт бид бүгдээрээ очоод л нөхрийг нь зоддог. . . . бид олон ч удаа цагдаад байцаалт өгөх гэж очиж байсан. Энэ хугацаанд тэд аль хэдийн 3 хүүхэдтэй болсон байсан. Нөхрийг нь олон ч удаа цагдаад өгч байсан ч эгч маань өргөдлөө буцаадаг байсан. Эгч маань гомдлоо бараг 7-8 удаа буцааж байсныг санаж байна. Эцэст нь эгч хамгаалах байранд очсон, бид энэ асуудал хууль, шүүхийн дагуу шийдэгдэх ёстой гэж үзсэн” гэж дүү нь хуваалцсан.*³¹⁴

³⁰⁸ 99 дугаар зүйл.

³⁰⁹ Сумын цагдаагийн ярилцлага, Э хот, 2013. 3 -19, 15:30

³¹⁰ Хохирогчийн ярилцлага, А хот, 2013. 3 -22, 15:30.

³¹¹ Цагдаагийн ажилтны ярилцлага 2, Д хот, 2013. 3 - 25, 12:00

³¹² Сумын шүүгчийн ярилцлага, Э хот, 2013. 3 -18, 15:30

³¹³ Сумын цагдаагийн ажилтны ярилцлага, Э хот, 2013. 3 - 19, 15:30. Судалгаанд оролцогч, байнгын хүчирхийллийг тарчлаан зовоосон гэж яллахаас татгалзаж, хүнд гэмт хэрэг байсан ч эвлэрсэн гэсэн үндэслэлээр хэргийг хэрэгсэхгүй болгохыг дэмжиж байгаагаа илэрхийлсэн байж магадгүй.

³¹⁴ Нийгмийн ажилтны ярилцлага, Д хот, 2013. 3 -27, 14:00.

“Эгч маань эх орноо орхин, Бельги улс руу орогнол хүсэхээр аргагүйн эрхэнд явсан” гэж тэр нэмж хэлсэн.³¹⁵

Хохирогчид ихэнх тохиолдолд өргөдөл, гомдлоо буцаадаг.³¹⁶ “Тухайн хохирогч хүчирхийлэл үйлдэгчийн дарамт, шахалтаар гомдлоо эргүүлэн татаж байгааг шалгах ёстой байдаг” гэж прокурор хэлсэн.³¹⁷ Гэвч хүчирхийлэл үйлдэгчийн дарамт, шахалт дор гомдлоо эргүүлэн татсанаар хаагдсан олон хэргийн тухай судлаачид ярилцлагын үеэр олж сонссон. Нэгэн тохиолдол: нөхөр нь хөрш айлын хүн охиныг хүчиндсэн гэж хэлэхийг шаардаж эхнэр, дагавар охиноо зодсон байдаг. Улмаар охин нь өөрийг нь хүчиндсэн хүнтэй хайр сэтгэлийн холбоотой гэж хэлж гомдлоосоо татгалзсан.³¹⁸ Хүчирхийлэл үйлдэгч нарын зүгээс хохирогчийг гомдлоо эргүүлэн татах хүртэл дарамталдаг. Нэгэн хүчирхийлэл үйлдэгчид эхнэрийнхээ хавиргыг хугалсан үйлдэлд нь эрүүгийн хэрэг үүсгэсэн. Тэр эхнэрийнхээ ээж, аав дээр байнга очиж, “хэрвээ би шоронд орох юм бол хураасан мөнгөө нар нарт өгөхгүй” гэж дарамталсан байдаг.³¹⁹

Хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын ажиллагааны явцад аюулгүй байдалд нь анхаардаггүй учраас хохирогчид гомдлоосоо татгалзахад хүрдэг.³²⁰ Энэ талаар “Хохирогчид айдастай байдаг, маш цөөхөн хоногийн дотор л тэд гомдлоо эргүүлэн татдаг” гэж нэгэн прокурор ажиглалтаа хуваалцсан.³²¹

“Хохирогчийн аюулгүй байдлыг хангах хууль байдаггүй. Монгол улсад энэ том асуудал болдог. Мэдүүлэг өгөх үед үед хохирогчийг хамгаалах боломж байдаггүй учраас тэд гомдлоосоо татгалздаг. Ингээд хэргийг шийдвэрлэхэд бэрхшээл тулгардаг. Хохирогчоор үнэн зөв мэдүүлэг өгүүлэхийн тулд тэдний аюулгүйн төлөвлөлтийг хийх нь маш чухал асуудал юм. Мөрдөн байцаах ажиллагааны үеэр хохирогчийг хамгаалах байранд байрлуулах эсвэл хамгаалалтанд авах зохицуулалтыг бий болгосноор хүчирхийлэл үйлдэгчээс ирэх заналхийлэл буурах болно” гэж өөр нэг прокурор тайлбарласан.³²²

Хохирогчоос мэдүүлэг авах шаардлага

Монгол улсад хөнгөн хэрэгт хэргийг талууд эвлэрснээр хэрэгсэхгүй болгон хааж болдог.³²³ Ялангуяа бэртэл гэмтэл нь хөнгөн, анх удаа гэмт хэрэг үйлдсэн, эсвэл хохирогч мэдүүлэг өгөхөөс татгалзсан бол хэргийг хаахад хүрдэг.³²⁴

³¹⁵ Дээр дурдагдсан.

³¹⁶ Хүүхдийн эрхийг хамгаалагч, 2013. 3 -22, 9:30; Нийгмийн ажилтан, Э хот, 2013. 3 -18, 12:00; Хамгаалах байрны сэтгэл зүйч, Д хот, 2013. 3 -23, 11:30.

³¹⁷ Улсын яллагчийн ярилцлага, Б хот, 2013. 1 -28, 15:40.

³¹⁸ Нийгмийн ажилтны ярилцлага, Э хот, 2013. 3 -18, 12:00

³¹⁹ Хамгаалах байрны сэтгэл зүйч, Д хот, 2013. 3 - 26, 11:30.

³²⁰ Хуульчийн ярилцлага, С хот, 2013. 3 - 18,900; Прокурорын ярилцлага, Д хот, 2013. 3 -28,14:00; Прокурорын ярилцлага, Г хот, 2013. 3 - 21, 14:30.

³²¹ Прокурорын ярилцлага, Д хот, 2013. 3 - 28,1400; Прокурорын ярилцлага, Ф хот, 2013. 3 - 22,16:30 (Шүүх тэнхимийн гадна талд хүчирхийлэл үйлдэгч дарамт үзүүлдэг).

³²² Прокурорын ярилцлага 1, Э хот, 2013. 3 -18, 9:30.

³²³ Дээр дурдагдсан. Прокурорын ярилцлага, Г хот, 2013. 3 - 21, 14:30

³²⁴ Шүүгчийн ярилцлага, Э хот, 2013.3 - 18, 16:00.

Хохирогч хүчирхийлэл үйлдэгчийн эсрэг мэдүүлэг өгснөөр тухайн хэрэгт эрүүгийн хариуцлага хүлээлгэх боломж бүрдэнэ. Хохирогч хүчирхийлэл үйлдэгчийн эсрэг мэдүүлэг өгсөн тохиолдолд хүчирхийлэл үйлдэгчийг “хөнгөн гэмтэл учруулсан” гэх үндэслэлээр гурван сар хүртэл хорих ялаар шийтгэнэ.³²⁵

*“Эмэгтэйг хаалгаар дөнгөж оронгуут л нөхөр нь түүнийг хаалга мөргөж унатал алгадсан. Өөрийгөө хамгаалж чадахгүй болтол нь гурав дөрвөн удаа тийрсэн. Дараа нь цаасны хутгаар хувцсыг нь зүсэж, “хувцасгүй болгоод хаачих юм бэ, чи одоо хаашаа ч явж чадахгүй.” гэж хэлсэн. Эмэгтэй юу ч хийж чадахгүй болсон. Мөрдөн байцаалтын үеэр, найз нөхдөөс нь асуухад бүгд л гэр бүлийн хүчирхийлэл өмнө нь байсан талаар ярьсан....эмэгтэй биднийг дуудсан үед ирж мэдүүлэг өгч байсан. Удалгүй хэрэг шүүхэд шилжсэн” гэж цагдаагийн ажилтан ярьсан.*³²⁶

“Хохирогч эмэгтэй одоо хүчирхийлэлгүй, тайван сайхан амьдарч байгаа” гэж цагдаагийн ажилтан нэмж хэлсэн.”³²⁷ “Хэрвээ хохирогч мэдүүлэг өгөхгүй л бол хангалттай баримт байхгүй учраас хэргийг шүүхээр шийдвэрлэх боломжгүй” гэж прокурор хэлсэн. “Хохирогч заавал мэдүүлэг өгөх ёстой, үгүй бол хэргийг шийдэхэд хэцүү болно” гэж тэрээр тодруулга хийсэн.³²⁸ “Ихэнх хүмүүс гэрчээр татагдахаас эмээдэг” гэж өөр нэг цагдаа хэлсэн.³²⁹

Эрүүгийн эрх зүйн зохицуулалт

Эрүүгийн хуульд гэр бүлийн хүчирхийллийн хэргийг шийдвэрлэх боломжтой хэд хэдэн зүйл, заалт байдаг ч гэр бүлийн хүчирхийллийн ноцтой хэргийг шийдэхэд нэг ч удаа ашиглаагүй байдаг. Гэр бүлийн хүчирхийллийн хэргийг шийдвэрлэхэд зүйлчлэл нь тохирч байсан ч хуульчид тэр бүр Эрүүгийн хуулийг ашигладаггүй. Эрүүгийн хуулиар хариуцлага тооцох үед тохирсон ял шийтгэл хүлээлгэхэд тодорхой бэрхшээл тулгардаг. Эрүүгийн хуулийг хэрэглэн гэр бүлийн хүчирхийллийн хэргийг шийдвэрлэхдээ “тарчлаах” зүйлийг ихэвчлэн ашигладаг.³³⁰

“Гэр бүлийн хүчирхийллийн хэрэгт Эрүүгийн хуулийн “тарчлаах” зүйл, заалтыг талууд эвлэрсэн байсан ч ашиглах боломжтой”³³¹. “Гэвч уг хуулийн энэ заалтыг хэрэглэхэд хангалттай нотлох баримт байдаггүй” гэж прокурор нэмж хэлсэн.³³² Шүүх эмнэлгийн дүгнэлт байхгүй

³²⁵ Эрүүгийн хууль, 99.1 дүгээр зүйл

³²⁶ Цагдаагийн ажилтны ярилцлага, А хот, 2013. 3 - 22, 14:30.

³²⁷ Дээр дурдагдсан.

³²⁸ Прокурорын ярилцлага1, Э хот, 2013. 3 - 18, 9:30.

³²⁹ Цагдаагийн ажилтны ярилцлага 1, Д хот, 2013. 1 - 24, 10:00.

³³⁰ Эрүүгийн хууль, 100 дугаар зүйл: “Байнга зодох буюу тарчлаах шинжтэй бусад үйлдэл хийсэн нь энэ хуулийн 96, 98 дугаар зүйлд заасан хор уршиг учруулаагүй бол гурваас дээш зургаан сар хүртэл хугацаагаар баривчлах, эсхүл хоёр жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ. Бусдын бие махбодид удаан хугацаагаар эрүүл мэндийг нь сарниулсан буюу хөдөлмөрийн чадварын гуравны нэгээс дээшгүйг алдагдуулсан гэмтэл санаатай учруулсан бол хоёр зуун тавин нэгээс дөрвөн зуун тавин цаг хүртэл хугацаагаар албадан ажил хийлгэх, эсхүл гурван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.98.2. Энэ хэргийг давтан буюу бүлэглэж үйлдсэн, уг үйлдэл нь зовоон тарчлаах шинжтэй байсан, эсхүл онц аюултай гэмт хэрэгтэн үйлдсэн бол гурваас дээш зургаан сар хүртэл хугацаагаар баривчлах, эсхүл гурваас дээш таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

³³¹ Прокурорын ярилцлага, А хот, 2013.3 - 21, 17:00.

³³² Шүүгчийн ярилцлага, Ф хот, 2013.3 - 22, 11:00.

гэсэн шалтгаанаар хуулийн энэ заалтыг хэрэглэдэггүй. Учир нь хүчирхийллийн тохиолдол бүртээ хохирогч гэмтэл бэртлээ баримтжуулах гэж ханддаггүй учраас прокурор хуулийн шаардлагыг хангах боломжгүй болдог.³³³

“Тарчлаах: энэ нь ямар нэг бэртэл гэмтэл учруулахгүй ч байнга давтан үйлдэгддэг үйлдлүүд, тухайлбал, шөнө бүр хэн нэгнийг байнга чимхэж зовоох гэх мэт. Гэр бүлийн хүчирхийллийн зарим нэг хэргүүд үүнтэй адил ч бидэнд нотолгоо байдаггүй. Ихэнх тарчлаан зовоосон хэргүүдэд хохирогч өнгөрсөн түүхээ ярьдаг. Жишээ нь: тэр намайг чимхдэг, хараадаг зэргээр. Иймд нотлоход хэцүү байдаг”³³⁴

Түн ховор тохиолдолд, тухайлбал тарчлаан зовоосон нотлох баримт хангалттай үед талууд эвлэрсэн ч прокурор хэрэгт ял оногдуулсан байдаг. Нэгэн тохиолдол: нөхөр нь эхнэрээ, дагавар хүүхдийн хамт найман жилийн түрш хүчирхийлсэн. Хохирогч цагдаагийн байгууллагад хандан, эрүүгийн хэрэг үүсгүүлж, шүүх эмнэлгийн дүгнэлт гаргуулсан. Мөн эрх хязгаарлах шийдвэр шүүхээс гаргуулсан ч уг шийдвэрийн хүчинтэй хугацаа дуусмагц хүчирхийлэл үйлдэгч эргэн ирж, хүчирхийлэл дахин давтагдсан:

“Дахиад л, бие махбодын хүчирхийлэл үргэлжилсэн. Эрүүгийн хэрэг үүсгэж, хэдэн долоо хоног түүнийг баривчилсан. Эмэгтэй биедээ хөнгөн гэмтэл авсан ч нүд нь хүнд гэмтсэн. Түүний нүд сохроогүй ч биед нь үлдсэн хөхрөлтөөс илүү хүнд байдалтай байсан. Хүчирхийлэл байнга давтагдаж, ноцтой байдалд хүрсэн, тарчлаан зовоосон гэж үзэн хүчирхийлэл үйлдэгчид шийтгэл хүлээлгэсэн. Хохирогч гомдолгүй гэж мэдүүлсэн ч хүчирхийлэл үйлдэгчид ял хүлээлгэсэн. Хохирогч болон хүүхэд хүнд бэртсэн талаар шүүх эмнэлгийн дүгнэлт гарсан. Хүчирхийлэл үйлдэгч ч буруугаа хүлээн зөвшөөрсөн”³³⁵

Шүүх эмнэлгийн дүгнэлт, эрх хязгаарлах шийдвэр, хохирогч, түүний гэр бүлийн гишүүдийн мэдүүлэг дээр үндэслэсэн, мэдээж хүчирхийлэл үйлдэгч буруугаа хүлээсэн нөхцөл байдал нөлөөлсөн, иймээс хохирогч хүчирхийлэл үйлдэгчтэй эвлэрсэн ч түүнд нийт 18 сар шоронд хорих ял оноосон.³³⁶

“Ийм тохиолдол тэр бүр гардаггүй, энэ хэргийн талаар харин ч боломжийн шийдвэрлэсэн” гэж прокурор тайлбарласан. Хохирогчийн аавыг бас ахыг нь зодсон гэж нөхөртөө гар хүрсэн гэх хохирогч гомдлоосоо татгалзсан талаар:

“Тэд хамтдаа байхад нөхөр нь түүнд үргэлж гар хүрдэг учраас эмэгтэй байнга айдастай байдаг тухай ярьсан. Жирэмсэн байхад нь түүнийг зодсон учраас зулбаж байсан.....тэр маш том биетэй, хүчтэй, гудамжинд залуучуудтай зодолдоод шоронд 10 жил ял эдлэхээр явж байсан.....эхнэрээ зодохдоо чи

³³³ Прокурорын ярилцлага, Д хот, 2013.3 - 228, 14:00. (тухайн хэрэг болоод өнгөрсөн учраас эмчийн магадлагаа байхгүй)

³³⁴ Дээр дурдагдсан.

³³⁵ Хуульчийн ярилцлага, Д хот, 2013. 1 -24, 10:00

³³⁶ Дээр дурдагдсан.

шоронд байсан хүн ямар байдгийг үз гэж үргэлж хэлдэг..... Зодуулснаас болж эмэгтэй үр зулбасан гэдгийг эмч батлаагүй учраас би нотлох боломжгүй болсон. Нөхөр нь бусдын өмнө эхнэрээ халамжилсан дүр үзүүлж, харин гэртээ байнга тарчлаан зовоож, хүний нүдэнд харагдахгүй гэмтэл учруулдаг. Ийм учраас би шүүхэд хоёр хэрэг үүсгэсэн. Нэг нь төрөл төрөгсөддөө танхайрсан, нөгөө нь эхнэрээ тарчлаан зовоосон хэрэг. Анхан шатны шүүх хоёр хэрэгт ял оноосон, дараа нь давж заалдах шатны шүүхээр эхний шийдвэрийг хэвээр үлдээсэн. Дээд шүүх “тарчлаан зовоосон” гэсэн хангалттай нотлох баримт байхгүй гэсэн үндэслэлээр хэргийг хэрэгсэхгүй болгосон”³³⁷

Хохирогч, түүний найз нөхөд болон гэрчийн мэдүүлэг, хүчирхийлэл үйлдэгч баривчлагдаж, эрүүлжүүлэгдэж байсан тодорхойлолт³³⁸ зэрэг байсан ч прокурор эмнэлгийн магадлагаа байхгүй гэсэн үндэслэлээр авч хэлэлцээгүй.³³⁹

Тарчлаан зовоох зүйлчлэлээр эрүүгийн хэрэг үүсгэсэн тохиолдолд тухайн хохирогчийн биед санаатайгаар³⁴⁰ хүнд гэмтэл бэртэл³⁴¹ учирсныг нотлохыг прокурор шаарддаг. Гэр бүлийн хүчирхийллийн хэрэгт зөвхөн хөнгөн гэмтэл³⁴² учруулсан³⁴³ эсвэл танхайрсан³⁴⁴ гэж хариуцлага хүлээлгэдэг. Тарчлаан зовоох зүйл ангиар хариуцлага хүлээлгэхэд ялгаагүй нотлох баримтын хатуу шаардлагатай тулгардаг. “Хэдийгээр цагдаагийн байгууллагад дуудлага өгсөн тэмдэглэл хохирогчид байсан ч гэрч болон бусад нотлох баримт шаардлагатай” гэж прокурор тайлбарласан. “Хүчирхийлэл олон удаа давтагддаг” гэж хохирогч мэдүүлэг өгсөн ч хэргийг эрүүгийн журмаар шийдвэрлэх хангалттай үндэслэл болохгүй гэж тэр нэмж тайлбарласан.³⁴⁵

Эрүүгийн ял

Хохирогч нотлох баримттай холбоотой шалгуурыг давсан ч гэр бүлийн хүчирхийллийн олон хэрэгт эрүүгийн хариуцлага хүлээлгэдэггүй. “Гэр бүлийн хүчирхийллийн улмаас хэн нэгэнд хүнд шийтгэл хүлээлгэсэн гэж би бодохгүй байна” гэж цагдаагийн ажилтан хэлсэн.³⁴⁶ Хохирогчийн гомдлоор эрүүгийн хэрэг үүсгэж, хүчирхийлэл үйлдэгчийг шоронд хорих ял оногдуулаагүй тохиолдолд хохирогч хүчирхийлэлтэй харилцаандаа хэвээр үлддэг.³⁴⁷ Нэгэн тохиолдол: эхнэрийнхээ эрүүг хутгаар гэмтээсэн хэрэгт “санамсаргүй хөнгөн гэмтэл учруулсан” гэсэн үндэслэлээр нөхрийнх нь ялыг нэг жилийн хугацаагаар тэнссэн.³⁴⁸ Гэр бүлийн хүчирхийллийн хэрэг Эрүүгийн хуулийн 100 дугаар зүйлээр зүйлчлэгдсэн тохиолдолд л 3-6 сар баривчлах, эсхүл 2 жил хүртэлх хугацаатай хорих ял оногдуулдаг.

³³⁷ Прокурорын ярилцлага, Д хот, 2013.3 -28, 14:00.

³³⁸ Эрүүлжүүлэх газар нь ямар нэг хүчирхийллийг баримтжуулдаггүй. Дээр дурдагдсан.

³³⁹ Дээр дурдагдсан.

³⁴⁰ Эрүүгийн хууль, 96 дугаар зүйл.

³⁴¹ Дээр дурдагдсан. 97 дугаар зүйл.

³⁴² Дээр дурдагдсан. 98 дугаар зүйл.

³⁴³ Дээр дурдагдсан. 99 дүгээр зүйл.

³⁴⁴ Дээр дурдагдсан. 181 дүгээр зүйл.

³⁴⁵ Прокурорын ярилцлага, Г хот, 2013. 3 - 21, 14:30.

³⁴⁶ Цагдаагийн ажилтны ярилцлага, Э хот, 2013. 3 -19,12:30

³⁴⁷ Эрүүгийн хууль, 61 дүгээр зүйл.

³⁴⁸ Цагдаагийн ажилтны ярилцлага, С хот, 2013. 3- 20, 10:00

Тарчлаан зовоосон гэсэн зүйлчлэлээр яллаж, нөхөр нь 18 сарын хугацаатай ял шийтгүүлсэн хэргийн тухайд:

*“Нөхөр нь эхнэрээ гадаа хоно гэж зодож хөөсөн. Эхнэр лүүгээ эд зүйлс шидэлж, гудасгүй орны пүршин дээр нүцгэн хэвтүүлж зодсон. 10-11 орчим настай хүүгээ нүцгэлэхийг шаардаж, түүний биеийг халуун зууханд түлсэн. Хүүгийнхээ хүзүүнд мод барьж морь болгон унаж, хүзүүн дээр нь дарж унагасан. Хүүгээ нүцгэлээд мал шиг хөнгөлнө гэж айлган сүрдүүлсэн. Тэрээр үргэлж л хутга барин эхнэр лүүгээ дайрдаг байсан. Орны пүршний ором эхнэрийнх нь биед үлдсэн.....эхнэр нь 37 настай ч шүүхэд ирэхдээ наснаасаа илүү хөгшин харагдаж байсан”*³⁴⁹

Гэр бүлийн хүчирхийлэл үрт удаан хугацаанд үйлдэгдсэн, бас хүнд гэмтэл бэртэл авсан байсан ч хөнгөн хариуцлага хүлээлгэдэг. Эрүүгийн хуулийн “танхайрах” зүйлчлэлийн хүрээнд хөнгөн ял хүлээлгэж байгаа талаар цагдаагийн ажилтан ярихдаа:

*“Эхлээд тэр эхнэрээ хаана ч хамаагүй зоддог байсан бол хохирогчийг хамгаалах хуулийн талаар мэдсэнээс хойш хүн харах ил газар зодохоо больсон. Ихэнхдээ эхнэрээ унтсан хойно нь чимхэж зоддог, хэд хэдэн удаа хоолойг нь боосон байсан.....тэр хоолойг нь боохдоо хувцас хэрэглэсэн учраас бид үл мөр олж чадаагүй.. . Шүүхэд хэргийг шилжүүлсэн. . . тэр танхайрсан хэргээр нэг жил шоронд хоригдсон.”*³⁵⁰

Хүчирхийлэл үйлдэгч хөнгөн ялаа эдэлж, шоронгоос гарч ирээд, хүчирхийллээ үргэлжлүүлдэг:

*“Тэр дахиж шийтгүүлээгүй. . . . Хүчирхийлэл үйлдэгч хандлагаа хэзээ ч өөрчлөхгүй. Эмэгтэй дахин цагдаа дуудахаас ичдэг. Бид гудамжинд тааралдахад тэр над руу харж чаддаггүй”*³⁵¹

Амиа хорлох оролдлого ба аргагүй хамгаалалт

Эмэгтэйчүүд шаардлагатай хамгаалалт авч чадаагүй тохиолдолд хүчирхийлэл үргэлжилсээр л байдаг. Зарим эмэгтэйчүүд өөрийгөө хамгаалах, хүчирхийллийг зогсоох ямар нэг алхам хийдэг.³⁵² Зарим тохиолдолд эмэгтэй нөхрийнхөө гарт тарчлахаас айж, амиа хорлохыг оролддог.

“Нөхөр нь тонгорог авчраад “Би чамайг алах болно, яг энд чамайг дуусгана, чи намайг орхиод явсан, тэгэхээр надад алдах юм байхгүй, эхнэр хүүхэд байхгүй, амьдрах зорилго алга. Энэ бүхэн одоо төгсгөл болно. Би чамайг энд хэрчиж хаяад явахад хэн ч чамайг олохгүй. Бидний амьдрал ийм богинохон гэж бодож

³⁴⁹ Шүүгчийн ярилцлага, Ф хот, 2013. 3 -22, 11:00

³⁵⁰ Цагдаагийн ажилтны ярилцлага, Э хот, 2013. 3 - 19, 14:30

³⁵¹ Дээр дурдагдсан.

³⁵² Эрүүгийн хууль, 40.1 дүгээр зүйл, өөрийгөө хамгаалах зорилгоор аргагүй хамгаалалт бол гэмт хэрэгт тооцохгүй.

*байна” гэж хэлсэн. Дараа нь маш аймшигтайгаар гарт тааралдсан бүх л эд зүйлсээр намайг зодсон. Би доош харан унахад тэр миний дээр үсрээд нуруу руу өшиглөж байсан. Тэр намайг ална гэдгийг би мэдсэн, тэгээд тамлуулж үхэж байхаар өөрөө үхье гэж бодсон. Би түүний тонгоргыг аваад өөрийгөө дүрж амиа хорлохыг оролдсон. Тэр харж зогсоод битгий худлаа жүжиглээд бай гэж хэлсэн. Миний гэдэс цуваад гарч ирсэн, тэр надад ер туслаагүй, удалгүй би ухаан алдсан байсан” гэж нэгэн хохирогч ярьсан.*³⁵³

Нөхрийнхөө амь насыг хороох нь хүчирхийллээс ангижрах эцсийн алхам гэж зарим эмэгтэйчүүд үздэг. Хүчирхийлэл үйлдэгчийн амь насыг хөнөөсөн хэргээр ойролцоогоор 130 гаруй эмэгтэйчүүд ял эдэлж байна.³⁵⁴ Гэрлэснээс хойш 10 жилийн турш хүчирхийлэлд өртсөн эмэгтэй дахин зодуулахгүйн тулд нөхрөө буудсан.³⁵⁵

*“Нэг удаа нөхөр нь түүнийг чулуугаар шидэн зодож, хурууг нь гэмтээж байсан. Мэдээж энд тэндгүй маш их цус болсон. Дараа нь эхнэрээ эцэг, эхийндээ очихыг зөвшөөрсөн. Араас чинь очихгүй учраас өөрийн гэсэн эд зүйлээ аваад яваарай гэж хэлсэн. Нөхөр нь ингэж хэлсэн учраас эмэгтэй явахаар шийдсэн. Тэднийх аймгийн төвөөс 100 гаруй км зайтай байдаг. Эхнэр нь буу аваад 6-7 км явган явсан. Яагаад буу авч явсныг асуухад, замд тааралдах араатан чононоос хамгаалах зорилготой байсан гэж эмэгтэй хариулсан.....Гэтэл нөхөр нь араас нь морьтой давхиад ирсэн. Түүнийг дахин зодохоор ирлээ л гэж бодсон учраас ойртох л юм бол буудна шүү гэж нөхөртөө анхааруулсан. Гэвч анхааруулсаар байтал тэр мориноосоо буугаад түүнийг шууд л чиглээд алхаад ирсэн. Анхааруулга нөхөрт нь ер нөлөөлөөгүй учраас эмэгтэй агаарт хий буудсан. Тэр ер тоохгүй чиглээд ирсэн учраас эмэгтэй түүнийг буудсан” гэж прокурор тайлбарласан.*³⁵⁶

Азаар нөхөр нь амьд гарсан, эрүүгийн хэрэг үүсгэж, мөрдөн байцаалт явуулсан. Хохирогч эмэгтэйг хүний амь нас хөнөөхийг завдсан, гэнэтийн цочролд орсон³⁵⁷ гэж хоёр жилийн хугацаатай ялыг нь тэнссэн. “Нөхөр нь үргэлж хүчирхийлж зоддог байсан, түүнийг гэртээ аваачаад дахиад л зодох байсан учраас тэр эмэгтэй буудсан”³⁵⁸ гэж прокурор ярьсан.

Өөр нэг тохиолдол: арав гаруй жил хүчирхийлэлд өртсөн эмэгтэй цагдаагийн байгууллагад гурваас дөрвөн удаа дуудлага өгсөн. Цагдаагийн ажилтан эрүүлжүүлэх байранд аваачиж, эсвэл Захиргааны хариуцлагын тухай хуулийн дагуу богино хугацаагаар баривчилдаг байсан. Эцэст нь хохирогч эмэгтэйд хүчирхийлэл үйлдэгчийн амь насыг хороох л арга зам үлдсэн.... Ямар ч үр дүнгүй захиргааны хариуцлага эцэст нь эмэгтэй шоронд ороод л дуусаж байна.”³⁵⁹

³⁵³ Ф хот, 2013.3 -22,14:00. Энэ түүхийг 5, 10, 29, 44, 49 хуудсанд иш татсан

³⁵⁴ Нийт хоригдож буй эмэгтэйчүүдийн 88% нь урт хугацааны гэр бүлийн хүчирхийлэл, дарамтын улмаас хүн амины хэрэг үйлдсэн байдаг. 30% нь шүүхэд гэрлэлт цуцлах хүсэлт гаргасан байдаг. Судлаач Хэлэн Рубенстэйнд ТББ-аас ирсэн цахим шүүдэн (2013. 7 -16) (судлаачын файл) (Хүчирхийлэл үйлдэгчийн амь насыг хороосоны улмаас хүн амины хэргээр хоригдож байгаа. Хүний эрхийн үндэсний комисс, 2012).

³⁵⁵ Прокурорын ярилцлага, Ф хот, 2013. 3 - 22, 16:30.

³⁵⁶ Дээр дурдагдсан.

³⁵⁷ Эрүүгийн хууль, 93 дугаар зүйл.

³⁵⁸ Прокурорын ярилцлага, Ф хот, 2013. 3 - 22, 16:30.

³⁵⁹ Улсын яллагч, Б хот, 2013. 1 -28,15:40 (хохирогч дунджаар 10 жилийн хорих ял авдаг.

ГЭРЛЭЛТ ЦУЦЛАЛТ

Мэдээж, эрх зүйн хамгаалалт хангалтгүй байгаагаас гэрлэлт цуцлах нь гэр бүлийн хүчирхийлэлээс зугтах гарц болсон.³⁶⁰ “Олон тохиолдолд хүчирхийллийн хэргүүдэд гэрлэлт цуцлах нь гол шийдвэрлэх арга зам болсон.”³⁶¹ гэж нэгэн шүүгч хэлсэн. Судалгаанд оролцогчид “хүчирхийллийн харилцаанаас ангижрах нэг арга зам нь гэрлэлт цуцлалт” гэж үзэж байгаагаа хэлсэн.³⁶² Өөр нэг шүүгч “жилд гэр бүл цуцлах 45 хэрэг бүртгэгдсэнээс 80% нь гэр бүлийн хүчирхийллийн улмаас байдаг” тухай тайлбарласан.³⁶³ Хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтаас илүүтэйгээр гэрлэлт цуцлах өргөдөлд хүчирхийлэл илүү мэдээлэгддэг. “Хохирогч арай дээр амьдралыг л хүлээж, гэрлэлт цуцлах шийдвэр гаргадаг”³⁶⁴ гэж нэгэн өмгөөлөгч хэлсэн. Харамсалтай нь гэрлэлт цуцлагдсан дараа ч хохирогчийг хамгаалах тогтолцоо байдаггүй учраас хүчирхийлэл дуусгавар болдоггүй.

Гэрлэлт цуцлуулахад учирдаг саад бэрхшээл

Гэрлэлт цуцлах процесс нь тийм хурдан байдаггүй. Бас хүн бүрт ч боломжтой байдаггүй. Жирийн нэг гэрлэлт цуцлахад эвлэрүүлэх хугацааг тооцохгүйгээр гурваас найман долоо хоног шаарддаг.³⁶⁵ Хэдийгээр хуулиар гэр бүлийн хүчирхийллийн харилцаатай гэрлэлт цуцлах хүсэлтийг нэн даруй шийдвэрлэхийг шүүгчид үүрэг болгосон ч³⁶⁶ тэд ихэнхдээ үүнд ач холбогдол өгдөггүй.³⁶⁷ Иймд гэрлэлт цуцалсны дараа ч хэдэн сарын турш хохирогчийн хүчирхийлэлтэй амьдралд ямар нэгэн өөрчлөлт гардаггүй.

Гэрлэлт цуцлалт хүн бүрт боломжтой байдаггүй. Хэрвээ эхнэр нь жирэмсэн, эсвэл хүүхэд нь нэг ой хүрээгүй бол гэрлэлтийг цуцлахгүй.³⁶⁸ Гэрлэлт цуцлахад гарах зардал нь зарим эмэгтэйчүүдэд бэрхшээл болдог. Нэхэмжлэлд улсын тэмдэгтийн хураамж 70,200 төгрөг төлнө. (ойролцоогоор 44 ам доллар)³⁶⁹ Хэрвээ хүүхдийн асрамж, тэтгэлэг, өмч хөрөнгө хуваах зэрэг асуудал байвал төлөх төлбөрүүд нэмэгдэнэ.³⁷⁰ Хохирогч улсын тэмдэгтийн хураамж төлөх боломжгүй бол төлбөрөөс чөлөөлөх механизм байдаг ч³⁷¹ ихэнх хохирогч, үйлчилгээний ажилтнууд энэ талаар мэддэггүй. Нэгэн хохирогч гэрлэлтээ цуцлуулахын тулд бараг бүтэн жил мөнгө цуглуулах хэрэгтэй болсон гэж хэлсэн:

³⁶⁰ Эрх хязгаарлах арга хэмжээ; Захиргааны хариуцлага; Эрүүгийн хууль; Хамгаалах байр, дэмжих үйлчилгээний хүрэлцээгүй байдал хэсгээс харна уу

³⁶¹ Сумын шүүгчийн ярилцлага, Б хот, 2013. 1 -28, 9:00.

³⁶² Сумын шүүгчийн ярилцлага 2, Д хот, 2013.3 -28, 10:00

³⁶³ Шүүгчийн ярилцлага, С хот, 2013.3 - 18, 14:00

³⁶⁴ ТББ -ын ярилцлага, С хот, 2013.3 - 18, 17:30

³⁶⁵ Шүүхийн нарийн бичгийн ярилцлага, Г хот, 2013. 3 -19,17:20

³⁶⁶ Гэр бүлийн тухай хууль,14.4. дугаар зүйл

³⁶⁷ Хохирогчийн ярилцлага, А хот, 2013. 3 - 22, 15:30;Шүүгчийн ярилцлага, Э хот, 2013.3- 18,15:30

³⁶⁸ Гэр бүлийн тухай хууль, 12.2 дугаар зүйл; Гэрлэлт цуцлах шүүх хурал, Д хот, 2013.3- 19,10:00.

³⁶⁹ Шүүхийн нарийн бичгийн ярилцлага, Г хот, 2013.3 -19,17:20;Шүүгчийн ярилцлага, А хот, 3- 21, 2013.15:30.

³⁷⁰ Сумын шүүгийн ярилцлага, А хот, 3 - 21, 2013.15:30.

³⁷¹ Сумын шүүгчийн ярилцлага, Э хот, 2013. 3- 18, 15:30.Иргэний шүүхийн шүүгч, А хот, 2013. 3-21, 15:30. Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хууль, 41.1.5 болон 41.1.6 дугаар зүйл

“Өнгөрсөн долоон сараас хойш би гэрлэлтээ цуцлуулахыг хүссэн ч, тэмдэгтийн хураамжийг нь төлж чадахгүй байсан. Хэрвээ тийм хэмжээний мөнгө надад байсан бол, тэр миний хамрыг хугалсны дараа л шууд салах байсан”³⁷²

Хуулийн ийм боломж байсаар байтал, хохирогч эмэгтэйд нийгмийн ажилтан энэ талаар мэдээлэл өгөлгүй хайхрамжгүй хандсан.³⁷³

Эвлэрүүлэх хугацаа ба эрсдэлт нөхцөл байдал

Гэр бүлийн тухай хуулиар гэрлэлт цуцлахад шүүх өөрийн үзэмжээр гурван сар хүртэлх эвлэрүүлэх хугацаа өгөхийг хуульчилсан байдаг.³⁷⁴ Практик дээр ихэнх шүүгчид гэр бүл цуцлах хэрэгт³⁷⁵ гурван сарын эвлэрүүлэх хугацаа өгч хэвшчихсэн учраас энэ нь гэр бүлийн хүчирхийллийн хохирогчийг аюултай байдалд оруулдаг.³⁷⁶ Хэдийгээр, шүүгчид өөрийн үзэмжээр шийддэг ч Гэр бүлийн тухай хуулиар “хэрвээ гэр бүлийн хүчирхийллийн харилцаатай бол эвлэрүүлэх хугацаа өгөхгүй” гэрлэлт цуцлахыг хуульчилсан.³⁷⁷ Гэвч ихэнх шүүгчид эвлэрүүлэх хугацаа бол заавал байх ёстой гэж үздэг.³⁷⁸ Шүүгч гэрлэлтээ цуцлуулах хүсэлт хоёр ч удаа гаргасан эмэгтэйд эвлэрэх хугацаа өгснөөр айдас, дарамт улам нэмэгдсэн талаар ярьсан нь:

“Мэдээж, шүүгчдэд хүчирхийллийн талаар хоёр ч удаа хүсэлт гаргахдаа хэлсэн. Бүгдийг хэлсээр байтал “чамд хангалттай нотлох баримт байхгүй” гэж тэд хариулсан. . . тэд надад итгээгүй. Шүүх танхимд манай нөхөр “миний эхнэр өөр хүнтэй, тэрийгээ баригдахаар айгаад надаас салах гэж байгаа” гэж хэлсэн. Надад хангалттай нотлох баримт байгаагүй учраас шүүгч намайг зохиож байна гэж бодсон. Хоёр ч удаа гурван сарын эвлэрэх хугацаа өгсөн. . . шүүгч хангалттай баримт байхгүй гэсэн байж эвлэрэх хугацаа өгч байгаа нь зөв биш. Би үнэхээр сэтгэл дундуур үлдсэн. Гэрлэлтээ цуцлуулах хэрэгт эвлэрэх гурван сарын хугацаа шүүхээс өгч, энэ хугацаанд нөхөр нь эхнэрээ хороосон хэрэг телевизээр мэдээлж байгааг би үзсэн. “Миний хамрыг хугалсан тэр өдөр би зугтаагүй бол... тэр намайг алах байсан” гэж би бодож маш их харамссан. . . эвлэрүүлэх хугацаа бол тийм зөв зүйл биш. Шүүгчид хүмүүсийг айдас руу, бас аюултай байдалд түлхэж байгаагаа мэддэггүй”³⁷⁹

³⁷² Хохирогчийн ярилцлага, А хот, 2013.3 -22,15:30.

³⁷³ Дээр дурдсан.

³⁷⁴ Гэр бүлийн тухай хууль, 14.2 дугаар зүйл (“шаардлагатай гэж үзвэл шүүх хурлыг 3 сар хүртэл хойшлуулж, талуудад эвлэрэх хугацаа өгдөг”)

³⁷⁵ Гэр бүлийн тухай хууль, 14.2. дугаар зүйл

³⁷⁶ Шүүхийн нарийн бичгийн ярилцлага. Г хот, 2013.3 -19,17:30;Багийн нийгмийн ажилтан, Б хот, 2013.1 -31,14:00.

³⁷⁷ Гэр бүлийн тухай хууль, 14.4 дугаар зүйл (“Гэрлэгчдийн хэн нэгний байнгын хүчирхийлэл, дарамтаас болж гэр бүлийн гишүүдийн амь нас, эрүүл мэнд болон хүүхдийн хүмүүжилд ноцтой хохирол учирч болзошгүй, эсхүл учирсан нь тогтоогдсон бол шүүх энэ хуулийн 14.2-т заасан эвлэрүүлэх арга хэмжээ авахгүйгээр гэрлэлтийг цуцална.”)

³⁷⁸ Хуульчийн ярилцлага, Г хот, 2013. 3 -19,14:30 (Шүүгч гэр бүлийн хүчирхийлэлтэй ч гэрлэлт цуцлах хэрэг бүрт эвлэрүүлэх хугацаа өгдөг); Цагдаагийн байгууллага, хүүхдийн байцаагч, С хот, 2013. 3 -19,11:00 (эвлэрүүлэх хугацааг шүүхээс өгсөн байхад нөхөр нь эхнэрээ хутгалж байсан хэрэг гарсан); Иргэний шүүхийн шүүгч, А хот, 2013.3 - 21,15:30 (гэр бүлийн хүчирхийллийн ноцтой харилцаа байсан ч шүүгч гэрлэлтийг цуцлах шийдвэр гаргаагүй).

³⁷⁹ Хохирогчийн ярилцлага, А хот, 2013. 3 -22,15:30..

Энэ практик нь хохирогчид “шүүгч зөвхөн эвлэрүүлэхийн төлөө л ажилладаг” гэсэн ойлголт, хандлагыг бэхжүүлж³⁸⁰ нөгөө талаас Монголын эрх зүйн систем гэр бүлийн бат бэх байдлыг л хангахад зорьдог гэсэн дүр зураг бий болгосон.³⁸¹ Дээр дурдсанчлан, эмэгтэй жирэмсэн эсвэл нэг нас хүртэлх хүүхэдтэй бол гэрлэлт цуцлахыг хориглож байгаа нь хүчирхийллээс ангижрахыг хүссэн эмэгтэйчүүдэд саад болж байна.³⁸² Энэ талаар шүүгч мэдээлэхдээ:

“Эвлэрүүлэх хугацаа нь маш чухал. Хуулиар шүүгч бид нарт гэр бүлийг заавал эвлэрүүл гэж заасан байдаг. Тэгэхээр бид гэр бүлийг эвлэрүүлэхийн тулд авах шаардлагатай бүх арга хэмжээг авч ажилладаг. Энэ талаар ч хуульчилсан байгаа. Иймд гэрлэлт цуцлахаас илүү гэр бүлийг эвлэрүүлэх шийдвэр олон байдаг.”³⁸³

Эвлэрүүлэх хугацаанд зөвлөгөө авсан хүчирхийлэл үйлдэгчийн зан үйл өөрчлөгдөж, талууд хамтдаа үлдэх боломжтой болно гэж шүүгчид итгэдэг.³⁸⁴ Тухайн гэр бүл хүчирхийллийн харилцаатай эсэхээс үл хамааран талуудын хэн нэг нь эвлэрэх хүсэлтэй бол шүүгч тухайн талыг дэмжиж асуудлыг шийддэг. “Хохирогчийн мэдүүлэгт үндэслэн эвлэрүүлэх шийдвэр гаргахаас татгалзах нь хангалттай биш. Манай хуулиар, хэрвээ аль нэг тал нь гэрлэлтээ цуцлуулахыг хүсэхгүй, хохирогчийн хувьд хангалттай нотолгоо байхгүй бол талуудад эвлэрэх гурван сарын хугацаа өгөх ёстой. Аль талд нь итгэж байгаа нь чухал биш. Би зөвхөн хуулийн хүрээнд ажиллаж байгаа. Хэрвээ хариуцагч этгээд эхнэрээ хэзээ ч зоддоггүй, гэрлэлтээ цуцлахыг хүсэхгүй байна гэж хэлбэл бид хуулиа л барих ёстой болно” гэж шүүгч хэлсэн.³⁸⁵

Хохирогчийн мэдүүлэгт зарим шүүгчид итгэхгүй байснаар “эвлэрүүлэх хугацаа заавал байх ёстой” гэсэн стандартыг бий болгодог. Шүүгч гэрлэлт цуцлах шийдвэр гаргахаас өмнө хохирогчоос ихэнхдээ шүүх эмнэлгийн дүгнэлт шаарддаг.³⁸⁶ Шүүхээс гэр бүлийн хүчирхийллийн хэргийг шийдвэрлэхдээ нийгмийн ажилтны нөхцөл байдлын үнэлгээг заавал шаарддаг.³⁸⁷ Шүүх эмнэлгийн дүгнэлттэй байсан ч шүүгч эвлэрүүлэх хугацаа өгдөг, эсвэл хөнгөн хэлбэрийн гэмтэл гэж үзэж татгалздаг.³⁸⁸ Шүүгч гэрлэлт цуцлахдаа гэр бүлийн хүчирхийллийн харилцаатай эсэхийг анхаарч үздэггүй. “Гэрлэлт цуцлах нэхэмжлэлд гэр бүлийн хүчирхийлэл онцгойлон дурдагдаагүй л бол, гэр бүлийн хүчирхийллийн хэрэг гэж хардаггүй” гэдгээ шүүгч хүлээн зөвшөөрсөн.³⁸⁹

³⁸⁰ Хохирогчийн ярилцлага, А хот, 2013. 3 - 22,15:30.

³⁸¹ Гэр бүлийн тухай хууль, 14.2 дугаар зүйл; Иргэний шүүхийн шүүгч, А хот, 2013. 3 -21,15:30 (“манай эрх зүйн тогтолцоо эвлэрүүлэх арга хэмжээг илүү дэмждэг”)

³⁸² Гэр бүлийн тухай хууль, 12.2 дугаар зүйл; Гэрлэлт цуцлах шүүх хурал, Д хот, 2013. 3 - 29,10:00

³⁸³ Сумын шүүгчийн ярилцлага, Э хот, 2013.3- 18,15:30. Шүүхийн нарийн бичгийн ярилцлага, Г хот, 2013.3 -19,17:30;Гэр бүлийн тухай хууль, 14.2. дугаар зүйл

³⁸⁴ Сумын шүүгчийн ярилцлага, Б хот, 2013. 1 -28, 9:00

³⁸⁵ Дүүргийн шүүгчийн ярилцлага1, Д хот, 2013. 3 -28, 10:00

³⁸⁶ Сүвिलाгчын ярилцлага, Д хот, 2013, 1 сар 28, 1000. Д хот, 2013.1 -28, 10:00. Иргэний журмаар эрх хязгаарлах арга хэмжээ болон Захиргааны зөрчил болон эрүүгийн хэргийг хянан шийдвэрлэх үйл ажиллагаанд тулгарч буй бэрхшээл хэсгээс харна уу

³⁸⁷ Хорооны нийгмийн ажилтны ярилцлага, Д хот, 2013. 1 -23,10:00

³⁸⁸ Иргэний шүүхийн шүүгч, А хот, 2013, 3- 21.15:30

³⁸⁹ Сумын шүүгчийн ярилцлага, Б хот, 2013. 1 -28, 9:00

Гэрлэлт цуцлах үед болон гэрлэлт цуцалсны дараа үйлдэгдэх хүчирхийлэл

Гэр бүлийн хүчирхийллийг зогсооход гэрлэлт цуцлалт тийм ч үр дүнтэй байдаггүй. Маш олон тохиолдолд гэрлэлт цуцлах процесс эхэлсэн л бол эрх хязгаарлах шийдвэрийг хамтатган авах зайлшгүй шаардлагатай байдаг. Учир нь хохирогч гэрлэлтээ цуцлуулах хүсэлт гаргасныг хүчирхийлэл үйлдэгч мэдсэн бол хүчирхийлэл улам ноцтой хэмжээнд хүрдэг. Хохирогч эрх хязгаарлах шийдвэр гаргуулах боломжтой эсвэл эрх хязгаарлах арга хэмжээ үр дүнгүй байдаг талаар нөхөр нь мэдсэн тохиолдолд нэхэмжлэл гаргагч илүү эрсдэлтэй нөхцөл байдалд ордог.³⁹⁰ Жишээ нь: нөхөр нь салах гэж байгааг нь мэдсэнээр ямар эрсдэлд орсон тухайгаа нэгэн хохирогч мэдээлсэн нь:

“Би яг одоо түүнээс салахыг хүсэж байна. . . . гэнэт л тэр манай ажил дээр хүрч ирээд хүүхэдтэйгээ уулзахыг хүссэн. Миний ажиллаж байгаа хотыг тэр яаж олж мэдсэнийг нь би мэдээгүй. Би түүнд “ямар ч боломж байхгүй, миний амьдралаас яваад өг” гэж хэлсэн. Тэр намайг бараг бүтэн долоо хоног дагаж явсныг нь би мэдээгүй байсан. Тэр намайг ганцаараа үлдэх мөчийг л хүлээж байсан гэж сүүлд бодсон. . . .Нэг орой би ажлаа тараад гэртээ тун ойрхон алхаж явсан. Шөнө дунд байсан... тэр гэнэт гарч ирээд миний толгой руу цохиж унагаасан. Тэр миний нүүр, хүзүүг хутгаар сийчсэн. Маш гүн сийчсэн учраас миний нүүр бүхэлдээ цусанд будагдсан. Тэр намайг ууланд байдаг байшинд аваачиж хүчиндсэн. Тэр намайг байшингийн хонгилд хорьсон, тэнд ямар ч гарах гарц байхгүй зөвхөн жижигхэн цонх л байсан. Бүтэн хоёр өдөр, хоёр шөнө надад ямар ч хоол, унд өгөхгүй хүчиндсэн”³⁹¹

Өөр нэг тохиолдол: хүчирхийлэл үйлдэгч нөхрөөсөө сална гэдгээ хэлээд амь насаа алдсан эмэгтэйн түүх:

“Нөхрөө шоронд хоригдож байх үед нь эхнэр нь түүнээс салахыг хүссэн. Эхнэрээ надаас салах л юм бол ална гэж үргэлж сануулж, дарамталж байсан. . . энэ бүхэн болохоос 10 хоногийн өмнө эмэгтэй гэрлэлтээ цуцлуулахаар шийдсэн байсан. Нөхөр нь өдөржин найзындаа байж байгаад, шөнө дунд эхнэрийнхээ ээжийнд очсон. . . .тэр хаалгыг нь яаж онгойлгохыг мэддэг. Эхнэрээ ээж, гурван хүүхдийнх нь өмнө хутгалж амь насыг нь хөнөөсөн байна”³⁹²

Хохирогч гэрлэлт цуцлах нэхэмжлэлтэйгээ хамт эрх хязгаарлах шийдвэр гаргуулахыг хүссэн хүсэлтийг давхар гаргах боломжтой.³⁹³

ШШГГ-ын ажилтан гэр бүл цуцлуулах хэрэгт эрх хязгаарлах арга хэмжээг хамт авч хэрэгжүүлсэн тухай туршлагаа хуваалцсаныг харна уу:

³⁹⁰ Иргэний журмаар эрх хязгаарлах арга хэмжээ хэсгийг харна уу

³⁹¹ Хохирогчийн ярилцлага, Ф хот, 2013. 3 -22, 14:00. энэ түүхийг 5, 10, 29, 44, 49 хуудсанд иш татсан

³⁹² Хуульчийн ярилцлага, С хот, 2013. 3 - 18, 9:00.

³⁹³ Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль, 9.1.8, 17 дугаар зүйл; Иргэний хууль , 82.1.8, дугаар зүйл;Шүүгчийн ярилцлага, Д хот, 2013. 3 - 28,10:00

“Дээр үед би эрх хязгаарлах шийдвэрийг гүйцэтгэхээр хүлээж авсан. Хүчирхийлэл үйлдэгч үргэлж архи уудаг, согтохоороо хохирогчийг зодож хүчирхийлдэг. Тэр маш их хартай, хохирогчийг хүсээгүй байхад нь хүчээр бэлгийн харьцаанд ордог байсан. Эрх хязгаарлах арга хэмжээ авснаар гэрлэлт цуцлах шүүх хурал болох хүртэл хүчирхийлэл үйлдэгчийг эхнэр, хүүхдээс нь тусад нь байлгасан. . . . эрх хязгаарлах шийдвэр гарангуут бид хүчирхийлэл үйлдэгчийг хохирогчоос тусад нь байлгах үүрэгтэй байсан. Бид хүчирхийлэл үйлдэгчийг ах, аав нартай нь хамт дуудаад, хэрвээ хүүгээ хохирогчоос тусад нь байлгахгүй бол түүнд эрүүгийн хуулийн дагуу арга хэмжээ авна гэж сануулсан. Захирамж хүлээн авсан гарын үсэг зурснаас хойш тэр дахиж үзэгдээгүй”³⁹⁴

Хэрвээ хохирогч эрх хязгаарлах арга хэмжээ авахуулах хүсэлт гаргаагүй л бол шүүх санаачилгаараа шийдвэр гаргахгүй.³⁹⁵

Гэрлэлт цуцалсны дараа хүчирхийлэл үргэлжлэх нь нийтлэг үзэгдэл. Заримдаа хүчирхийлэл үйлдэгч хохирогчийг өөрөөс нь салсанд өширхдөг.

“Гэрлэлт цуцалсаны дараа хүчирхийлэл үйлдэгч маш их архи уусан. Тэр архи уугаад, хохирогчийн гэрт согтуу ирж түүнийг зодож хүчирхийлэл үйлддэг” гэж шүүгч хэлсэн.³⁹⁶

Заримдаа гэрлэлт цуцалсны дараа хүчирхийлэл илүү ноцтой хэмжээнд хүрдэг.

“Гэрлэлт цуцалсны дараа хүчирхийлэл ихэнхдээ л үргэлжилдэг. . . . Тэдний гэрлэлтийг цуцалсан шийдвэрийн дараа нөхөр нь эхнэрээ машинд суулгаад явсан. Урьдчилан бэлдсэн газар эхнэрээ аваачаад, нүцгэлэн дөрөв таван цагийн турш хүчиндэхээр оролдсон. Эхнэр нь орилж хашгиран боломж олгоогүй ба шөнө дунд болсон хойно нүцгэн зугтаж амиа аварсан” гэж шүүгч ярьж байв.³⁹⁷

“Гэрлэлтээ цуцлуулаад тусдаа амьдарч эхэлсэн ч нөхөр нь ойр ойрхон ирж үргэлж хаалгыг нь эвдэж байсан. Тэр бүрт цагдаа дууддаг ч тусалж чадаагүй” гэж нэг хохирогч ярьсан.³⁹⁸ Учир нь ГБХТТХууль зөвхөн гэр бүлийн гишүүд, төрөл төрөгсөд, эсвэл хамт амьдардаг хүмүүст л үйлчилнэ³⁹⁹, гэрлэлт цуцалсны дараа эрх хязгаарлах арга хэмжээ авах боломжтой эсэх нь хуулиар тодорхой биш. Нэгэн шүүгч “ийм практик байхгүй ч онолын хувьд бид гэрлэлт цуцалсны дараа эрх хязгаарлах арга хэмжээ авч болно гэж итгэдэг, гэхдээ....хохирогч ийм хүсэлт гаргах нь хууль ёсных эсэхийг бид нар мэдэхгүй” гэж хэлсэн.⁴⁰⁰

³⁹⁴ Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар 1, Д хот, 2013. 3 -27,10:00

³⁹⁵ Сумын шүүгчийн ярилцлага, Б хот, 2013. 1 -28, 9:00

³⁹⁶ Дүүргийн шүүгчийн ярилцлага1, Д хот, 2013. 3 -28,10:00. ТББ- ын ярилцлага, Б хот, 2013.1 -28, 14:00 (салсан нөхөр нь хохирогчийн гэрт нь ирж түүнийг хүүхдийнх нь хамт зодож, хэл амаар доромжилсон.)

³⁹⁷ Шүүгчийн ярилцлага, Г хот, 2013. 3 -22,11:00

³⁹⁸ ТББ- тай хийсэн ярилцлага, Э хот, 2013. 3 -18, 11:00.

³⁹⁹ Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль, 3 дугаар зүйл.

⁴⁰⁰ Сумын шүүгчийн ярилцлага, Б хот, 2013 .1-28, 9:00

ХАМГААЛАХ БАЙР, ДЭМЖИХ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ХҮРЭЛЦЭЭГҮЙ БАЙДАЛ

Хамгаалах байруудын хэрэгцээ

Хүчирхийллийн хохирогчийн аюулгүй байдлыг хамгаалах нэг арга зам нь төрийн зүгээс хохирогчийг аюулгүй байраар хангах явдал юм. Хэдийгээр хамгаалах байр нь хохирогчийг хамгаалах түр зуурын алхам ч хуулийн байгууллагад хандсан үедээ аюулгүй байдлаа хангах боломжийг хүчирхийллээс зугтаж буй эмэгтэйчүүдэд олгодог. “Энэ бүх дарамт, хүчирхийллээс болоод би бодох, шийдвэр гаргах ямар ч чадваргүй болсон байсан” гэж нэгэн хохирогч хэлсэн.⁴⁰¹ “Хамгаалах байранд байрлаж, зөвлөгөө авснаар өөртөө итгэх итгэл нэмэгдэж, хүчирхийлэлтэй харилцааг орхих шийдвэр гаргасан” гэж хохирогч хэлсэн.⁴⁰² “Намайг хүчирхийллийг даван түүлахад, хүчтэй зоригтой байхад хамгаалах байрны ажилтнууд маш их тусалсан. Тэд байгаагүй бол би хэзээ ч давж гарч чадахгүй байсан” гэж маш хүнд гэмтэл авсны улмаас хүчирхийллээс дайжин 15 жилийн өмнө ХЭҮТ-ийн хамгаалах байранд байрлаж байсан талаараа нэг хохирогч дурсан ярьсан.⁴⁰³

Санхүүжилт, нөөц хүрэлцээгүй

ГБХТТХуулиар гэр бүлийн хүчирхийллийн хохирогчийг хамгаалах байраар хангах талаар хуульчилсан ч⁴⁰⁴ бодит байдал дээр хамгаалах байр хүрэлцээгүй байна. Хамгаалах байрны санхүүжилт эсвэл шинээр байгуулах талаар хуульд тодорхой тусгаж өгөөгүй.⁴⁰⁵ Одоогоор ажиллаж байгаа хамгаалах байр нь гадны санхүүжүүлэгч байгууллагын төслийн санхүүжилт, Нийгмийн халамж, үйлчилгээний газартай гэрээлсэн ажиллагааны зардал болон ТББ-ын хөрөнгө босгох замаар олсон нөөцийг зарцуулж байна. Бусад хамгаалах байрууд нь санхүүгийн нөөц хязгаарлагдмал байдлаас шалтгаалан хаагдсан. Монгол улсын хэмжээнд зөвхөн нэг хамгаалах байр л бүрэн хэмжээгээр үйл ажиллагаа явуулж байна.⁴⁰⁶ Энэ нь нийслэл Улаанбаатар хотод байрладаг⁴⁰⁷ 20 ортой ч өвлийн улиралд багтах зайгүй болдог. Хамгаалах байр дүүрсэн үед хохирогчийн амь нас, эрүүл мэндэд ноцтой аюул занал тулгарсан ч авах ямар ч боломжгүй болдог.⁴⁰⁸ Улаанбаатар хотод ХЭҮТ-ийн хамгаалах байрнаас гадна эмнэлэгт түшиглэсэн Нэг цэгийн үйлчилгээний төвүүд ажилладаг. Энэ 3 төв нь гэр бүлийн хүчирхийллийн хохирогчийг аюул, эрсдэлтэй үед нь харъяалал харгалзахгүй 72 цаг хүртэл хугацаагаар байрлуулдаг.⁴⁰⁹ Эдгээр төвүүдэд хоол, хүнсний төсөв байдаггүй

⁴⁰¹ Хохирогчийн ярилцлага, Б хот, 2013.1 - 29, 15:00. 10, 16, 18, 20, 51, 54 болон 55 хуудсанд иш татсан

⁴⁰² Дээр дурдсан.

⁴⁰³ Хохирогчийн ярилцлага, Б хот, 2013.1 - 21, 16:00

⁴⁰⁴ Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль. 5.1.3, 9.1.4, 15.1.1, 16.1.2. дугаар зүйл

⁴⁰⁵ Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль засгийн газар “ хуулийн 7.1.1 дугаар зүйлд заасан хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд шаардагдах зардлыг улсын төсвөөс хангах, шаардагдах төсвийг УИХд танилцуулах, 7.1.2 болон 7.2.2 дугаар зүйлд заасан хамгаалах байранд тавигдах шаардлага

⁴⁰⁶ ТББ-ын ярилцлага, Д хот, 2013, 2 - 1, 10:00 Хамгаалах байранд нийгмийн ажлын үйлчилгээ үзүүлдэг.Хуульчийн ярилцлага, Д хот, 2013, 1 - 30,12:00. “Цөлийн сарнай” байгууллагаас охидод зориулсан хамгаалах байрны үйлчилгээ үзүүлдэг. Гэвч,энэ байранд 20-оос дээш настай эмэгтэйг байрлуулах боломжгүй байдаг. ТББ-ын ярилцлага, Д хот, 2013. 1 - 29, 9:00.

⁴⁰⁷ Хамгаалах байр нь Нийгмийн халамж үйлчилгээний газар, олон улсын “ Dufresne, Gauthier” сангийн дэмжлэг болон ХЭҮТ-ийн хөрөнгө босгох үйл ажиллагаанаас санхүүждэг. Судлаач Хэлэн Рубенстэйнд ТББ-аас ирсэн цахим шуудан (2013.7- 16) (судлаачын файл).

⁴⁰⁸ ТББ-ын ярилцлага, Д хот, 2013. 2 -1, 10:00

⁴⁰⁹ Сувилагчийн ярилцлага, Д хот, 2013. 1 -21,10:00;Нийгмийн ажилтны ярилцлага, Д хот, 2013. 1 - 21,10:00

учраас урт хугацаагаар байрлуулах боломжгүй. Эндээс хохирогч ХЭҮТ-ийн хамгаалах байр луу эсвэл өөр газар очихоор явдаг.⁴¹⁰

Санхүүжилт хүрэлцээгүйн улмаас хамгаалах байрууд хаагдаж байна.

Монгол улсад өмнө нь Улаанбаатар хот дахь хамгаалах байрыг оролцуулан 5 хамгаалах байр ажиллаж байсан ч бүгд санхүүжилтгүйн улмаас хаалгаа хаахад хүрсэн.⁴¹¹ Нэгэн аймагт 2009 оны 6 дугаар сараас 2010 оны 10 дугаар сарын хооронд орон нутгийн санхүүжилттэй хамгаалах байр үйл ажиллагаагаа явуулж байсан. Энэ байр нь нэг удаа 8 эмэгтэйг 10 хүртэлх хоног байрлуулах боломжтой байсан. 2010 онд, орон нутгийн захиргаа нь дээрх байрыг зарсан учраас хамгаалах байрны үйлчилгээ зогссон.⁴¹² Гурван хүүхэд, эхийнх нь өмнө эхнэрийнхээ амь насыг нь хороосон хэргийн шалтгааныг хамгаалах байр хаагдсантай холбож нэгэн өмгөөлөгч тайлбарлахдаа:⁴¹³

“Энэ хэрэг хамгаалах байр хаагдсаны дараа болсон. Эхнэр нь амь насаа эрдэлд байгааг тухайн үед мэдэж байсан. Хэрвээ хамгаалах байр ажиллаж байсан бол тэнд очиж нуугдах байсан. Байхгүй болохоор ээжийнхээ гэрт очсон. Нөхөр нь түүнийг хаана байгааг олж мэдээд хөнөөсөн. . . Хамгаалах байр байсан бол тэр эмэгтэй амь насаа алдахгүй байх байсан даа гэж өдийг хүртэл бид ярилцсаар л байгаа. . . . Ийм хэрэг дахин гарахгүй гэсэн баталгаа байхгүй, эмэгтэйчүүд эрсдэлтэй байгааг бид мэдсэн ч хангалттай тусалж чаддаггүй”⁴¹⁴

“Хуулиар хамгаалах байрны санхүүжилтийг төрөөс хангах талаар тодорхой зааж өгөөгүй тохиолдолд хамгаалах байрууд дахин нээгдэж чадахгүй, үйлчилгээ үзүүлэх боломжгүй хэвээр л байх болно” гэж нэгэн судалгаанд ярилцлага оролцогч ярьсан.⁴¹⁵

Санхүүгийн эх үүсвэр байхгүйн улмаас хоёр ч аймгийн хамгаалах байр хаагдсан. Үүний нэг нь урсгал засвар хийх зардал байдаггүйгээс шалтгаалан хүн байрлах боломжгүй болсон.⁴¹⁶ Эдгээр хамгаалах байрны нэг нь хаалга, цонх нь эвдэрсэн, өвлийн улиралд халаалтгүй байдаг. Учир нь хамгаалах байранд орон нутгийн төсвөөс урсгал засвар, хоол хүнсний зардал гэж өгдөггүй. Иймд дахин ажиллуулах нөөц бүрдэх хүртэл уг хамгаалах байрыг түр түрээсэлсэн.⁴¹⁷

⁴¹⁰ Сувиллагчийн ярилцлага, Д хот, 2013. 1 -21,10:00; Нийгмийн ажилтны ярилцлага, Д хот, 2013. 1 - 21,10:00

⁴¹¹ ТББ -ын ярилцлага, С хот, 2013. 3 -18,1730; Хүн амын хөгжил, нийгмийн хамгааллын яам, Улаанбаатар хот, 2013. 1 -22, 14:30; ТББ-ын ярилцлага, Д хот, 2013. 2 - 1,10:00.

⁴¹² ТББ-ын ярилцлага, С хот, 2013. 3- 18,17:30

⁴¹³ Хүүдас 49.

⁴¹⁴ Хуульчийн ярилцлага, С хот, 2013. 3 -18,9:00

⁴¹⁵ Дээр дурдсан

⁴¹⁶ ТББ-ын ярилцлага, Д хот, 2013. 2 -1, 10:00; ТББ-ын ярилцлага, Д хот, 2013. 2 - 1, 10:00; Хууль зүйн хэлтэс, Г хот, 2013.3сар 21,10:00; Олон нийттэй харилцах алба, Г хот, 2013. 3 - 21,15:30; Хүүхдийн нийгмийн ажилтны ярилцлага, Г хот, 2013. 3 - 22, 9:30

⁴¹⁷ Хууль зүйн хэлтэс, Г хот, 2013.3- 21,10:00; Цагдаагийн ажилтны ярилцлага, Г хот, 2013. 3- 21, 11:00; Хүүхдийн нийгмийн ажилтны ярилцлага, Г хот, 2013. 3- 22, 9:30

Монгол улсын бусад аймгуудад хамгаалах байрны үйлчилгээ үзүүлэх санаачилга гарсан ч санхүүжилтгүйн улмаас зогсонги байдалд орсон. Нэгэн өмгөөлөгч аймагтаа хамгаалах байр байгуулах хөрөнгө босгох гэж хичээж ажилласан. 2011 онд тэр өмгөөлөгч цагдаагийн байгууллагын хажууд газар авсан ч санхүүжилтгүйн улмаас өнөөг хүртэл хамгаалах байр барьж чадаагүй. Орон нутгийн захиргаандаа хандан дэмжлэг хүссэн ч анхаараагүй.⁴¹⁸

Дээр дурдсанчлан, хамгаалах байрны ихэнх зардлыг ТББ нуруун дээрээ үүрч байна. Засгийн газраас хамгаалах байранд зориулсан шууд санхүүжилт байдаггүй ч Нийгмийн халамж, үйлчилгээний газраас түр хамгаалан байрлуулах үйлчилгээг гэрээлэн гүйцэтгэлээр санхүүжүүлдэг.⁴¹⁹ Уг үйлчилгээг гэрээлэх замаар санхүүжилт олгож байгаа ч шаардагдах суурь зардлыг хангах хэмжээнд хүрэхгүй гэж яамны төлөөлөгч онцолсон.⁴²⁰

Орон нутаг дахь хамгаалах байрны хэрэгцээ

Орон нутагт хамгаалах байр нэн шаардлагатай байна. Судалгаанд оролцогчдын зарим нь “аймаг бүрт нэг хамгаалах байр байх хэрэгцээтэй” гэж онцолсон бол, нөгөө хэсэг нь “сумын түвшинд ч хамгаалах байр хэрэгтэй” гэсэн санал хэлсэн.⁴²¹ Одоо ажиллаж буй цөөхөн хамгаалах байранд хүрч очих гэж зарим эмэгтэйчүүд маш их хүчин чармайлт гаргахаас өөр аргагүй болдог тул орон нутагт хамгаалах байр зайлшгүй шаардлагатай. “Орон нутгаас ирсэн зарим эмэгтэйд зөвхөн 3-4 хоног л байрлах боломж олгодог” тухайгаа Нэг цэгийн үйлчилгээний төвийн ажилтан ярьсан.⁴²² Нэг цэгийн үйлчилгээний төв эсвэл ХЭҮТ-ийн хамгаалах байранд байрласан ихэнх эмэгтэйчүүд урт хугацаагаар байрлуулах боломжгүйгээс хүчирхийлэлтэй харилцаа руугаа буцахаас өөр гарц байдаггүй.⁴²³

Саяхан орон нутагт хаагдсан хамгаалах байрны ажилтан эмэгтэйчүүд хэрхэн урт зам туулж ирдэг тухай ярьсныг уншина уу:

“Нэг эмэгтэй 137 км зам туулж ирсэн. Гэр нь алслагдсан газар байдаг, нөхөр нь согтуу ирээд зодсон тохиолдолд тэр эмэгтэй олон удаа гадаа хонож байсан . . . Хамгийн сүүлд нөхөр нь түүнийг гэрийн униар зодож алах шахсан. Түүний нуруу маш их хөхрөлт, гэмтэлтэй, тэр их айдастай ирсэн”⁴²⁴

Тухайн үед тэр эмэгтэйг хамгаалах байр хүлээж авах боломжтой байсан. Түүнд эрүүл мэндийн яаралтай үйлчилгээ үзүүлж, цагдаад хандах хүртэл нь аюулгүй байранд байрлуулсан.⁴²⁵

⁴¹⁸ ТББ -ын ярилцлага, Ф хот, 2013. 3 -21, 9:00

⁴¹⁹ Нийгмийн халамж үйлчилгээний газрын ажилтны ярилцлага, Д хот, 2013. 1- 24, 14:00; Хүн амын хөгжил, нийгмийн хамгааллын яам, Улаанбаатар хот, 2013. 1- 22, 14:30.

⁴²⁰ Хүн амын хөгжил, нийгмийн хамгааллын яам, Улаанбаатар хот, 2013. 1 - 22, 14:30. Халамжийн газрын ажилтны ярилцлага, Д хот, 2013. 1 -24, 14:00

⁴²¹ Хууль зүйн хэлтэс, Г хот, 2013.3 -21,10:00; Олон нийттэй харилцах алба, Г хот, 2013. 3 -21,15:30.

⁴²² Сувилагчийн ярилцлага, Д хот, 2013.1 - 21, 10:00.

⁴²³ Дээр дурдсан.

⁴²⁴ ТББ -ын ажилтны ярилцлага, С хот, 2013. 3 -18,17:30

⁴²⁵ Дээр дурдсан.

Аймгуудад хамгаалах байр байхгүй учраас олон эмэгтэй, хүүхдүүдийнхээ хамтаар найз нөхөд, гэр бүлийн гишүүдийнхээ гэрт хоргодож байдаг.⁴²⁶ Хүчирхийлэл үйлдэгч эмэгтэйд хялбархан олоод оччихдог.⁴²⁷ Нэгэн тохиолдол: нөхөр нь алх, хутга барьж эхнэр, хүүхдээ ална гэж дайрч давшилсны дараа тэр эмэгтэй хамаатныдаа очсон ба нөхрөө олоод ирнэ гэж айж түгшсээр л байсан.⁴²⁸ Ямар тохиолдолд та өөрийгөө аюулгүй байна гэж үзэх байсан бэ гэсэн асуултанд хохирогч хариулахдаа:

“Ямар ч л байсан намайг олохгүй газар надад хэрэгтэй байна. Хэрвээ хамгаалах байр байсан бол тэр намайг олоод ирэхгүй байсан”⁴²⁹

Хамгаалах байр хүрэлцээгүй байх нь үйлчилгээ үзүүлэх үүрэг хүлээсэн үйлчилгээний ажилтнуудад хүндрэл авчирдаг. Хамгаалах байрны хүрэлцээг нэмэгдүүлэх нэн шаардлагатайг судалгааны явцад оролцогчид онцгойлон хэлж байсан.⁴³⁰ Хохирогч хамгаалалт хүсээд ирэхэд нь хамгаалах байр дүүрчихсэн байсан тул түүний аюулгүй байдлыг хангах зүйл хийж чадаагүй тухайгаа нийгмийн ажилтан тайлбарласан.⁴³¹

Хамгаалах байр аюулгүйн баталгааг хангах нь

Орон нутагт хамгаалах байр байхгүйн улмаас хохирогч хамгаалагдаж чадаагүй тухай өмгөөлөгчийн тайлбар:

“Нөхөр нь хайж олох боломжтойгоос эмэгтэй амь насаа алдсан хэрэг гарсан. Тэд гэрлээгүй ч хамтран амьдардаг байсан. . түүнийг хамтран амьдрагч нь бараг өдөр бүр хүчирхийлдэг байсан. ХЭҮТ-д хандаж ирэхэд нь түүнд гэр лүүгээ буцаж очих хэрэггүй, найзындаа очоорой гэж зөвлөсөн байдаг. Тэр үед 11 дүгээр сар байсан ч тэр эмэгтэй дулаан хувцасгүй, зүгээр л ноосон цамцтай ирсэн. Хамтрагч нь бүх хувцсыг нь шатаасан гэж хэлсэн. . . Тэр найзындаа очсон ч хамтран амьдрагч нь найзынх нь гэрийг олоод очсон. Удалгүй аль аль нь нас барсан олдсон, хамтран амьдрагч нь эмэгтэйд эхэлж хөнөөгөөд, дараа нь өөрийнхөө амийг хороосон байсан. Энэ бол маш харамсалтай хэрэг. Хэрвээ хамгаалах байр байсан бол эмэгтэй амьд байх байсан гэж хааяа боддог”⁴³²

Зарим эмэгтэйчүүд найз нөхөд, гэр бүлийнхнээ энэ асуудалд оролцуулах сонирхолгүй байдаг. Энэ тохиолдолд хамгаалах байр зайлшгүй хэрэгтэй. Нөхөр нь нь ална гэж сүрдүүлсэн эмэгтэйн тайлбар:

⁴²⁶ ТББ-ын ажилтны ярилцлага, Б хот, 2013.2 - 1, 9:00..

⁴²⁷ Дээр дурдсан

⁴²⁸ Хохирогчийн ярилцлага, Б хот, 2013.1 -31, 15:30. Энэ хохирогчийн түүх 10, 19, 20, 28, 29 болон 53 хуудсанд иш татагдсан

⁴²⁹ Дээр дурдсан.

⁴³⁰ Сургуулийн нийгмийн ажилтны ярилцлага, Б хот, 2013. 1 -29, 10:45; Нийгмийн ажилтны ярилцлага, Б хот, 2013. 1 - 30, 10:00; ТББ -ын ярилцлага, Б хот, 2013. 2-1419:00; Багийн засаг даргын ярилцлага, Э хот, 2013. 3 -19, 9:30; ТББ-ын ярилцлага, Э хот, 2013. 3 -19,11:00; Цагдаагийн ажилтны ярилцлага, Э хот, 2013. 3 -19,14:30; Цагдаагийн ажилтны ярилцлага, А хот, 2013.3 -21,11:30; Нийгмийн ажилтны ярилцлага, А хот, 2013.3 -22, 9:00.

⁴³¹ Нийгмийн ажилтны ярилцлага, А хот, 2013.3 -22, 9:00. ТББ -ын ярилцлага, Ф хот, 2013.3 - 21, 9:00 (“Хамгаалах байр байх нь чухал. Аймаг бүрт хамгаалах байр хэрэгтэй. Орон нутагт эмэгтэйчүүдэд унааны асуудал бэрхшээлтэй байдаг, гэвч хамгаалах байр байвал тэд хүрч ирнэ. Би тэдэнд туслах боломжтой болно.)

⁴³² ТББ-ын ярилцлага, Б хот, 2013.2 - 1, 9:00.

“Хамгаалах байр байсан бол их хэрэгтэй байх байсан. Түүнийг согтуу ирэхэд зугтаад очих газар олддоггүй. Би ах дүү нар дээрээ очихыг хүсдэггүй, учир нь хувийн амьдралаа тэдэнд дэлгэмээргүй байна. Түүнийг согтуу ирсэн үед би голдуу зочид буудал руу явдаг. Надад одоо аавынх руугаа эсвэл зочид буудал гэсэн сонголт л байна”⁴³³

Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны үеэр хохирогчийн аюулгүй байдлыг хамгаалахад хамгаалах байр чухал үүрэгтэй.⁴³⁴ Нийгмийн ажилтан,⁴³⁵ цагдаагийн ажилтан нар хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалт болон шүүх ажиллагааны үеэр хохирогчийг хамгаалахад хамгаалах байр чухал гэж тайлбарласан. “Хамгаалах байр байхгүй учраас хохирогчийг гэрт нь буцаах боломжгүй тохиолдолд эцэг эх, төрөл төрөгсөд, найз нөхдийнд нь хүргэж өгдөг” гэж цагдаагийн ажилтан хэлсэн.⁴³⁶ Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны үеэр хүчирхийлэл үйлдэгч гомдлоо буцаахыг шаардаж, хохирогчийг шахаж дарамтладаг учир хамгаалах байранд байрлахыг зөвлөдөг.⁴³⁷

Нийгмийн үйлчилгээнүүд

ГБХТТХуулиар хамгаалах байрны үйлчилгээнээс гадна хохирогчийг хамгаалах, дэмжлэг үзүүлэх үйлчилгээнүүдийг тодорхойлсон.⁴³⁸ Гэвч уг үйлчилгээг хэн, хэрхэн хүргэх талаар тодорхой тусгаагүй учраас ТТБ-ын нуруун дээр хэвээр үлдсэн.

Хохирогчийг дэмжих үйлчилгээнүүд

ГБХТТХуулиар гэр бүлийн хүчирхийллийн хохирогчид үйлчилгээ үзүүлэх үүргийг нийгмийн ажилтан зохион байгуулахаар хуульчилсан.⁴³⁹ Гэвч уг үйлчилгээг хэн үзүүлэх, Засгийн газраас хэрхэн дэмжих, хаанаас санхүүжүүлэх талаар тодорхой тусгаагүй. Засгийн газар хохирогчид чиглэсэн үйлчилгээнүүдээс зөвхөн түр хамгаалан байрлуулах үйлчилгээг хүргэхэд бага хэмжээний санхүүжилтийг гэрээний үндсэн дээр өгч байна. Бусад төрлийн

⁴³³ Хохирогчийн ярилцлага, Ф хот, 2013, 3 -33, 9:00 [энэ хохирогчийн түүхийг 12, 13, 17, 28, 35, 36 болон 54 хуудсанд иш татсан]. Хохирогчийн ярилцлага, Б хот, 2013, 1 -29, 15:00, (“Бид очих газар байдаггүй, хамгийн хэцүү үед л би ээжийхнээ гэрт хэд хонодог, гэвч удаан хугацаагаар байрлах газар байдаггүй. Заримдаа бид хаа очихоо ч мэддэггүй”) [Энэ түүхийг 10, 16, 18, 20, 51, 54 болон 55 хуудсанд иш татсан].

⁴³⁴ Эрүүгийн болон захиргааны хариуцлага хүлээлгэхэд тулгарч буй бэрхшээл хэсгээс харна уу.

⁴³⁵ Сүргүүлийн нийгмийн ажилтны ярилцлага, Б хот, 2013. 1 -29,10:45.

⁴³⁶ Цагдаагийн ажилтны ярилцлага, Б хот, 2013. 1 - 29, 14:00.

⁴³⁷ Прокурорын ярилцлага 1, Э хот, 2013. 3 -18, 9:30

⁴³⁸ Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль 15 дугаар зүйл (“Хохирогчийг хамгаалах арга зам, хохирогчийн нууцлалыг хадгалах үүрэг”), 17.5 дугаар зүйл (“17.1 дугаар зүйл шүүхийн шийдвэр нь гэр бүлийн хүчирхийллийн хэргийг захиргааны журмаар шалгах эсвэл эрүүгийн журмаар иргэний хэргийг шийдвэрлэхтэй зөрчилдөж байна”).

⁴³⁹ ГБХТТХуулийн 15 дугаар зүйл: 15.1 .Хохирогчийг хамгаалах зорилгоор дараахь аргыг хэрэглэж болно:

15.1.1 .хамгаалах байранд хүргэх;

15.1.2.эцэг, эх, төрөл, садны хүн, эсхүл хамт олны нь түр хамгаалалтад өгөх;

15.1.3.шаардлагатай гэж үзвэл хүүхэд асран хүмүүжүүлэх, эсхүл нийгмийн халамжийн байгууллагад шилжүүлэх;

15.1.4.энэ хуулийн 15.1.5-д заасан үйлчилгээнд хамруулах.15.1.5. Энэ хуулийн 15.2. Хохирогч нь эрх зүйн асуудлаар хууль зүйн туслалцаа авах, хүчирхийлэл үйлдэгчээс гэрлэлтээ цуцлуулах, хүүхдийн тэтгэлэг гаргуулах, тэжээн тэтгүүлэх, эсхүл хууль тогтоомжийн дагуу эдийн болон эдийн бүс гэм хорыг арилгуулахаар нэхэмжлэл гаргах эрхтэй.15.3.Нийгмийн ажилтан болон энэ хуулийн 12 дугаар зүйлд заасан этгээд зөвлөгөө өгөх явцдаа итгэмжлэлээр олж мэдсэн зүйлээ бусдад задруулахыг хориглоно.15.4.Ажил үүргээ гүйцэтгэж байсантай холбоотой эсэхээс үл хамааран хамгаалах байрны байршлын талаар мэдсэн этгээд энэ тухай бусдад задруулахгүй байх үүрэгтэй.

үйлчилгээг ТББ дангаараа үүрч ирлээ⁴⁴⁰ ХЭҮТ нь хохирогчид зориулсан үйлчилгээг орон нутаг дахь салбаруудаараа дамжуулан үзүүлэхийг зорьдог ч санхүүгийн хязгаарлагдмал байдлаас шалтгаалан хүртээмжтэй хүргэж чаддаггүй. ХЭҮТ-ийн орон нутаг дахь салбарын зохицуулагч нар цалин хөлсгүйгээр, бас үнэ төлбөргүйгээр гэр бүлийн хүчирхийллийн хохирогчийг хамгаалах үйлчилгээг үзүүлж ажилладаг.⁴⁴¹ ХЭҮТ-ийн ганцаарчилсан зөвлөгөө, дэмжих бүлэгт хамрагдсан хохирогчид “өөртөө итгэх итгэлээ эргэж сэргээхэд үнэхээр тустай байсан” тухай хуваалцсан.⁴⁴² Хохирогчид үйлчилгээ үзүүлэх үүргийг ТББ-ын нуруунд үүрүүлснээр хохирогчид өөртөө хамгийн ойр байдаг засаг захиргааны нэгжээсээ үйлчилгээг хүртэх боломжгүй болоход хүргэж байна.⁴⁴³

Зан үйлд нөлөөлөх албадан сургалт ба саад бэрхшээлүүд

ГБХТТХуулиар зан үйлд нөлөөлөх албадан сургалтанд хамруулахыг хүчирхийлэл үйлдэгчийн эрхийг хязгаарлах арга хэмжээний нэг төрөл болгож хуульчилсан.⁴⁴⁴ “Хуульд заасан энэ сургалт огт хэрэгжээгүй”⁴⁴⁵ гэж нийгмийн ажилтан ярьсан. Нэгэн дүүргийн шүүгч зан үйлд нөлөөлөх албадан сургалт байхгүй нь бэрхшээл учруулж байгааг дурдсан:

“Хүчирхийлэл үйлдэгчийг зан үйлд нөлөөлөх албадан сургалтанд хамруулах талаар хуульд тусгагдсан. Гэвч хэрэгжээгүй. . . Шүүгч хуулийг баримтлан хүчирхийлэл үйлдэгчийг зан үйлд нөлөөлөх албадан сургалтанд хамруулах шийдвэр гаргасан ч энэ хөтөлбөрийг хэн, хаана, хэрхэн зохион байгуулах нь тодорхойгүй”⁴⁴⁶

Хүчирхийлэл үйлдэгчийн зан үйлд нөлөөлөх албадан сургалтыг ХЭҮТ түршин хэрэгжүүлж байсан. Цаашид шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага энэ сургалтын зохион байгуулалтыг хариуцаж, ТББ-ууд сургалтыг гардан явуулах боломжтой.⁴⁴⁷ Албадан сургалтыг зохион байгуулах механизм бүрдээгүй, хүчирхийлэл үйлдэгч уг сургалтанд идэвхтэй оролцоогүй тохиолдолд хариуцлага хүндрэх зохицуулалт байхгүй бол ямар ч ач холбогдолгүй болно.⁴⁴⁸

⁴⁴⁰ Нийгмийн ажилтны ярилцага, Д хот, 2013. 1-21, 10:00.

⁴⁴¹ ТББ-тай ярилцлага, Д хот, 2013. 2- 1, 10:30; ТББ-ын ярилцлага, Б хот, 2013.2- 1, 9:00; ТББ-ын ажилтны ярилцлага, Ф хот, 2013. 3 -21 9:00; ТББ-ын ажилтны ярилцлага, С хот, 2013. 3 -18, 17:301730.

⁴⁴² Хохирогчийн ярилцлага, Б хот, 2013. 1 -29, 15:00. Энэ хохирогчийн түүх 10, 16, 18, 20, 51, 54 болон 55 хуудсанд иш татагдсан.

⁴⁴³ Нийгмийн халамж үйлчилгээний газар, Д хот, 2013.1 - 24,14:00(харьяа дүүрэгт нь нэг цэгийн үйлчилгээ байгуулах хүсэлт ирсэн).

⁴⁴⁴ Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль,16.1.5 дугаар зүйл (зан үйлд нөлөөлөх албадан сургалтад хамруулах); 7.3.2 дугаар зүйл(гэр бүлийн хүчирхийлэл үйлдэгчийн зан үйлд нөлөөлөх албадан сургалтын хөтөлбөрийг нийгмийн хамгааллын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагатай хамтран баталж, мөрдүүлэх).

⁴⁴⁵ “Эрчүүдийн холбоо” сэтгэл зүйчийн ярилцлага, Д хот, 2013. 1 -30, 9:00. Хүн амын хөгжил, нийгмийн хамгааллын яам, Бодлого хэрэгжүүлэлт, зохицуулалтын газар, Улаанбаатар, 2013. 1 -22,14:30 (“гэр бүлийн хүчирхийллийн хохирогчид олон үйлчилгээ үзүүлэх боломжтой байдаг. Гэвч, хөтөлбөрүүд байдаггүй, жишээ нь зан үйл өөрчлөх хөтөлбөр, энэ талаар би сонсож байгаагүй”); Хүүхдийн төлөө үндэсний газар, Э хот, 2013. 3- 18, 12:30 (“зан үйл өөрчлөх хөтөлбөрийн талаар би нэг л удаа сонсож байсан, гэхдээ би хэзээ ч олж хараагүй”).

⁴⁴⁶ Дүүргийн шүүгчийн ярилцлага1, Д хот, 2013.3 -28, 10:00.

⁴⁴⁷ Сувилагчтай хийсэн ярилцлага, Д хот, 2013.1-21,10:00 (Эрх хязгаарлах арга хэмжээний нэг хэсэг болох албадан сургалт нь зан үйл өөрчлөх хөтөлбөр юм. Эрх хязгаарлах арга хэмжээ авсан шийдвэр маш цөөхөн байгаа нь энэ хөтөлбөрт цөөн эрчүүд л хамрагдана. Баривчлах байранд “Эрчүүдэд зөвлөгөө өгөх төв” хэлбэрээр энэ төрлийн үйлчилгээг ТББ хэрэгжүүлдэг. Энэ хөтөлбөр нь гэр бүлийн хүчирхийллийн улмаас баривчлагдсан эрчүүдэд мэдээлэл, зөвлөгөө өгч ажилладаг. Цагдаагийн байгууллагаас энэ хөтөлбөрийг үр дүнтэй гэж үзсэн учраас энэ үйлчилгээг ТББ-тай гэрээлэх болж байгаа тухай би сонссон)

⁴⁴⁸ Хуульчийн ярилцлага, Д хот, 2013. 1 -24, 10:00 (Ийм хөтөлбөр байдаг уу гэсэн асуултанд “Сайн дурын үндсэн дээр хамрагддаг ганцаарчилсан болон бүлгийн хэд хэдэн дэмжих бүлгийг ТББ-аас зохион байгуулдаг гэж би боддог. Ийм хөтөлбөр байдаг бол маш цөөхөн ганц эсвэл хоёрхон байдаг байх. . . Оролцоог хангах нь бэрхшээлтэй. Энэ хөтөлбөр бол Цагдаагийн байгууллагаас архины эсрэг хэрэгжүүлдэг хөтөлбөрөөс өөр юм. Хэрвээ энэ зан үйл өөрчлөх хөтөлбөр бол хэн ч хянадаггүй, хүчирхийлэл үйлдэгч хамрагдаггүй.”)

Зан үйлд нөлөөлөх хөтөлбөрийг хэрэгжүүлэхээр оролдож байсан түршлагынхаа талаар ХЭҮТ-ийн зохицуулагч хуваалцсан:

“Эхлээд Цагдаагийн Ерөнхий газартай хамтран Албадан саатуулах, баривчлах төв дээр зан үйлд нөлөөлөх сургалтуудыг зохион байгуулсан. Баривчлагдсэн хүчирхийлэл үйлдэгчдийг суллагдахаас нь өмнө цагдаагийн ажилтны хамт ганцаарчлан уулзаж, цуврал уулзалт, ярилцлага хийдэг байсан. Гэвч санхүүжилтээс шалтгаалан зогссон”⁴⁴⁹

Засаг захиргааны анхан шатны нэгж дээр ажилладаг мэргэжилтнүүдийн хуулиар хүлээсэн үүрэг хариуцлагаа хэрэгжүүлж байгаа байдал

ГБХТТХууль нь гэр бүлийн хүчирхийллийг илрүүлэх, таслан зогсоох, хохирогчийн аюулгүй байдлыг хамгаалах, үйлчилгээ үзүүлэх чиглэлээр Цагдаагийн ажилтан, шүүгч, нийгмийн ажилтан, сум багийн Засаг дарга нар гэх мэт зарим мэргэжилтэн, албан тушаалтнуудын үүрэг хариуцлагыг тусгайлан хуульчилсан.⁴⁵⁰ Гэвч энэ мэргэжилтнүүд хуулиар хүлээсэн үүргээ биелүүлэхэд онцгойлон анхаардаггүй.⁴⁵¹

Нийгмийн ажилтан

ГБХТТХуулиар нийгмийн ажилтан нь хохирогчийн аюулын зэрэг, эрсдлийн түвшинг тогтоож, нөхцөл байдлыг үнэлж, дүгнэлт гаргах үүрэгтэй ч⁴⁵² зарим нийгмийн ажилтан “бидэнд гэр бүлийн хүчирхийлэл байна уу үгүй юу гэж айл өрхүүдээр ажиглалт хийж явах зөвшөөрөл байхгүй” гэж хариулсан.⁴⁵³ Энэ үйлчилгээг хэрхэн үзүүлэх тухай мэргэжлийн удирдамж, чиглэл байдаггүй.⁴⁵⁴ Зарим нийгмийн ажилтан айл өрхүүдээр очиж ажиллах нь ажлын бүс цагаар амжуулах ажил гэж ханддаг.⁴⁵⁵ Гэр бүлийн хүчирхийллийн хэрэгт анхаарал хандуулж ажиллахад удирдлага дэмждэггүй, харин ч зориг мохоож урам хугалдаг тухай багийн нийгмийн ажилтан хуваалцсан: “яагаад энэ хэрэг дээр ийм их цаг зарцуулж байгаа тухай” дарга нар асууж уцаарладаг. Ингээд удирдлагын зүгээс өөр ажил хийх үүрэг өгдөг”⁴⁵⁶ Гэр бүлийн хүчирхийллийн хохирогчдод үйлчилгээ үзүүлэх үүргийг ажлын байрны тодорхойлолт, ажлын гүйцэтгэлийг үнэлэх үнэлгээнд багтаах шаардлагатайг судалгаанд хамрагдсан нийгмийн ажилтнууд хуваалцсан.⁴⁵⁷ Хороо, багийн түвшинд гэр бүлийн хүчирхийллийн асуудал дээр анхаарал хандуулж ажиллахад шаардлагатай төсөв байдаггүй

⁴⁴⁹ ТББ-тай хийсэн ярилцлага, Б хот, 2013. 2 - 1, 9:00

⁴⁵⁰ Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль

⁴⁵¹ 14 дүгээр зүйл

⁴⁵² Дээр дурдсан. 10.1.1. дугаар зүйл

⁴⁵³ Нийгмийн ажилтны ярилцлага, Д хот, 2013. 1 - 24, 16:00.

⁴⁵⁴ Нийгмийн ажилтны ярилцлага, Д хот, 2013. 1 - 24, 16:00; Хуульчийн ярилцлага, Ф хот, 2013. 3 - 23, 18:00

⁴⁵⁵ Нийгмийн ажилтны ярилцлага, Д хот, 2013. 1 - 24, 16:00

⁴⁵⁶ Багийн нийгмийн ажилтны ярилцлага, Б хот, 2013. 1 сар 31, 14:00 (“Заримдаа бид өрхүүдэд очиж уулзалт хийж, кейс дээр ажиллахад багийн засаг дарга биднийг ийм ажил хийлээ гэж буруутгадаг. . . .Заримдаа өрхүүдэд очиж ажиллах, кейс менежмент хийхийг дарга зөвшөөрдөггүй”)

⁴⁵⁷ Нийгмийн ажилтны ярилцлага, Д хот, 2013.1 - 23, 10:00; Нийгмийн ажилтны ярилцлага, Д хот, 2013. 1 - 24, 16:00; Хуульчийн ярилцлага, Ф хот, 2013. 3 - 23, 18:00

талаар нийгмийн ажилтнууд онцгойлж байсан.⁴⁵⁸ Хязгаарлагдмал санхүүжилтын улмаас ажилтнууд хүрэлцээгүй байдаг. Иймээс хохирогчийн хэрэгцээг анхаарч ажиллах гэхээр олон кейс дээр зэрэг ажиллах шаардлага нь хүндрэл учруулдаг.⁴⁵⁹

Сум, багийн Засаг дарга

Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэхэд сум, багийн Засаг дарга нарын үүрэг хариуцлагыг хуульчилсан байдаг ч,⁴⁶⁰ ихэнх Засаг дарга нар анхаарал хандуулдаггүй.⁴⁶¹ Сум, баг, хорооны Засаг дарга нь өөрийн нутаг дэвсгэрт харьяалагдах гэр бүлийн хүчирхийллийн хэрэгт хариу арга хэмжээ авах үүрэгтэй.⁴⁶² Гэвч тэдэнд хариу арга хэмжээ авах чадавх байхгүй, асуудалд ач холбогдол өгдөггүй учраас хуулиар хүлээсэн үүргээ биелүүлж чаддаггүй. Тухайлбал, ГБХТТХуулиар сум, баг, хорооны Засаг дарга гэр бүлийн хүчирхийллийн хэрэг дээр хамтарсан багаар ажиллахад шаардагдах зардлыг төсөвтөө тусгах ёстой ч малын өвс тэжээл зэрэг асуудалд илүү анхаарал хандуулдаг. Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэхэд зориулж тусгайлан хөрөнгө төсөвлөдөггүй. “Багийн төсөвт харьяа малчин өрхүүдээр явж, мал тооллого хийхэд зориулан унааны зардлыг тусгаж өгдөг хэрнээ тархай бутархай нүүдэллэн амьдардаг малчин өрхүүдээр гэр бүлийн хүчирхийлэл гарч байгаа эсэхэд хяналт тавьж ажиллах унааны зардал байдаггүй нь бэрхшээлтэй байдаг” гэж нэгэн багийн Засаг дарга тайлбарласан.⁴⁶³ Засаг дарга нар гэр бүл бүрийн нөхцөл байдлыг хянах ёсгүй хэдий ч, ГБХТТХуулиар хүчирхийллийг таслан зогсоох, хүчирхийлэл үйлдэгчид шаардлага тавих, хохирогчийн аюулгүй байдлыг хамгаалах үүргээ хэрхэн хэрэгжүүлэх талаар мэддэг байх хэрэгтэй.

⁴⁵⁸ Нийгмийн ажилтны ярилцлага, Д хот, 2013.1-23, 10:00; Нийгмийн ажилтны ярилцлага, Д хот, 2013. 1- 23, 10:00;Өмгөөлөгчийн ярилцлага, Б хот, 2013. 1- 28,14:00; ТББ-ын өмгөөлөгчийн ярилцлага, Э хот, 2013. 3-19, 11:00; Багийн зохион байгуулагчийн ярилцлага, Г хот, 2013. 3- 22 14:00; Нийгмийн ажилтны ярилцлага, Д хот, 2013. 1 -23,11:00; Багийн засаг даргын ярилцлага1, Э хот, 2013. 3-19,9:30.

⁴⁵⁹ Нийгмийн ажилтны ярилцлага, Д хот, 2013. 1-23, 10:00; Нийгмийн ажилтны ярилцлага, Д хот, 2013. 1сар 24, 16:00; Нийгмийн ажилтны ярилцлага, Б хот, 2013.1 - 29,10:45; Нийгмийн ажилтны ярилцлага, А хот, 2013. 3 -29, 9:00

⁴⁶⁰ Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль, 14.1 дүгээр зүйл:

14.1.Тухайн харьяалах нутаг дэвсгэртээ сум, багийн Засаг дарга гэр бүлийн хүчирхийллийг таслан зогсоох, болзошгүй хүчирхийллээс урьдчилан сэргийлэх талаар дараахь үүрэг хүлээнэ

14.1.1.хохирогчийн аюулгүй байдлыг хангах зорилгоор хүчирхийлэл үйлдэгчийг захиргааны байранд дуудан ирүүлж, шаардлага тавих;

14.1.2.шаардлагатай гэж үзвэл хохирогчийн байгаа гэр, орон байрны аюулгүй байдлыг хангах арга хэмжээ авах, эсхүл боломжтой бол хохирогчийг төрөл, садангийн хүний нь төр хамгаалалтад өгөх;

14.1.3.Гэр бүлийн хүчирхийлэл үйлдэгдсэн тухай хохирогч, хүчирхийлэл үйлдэгч болон гэрчээс асууж, тэмдэглэл хөтлөх, шаардлагатай бусад ажиллагаа явуулах.

⁴⁶¹ Багийн засаг даргын ярилцлага, Б хот, 2013. 1- 30, 14:00 (Гэр бүлийн хүчирхийлэлд анхаарал бага хандуулдаг гэсэн түүний яриа); Дүүргийн шүүгчийн ярилцлага, Г хот, 2013. 3 -22 11:00 (“Ер нь бол орон нутгийн удирдлага сайн анхаарч үздэггүй, тэд энэ талаар мэддэггүй гэж бодож байна”); Багийн цагдаагийн ажилтны ярилцлага,Э хот, 2013.3 -19 14:30 (Багийн засаг дарга энэ асуудалд анхаарал хандуулдаг уу гэсэн асуултанд : “ хэрвээ дарга нарыг энэ сургалтанд хамруулдаг бол тэд хуулиа мэддэг болно. Тэдний ихэнх нь хуулиа мэддэггүй”); ТББ-ын утасны зөвлөгчийн ярилцлага , Д хот, 2013.1 -31, 9:00 (“Орон нутгийн удирдлагуудын ихэнх нь үүргээ мэддэггүй”); ТББ-ын ажилтны ярилцлага, Б хот, 2013. 2 -1, 9:00 (“Бодит байдал дээр сум, багийн засаг дарга нар тийм ч их зүйл хийдэггүй”).

⁴⁶² Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль,14 дүгээр зүйл.

⁴⁶³ Багийн засаг даргатай хийсэн ярилцлага1, Э хот, 2013. 3 -19, 9:30.

Зарим Засаг дарга нар өөрсдийгөө цагдаагийн ажилтан, нийгмийн ажилтан нарт чиглэл өгч ажиллах үүрэгтэй л гэж ойлгодог.⁴⁶⁴

*“Засаг даргын гол үүрэг бол нийгмийн ажилтан, хэсгийн байцаагч нарт гэр бүлийн хүчирхийллийн хэргийг хэрхэн илрүүлэх талаар чиглэл өгч ажиллах юм. Дараа нь тухайн хэрэгт шаардлагатай мэргэжлийн үнэлгээ хийж, холбон зуучлах үйлчилгээ үзүүлнэ. Бид багийн түвшинд хэргийг илрүүлж, дараагийн шат руу холбон зуучлахад мэргэжилтнүүдийг удирдамжаар хангаж ажилладаг” гэж нэг багийн Засаг дарга ярьсан.*⁴⁶⁵

Сум, баг, хорооны Засаг дарга нар гэр бүлийн хүчирхийллийн мөн чанарын талаар ойлголт, мэдлэг байхгүй, хандлага сөрөг, нөөц чадавх хангалтгүй зэрэг хүчин зүйлсээс шалтгаалан хуулиар хүлээсэн үүргээ үр дүнтэй биелүүлдэггүй. Тэд хохирогчийг хамгаалж, хүчирхийлэл үйлдэгчид хариуцлага тооцож ажиллаж чаддаггүй.

⁴⁶⁴ Багийн засаг даргын ярилцлага, Б хот, 2013. 1 - 30, 14:00 (“Заримдаа хүчирхийлэл үйлдэгч архинаас хамааралтай байдаг учраас архины эмчилгээний хөтөлбөрт шилжүүлдэг. Эрүүгийн шинжтэй ямар нэг зан авир илрүүлбэл, цагдаагийн байгууллагад шижлүүлдэг. Харин, зөвлөгөө өгч ажиллах хангалттай орон байр багт байдаггүй.”)

⁴⁶⁵ Багийн засаг даргатай хийсэн ярилцлага, Б хот, 2013. 1- 30, 14:00.

ДҮГНЭЛТ

Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх, хохирогчийг хамгаалах үүрэг хариуцлагаа Монгол улс хэрхэн хэрэгжүүлж байгаад энэ судалгааны хүрээнд хөндлөнгийн хяналт хийлээ. Монгол улсын төр, засаг хүний эрхийг бүх түвшинд хангах талаар олон улсын хамтын нийгэмлэгийн өмнө хүлээсэн үүрэг, амлалтаа биелүүлэхийг чармайж байгаагийн баталгаа нь 2004 онд ГБХТТХуулийг баталсан явдал юм.

Монгол улс эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийлэлтэй тэмцэх анхны алхмаа гэр бүлийн хүчирхийлэлд анхаарал хандуулж чадсан хууль баталснаар эхэлсэн. Энэ судалгааны тайлангаар төрийн албан хаагчид гэр бүлийн хүчирхийлэлд анхаарал хэрхэн хандуулж ажилладаг, хуулийн цоорхой түүнд тулгарч буй саад бэрхшээл нь хохирогчийн аюулгүй байдлыг хэрхэн эрсдэлд оруулж, хүчирхийлэл үйлдэгчид хариуцлагаас мултрах боломж олгож байгааг бодит жишээгээр үзүүлж, хуулийн хэрэгжилтэнд тогтмол хяналт, үнэлгээ хийх шаардлагатайг байгааг анхааруулсан.

ГБХТТХуулийн хамрах хүрээ, зохицуулалт явцуу байгаагаас гадна хэрэгжилт хангалтгүй байна. ГБХТТХууль хэрэгжиж эхэлснээс хойш 9 жилийн хугацаанд хохирогчийг хамгаалах зорилгоор цөөхөн тооны эрх хязгаарлах шийдвэрийг шүүхээс гаргажээ. Төрийн албан хаагч, хуулиар үүрэг хүлээсэн мэргэжилтнүүд болон хохирогчдын ойлголт, мэдлэг хомс, нотлох баримт бүрдүүлэхэд тулгардаг бэрхшээл, хохирогчийн аюулгүй байдлын хамгаалалт сул, эрх хязгаарлах шийдвэрийг шүүхээс гаргахгүй байх зэрэг олон төрлийн бэрхшээл байна. Холбогдох хуулиудын уялдаа сул, эрх хязгаарлах шийдвэрийг хэрхэн хэрэгжүүлэх талаар тодорхой удирдамж байхгүйгээс шүүхийн шийдвэр бодит хамгаалалт биш цаас болон хувирч байна. Хохирогчдын аюулгүй байдал хамгаалагдаж чадахгүй байгаа учраас олон эмэгтэйчүүд хүчирхийллээс ангижрах эцсийн боломжийг гэрлэлт цуцлах алхам гэж үзэж байна.

Гэр бүлийн хүчирхийллийн хэргийг шийдвэрлэхэд гол үүрэг гүйцэтгэх ёстой цагдаагийн ажилтан, нийгмийн ажилтан, Засаг дарга, прокурор, шүүгч, эрүүл мэндийн ажилтан нар нь гэр бүлийн хүчирхийллийн мөн чанарыг ойлгодоггүйгээс хохирогчийг буруутгадаг хэвшмэл, сөрөг хандлагатайн зэрэгцээ хуулиар хүлээсэн үүрэг хариуцлагаа гүйцэд ухамсарлахгүй байна. Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийг хэрэглэх, хохирогчдын аюулгүй байдлыг хамгаалах талаар мэргэшүүлэх сургалтууд тогтмол хийгддэггүй нь хуулийн хэрэгжилт болон хохирогчийг хамгаалахад хүндрэл учруулж байгааг судалгаанд оролцогчид онцлон тэмдэглэсэн.

Эрүүгийн эрх зүйн тогтолцоо нь гэр бүлийн хүчирхийллийн хохирогчийг хуулиас гадуур үлдээж, хамгаалалтгүй орхиж байна. Гэмт хэргийн шинжтэй гэр бүлийн хүчирхийллийн хэрэгт хүчирхийлэл үйлдэгчийг баривчлахгүй, харин эрүүлжүүлэх байранд хүргээд, маргаааш нь суллахыг чухалчилдаг. Гэр бүлийн хүчирхийллийн ихэнх хэрэгт, ялангуяа хүнд гэмтэл учруулсан гэмт хэрэгт эрүүгийн хариуцлага оногдуулахын оронд захиргааны хариуцлага буюу богино хугацаагаар баривчлах, торгох шийтгэл хүлээлгэдэг. Цагдаагийн ажилтан тухайн хэрэгт эрүүгийн хэрэг үүсгэлээ ч хохирогчтой эвлэрсэн гэдэг үндэслэлээр хэрэгсэхгүй болж, хүчирхийлэл үйлдэгч ял завшиж байна.

Дээрх нөхцөл байдлын улмаас хохирогч амь насаа алдаж байгаа нь сэтгэл зовоосон асуудал болж байна. Энэ судалгааны тайланг хэвлэх мөчид 2,8 сая гаруй хүн амтай Монгол улсад 20 ортой нэгхэн хамгаалах байр л үйл ажиллагаагаа явуулж байна. Хүчирхийллээс ангижрах, даван туулахад нь тусалж чадахуйц эдийн засгийн дэмжлэг байхгүй байна. Монгол улсад хамгаалах байр, бусад үйлчилгээнд шаардагдах зардлыг улсын болон орон нутгийн төсөвт суулгадаггүйгээс үйлчилгээний хүртээмж багасч, үүнээс шалтгаалан хохирогчийн аюулгүй байдал хамгаалагдаж чадахгүй байна.

Дэлхийн түвшний судалгаа, практик туршлагаас харахад гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх, хохирогчийн аюулгүй байдлыг хамгаалахад төр болон ТББ-үүд хамтран ажиллах нь сайн загвар болон хөгжиж байна. ХЭҮТ-өөс санаачилсан “Хамтарсан баг”-аар ажиллах арга зүйг үндэсний хэмжээнд нэвтрүүлэх, салбар дундын зохицуулалтыг хангах шаардлага тулгарч байна.

Монгол улсын Засгийн газраас гэр бүлийн хүчирхийллийн хохирогчийн аюулгүй байдлыг хамгаалахын тулд хуулиар үүрэг хүлээсэн мэргэжилтнүүдийг системтэйгээр чадавхжуулах, нийгмийн үйлчилгээ, үртдчилан сэргийлэх үйл ажиллагаанд хангалттай санхүүжилт төсөвлөх шаардлагатай байна. Энэ санхүүжилт нь ГБХТТХуулийг хэрэгжүүлэх, хэрэгжилтийг хянах, эрүүгийн болон иргэний хамгаалалтын хүрээнд хохирогчийг баталгаатай, үр дүнтэй хамгаалах, хохирогчийн эрх, хэрэгцээнд нийцсэн цогц үйлчилгээнүүдийг хөгжүүлэх, хүртээмжийг нэмэгдүүлэх, гэр бүлийн хүчирхийллийн талаарх мэдээллийн санг хөгжүүлэх, олон нийтийн ойлголт, мэдлэгийг нэмэгдүүлэх, эерэг хандлагыг төлөвшүүлэхэд анхаарал хандуулсан байх шаардлагатай.

Хохирогчийн аюулгүй байдлыг хангах, хүчирхийлэл үйлдэгчид хариуцлага хүлээлгэхэд тулгарч буй бэрхшээлийг арилгахын тулд дараах зөвлөмжинд анхаарал хандуулж ажиллахыг Судалгааны багаас санал болгож байна.

ЗӨВЛӨМЖ

Монгол Улсын Засгийн газар болон бусад салбарууд цаашид анхаарах зөвлөмжүүд

Улсын Их Хурал

- ❖ Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль тогтоомжийг хэрэгжүүлэхэд шаардлагатай хууль хэрэгжүүлэгч, мэргэшсэн хүний нөөцийг бэлтгэх, цагдаа, прокурор болон шүүгч нарт зориулсан сургалтыг дэмжиж, хүрэлцэхүйц санхүүжилтээр хангах;
- ❖ Гэр бүлийн хүчирхийллийн хохирогчдод чиглэсэн хамгаалах байр болон эрүүл мэнд, нийгмийн ажлын, хууль зүйн зэрэг үйлчилгээ, туслалцаа, хүчирхийлэл үйлдэгчийн зан үйлд нөлөөлөх албадан сургалтын хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагааг хүрэлцэхүйц санхүүжилтээр хангах;
- ❖ 10 мянган хүн ам тутамд нэг хамгаалах байртай байх НҮБ-ын стандартыг хангахад анхаарч, үндэсний хэмжээнд хамгаалах байруудын тоог нэмэгдүүлэхийг зорих, тэдгээрийн урсгал зардал, аюулгүй байдал, дохиолол хамгаалал, хүний нөөц болон тогтмол засварын зардлыг хангах санхүүгийн эх үүсвэрийг шийдвэрлэх;
- ❖ Гэр бүлийн хүчирхийллийн хохирогчдод туслах зорилго бүхий утсаар зөвлөгөө өгөх үйлчилгээг үндэсний хэмжээнд бий болгож хөгжүүлэх, уг үйлчилгээг гэр бүлийн хүчирхийллийн хохирогчдод үйлчилгээ үзүүлэх асуудлаар мэргэшсэн ТББ-ын сургалтад сууж мэдлэг, ур чадвар эзэмшсэн мэргэжилтнүүд 24 цагийн түрш, үнэ төлбөргүй хүргэж байх;
- ❖ Гэр бүлийн хүчирхийллийн хохирогчдод эдийн засгийн тусламж дэмжлэг үзүүлэх бодлогыг барих, үүнд, амьдрах байр, хоол хүнс, бэлэн мөнгөний дэмжлэг, ажил олгох г.м;
- ❖ Үндэсний хэмжээнд гэр бүлийн хүчирхийллийн статистик мэдээллийн нэгдсэн санг бий болгох, уг сангийн мэдээллийг гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх чиглэлээр үйл ажиллагаа явуулж байгаа байгууллагууд хоорондоо солилцох, ашиглах боломжтой байх. Мэдээллийн нэгдсэн сан нь эрх хязгаарлах арга хэмжээ авагдсан хүний тоо, нас, хүйс, эрх хязгаарлах шийдвэрийн хэрэгжилтийн байдал, зөрчсөн тоо, гэр бүлийн хүчирхийллийн гэмт хэрэг, зөрчил үйлдэж ял шийтгэл хүлээсэн хүн, хүчирхийллийн улмаас цуцалсан гэрлэлтийн тоо, тэдгээрийн газар зүйн байршил зэрэг мэдээллийг багтаасан байх.

Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн шинэчлэлийн хүрээнд:

- ❖ Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн шинэчилсэн найруулгыг боловсруулахдаа судалгааны зөвлөмжүүдийг бүхэлд нь анхаарч үзэх (хавсралт С);
- ❖ Гэр бүлийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэх, илрүүлэх, таслан зогсоох, хэргийг шийдвэрлэх, хохирогчийг хамгаалах, үйлчилгээ үзүүлэх үүрэг хариуцлага хүлээсэн байгууллагуудын **салбар хоорондын хамтын ажиллагааг уялдуулан зангидах механизмыг** үндэсний болон орон нутгийн түвшинд бий болгох (үүнд: шүүх, цагдаа, шийдвэр гүйцэтгэх, төрийн нийгмийн халамж, хамгаалал, эрүүл мэнд, боловсролын асуудал хариуцсан байгууллагууд, хүүхэд, эмэгтэйчүүдийн ТББ, хамтарсан багууд багтана);

- ❖ Гэр бүлийн хүчирхийллийн хэрэгт шүүгчийн эрхийг өргөтгөх, тухайлбал, хүүхдийг түр асрамжид өгөх, хохирогч болон хүүхдэд туслалцаа, санхүүгийн дэмжлэг үзүүлэх, хохирогчид учруулсан эрүүл мэндийг нөхөн сэргээх эмчилгээний зардал, алдагдсан цалин, эвдэрч хэмхэрсэн эд хөрөнгө зэрэг хохирлыг хүчирхийлэл үйлдэгчээр төлүүлэх шийдвэр гаргах эрхтэй байх зохицуулалтыг хуульд нэмэх;
- ❖ Талуудын аль нэг нь мэдүүлэг өгөхгүй, шүүх хуралдаанд оролцохгүй байсан ч нотлох баримт гаргаж өгөх боломжтой байх, шүүгч зөвхөн хохирогчийн мэдүүлэгт үндэслэн эрх хязгаарлах шийдвэр гаргах эрхтэй байх зохицуулалтыг нэмэх;
- ❖ Гэр бүлийн хүчирхийлэлтэй холбоотой гэмт хэргийг шийдвэрлэх болон эрх хязгаарлах шийдвэр гаргахдаа шүүх эмнэлгийн дүгнэлт шаардахгүй байхыг ГБХТТ хууль, Эрүүгийн хуульд тодорхой зааж өгөх;
- ❖ Эрх хязгаарлах шийдвэрийг хүчирхийлэл үйлдэгчид гардуулах, албадан биелүүлэх, хэрэгжилтэд нь хяналт тавих талаарх байгууллагуудын үүрэг, хариуцлагыг тодорхой болгох, шүүхийн шийдвэрийг зөрчсөн тохиолдолд дараагийн шатны хариуцлага хүлээлгэх зохицуулалтыг хуульчлах;
- ❖ Хүчирхийлэл дахин үйлдэгдсэн эсэхээс үл хамааран эрх хязгаарлах арга хэмжээг зөрчсөн тохиолдлыг гэмт хэрэгт тооцохоор хуульд нэмэлт оруулах;
- ❖ Шүүхээс хохирогчийн амь нас, эрүүл мэнд, аюулгүй байдалд аюул учрах эрсдэл арилсан гэдгийг тогтоосон тохиолдолд л эрх хязгаарлах шийдвэрийг өөрчлөх буюу зогсоох, эрсдэл буураагүй буюу арилаагүй бол шийдвэрийн хугацааг сунгах эсвэл үргэлжүүлэх зохицуулалтыг бий болгох;
- ❖ Хүүхэд болон хөгжлийн бэрхшээлтэй, сэтгэцийн өвчтэйн улмаас биеэ хамгаалах чадваргүй хохирогч гэр бүлийн хүчирхийлэлд өртөж байгааг мэдсэн хэн боловч заавал мэдээлэх үүрэгтэй байх, бусад тохиолдолд хохирогчийн зөвшөөрлөөр мэдээлэхээр хуульчлах;
- ❖ Эрх хязгаарлах шийдвэрийг хэрэгжүүлэх, хяналт тавих, албадан гүйцэтгэх үүрэг хариуцлагыг цагдаа, шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын аль нь хариуцах, холбогдох бусад байгууллага ямар үүрэг хүлээхийг тодорхой тусгах;
- ❖ Хүчирхийлэл үйлдэгчийн зан үйлд нөлөөлөх болон архины хамаарлаас гаргах хөтөлбөрийг хэрэгжүүлэх мэргэшсэн мэргэжилтнүүдийг бэлтгэх, шаардагдах санхүүжилтээр хангах. Гэхдээ хохирогчид чиглэсэн үйлчилгээ, хамгаалах байрны сэнхүүжилтийг эдгээр хөтөлбөрөөс тэргүүн зэрэгт авч үзэж байхаар хуульчлах.

Гэрлэлт цуцлах эрх зүйн зохицуулалтын хүрээнд:

- ❖ Гэрлэлт цуцлуулах хэргийг шийдвэрлэхдээ хүчирхийллийн харилцаатай гэр бүлд эвлэрүүлэх хугацаа өгөхөөс татгалзах;
- ❖ Гэр бүлийн хүчирхийллийн талаар шүүхэд гаргасан хүсэлт, гомдол, нэхэмжлэлийг улсын тэмдэгтийн хураамжаас чөлөөлөх зохицуулалтыг бий болгох;
- ❖ Хүчирхийллийн харилцаатай гэр бүлийн гэрлэлт цуцлах нэхэмжлэлийг авч хэлэлцэхэд саад болж байгаа “...жирэмсэн эсвэл хүүхэд нь нэг нас хүрээгүй... бол гэрлэлт цуцлахыг хориглоно” гэсэн Гэр бүлийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.2 дахь хэсгийг хүчингүй болгох.

Гэмт хэргийн эрх зүйн зохицуулалтын хүрээнд:

- ❖ Гэр бүлийн хүчирхийллийг гэмт хэрэг гэж тодорхойлж Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах, гэмтэл учруулах, тарчлаах зэрэг гэр бүлийн хүчирхийлэлтэй холбогдох хэрэгт оногдуулах хариуцлагыг чангатгах;
- ❖ Дагаж мөшгих, дарамтлан туйлдуулах, хохирогч болон түүний гэр бүлийн гишүүдийг заналхийлэх болон гэрлэгсдийн хүчинг гэмт хэрэгт тооцох;
- ❖ Гэр бүлийн хүчирхийлэлтэй холбоотой гэмт хэргийг хянан шийдвэрлэхэд шүүх эмнэлэгийн дүгнэлт шаардахгүй байхаар хуульчлах;
- ❖ Хохирогчтой эвлэрснээр хэргийг хэрэгсэхгүй болгодог зохицуулалтыг гэр бүлийн хүчирхийлэлтэй холбогдох гэмт хэрэгт хэрэглэхийг хориглох;
- ❖ Хохирогчид санхүүгийн дарамт үзүүлэхээр байгаа тохиолдолд хүчирхийлэл үйлдэгчид торгох ял, шийтгэл хүлээлгэхгүйгээр хариуцлагын өөр төрлийг сонгох эрхийг шүүгчид өгөх;
- ❖ Эрүүгийн хэргийг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад хохирогчийн аюулгүй байдлыг хамгаалахын тулд хүчирхийлэл үйлдэгчийн зарим эрхийг хязгаарлах зохицуулалтыг таслан сэргийлэх арга хэмжээний төрөл болгон хуульчлах. Энэ нь ГБХТТ хуулийн дагуу иргэний журмаар эрх хязгаарлах шийдвэр гаргахаас тусдаа бие даасан арга хэмжээ байхаар зохицуулах.

Хууль зүйн яаманд:

- ❖ Гэр бүлийн хүчирхийлэлд холбогдон ажилладаг бүх байгууллагуудыг сайн туршлагад тулгуурлан, хохирогч төвтэй, салбар хоорондын уялдаа холбоо, хамтын ажиллагааг хангасан **албан ёсны бодлого, стандартуудыг** боловсруулан мөрдөхийг шаардах;
- ❖ Гэр бүлийн хүчирхийллийн хэргийг илрүүлэх, шийдвэрлэх үүрэг хүлээсэн шүүгч, цагдаа, прокурор, шийдвэр гүйцэтгэгч, нийгмийн ажилтан болон төрийн албан хаагчдыг **цуврал сургалтад хамруулах** ажлыг зохион байгуулах;
- ❖ Орон даяар **шүүх эмнэлгийн үйлчилгээг** бий болгох, уг үйлчилгээ нь 24 цагийн турш ажиллах боломжтой, сургагдаж бэлтгэгдсэн ажилтнуудтай байх;
- ❖ Сайн туршлагад үндэслэн эрх хязгаарлах шийдвэрийг гүйцэтгэх, хяналт тавих **удирдамжийг** боловсруулах. Уг удирдамжид эрх хязгаарлах шийдвэрийг хүчирхийлэл үйлдэгчид танилцуулах, орон гэрээс нь гаргах, тусгаарлах ажиллагааг шуурхай гүйцэтгэх шаардлага, зан үйлд нөлөөлөх хөтөлбөрийг хэрэгжүүлэх нарийвчилсан журмыг тусгаж өгөх;
- ❖ Хүчирхийлэл үйлдэгч, хохирогч, эрх хязгаарлах шийдвэрийн үргэлжлэх хугацаа, зөрчигдсөн байдал зэрэг мэдээллийг агуулсан эрх хязгаарлах шийдвэрийн **электрон мэдээллийн санг** бүрдүүлэх. Үндэсний хэмжээнд хууль хэрэгжүүлэгч бүр энэ мэдээллийн санг ашиглах боломжтой байхаар зохион байгуулах;
- ❖ **Цахим хяналт** тавих, дохиолол ирсэн тохиолдолд яаралтай арга хэмжээ авах эрхийг шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагад олгохоор хуульчлах;
- ❖ **Хүчирхийлэл үйлдэгчийн зан үйлд нөлөөлөх албадан сургалт** зохион байгуулах хөтөлбөрийг гэр бүлийн хүчирхийллийн хохирогчид үйлчилгээ үзүүлдэг ТББ-ын туршлагад суурилан боловсруулан баталж, хэрэгжилтийг зохион байгуулах, хянах;

- ❖ Гэр бүлийн хүчирхийлэл үйлдсэн нь илэрхий байгаа, хохирогчийн амь нас, эрүүл мэндэд нь аюул учруулах эрсдэлтэй, эсхүл хүчирхийлэл үйлдэгч **эрх хязгаарлах шийдвэрийг зөрчсөн тохиолдолд гэрчгүй байсан ч** баривчлах, саатуулах эрхийг цагдаагийн ажилтанд олгох, **нотолгоонд суурилсан баривчлах стандартыг** баталж, захиргааны зөрчил болон эрүүгийн хэргийг хянан шийдвэрлэхэд ашиглах;
- ❖ Засаг захиргааны анхан шатны нэгжид, тэргүүн шугаманд ажилладаг цагдаагийн ажилтнуудад архи ууж согтуурсан эсэхээс үл хамааран хүчирхийлэл үйлдэгчийг **баривчлах** бодлого батлан хэрэгжүүлэх;
- ❖ Гэр бүлийн хүчирхийллийн хэрэгт **мөрдөн шалгах ажиллагааг тууштай явуулах, нотлох баримт цуглуулахыг цагдаад даалгах**, тухайлбал: цагдаагийн байгууллагад өгсөн дуудлагыг бүртгэх, гэрчээс мэдүүлэг авах, гэмтлийн зургийг авах, дуудлагаар очих үеийн гэр бүлийн гишүүдийн дүр төрх, сэтгэл хөдлөл, хүчирхийлэл үйлдэгдсэн хэргийн газрын байдал зэрэг үйл явцыг нарийвчлан дүрсэлсэн тэмдэглэл, бусад холбогдох баримтыг цуглуулах, бэхжүүлэх;
- ❖ Гэр бүлийн хүчирхийллийг захиргааны зөрчилд тооцохгүй байх, **Захиргааны хариуцлагын тухай хуулийг гэр бүлийн хүчирхийллийн хэрэгт хэрэглэхгүй** байх;
- ❖ Хөдөө, орон нутгийн болон алслагдсан дүүрэг, хороодын цагдаагийн ажилтнуудыг хохирогчид хүрч үйлчлэх унаагаар хангах.

Боловсрол, сургалтын хүрээнд:

- ❖ Цагдаагийн ажилтан, прокурор, шүүгч нарт зориулсан сайн туршлагад үндэслэсэн **сургалтын удирдамжийг** хохирогчдод үйлчилгээ үзүүлдэг төрийн бус байгууллагатай зөвлөлдөн боловсруулах, удирдамжийн агуулгад гэр бүлийн хүчирхийллийн мөн чанар, суурь шалтгаан, ГБХТТ хуулийг хэрэглэх, гэр бүлийн хүчирхийлэлтэй холбогдох захиргааны зөрчил, гэмт хэргийг хянан шийдвэрлэх, хохирогчид үйлчилгээ үзүүлэх мэдлэг, ур чадвар олгох агуулгыг багтаасан байх;
- ❖ Цагдаагийн ажилтан, эрх зүйч, нийгмийн ажилтан, сэтгэл зүйч бэлтгэдэг сургуулиудыг гэр бүлийн хүчирхийллийн мөн чанарыг ойлгуулах, ГБХТТ хуулийг хэрэглэх агуулгыг багтаасан **мэргэшүүлэх хөтөлбөртэй** болгох;
- ❖ ТББ зэрэг хохирогчийн эрхийн төлөө ажилладаг талуудыг оролцуулан **үргэлжилсэн сургалтын хөтөлбөрийг** боловсруулан батламжлах, Цагдаагийн ажилтан, прокурор, шүүгч нарыг энэ хөтөлбөрт тогтмол хамрагдахыг шаардах.

Шүүх, шүүгчдэд:

- ❖ Гэр бүлийн **дагнасан шүүх** байгуулах, гэр бүлийн хүчирхийллийн хэргийг шуурхай, мэргэжлийн түвшинд шийдвэрлэх чадвартай **мэргэшсэн шүүгч** ажиллуулах;
- ❖ Эрх хязгаарлах шийдвэр гаргахдаа хохирогчоос **шүүх эмнэлгийн дүгнэлт** шаардахгүй байх, **хохирогчийн мэдүүлэгт үндэслэх**;
- ❖ Гэр бүлийн хүчирхийллийн мөн чанар, хохирогчийн сэтгэл зүйн онцлог, нөхцөл байдлын үнэлгээ, хохирогч гомдлоосоо татгалзахад хүргэдэг хүчин зүйлийг ойлгох, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны турш хохирогчийн аюулгүй байдлыг хамгаалах зэрэг гэр бүлийн хүчирхийлэлтэй холбоотой бүхий л агуулгыг багтаасан **сургалтад тогтмол хамрагдах**;
- ❖ Шүүхэд хэргийг хянан шийдвэрлэх ажиллагааны туршид хохирогч, түүний гэр

бүлийн гишүүд, холбогдох бусад оролцогч талуудын **аюулгүй байдлыг хангах арга хэмжээг авах**. Үүнд, хохирогчийг шүүхэд ирэх, шүүх хуралдаанд оролцох, шүүх хуралдааны завсарлагын үед болон шүүхээс явахад нь хамгаалалтаар хангах, хохирогч болон хүчирхийлэл үйлдэгчийн хүлээлгийн өрөөг тусдаа байхаар зохион байгуулах, шүүхийн байранд хохирогчийг айлган сүрдүүлсэн, заналхийлсэн хүчирхийлэл үйлдэгчид хариуцлага оногдуулах зэрэг асуудал багтана;

- ❖ Шүүхээс гэр бүлийн хүчирхийллийн хэрэгт гаргасан эрх хязгаарлах шийдвэр, захиргааны журмаар хүлээлгэсэн хариуцлага, гэмт хэрэгт оногдуулсан ял болон хүүхдэд асрамж тогтоосон талаарх **мэдээллийн сантай болох, уг мэдээллээ харилцан солилцож байх**.

Шүүхээс эрх хязгаарлах шийдвэр гаргах хүрээнд:

- ❖ Эрх хязгаарлах шийдвэр гаргуулах тухай гомдол, хүсэлт, нэхэмжлэлийг **улсын тэмдэгтийн хураамжаас чөлөөлөх**;
- ❖ Гэрээсээ явахыг даалгах, хохирогчтой аливаа хэлбэрээр харилцаа холбоо тогтоохыг хориглох, галт зэвсгийг нь хураах зэрэг хүчирхийлэл үйлдэгчийн эрхийг хязгаарлах замаар **хохирогчийн аюулгүй байдлыг тэргүүн ээлжинд хангах**;
- ❖ Эрх хязгаарлах шийдвэр бүртээ **хүчирхийлэл үйлдэгчийн** хохирогч болон хүүхдэд ойртож болохгүй зай, хязгаарыг тодорхой зааж өгөх. Хүчирхийлэл үйлдэгчийг хүүхдийн сургууль, хохирогчийн гэр, ажил, төрөл садан, найз нөхөд болон тогтмол зорчдог бусад газруудаар очихыг хориглох;
- ❖ **Хүүхдэд түр асрамж тогтоох, хохирогч болон хүүхдэд туслалцаа, санхүүгийн дэмжлэг үзүүлэх**, эмчилгээний зардал, алдагдсан цалин, эвдэрч хэмхэрсэн эд хөрөнгө зэрэг **хохирлыг** хүчирхийлэл үйлдэгчээр нөхөн төлүүлэх хүсэлтийг эрх хязгаарлах асуудалтай хамтатган шийдвэрлэх;
- ❖ Эрх хязгаарлах шийдвэрийн үргэлжлэх хугацааг хуульд заасан **хамгийн дээд хугацаагаар** тогтоох;
- ❖ Эрх хязгаарлах шийдвэр гармагц хувийг нь хохирогч, хүчирхийлэл үйлдэгч, шүүхийн шийдвэр биелүүлэх газар, цагдаагийн байгууллага болон хэрэгжүүлэх, хяналт тавих чиг үүрэг бүхий бусад этгээдэд **нэн даруй хүргүүлэх**, эрх хязгаарлах шийдвэр гарсан талаарх мэдээллийг өгөх;
- ❖ **Яаралтай эрх хязгаарлах шийдвэрийг** гарсан даруйд нь гүйцэтгүүлэх зохицуулалтыг хийх;
- ❖ **Хүчирхийлэл үйлдэгчид зориулсан хөтөлбөрийг** хохирогч болон хүүхдийн аюулгүй байдлыг яаралтай хамгаалахтай адилтгаж үзэх, эсвэл хамгаалалтын арга хэмжээнээс илүү чухалчлан үзэхийг хориглох. Зан үйлд нөлөөлөх албадан сургалтад хүчирхийлэл үйлдэгчийг хамруулах шийдвэр гаргахдаа хохирогчийн аюулгүй байдлыг хамгаалахад зайлшгүй шаардагдах бусад хамгаалах арга хэмжээнүүдтэй хамтатган авах;
- ❖ Хохирогчийн гэр, ажлын газрын хаяг, хүүхдийн сургууль, цэцэрлэгийн хаяг болон хүчирхийлэл давтагдах, хохирогчийг эрсдэлд хүргэж болзошгүй холбогдох бүх **мэдээллийн нууцлалыг хамгаалах**.

Шүүхээс эрүүгийн хэрэгт ял оногдуулах хүрээнд:

- ❖ Амь нас, эрүүл мэнд, аюулгүй байдалд нь аюул занал учрах эрсдэлтэй үед эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны түрш хохирогчийг хамгаалалтаар хангах, хүчирхийлэл үйлдэгчид хүлээлгэх ял шийтгэлийг **хойшлуулах, түдгэлзүүлэхээс татгалзах;**
- ❖ Гэр бүлийн хүчирхийлэл үйлдсэний улмаас **ноцтой үр дагавар** авчирсан хэрэгт хорих ял оногдуулах;
- ❖ Хохирогч хүчирхийлэл үйлдэгчээс санхүүгийн хамааралтай, орлогын нэг эх үүсвэртэй эсхүл эд хөрөнгөө хамтдаа эзэмшиж, ашиглаж, захиран зарцуулдаг бол мөнгөн торгууль оногдуулж хохирогчийг давхар хохироохгүй байх.

Шүүхээс гэрлэлт цуцлах асуудлыг шийдвэрлэх хүрээнд:

- ❖ Гэр бүлийн хүчирхийллийн харилцаатай тохиолдолд гэрлэлт цуцлах хэргийг **шүүрхай** шийдвэрлэх, **эвлэрүүлэх хугацаа** өгч, хэргийг түдгэлзүүлэхгүй байх;
- ❖ Гэр бүлийн хүчирхийлэлтэй холбоотой хэргийг шийдвэрлэхдээ заавал урьдчилж **эвлэрүүлэн зүүчлалын ажиллагаа явуулсан байхыг** шаардахгүй байх;
- ❖ Хүчирхийллийн харилцаатай гэр бүлийн гэрлэлт цуцлахтай холбоотой хэргийг шийдвэрлэх явцад хүүхдэд түр асрамж тогтоох, хохирогчтой холбоо харилцаа тогтоохыг хориглох зэрэг **хохирогчийн аюулгүй байдлыг хангах** боломжит бүхий л арга хэмжээг авах;
- ❖ Гэрлэлт цуцлах нэхэмжлэлийг хүлээн авмагц гэрлэснээс хойш бий болсон болон хамтран өмчлөх дундын эд хөрөнгөд хамгаалалт тогтоох, хүчирхийлэл үйлдэгчийн эд хөрөнгөө бусдад худалдах, шилжүүлэх, барьцаалах эрхийг түр хугацаагаар хориглох шийдвэр гаргах;
- ❖ Төлбөрийн чадваргүй хохирогчийг шүүхийн төлбөр, тэмдэгтийн хураамжаас чөлөөлөх.

Цагдаагийн ерөнхий газарт:

- ❖ Цагдаагийн бүх албан хаагчдыг ГБХ-ийн мөн чанар, суурь шалтгаан, ГБХТТХ-ийн хууль, холбогдох бусад хуулийг хэрхэн хэрэглэх, хэрэгжүүлэх, хохирогчид үйлчилгээ үзүүлэх мэдлэг, үр чадвар олгох агуулгыг багтаасан **сургалтад тогтмол хамруулах;**
- ❖ Гэр бүлийн хүчирхийллийн асуудлаар **дагнан ажиллах тусгай нэгж** байгуулах, энэ нэгж нь мэргэшсэн байх, бүрэлдэхүүндээ гэр бүлийн хүчирхийллийн мөн чанарыг ойлгодог, энэ чиглэлээр ажиллаж байсан туршлагатай цагдаагийн эмэгтэй ажилтнуудыг багтаасан байх;
- ❖ Цагдаагийн байгууллага дээр гэр бүлийн хүчирхийллийн хохирогчтой уулзаж ярилцах нууцлалыг хангасан **тусгай өрөө** байгуулах;
- ❖ Цагдаагийн ажилтнаас гэр бүлийн хүчирхийллийн дуудлагаар ажиллах удирдамжийг шинэчлэн баталж мөрдүүлэх. Уг удирдамжид:
 - Гэр бүлийн хүчирхийллийн дуудлагад **онцгойлон анхаарал хандуулах**, ялангуяа тусламж хүссэн дуудлагад яаралтай арга хэмжээ авах;
 - Гэр бүлийн хүчирхийллийн бүх хэрэгт нөхцөл байдлын үнэлгээ хийж, дүгнэлт гаргах;

- Нөхцөл байдлын үнэлгээнд үндэслэн хохирогчийн амь нас, эрүүл мэнд, аюулгүй байдлыг хамгаалах шаардлагатай гэж үзвэл **архидан согтуурсан эсэхээс нь үл хамааран** хүчирхийлэл үйлдэгчийн эрхийг **түр хязгаарлах арга хэмжээг яаралтай авах**;
- Хохирогчийн **зөвшөөрлөөр, түүнийг төлөөлөн эрх хязгаарлах шийдвэр гаргуулах хүсэлтийг** шүүхэд гаргах;
- Хохирогчид хамгаалах байр, эрүүл мэндийн болон хуулийн туслалцаа, нийгмийн үйлчилгээ, эрх хязгаарлах шийдвэр гаргуулах зэрэг **боломжит хамгаалалтын арга хэмжээнүүдийн тухай мэдээлэл өгөх**;
- Гэр бүлийн хүчирхийллийн хэргийг шийдвэрлэх, гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тогтолцоог сайжруулах, үнэлэх зорилгоор **Хамтарсан багт** орж ажиллах зэрэг асуудлууд багтсан байх.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газарт:

- ❖ Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын ажилтнуудыг гэр бүлийн хүчирхийллийн мөн чанар, гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх хууль тогтоомжууд, түүний хэрэглээ болон эрх хязгаарлах арга хэмжээг хэрэгжүүлэх, хохирогчдод үзүүлэх үйлчилгээний талаарх агуулгыг багтаасан **мэргэшүүлэх сургалтад тогтмол хамруулах**;
- ❖ Эрх хязгаарлах шийдвэрийг хэрэгжүүлэхтэй холбогдуулан ажилтнуудын үүрэг, үр дүнг тооцох үзүүлэлт, хүлээх хариуцлагыг тодорхойлсон удирдамжийг боловсруулан хэрэгжүүлэх;
- ❖ Эрх хязгаарлах шийдвэрийг гүйцэтгэхэд унааны зардал болон бусад төлбөр, хураамжийг **хохирогчоос шаардахыг зогсоох**;
- ❖ Шүүхийн шийдвэргүйгээр эрх хязгаарлах шийдвэрийг өөрчлөх, биелэлтийг зогсоохоос татгалзах.

Прокурорт:

- ❖ Гэр бүлийн хүчирхийллийн мөн чанар, хохирогчийн сэтгэл зүйн онцлог, гомдлоосоо татгалзахад нөлөөлдөг хүчин зүйл, нөхцөл байдлын үнэлгээ, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад хохирогчийн аюулгүй байдлыг хамгаалах, **нотлох баримт** бүрдүүлэх, бэхжүүлэх, хохирогч гомдлоосоо татгалзсан ч хэргийг үргэлжлүүлэх шаардлага зэрэг гэр бүлийн хүчирхийлэлтэй холбоотой бүхий л агуулгыг багтаасан **сургалтад тогтмол хамрагдах**;
- ❖ Эрүүгийн хэрэг үүссэн эсэхээс үл хамааран гэр бүлийн хүчирхийллийн хэрэгт **онцгой ач холбогдол өгөх**.
- ❖ Хохирогч гомдлоосоо татгалзсан эсхүл мэдүүлэг өгөхийг хүсэхгүй байгаа болон **шүүх эмнэлгийн дүгнэлт байхгүй** тохиолдолд хүчирхийлэлтэй харилцааны түүхийг судлах, цагдаагийн ажилтны цуглуулсан бүхий л баримтуудыг нэг бүрчлэн авч үзэх, хохирогчийн мэдүүлгийг баримтаар нотлох зэрэг **нотолгоонд суурилан хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг үргэлжлүүлэх**, хүчирхийлэл үйлдэгчид хариуцлага хүлээлгэх бодлогыг батлан хэрэгжүүлэх.
- ❖ Яллагдагч, хохирогч хоёр эвлэрсэн эсэхээс үл хамааран гэр бүлийн хүчирхийллийн хэргийг **хэрэгсэхгүй болгохгүй байх**;
- ❖ Гэр бүлийн хүчирхийлэлтэй холбогдох гэмт хэргийн улмаас хохирогчийн биед

хөнгөн гэмтэл учирсан ч тарчлаан зовоосон гэж үзэж эрүүгийн хэрэг үүсгэн шалгахад анхаарах;

- ❖ Гэр бүлийн хүчирхийллийн бүх хэрэгт эрх хязгаарлах шийдвэр гаргуулах хүсэлтийг шийдвэрлэх болон хэргийг хянан хэлэлцэх хүртэл хохирогчийн аюулгүй байдлыг хамгаалах зорилгоор **хүчирхийлэл үйлдэгчийг баривчлах, саатуулах;**
- ❖ Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх төрийн бодлогыг олон нийтэд сурталчлах, ялангуяа хохирогч, даван туулагчдад дэмжлэг үзүүлдэг бүх **бүлгүүдтэй хамтран ажиллах.**

Эрүүл мэндийн яаманд:

- ❖ Эмч, эмнэлгийн мэргэжилтнүүдийг гэр бүлийн хүчирхийллийн мөн чанар, хохирогчийн сэтгэл зүйн онцлог, хохирогчид үйлчилгээ, түслэмж үзүүлэх, мэдээлэл өгөх, аюулгүй байдлыг хамгаалах зэрэг агуулгыг багтаасан **сургалтад тогтмол хамруулах;**
- ❖ **Эмнэлэгт суурилсан нэг цэгийн үйлчилгээний төвүүдийг** нэмэгдүүлэх, ялангуяа хөдөө, орон нутагт байгуулах, бүх төвүүдэд нийгмийн ажилтан, эрүүл мэндийн ажилтнууд, сэтгэл зүйч, хуулийн зөвлөгчийг ажиллуулах;
- ❖ Шүүх эмнэлгийн эмч нарт зориулсан “Гэр бүлийн хүчирхийллийн улмаас үүссэн гэмтлийг тогтоох **стандарт**”-ыг батлах. Уг стандарт нь гэр бүлийн хүчирхийллийн мөн чанар, хүчирхийллийн давтамж, онцлогт суурилсан байх, хөхрөлт няцралт, хөнгөн гэмтэл, ил харагдахгүй дотоод гэмтэл зэргийг үнэлэхдээ эрсдлийг тооцоход анхаарах;
- ❖ Гэр бүлийн хүчирхийллийн улмаас үүссэн бэртэл, гэмтлийг илрүүлэх, баримтжуулах, хохирогчид мэдээлэл өгөх, шаардлагатай тохиолдолд цагдаагийн байгууллагад мэдээлэх үүргийг **өрхийн эмч, сувилагч нарын хүлээх үүрэг хариуцлагын нэг хэсэг** болгох;
- ❖ Гэр бүлийн хүчирхийллийн улмаас эрүүл мэндийн үйлчилгээ авсан тохиолдлын талаарх тоон мэдээллийг **цуглуулах, нэгтгэх, тайлагнах**, эрүүл мэндийн үйлчилгээний зардлыг тооцох.

Хүн ам, хөгжил, нийгмийн хамгааллын яаманд:

- ❖ Гэр бүлийн хүчирхийллийн мөн чанар, онцлог, гэр бүлийн хүчирхийллийн хууль тогтоомжийн хэрэглээ, хохирогчийн сэтгэл зүйн онцлог, эрх хязгаарлах шийдвэрийг гаргуулах үйл явц, эрүүл мэндийн түслэмж, эрх зүйн туслалцаа, нийгмийн ажлын үйлчилгээний боломж зэрэг агуулгыг багтаасан сургалтад нийгмийн ажилтан, бусад нийгмийн ажлын үйлчилгээ үзүүлэгчдийг тогтмол хамруулах;
- ❖ Гэр бүлийн хүчирхийллийн хохирогч хүүхэд, эмэгтэйчүүдэд **санхүүгийн туслалцаа, бүх төрлийн хөнгөлөлтөд хамруулах, орон байраар хангах** зэрэг урт хугацааны дэмжлэг үзүүлэхэд анхаарах;
- ❖ Эмэгтэйчүүд, охидыг **ажлын байртай болгох, мэргэжил эзэмшүүлэх, эдийн засгийн хувьд биеэ даахад** нь дэмжлэг үзүүлэхэд чиглэсэн хөтөлбөрийг бий болгон санхүүжүүлэх;
- ❖ Хамгаалах байр ажиллуулж байгаа ТББ-ын туршлагад үндэслэн, тэдний оролцоотойгоор **хамгаалах байрны стандартыг шинэчлэх;**

- ❖ Нийгмийн ажилтны **ажлын байрны тодорхойлолт, ажил дүгнэх үзүүлэлтэд** гэр бүлийн хүчирхийллийн хохирогч, түүний гэр бүлийн гишүүдэд үйлчилгээ үзүүлэх, хохирогчийн аюулгүй байдлыг хамгаалах арга хэмжээг яаралтай авах, нөхцөл байдлын үнэлгээ хийх, Хамтарсан багийг зохицуулах үүрэг, хариуцлагыг тодорхой тусгах;
- ❖ Гэр бүлийн хүчирхийллийн хохирогчид зөвлөгөө өгөх, эрх зүйн туслалцаа үзүүлэх зэрэг **нийгмийн үйлчилгээнүүдийн хүртээмж**, санхүүжилтийг нэмэгдүүлэх;
- ❖ Нийгмийн ажлын үйлчилгээг улс даяар хүртээмжтэй болгох, нууцлалыг хамгаалах үүднээс хохирогчтой ганцаарчлан уулзах **зөвлөгөө өгөх өрөөгөөр** нийгмийн ажилтныг хангах.

Сум, баг, хорооны Засаг даргад:

- ❖ Гэр бүлийн хүчирхийллийн мөн чанар, онцлог, гэр бүлийн хүчирхийллийн хууль тогтоомжийн хэрэглээ, хохирогчийн сэтгэл зүйн онцлог, хохирогчийг хамгаалах арга, эрх хязгаарлах шийдвэрийг гаргуулах үйл явц, эрүүл мэндийн тусламж, эрх зүйн туслалцаа, нийгмийн ажлын үйлчилгээний боломж зэрэг агуулгыг багтаасан **сургалтад** тогтмол хамрагдах;
- ❖ Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулиар хүлээсэн үүргээ тэргүүн ээлжинд биелүүлэх, гэр бүлийн хүчирхийллийн хохирогчид үйлчилгээ үзүүлэх, гэр бүлийн бусад гишүүдэд дэмжлэг үзүүлэх ажлыг **хангалттай санхүүжилтээр** хангах;
- ❖ Нууцлалыг хамгаалах үүднээс хохирогчтой ганцаарчлан уулзах, **зөвлөгөө өгөх өрөөгөөр** нийгмийн ажилтныг хангах;
- ❖ Гэр бүлийн хүчирхийллийн хэргийг шийдвэрлэх, гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тогтолцоог сайжруулах, үнэлэх зорилгоор **Хамтарсан багт** орж ажиллах;
- ❖ Засаг Даргын **ажлын байрны тодорхойлолт, ажил дүгнэх үзүүлэлтэд** гэр бүлийн хүчирхийллийн хохирогч, түүний гэр бүлийн гишүүдийн аюулгүй байдлыг нэн тэргүүнд шуурхай хангах, нөхцөл байдлын үнэлгээг баталгаажуулах, Хамтарсан багийг санхүүжилтээр хангах үүрэг хариуцлагыг тодорхой тусгах.

Нийгмийн ажилтанд:

- ❖ Гэр бүлийн хүчирхийллийн хохирогчид үйлчилгээ үзүүлэх, хохирогчийн аюулгүй байдлыг хамгаалах ажлыг тэргүүн ээлжинд зохион байгуулах;
- ❖ Гэр бүлийн хүчирхийллийн бүх хэргүүдэд хохирогчийн хүчирхийлэлтэй харилцааны түүхийг үндэслэн **нөхцөл байдлын үнэлгээ** хийж, дүгнэлт гаргах;
- ❖ Гэр бүлийн хүчирхийллийн хэргийг шийдвэрлэх, гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тогтолцоог сайжруулах, үнэлэх зорилгоор **Хамтарсан багийн** өдөр тутмын үйл ажиллагааг уялдуулан зохицуулах;
- ❖ Хохирогчийн нууцлалыг хангах.

Эрүүл мэндийн ажилтанд:

- Хөгжлийн бэрхшээлтэй, сэтгэцийн өвчтэй, эсвэл хүүхэд гэр бүлийн хүчирхийлэлд өртөж байгаагаас бусад тохиолдолд хохирогчийн зөвшөөрлөөр цагдаагийн байгууллагад **заавал мэдээлэх**;

- ❖ Шүүх эмнэлгийн эмч нь заавал байгууллага, мэргэжилтнээс **холбон зуучилсан байхыг хохирогчоос шаардахгүйгээр** үзлэг, шинжилгээг шүүрхай хийх;
- ❖ Гэр бүлийн хүчирхийллийн хохирогчийн **хувийн нууцлалыг хадгалах**, өөрөө зөвшөөрсөн, хэргийг мэдээлэхийг хүссэн тохиолдолд л гэмтлийг баримтжуулах;
- ❖ Гэр бүлийн хүчирхийллийн хохирогчид **эрхийг нь ойлгуулах**, шаардлагатай үйлчилгээ, байгууллагуудын талаарх мэдээллийг өгөх.

Олон нийтийн боловсролын хүрээнд:

- ❖ Гэр бүлийн хүчирхийллийн мөн чанар, суурь шалтгаан болон хохирогчийн амь нас, эрүүл мэнд, аюулгүй байдлыг хамгаалах боломжит арга хэмжээнүүдийн талаар олон нийтийг гэгээрүүлэх кампанит аяныг тогтмол зохион байгуулах;
- ❖ Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх төрийн үүрэг амлалтыг олон нийтэд таниулах, **төр, хувийн хэвшил, иргэний нийгмийн байгууллагууд** хохирогчид дэмжлэг үзүүлэх, хамтран ажиллах.

ХАВСРАЛТ - А.
ГЭР БҮЛИЙН ХҮЧИРХИЙЛЭЛТЭЙ ТЭМЦЭХ ТУХАЙ ХУУЛЬ

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ Нийтлэг үндэслэл

1 дүгээр зүйл. Хуулийн зорилт

- 1.1. Энэ хуулийн зорилт нь хохирогчийн зөрчигдсөн эрхийг хамгаалах, аюулгүй байдлыг хангах, хүчирхийлэл үйлдэгчид хариуцлага хүлээлгэх, гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх, түүнээс урьдчилан сэргийлэхэд төрийн болон төрийн бус байгууллага, иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын оролцоог тодорхойлохтой холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

2 дугаар зүйл. Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль тогтоомж

- 2.1. 2.2. Монгол Улсын олон улсын гэрээнд энэ хуульд зааснаас өөрөөр заасан бол олон улсын гэрээний заалтыг дагаж мөрдөнө.

3 дугаар зүйл. Хуулийн зохицуулалтад хамаарах этгээд

- 3.1. Энэ хуулийн зохицуулалтад Гэр бүлийн тухай хуульд заасан гэр бүлийн гишүүн, төрөл, садангийн хүн хамаарна.
- 3.2. Энэ хуулийн зохицуулалтад гэрлэлтээ хуульд заасны дагуу төрийн эрх бүхий байгууллагад бүртгүүлээгүй боловч хамтын амьдралтай байгаа хүмүүс, түүнчлэн Гэр бүлийн тухай хуульд заасны дагуу хүүхдийг гэр бүлдээ авч хүмүүжүүлсний, эсхүл асран хамгаалагч, харгалзан дэмжигч тогтоосны үр дүнд тухайн иргэний асрамжид байгаа этгээд нэгэн адил хамаарна.

4 дүгээр зүйл. Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх үйл ажиллагааны зарчим

- 4.1. Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх үйл ажиллагаа нь хүний эрх, эрх чөлөөг хүндэтгэх, хууль дээдлэх, хүчирхийлэл үйлдэгдэхээс урьдчилан сэргийлэх, хүчирхийллийг таслан зогсоох арга хэмжээг шуурхай авах, хохирогчийн аюулгүй байдлыг хангах, хүчирхийлэл үйлдэгчийн зан үйлд нөлөөлөх зарчимд үндэслэнэ.

5 дугаар зүйл. Хуулийн нэр томъёоны тодорхойлолт

- 5.1. Энэ хуульд хэрэглэсэн дараахь нэр томъёог дор дурдсан утгаар ойлгоно:
- 5.1.1. "гэр бүлийн хүчирхийлэл" гэж гэр бүлийн хүрээнд энэ хуулийн 3 дугаар зүйлд заасан аль нэг этгээд нөгөө этгээдийн эрх, эрх чөлөөг зөрчиж гэм хор учруулсан, эсхүл учруулахаар заналхийлсэн эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй үйлдэл, эс үйлдэхүйг;
- 5.1.2. "болзошгүй хүчирхийлэл" гэж тухайн нөхцөл байдал нь гэр бүлийн хүчирхийлэлд хүргэхээр, эсхүл хүчирхийлэл дахин үйлдэгдэхээр байгааг;
- 5.1.3. "хамгаалах байр" гэж гэр бүлийн хүчирхийлэлд өртсөн, эсхүл болзошгүй хүчирхийлэлд өртөх магадлалтай хохирогч, түүний бага насны хүүхдийг тодорхой хугацаагаар байрлуулж, хохирогчид үйлчилгээ үзүүлэх газрыг;
- 5.1.4. "хүчирхийлэл үйлдэгчийн зан үйлд нөлөөлөх албадан сургалт" гэж хүчирхийлэл үйлдэгчид гэр бүлийн гишүүдийн хоорондын харилцаанаас үүссэн асуудлыг хүч хэрэглэхгүйгээр шийдвэрлэх зан үйлийг төлөвшүүлэхэд чиглэсэн зохих хөтөлбөрийн дагуу явуулах сургалтыг;
- 5.1.5. "хохирогчид үзүүлэх үйлчилгээ" гэж хохирогчид хэрэгцээтэй мэдээлэл, эрх зүйн болон бусад зөвлөгөө өгөх, сэтгэхүй нь түр хямарсан үед эмчилгээ хийх, нөхөн сэргээх ажиллагааг;
- 5.1.6. "эрх хязгаарлах арга хэмжээ" гэж хохирогчийн аюулгүй байдлыг хамгаалахад чиглэсэн хүчирхийлэл үйлдэгчид хүлээлгэх албадлагыг.

¹ Монгол Улсын Үндсэн хууль, Төрийн мэдээлэл сэтгүүл, дугаар 1 1992.

² Иргэний хууль, Төрийн мэдээлэл сэтгүүл, дугаар 7, 200.

³ Эрүүгийн хууль, Төрийн мэдээлэл сэтгүүл, дугаар 8, 2002.

⁴ Гэр бүлийн тухай хууль, Төрийн мэдээлэл сэтгүүл, дугаар 8, 1999.

6 дугаар зүйл. Гэр бүлийн хүчирхийллийн хэлбэр

- 6.1. Энэ хуульд заасан гэр бүлийн хүчирхийлэл нь бие махбодын, сэтгэл санааны, бэлгийн, эдийн засгийн хэлбэртэй байж болно

ХОЁРДУГААР БҮЛЭГ Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх, түүнээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагаанд оролцогчдын эдлэх эрх, хүлээх үүрэг

7 дугаар зүйл. Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх талаархи төрийн байгууллагын бүрэн эрх

- 7.1. Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх талаар Засгийн газар дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:
 - 7.1.1.гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх талаархи бодлого, хөтөлбөрийг баталж, хэрэгжүүлэх;
 - 7.1.2. энэ хуулийн 7.1.1-д заасан хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний зардлыг улсын төсвийн төсөлд тусгаж, Улсын Их Хуралд оруулах.
- 7.2. Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх талаар нийгмийн хамгааллын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:
 - 7.2.1.гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх талаархи төрийн бодлогыг хэрэгжүүлэх, хохирогчид үзүүлэх нийгмийн үйлчилгээг зохион байгуулах;
 - 7.2.2. хамгаалах байранд тавигдах наад захын шаардлагыг тодорхойлох.
- 7.3. Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх талаар хууль зүй, дотоод хэргийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:
 - 7.3.1.гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх ажлыг Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай 6 хуулийн 7 дугаар зүйлийн 3 дахь хэсэгт заасан бүрэн эрхийнхээ хүрээнд зохион байгуулах;
 - 7.3.2.гэр бүлийн хүчирхийлэл үйлдэгчийн зан үйлд нөлөөлөх албадан сургалтын хөтөлбөрийг нийгмийн хамгааллын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагатай хамтран баталж, мөрдүүлэх.

Захиргааны байгууллагын бүрэн эрх

- 8.1. Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх талаар нутгийн өөрөө удирдах болон нутгийн захиргааны бүх шатны байгууллага дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:
 - 8.1.1. харьяа нутаг дэвсгэртээ гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх бодлогыг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах;
 - 8.1.2. гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх арга хэмжээний зардлыг мэдээ, судалгаанд үндэслэн өөрийн төсвөөс тусгайлан төлөвлөж санхүүжүүлэх;
 - 8.1.3. хууль хамгаалах байгууллагуудтай хамтран ажиллаж, гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх үйл ажиллагаа явуулдаг төрийн бус байгууллагыг дэмжих;
 - 8.1.4. хууль тогтоомжид заасан бусад бүрэн эрх.

9 дүгээр зүйл. Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх талаархи цагдаагийн байгууллагын үүрэг

- 9.1. Цагдаагийн байгууллага нь гэр бүлийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэх, хүчирхийллийг таслан зогсоох талаар дараахь үүрэг хүлээнэ:
 - 9.1.1.гэр бүлийн хүчирхийлэлтэй холбоотой гомдол хүлээн авч, бүртгэх, хүчирхийлэл үйлдэгдсэн газар дээр хүрэлцэн очиж хохирогч, хүчирхийлэл үйлдэгч болон гэрчээс асууж, тэмдэглэл хөтлөх, шаардлагатай бусад ажиллагаа явуулах;
 - 9.1.2.энэ хуульд заасны дагуу хохирогчид түүний эдлэх эрх болон хүчирхийлэл үйлдэгчид эрхийг нь хязгаарлах арга хэмжээ авахуулахаар шийдвэр гаргуулах журмын талаар тайлбарлан өгөх;
 - 9.1.3.хүчирхийлэл үйлдэгчид захиргааны болон эрүүгийн шийтгэл ногдуулж болох тухай сануулах;
 - 9.1.4.шаардлагатай тохиолдолд хохирогчийг эмнэлэгт, эсхүл хамгаалах байранд хүргэх, боломжтой бол төрөл, садангийн хүний нь түр хамгаалалтад өгөх;
 - 9.1.5.шаардлагатай гэж үзвэл хүчирхийлэл үйлдэгчийг хууль тогтоомжийн дагуу захиргааны журмаар албадан саатуулах;

- 9.1.6.согтууруулах ундаа хэтрүүлэн хэрэглэсэн этгээдийг хууль тогтоомжийн дагуу эрүүлжүүлэх байранд хүргэх;
- 9.1.7.хохилогчийг энэ хуулийн 5.1.5-д заасан үйлчилгээнд хамруулах талаар нийгмийн ажилтанд мэдэгдэх;
- 9.1.8.хүчирхийлэл үйлдэгчийн эрхийг хязгаарлах арга хэмжээ авахуулах хүсэлтээ эрх бүхий байгууллага, албан тушаалтанд гаргах;
- 9.1.9.хууль тогтоомжид заасан бусад үүрэг.

⁶Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хууль, Төрийн мэдээлэл сэтгүүл, дугаар 1, 1998.

10 дугаар зүйл. Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх талаархи нийгмийн ажилтны үүрэг

- 10.1. Нийгмийн ажилтан нь гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх талаар дараахь үүрэг хүлээнэ:
 - 10.1.1.тухайн гэр бүлийн хүчирхийллийн нөхцөл байдлын талаар үнэлгээ өгөх, орчны сөрөг нөлөө, аюулын зэргийн түвшинг цагдаагийн ажилтантай хамтран тогтоох;
 - 10.1.2.хүчирхийлэл үйлдэгчийн зан үйлд нөлөөлөх албадан сургалтыг цагдаагийн байгууллагатай хамтран зохион байгуулж, энэ хуулийн 7.3.2-т заасан хөтөлбөрийн дагуу явуулах;
 - 10.1.3.хохилогчид үзүүлэх үйлчилгээ, гэр бүлийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэхэд чиглэсэн сургалт, сурталчилгааг энэ төрлийн үйл ажиллагаа эрхэлдэг төрийн бус байгууллагын туслалцаатайгаар явуулах;
 - 10.1.4.хохилогчид үзүүлсэн үйлчилгээний талаархи тайлан мэдээ гаргаж, гэр бүлийн хүчирхийллийн холбоотой мэдээллийн сүлжээ бий болгоход оролцох.

ГУРАВДУГААР БҮЛЭГ Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх, урьдчилан сэргийлэхэд төрийн бус байгууллагын оролцоо

11 дүгээр зүйл.Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх, урьдчилан сэргийлэхэд төрийн бус байгууллагын оролцоо

- 11.1. Хохилогчийг хамгаалах байраар хангах, хүчирхийлэл үйлдэгчийн зан үйлд нөлөөлөх албадан сургалт явуулах, хохилогчид үзүүлэх үйлчилгээ болон гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх, түүнээс урьдчилан сэргийлэх талаархи бусад үйл ажиллагааг хууль тогтоомжид заасан журмын дагуу төрийн бус байгууллагаар гүйцэтгүүлж болно.
- 11.2. Төрийн бус байгууллага нь энэ хуулийн 11.1-д заасан үйл ажиллагааг дүрмийнхээ зорилгод нийцүүлэн явуулж болно.

12 дугаар зүйл. Итгэмжлэгдсэн төлөөлөгч

- 12.1.Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх чиглэлээр үйл ажиллагаа эрхэлдэг төрийн бус байгууллага нь хохилогчийн эрх, х-ууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах үйл ажиллагааг итгэмжлэгдсэн төлөөлөгчөөр дамжуулан хэрэгжүүлж болно.
- 12.2.Итгэмжлэгдсэн төлөөлөгч дараахь эрх эдэлнэ:
 - 12.2.1 .хохилогчийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах чиглэлээр төрийн болон төрийн бус байгууллага, бусад этгээдтэй харилцах;
 - 12.2.2.гэр бүлийн хүчирхийлэлтэй холбоотой мэдээлэл олж авах, судалгаа явуулах;
 - 12.2.3.гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны талаархи саналаа эрх бүхий байгууллагад оруулах.

ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ Гэр бүлийн хүчирхийллийн тухай мэдээлэл өгөх, хүчирхийллийг таслан зогсоох арга хэмжээ

13 дугаар зүйл. Гэр бүлийн хүчирхийллийн тухай мэдээлэл

- 13.1. Цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуулийн багш, эмнэлгийн мэргэжилтэн албан үүргээ биелүүлж байх үедээ гэр бүлийн хүчирхийлэл үйлдэгдсэн, эсхүл үйлдэгдэж болзошгүй байгаа нь илэрхий болсон тохиолдолд цагдаагийн байгууллага, боломжгүй бол нутгийн захиргааны байгууллагад мэдээлэх үүрэгтэй.

- 13.2. Иргэн, аж ахуйн нэгж, байгууллага нь гэр бүлийн хүчирхийлэл үйлдэгдсэн, эсхүл үйлдэгдэж болзошгүй байгаа тухай цагдаагийн буюу нутгийн захиргааны байгууллагад мэдээлж болно.
- 13.3. Энэ хуулийн 13.1, 13.2-т заасан этгээд мэдээллээ цахилгаан холбоо, шуудан, мэдээллийн хэрэгслийг ашиглан өгч болно.
- 13.4. Гэр бүлийн хүчирхийллийн тухай мэдээллийг хүчирхийлэл үйлдэгч, хохирогчийн байнга буюу түр оршин сууж байгаа, эсхүл хүчирхийлэл үйлдэгдсэн газрын, хэрэв хохирогч нь эрүүл мэндийн байгууллага, хамгаалах байранд болон хүчирхийлэл үйлдэгч нь энэ хуулийн 5.1.4-т заасан албадан сургалт явуулдаг байгууллагад байгаа бол уг байгууллагын оршин байгаа нутаг дэвсгэрийн цагдаагийн байгууллага хүлээн авч, энэ хуулийн 9 дүгээр зүйлд заасан арга хэмжээ авна.

14 дүгээр зүйл. Гэр бүлийн хүчирхийллийг таслан зогсоох талаархи сүм, багийн Засаг даргын үүрэг

- 14.1. Тухайн харьяалах нутаг дэвсгэртээ сүм, багийн Засаг дарга гэр бүлийн хүчирхийллийг таслан зогсоох, болзошгүй хүчирхийллээс урьдчилан сэргийлэх талаар дараахь үүрэг хүлээнэ:
- 14.1.1. хохирогчийн аюулгүй байдлыг хангах зорилгоор хүчирхийлэл үйлдэгчийг захиргааны байранд дуудан ирүүлж, шаардлага тавих;
- 14.1.2. шаардлагатай гэж үзвэл хохирогчийн байгаа гэр, орон байрны аюулгүй байдлыг хангах арга хэмжээ авах, эсхүл боломжтой бол хохирогчийг төрөл, садангийн хүний нь төр хамгаалалтад өгөх;
- 14.1.3. гэр бүлийн хүчирхийлэл үйлдэгдсэн тухай хохирогч, хүчирхийлэл үйлдэгч болон гэрчээс асууж, тэмдэглэл хөтлөх, шаардлагатай бусад ажиллагаа явуулах.

15 дугаар зүйл. Хохирогчийг хамгаалах арга, түүний нууцыг задруулахгүй байх талаар бусад этгээдийн хүлээх үүрэг

- 15.1. Хохирогчийг хамгаалах зорилгоор дараахь аргыг хэрэглэж болно: 15.1.1. хамгаалах байранд хүргэх;
- 15.1.2. эцэг, эх, төрөл, садны хүн, эсхүл хамт олны нь түр хамгаалалтад өгөх;
- 15.1.3. шаардлагатай гэж үзвэл хүүхэд асран хүмүүжүүлэх, эсхүл нийгмийн халамжийн байгууллагад шилжүүлэх;
- 15.1.4. энэ хуулийн 5.1.5-д заасан үйлчилгээнд хамруулах.
- 15.2. Хохирогч нь эрх зүйн асуудлаар хууль зүйн туслалцаа авах, хүчирхийлэл үйлдэгчээс гэрлэлтээ цуцлуулах, хүүхдийн тэтгэлэг гаргуулах, тэжээн тэтгүүлэх, эсхүл хууль тогтоомжийн дагуу эдийн болон эдийн бус гэм хорыг арилгуулахаар нэхэмжлэл гаргах эрхтэй
- 15.3. Нийгмийн ажилтан болон энэ хуулийн 12 дугаар зүйлд заасан этгээд зөвлөгөө өгөх явцдаа итгэмжлэлээр олж мэдсэн зүйлээ бусдад задруулахыг хориглоно.
- 15.4. Ажил үүргээ гүйцэтгэж байсантай холбоотой эсэхээс үл хамааран хамгаалах байрны байршлын талаар мэдсэн этгээд энэ тухай бусдад задруулахгүй байх үүрэгтэй.

16 дугаар зүйл. Хүчирхийлэл үйлдэгчийн эрхийг хязгаарлах арга хэмжээ

- 16.1. Хүчирхийлэл үйлдэгчийн эрхийг хязгаарлах зорилгоор дараахь арга хэмжээ авч болно:
- 16.1.1. тусдаа амьдрахыг даалгах;
- 16.1.2. хамгаалах байранд, эсхүл энэ хуулийн 15.1.3-т заасны дагуу өөр газарт байгаа хохирогчтой уулзах болон уулзахаар оролдохыг хориглох;
- 16.1.3. хамтран өмчлөх дундын эд хөрөнгөө эзэмших, ашиглах, захиран зарцуулахыг хориглох;
- 16.1.4. асрамжиндаа байгаа насанд хүрээгүй хүнтэй харилцахыг түр хориглох;
- 16.1.5. зан үйлд нөлөөлөх албадан сургалтад хамруулах;
- 16.1.6. шаардлагатай гэж үзвэл согтуурах, мансуурах донтой өвчтэй этгээдийг хууль тогтоомжийн дагуу захиргааны журмаар албадан эмчилгээ хийлгэх, эсхүл албадан хөдөлмөрлүүлэх.
- 16.2. Энэ хуулийн 16.1-д заасан арга хэмжээ авагдсан этгээд хохирогчийг хуулийн дагуу

асран хамгаалах, харгалзан дэмжих үүргээсээ чөлөөлөгдөхгүй.

17 дугаар зүйл. Хүчирхийлэл үйлдэгчийн эрхийг хязгаарлах арга хэмжээ авах тухай шүүхийн шийдвэр

- 17.1. Хохирогчийн гомдол, цагдаагийн байгууллагын ажилтны, эсхүл өмгөөлөгч, итгэмжлэгдсэн төлөөлөгчийн хүсэлт, түүнд хавсаргасан нотлох баримтыг үндэслэн хүчирхийлэл үйлдэгчийн эрхийг хязгаарлах арга хэмжээ авах тухай шийдвэрийг шүүх Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай 7 хуулийн 82.1.8-д заасны дагуу гаргана.
- 17.2. Хохирогчийн амь нас, эрүүл мэндийг хамгаалах зорилгоор шүүх нь гэр бүлийн хүчирхийлэл үйлдэгдсэн тухай гомдол хүлээн авснаас хойш 24 цагийн дотор энэ хуулийн 16.1.1-16.1.5-д заасан арга хэмжээ авах тухай шийдвэр гаргаж болно.
- 17.3. Энэ хуулийн 16.1-д заасан хүчирхийлэл үйлдэгчийн эрхийг хязгаарлах арга хэмжээг тухайн нөхцөл байдалд нь тохируулж нэг жил хүртэл хугацаагаар авч болно.
- 17.4. Талууд энэ хуулийн 17.1-д заасан шийдвэрт давж заалдах гомдол гаргах эрхтэй. Ийнхүү гомдол гаргасан явдал тухайн шийдвэрийг гүйцэтгэх ажиллагааг зогсоох үндэслэл болохгүй.
- 17.5. Энэ хуулийн 17.1-д заасан шийдвэр нь гэр бүлийн хүчирхийлэл үйлдэгдсэн талаар захиргааны зөрчлийг хянан шалгах ажиллагаа явуулах, эсхүл эрүүгийн хэрэг үүсгэн шалгах болон иргэний хэрэг хянан шийдвэрлэхэд саад болохгүй.
- 17.6. Шүүх энэ хуулийн 17.1-д заасны дагуу шийдвэрээ гаргахдаа дараахь нөхцөл байдлыг харгалзан үзнэ:
 - 17.6.1. хохирогчтой удаа дараа хэрцгий хандсан, заналхийлсэн, хүч хэрэглэсэн;
 - 17.6.2. хүчээр бэлгийн харьцаанд оруулсан буюу оруулахыг завдсан;
 - 17.6.3. хохирогчийг төрөл садан, хамт олноос нь тусгаарлаж, сэтгэл санааны хүнд дарамтад оруулсан;
 - 17.6.4. тэжээн тэтгэх үүргээс санаатайгаар зайлсхийсэн буюу хүүхдийн хүмүүжилд ноцтой хохирол учруулж байсан;
 - 17.6.5. согтууруулах ундаа, мансууруулах бодис байнга буюу удаа дараа хэрэглэж хохирогчийг айдас, түгшүүрт байдалд оруулсан;
- 17.1.6. гэр бүлийн хүчирхийллийн улмаас энэ хуулийн 3 дугаар зүйлд заасан этгээдийн хэн нэгний амь нас, эрүүл мэндэд ноцтой хохирол учирч болзошгүй байгаа.

18 дугаар зүйл. Хүчирхийлэл үйлдэгчтэй уулзуулах журам

- 18.1. Шүүхийн шийдвэрт энэ хуулийн 16.1.2, 16.1.4-т заасан арга хэмжээ тусгагдаагүй бөгөөд уг шийдвэр хүчинтэй байх хугацаанд хохирогч өөрөө буюу насанд хүрээгүй болон иргэний эрх зүйн чадамжгүй хохирогчийн хувьд асран хамгаалагч, харгалзан дэмжигч хүсэлт гаргасан бол нийгмийн ажилтны зөвшөөрлөөр хүчирхийлэл үйлдэгчтэй уулзуулж болно.
- 18.2. Шүүхийн шийдвэрт энэ хуулийн 16.1.2, 16.1.4-т заасан арга хэмжээ тусгагдсан бөгөөд зайлшгүй шаардлагаар насанд хүрээгүй этгээдийг хүчирхийлэл үйлдэгчтэй уулзуулах бол нийгмийн ажилтны зөвшөөрлөөр итгэмжлэгдсэн төлөөлөгчийг байлцуулан уулзуулж болно.
- 18.3. Энэ хуулийн 18.1, 18.2-т заасан уулзалтыг цагдаагийн эрх бүхий ажилтан зохион байгуулж болно.

ТАВДУГААР БҮЛЭГ Бүсэд зүйл

19 дүгээр зүйл. Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль тогтоомж зөрчигчид хүлээлгэх хариуцлага

- 19.1. Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль тогтоомжийг зөрчсөн этгээдэд түүний үйлдэл, эс үйлдэхүйн нийгмийн аюулын шинж чанар, зөрчлийн байдал, учруулсан хохирлын хэмжээг харгалзан хууль тогтоомжид заасан хариуцлага хүлээлгэнэ.

20 дугаар зүйл. Хууль хүчин төгөлдөр болох

20.1. Энэ хуулийг 2005 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

⁷ Иргэний хэргийг шүүхээр хянан шийдвэрлэх тухай хууль, Төрийн мэдээлэл сэтгүүл, дугаар 8, 2008

ХАВСРАЛТ Б. ИШ ТАТСАН БУСАД ХОЛБОГДОХ ХУУЛЬ

Эрүүгийн хууль

17 дугаар зүйл. Гэмт хэргийн ангилал

17.1. Гэмт хэргийн нийгмийн аюулын шинж чанар, хэр хэмжээ, оногдуулж болох ялын хүнд, хөнгөнийг харгалзан гэмт хэргийг:

17.1.1. хөнгөн;

17.1.2. хүндэвтэр;

17.1.3. хүнд;

17.1.4. онц хүнд гэж ангилна.

17.2. Энэ хуулийн тусгай ангид нэг сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг таваас тавь дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, нэг зуугаас хоёр зуун тавин цаг хүртэл хугацаагаар албадан ажил хийлгэх, эсхүл нэгээс гурван сар хүртэл хугацаагаар баривчлах ял шийтгэхээр заасан гэмт хэргийг хөнгөн гэмт хэрэг гэнэ

17.3. Энэ хуулийн тусгай ангид нэг сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг тавин нэгээс хоёр зуун тавь дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, хоёр зуун тавин нэгээс таван зуун цаг хүртэл хугацаагаар албадан ажил хийлгэх, гурваас дээш зургаан сар хүртэл хугацаагаар баривчлах, эсхүл таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэхээр заасан гэмт хэргийг хүндэвтэр гэмт хэрэг гэнэ

17.4. Энэ хуулийн тусгай ангид нэг сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг хоёр зуун тавин нэгээс таван зуу дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл таван жилээс дээш арван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэхээр заасан гэмт хэргийг хүнд гэмт хэрэг гэнэ

17.5. Энэ хуулийн тусгай ангид арван жилээс дээш арван таван жил хүртэл хугацаагаар хорих, онцгой тохиолдолд хорин таван жил хүртэл хугацаагаар хорих буюу цаазаар авах ял шийтгэхээр заасан гэмт хэргийг онц хүнд гэмт хэрэг гэнэ.

22 дугаар зүйл. Хэрэг хариуцах чадваргүй байдал

22.1. Гэмт хэрэг үйлдэх үедээ хэрэг хариуцах чадваргүй, өөрөөр хэлбэл, сэтгэцийн архаг өвчтэй, сэтгэцийн үйл ажиллагаа нь түр сарнисан, эсхүл оюун ухааны хомсдолтой буюу өөр бусад хүнд өвчний улмаас сэтгэцийн хувьд өөрийн үйлдэл, эс үйлдэхүйн нийгмийн аюулын шинж чанарыг ухамсарлах буюу үйл ажиллагаагаа удирдан жолоодох чадваргүй болсон этгээдэд ял оногдуулахгүй. Ийм этгээдэд шүүх энэ хуульд заасан эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээ хэрэглэнэ

22.2. Гэмт хэрэг үйлдэх үедээ хэрэг хариуцах чадвартай байсан боловч шүүх хэргийг шийдвэрлэх үед сэтгэцийн өвчтэй, сэтгэцийн үйл ажиллагаа нь түр сарнисан, эсхүл өөр бусад хүнд өвчний улмаас сэтгэцийн хувьд өөрийн үйлдэл, эс үйлдэхүйн нийгмийн аюулын шинж чанарыг ухамсарлах буюу үйл ажиллагаагаа удирдан жолоодох чадваргүй болсон этгээдэд ял оногдуулахгүй. Ийм этгээдэд энэ хуульд заасан эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээ хэрэглэж, эдгэрсний нь дараа ял оногдуулах эсэхийг шүүх шийдвэрлэнэ.

40 дүгээр зүйл. Аргагүй хамгаалалт

40.1. Аргагүй хамгаалалтын байдалд, өөрөөр хэлбэл, энэ хуулиар хамгаалагдсан төр, нийгмийн ашиг сонирхол, өөрийн болон бусдын амьд явах, халдашгүй чөлөөтэй байх, түүнчлэн бусад эрх, эрх чөлөөг нийгэмд аюултай халдлагаас хамгаалахдаа энэ хуулийн тусгай ангид заасан үйлдэл хийж, халдагч этгээдэд гэм хор учруулсныг гэмт хэрэгт тооцохгүй

40.2. Хүн бүр албан тушаалын байдал, мэргэжил, хуулиар хүлээлгэсэн үүрэг, албаны тусгай бэлтгэлээс хамаарахгүйгээр аргагүй хамгаалалт хийх эрхтэй. Хамгаалагч нийгэмд аюултай халдлагаас зайлсхийх, төрийн байгууллага, албан тушаалтан, бусад хүмүүсээс тусламж хүсэх боломжтой байсан эсэх нь аргагүй хамгаалалт хийх эрхэд нөлөөлөхгүй.

46 дугаар зүйл. Ялын төрөл

46.1. Гэмт хэрэг үйлдсэн этгээдэд дор дурдсан ял оногдуулна:

46.1.1. торгох;

46.1.2. тодорхой албан тушаал эрхлэх, үйл ажиллагаа явуулах эрхийг хасах;

46.1.3. эд хөрөнгө хураах;

46.1.4. албадан ажил хийлгэх;

46.1.5. баривчлах;

46.1.6. хорих;

46.1.7. цаазаар авах.

46.2. Торгох, албадан ажил хийлгэх, баривчлах, хорих, цаазаар авах ялыг үндсэн ялын чанартай, тодорхой албан тушаал эрхлэх, үйл ажиллагаа явуулах эрхийг хасах ялыг үндсэн ба нэмэгдэл ялын чанартай, эд хөрөнгө хураах ялыг зөвхөн нэмэгдэл ялын чанартай хэрэглэнэ.

55 дугаар зүйл. Ял хөнгөрүүлэх нөхцөл байдал

55.1. Шүүх ял оногдуулахдаа дор дурдсан хөнгөрүүлэх нөхцөл байдлыг харгалзан үзнэ:

55.1.1. тохиолдлын шинжтэй нөхцөл байдлын улмаас анх удаа хөнгөн, хүндэвтэр гэмт хэрэг үйлдсэн;

55.1.2. гэмт хэргийн улмаас учрах хор үршгийг зайлуулсан

55.1.3. гэмт хэрэг үйлдэж учруулсан хохирлоо сайн дураараа нөхөн төлсөн буюу гэм хорыг арилгасан;

55.1.4. хүч хэрэглэх буюу хүч хэрэглэхээр заналхийлэхэд автсан, эсхүл эд хөрөнгө, албан тушаалын болон өөр байдлаар эрхшээлд нь орсноос гэмт хэрэг үйлдсэн;

55.1.5. хохирогчийн хууль бус үйлдлээс болж санаа сэтгэл нь хүчтэй цочрон давчдсаны улмаас болон хохирогчийн хэт хайхрамжгүйгээс гэмт хэрэг үйлдсэн;

55.1.6. өөрт нь болон гэр бүлийн гишүүнд нь, түүнчлэн бусад хүмүүст тохиолдсон хүнд нөхцөл байдлын улмаас гэмт хэрэг үйлдсэн

55.1.7. арван найман насанд хүрээгүй этгээд гэмт хэрэг үйлдсэн;

55.1.8. жирэмсэн буюу бага насны хүүхэдтэй эмэгтэй гэмт хэрэг үйлдсэн;

55.1.9. үйлдсэн гэмт хэрэгтээ чин санаанаас гэмшсэн буюу гэмт хэргээ сайн дураар илчилж ирсэн, түүнчлэн гэмт хэрэг болон гэмт хэрэг үйлдсэн этгээд, гэмт хэрэг үйлдэж олсон эд зүйлийг илрүүлэхэд идэвхтэй дэмжлэг үзүүлсэн;

55.1.10. бусдын амь нас, эрүүл мэндэд гэм хор учруулсан гэмт хэрэг үйлдсэн даруйдаа хохирогчид эмнэлгийн болон бусад тусламж үзүүлсэн.

55.2. Энэ хуулийн 55.1-д заасан хөнгөрүүлэх нөхцөл байдал нь уг хуулийн тусгай ангийн тодорхой зүйл, хэсэгт заасан гэмт хэргийн бүрэлдэхүүний шинж болж байгаа бол түүнийг ял оногдуулахдаа харгалзаж үзэхгүй

56 дугаар зүйл. Ял хүндрүүлэх нөхцөл байдал

56.1. Шүүх ял оногдуулахдаа зөвхөн дор дурдсан хүндрүүлэх нөхцөл байдлыг харгалзан үзнэ:

56.1.1. гэмт хэрэг давтан үйлдсэн;

56.1.2. гэмт хэрэг бүлэглэж үйлдсэн;

56.1.3. эрүүгийн хариуцлага хүлээх насанд хүрээгүй этгээдийг гэмт хэрэгт татан оруулсан, эрүүгийн хариуцлага хүлээх насанд хүрээгүй, хэрэг хариуцах чадваргүй хүнээр гэмт хэрэг үйлдүүлсэн

56.1.4. гэмт хэргийн улмаас хүнд хор үршиг учирсан;

56.1.5. гэмт хэргийг онц харгис хэрцгий аргаар буюу хохирогчийг тохуурхан даажигнаж үйлдсэн;

56.1.6. жирэмсэн болон хөхүүл хүүхэдтэй эмэгтэй, бага насны хүүхэд, өндөр настан, биеэ

- хамгаалж чадахгүй хүн, түүнчлэн эд хөрөнгө, албан тушаалын болон өөр байдлаар эрхшээлдээ байсан хүний эсрэг гэмт хэрэг үйлдсэн
- 56.1.7. нийтэд учирсан гамшигт байдал, нийтийг хамарсан эмх замбараагүй байдлыг далимдуулан гэмт хэрэг үйлдсэн
- 56.1.8. албаны үйл ажиллагаа буюу олон нийтийн үүргээ биелүүлж байгаа хүн, түүний ойрын төрөл садангийн хүний эсрэг гэмт хэргийг тэдний гүйцэтгэж байгаа үүрэгтэй нь холбогдуулан үйлдсэн
- 56.1.9. нийтэд аюултай аргаар гэмт хэрэг үйлдсэн буюу галт зэвсэг, тэсэрч дэлбэрэх үйлчилгээтэй галт хэрэгсэл, хорт бодис, эм бэлдмэл, химийн болон биологийн гаралтай бодис ашиглаж гэмт хэрэг үйлдсэн;
- 56.1.10. согтуурсан буюу мансуурсан үедээ гэмт хэрэг үйлдсэн;
- 56.1.11. өөр гэмт хэргийг нуун далдлах буюу үйлдэхэд хялбарчлах зорилгоор үйлдсэн
- 56.1.12. шүүхийн шийтгэх тогтоол биелүүлэхийг хойшлуулсан буюу ялыг тэнсэж хянан харгалзсан хугацаанд, эсхүл ялтай байхдаа гэмт хэрэг дахин үйлдсэн.
- 56.2. Энэ хуулийн 56.1-д заасан хүндрүүлэх нөхцөл байдал нь уг хуулийн тусгай ангийн тодорхой зүйл, хэсэгт заасан гэмт хэргийн бүрэлдэхүүний шинж болж байгаа бол түүнийг ял оногдуулахдаа харгалзаж үзэхгүй.
- 56.3. Шүүх ял оногдуулахдаа энэ хуулийн 56.1-д зааснаас бусад байдлыг ялыг хүндрүүлэх нөхцөл байдалд тооцохгүй.

58 дугаар зүйл. Хэд хэдэн шийтгэх тогтоолоор ял оногдуулах

- 58.1. Шүүхийн шийтгэх тогтоол гарсны дараа буюу оногдуулсан ялыг бүрэн эдэлж дуусахын өмнө гэмт хэрэг шинээр үйлдэж шийтгүүлж байгаа бол шүүхийн сүүлчийн шийтгэх тогтоолоор оногдуулсан ял дээр өмнөх шүүхийн шийтгэх тогтоолоор оногдуулснаас эдлээгүй үлдсэн ялыг бүгдийг буюу заримыг нэмж нэгтгэн уг этгээдийн биечлэн эдлэх ялыг тогтооно.
- 58.2. Энэ хуулийн 58.1-д заасан журмаар ялыг хооронд нь нэмж нэгтгэхдээ биечлэн эдлэх ялын хугацааг тухайн төрлийн ялын энэ хуулиар тогтоосон дээд хэмжээнээс хэтрүүлж болохгүй.
- 58.3. Албадан ажил хийлгэх, баривчлах ялыг хооронд нь нэмж нэгтгэхдээ албадан ажил хийлгэх ялын найман цагийг баривчлах ялын нэг хоногтой тэнцүүлж тооцно.
- 58.4. Албадан ажил хийлгэх, хорих ялыг хооронд нь нэмж нэгтгэхдээ албадан ажил хийлгэх ялын найман цагийг хорих ялын нэг хоногтой тэнцүүлж тооцно.
- 58.5. Баривчлах, хорих ялыг хооронд нь нэмж нэгтгэхдээ баривчлах ялын нэг хоногийг хорих ялын нэг хоногтой тэнцүүлж тооцно.

59 дүгээр зүйл. Цагдан хоригдсон хугацааг тооцох

- 59.1. Шүүх цагдан хоригдсон хугацааг шүүгдэгчийн ял эдэлсэн хугацаанд оруулж тооцно.
- 59.2. Цагдан хоригдсон нэг хоногийг албадан ажил хийлгэх ялын найман цагтай, баривчлах, хорих ялын нэг хоногтой тэнцүүлж ялын хугацаанд оруулж тооцно
- 59.3. Цагдан хоригдсон этгээдэд торгох буюу тодорхой албан тушаал эрхлэх, үйл ажиллагаа явуулах эрхийг хасах ялыг үндсэн ялын чанартай оногдуулсан бол цагдан хоригдсон хугацааг харгалзан шүүх уг ялыг хөнгөрүүлэх буюу ял эдэлсэнд тооцож болно. Цагдан хоригдсон этгээдэд торгох ял оногдуулсан бол цагдан хоригдсон нэг хоногийг тухайн үед мөрдөгдөж байгаа нэг сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээтэй тэнцүүлж, торгох ялаас хасч тооцно.

60 дугаар зүйл. Гэмт хэрэг үйлдэхээр бэлтгэсэн буюу завдсан үйлдэлд ял оногдуулах

- 60.1. Шүүх гэмт хэрэг үйлдэхээр бэлтгэсэн буюу завдсан үйлдэлд ял оногдуулахдаа гэмт санаагаа хэрэгжүүлсэн хэр хэмжээ, завдалт төгссөн эсэх, бэлтгэсэн буюу завдсан гэмт хэргийн нийгмийн аюулын шинж чанар, хэр хэмжээ, гэмт хэргээ туйлд нь хүргэж чадаагүй нөхцөл байдлыг харгалзана.
- 60.2. Гэмт хэрэгт бэлтгэсэн үйлдэлд оногдуулах ялын дээд хэмжээ нь энэ хуулийн тусгай ангид тухайн төгссөн гэмт хэрэгт оногдуулахаар заасан аль хүнд төрлийн ялын доод хэмжээний хоёрны нэгээс хэтрэхгүй байна.
- 60.3. Гэмт хэрэг үйлдэхээр завдсан үйлдэлд оногдуулах ялын дээд хэмжээ нь энэ хуулийн

тусгай ангид тухайн төгссөн гэмт хэрэгт оногдуулахаар заасан аль хүнд төрлийн ялын доод хэмжээний гуравны хоёроос хэтрэхгүй байна.

60.4. Онц хүнд гэмт хэрэгт бэлтгэсэн буюу завдсан этгээдэд арван таван жилээс дээш хугацаагаар хорих буюу цаазаар авах ял оногдуулахгүй.

61 дүгээр зүйл.Тэнсэх

61.1.Хүндэвтэр гэмт хэрэгт анх удаа хорих ял шийтгүүлсэн этгээдийн үйлдсэн гэмт хэргийн нийгмийн аюулын шинж чанар, хэр хэмжээ, гэмт хэрэг үйлдсэн этгээдийн хувийн байдал, гэмт хэрэг үйлдсэн нөхцөл байдлыг харгалзан гэмт хэргийн улмаас учирсан хохирлыг нөхөн төлсөн буюу гэм хорыг арилгасан тохиолдолд түүнд оногдуулсан ялыг биечлэн эдлүүлэх шаардлагагүй гэж шүүх үзвэл уг ялыг тэнсэж, нэгээс таван жилийн хугацаагаар хянан харгалзахаар тогтоож болно. Тэнсэгдсэн ялтан шүүхээс тогтоосон хянан харгалзах хугацаанд гэмт хэрэг шинээр үйлдээгүй, засарч хүмүүжсэнээ харуулсан бол шүүхийн шийтгэх тогтоолыг биелүүлэхгүй

61.2.Энэ хуулийн 61.1-д заасан журмыг ялтай байгаа этгээдэд хэрэглэхгүй.

61.3.Тэнсэгдсэн ялтан хянан харгалзах хугацаанд гэмт хэрэг шинээр үйлдвэл шүүх түүнд энэ хуулийн 58 дугаар зүйлд заасан журмыг баримтлан ял оногдуулна

61.4.Тэнсэгдсэн ялтан цагдаагийн байгууллага хяналт тавина.

61.5.Тэнсэгдсэн ялтан хянан харгалзах хугацаанд захиргааны шийтгэл хүлээсэн бол цагдаагийн байгууллагын саналыг үндэслэн хорих ялыг биечлэн эдлүүлэх эсэхийг шүүх шийдвэрлэнэ.

68 дугаар зүйл. Архаг архичин буюу мансуурах донтой этгээдэд эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээ хэрэглэх, тэдэнд харгалзан дэмжигч тогтоох

68.1. Архаг архичин буюу мансуурах донтой этгээд гэмт хэрэг үйлдсэн бол эрүүл мэндийн байгууллагын дүгнэлтийг үндэслэн шүүх уг этгээдэд үйлдсэн гэмт хэрэгт нь ял оногдуулахын зэрэгцээ эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээ хэрэглэж болно.

69 дүгээр зүйл. Насанд хүрээгүй этгээдэд хүмүүжлийн чанартай албадлагын арга хэмжээ хэрэглэх

69.1. Хөнгөн буюу хүндэвтэр гэмт хэрэг анх удаа үйлдсэн насанд хүрээгүй этгээдэд ял оногдуулахгүй байх нь зохистой гэж шүүх үзвэл түүнд дор дурдсан хүмүүжлийн чанартай албадлагын арга хэмжээ оногдуулж болно:

АРВАНТАВДУГААР БҮЛЭГ ХҮНИЙ АМЬ БИЕ, ЭРҮҮЛ МЭНДИЙН ЭСРЭГ ГЭМТ ХЭРЭГ

91 дүгээр зүйл. Хүнийг санаатай алах

91.1.Энэ хуулийн 91.2-т заасан хүндрүүлэх нөхцөл байдалгүйгээр хүнийг санаатай алсан бол арваас дээш арван таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

91.2.Хүнийг

91.2.1.шунахайн сэдэлтээр;

91.2.2.танхайн сэдэлтээр;

91.2.3.өс хонзонгоор

91.2.4.захиалгаар;

91.2.5.хохирогчийн цус, эд, эрхтэнийг ашиглах зорилгоор

91.2.6.өөр гэмт хэргийг нуун далдлах буюу хялбарчлах зорилгоор;

91.2.7.уулгалан довтлох буюу дээрэмдэх хэргийг үйлдэхдээ;

91.2.8.хүн хулгайлах буюу бусдыг барьцаанд авах гэмт хэрэг үйлдэхдээ;

91.2.9.онц аюултай гэмт хэрэгтэн;

91.2.10.хүнийг санаатай алах гэмт хэргийг давтан үйлдсэн /энэ хуулийн 93 дугаар зүйл хамаарахгүй/;

91.2.11.бүлэглэж, урьдчилан үгсэж тохиролцсон бүлэг, зохион байгуулалттай бүлэг, гэмт бүлэглэл;

91.2.12.онц харгис хэрцгий аргаар;

91.2.13.нийтэд аюултай аргаар;

91.2.14.хохирогчийг жирэмсэн болохыг мэдсээр байж;

- 91.2.15. хохирогчийг биеэ хамгаалж чадахгүй байгааг мэдсээр байж;
91.2.16. хоёр буюу түүнээс олон хүнийг;
91.2.17. албаны үйл ажиллагаа буюу олон нийтийн үүргээ биелүүлж байгаатай нь холбогдуулан хүнийг өөрийг нь буюу түүний ойрын төрөл, садангийн хүнийг алсан бол арван таваас дээш хорин таван жил хүртэл хугацаагаар хорих, эсхүл цаазаар авах ял шийтгэх

93 дугаар зүйл. Санаа сэтгэл нь хүчтэй цочрон давчидсан үед бусдыг санаатай алах

- 93.1. Хохирогчид хүчээр дарлагдсан буюу хүндээр доромжлогдсон, эсхүл түүний хууль бус бусад үйлдлээс өөрт нь буюу ойр дотных нь хүмүүст хүнд хор уршиг учирсан, учирч болох байснаас санаа сэтгэл нь гэнэт хүчтэй цочрон давчидсан үедээ бусдыг санаатай алсан бол таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

94 дүгээр зүйл. Бусдыг болгоомжгүй алах

- 94.1. Бусдыг болгоомжгүй алсан бол таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

95 дугаар зүйл. Бусдыг амиа хорлоход хүргэх

- 95.1. Эд хөрөнгө, албан тушаалын болон өөр байдлаар эрхшээлдээ байгаа болон өөр бусад хүмүүстэй харгис хэрцгий харьцсан буюу нэр төр, алдар хүндийг нь байнга гутаан доромжилсны улмаас хохирогч амиа хорлосон бол хоёроос таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

96 дугаар зүйл. Бусдын бие махбодид хүнд гэмтэл санаатай учруулах

- 96.1. Бусдын бие махбодид хүнд гэмтэл санаатай учруулсан, өөрөөр хэлбэл амь биед нь аюултай гэмтэл учруулсан буюу хараа, сонсголгүй болгосон, эрхтнээс нь хагацуулсан, ажиллагаагүй болгосон, нүүрийг засаршгүй эвдэж дүрсийг алдагдуулсан, хүүхэд дутуу гаргуулсан буюу ураг зулбуулсан, сэтгэцийн өвчтэй болгосон, түүнчлэн хөдөлмөрийн чадварыг бүрмөсөн алдагдуулсан бол таваас дээш долоон жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

- 96.2. Энэ хэргийг:

96.2.1. танхайн сэдэлтээр;

96.2.2. захиалгаар;

96.2.3. онц аюултай гэмт хэрэгтэн;

96.2.4. давтан;

96.2.5. бүлэглэж, урьдчилан үгсэж тохиролцсон бүлэг, зохион байгуулалттай бүлэг, гэмт бүлэглэл;

96.2.6. онц харгис хэрцгий аргаар;

96.2.7. нийтэд аюултай аргаар;

96.2.8. тохуурхан даажигнаж, зовоон тарчлааж;

96.2.9. хохирогчийн биеэ хамгаалж чадахгүй байгааг мэдсээр байж;

96.2.10. хоёр буюу түүнээс олон хүнийг;

96.2.11. албаны үйл ажиллагаа буюу олон нийтийн үүргээ биелүүлж байгаатай нь холбогдуулан үйлдсэн бол долоогоос дээш арван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

97 дугаар зүйл. Бусдын бие махбодид хүнд гэмтэл болгоомжгүй учруулах

- 97.1. Бусдын бие махбодид хүнд гэмтэл болгоомжгүй учруулсан бол хоёр жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

98 дугаар зүйл. Бусдын бие махбодид хүндэвтэр гэмтэл санаатай учруулах

- 98.1. Бусдын бие махбодид удаан хугацаагаар эрүүл мэндийг нь сарниулсан буюу хөдөлмөрийн чадварын гуравны нэгээс дээшгүйг алдагдуулсан гэмтэл санаатай учруулсан бол хоёр зуун тавин нэгээс дөрвөн зуун тавин цаг хүртэл хугацаагаар албадан ажил хийлгэх, эсхүл гурван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

98.2. Энэ хэргийг давтан буюу бүлэглэж үйлдсэн, уг үйлдэл нь зовоон тарчлаах шинжтэй байсан, эсхүл онц аюултай гэмт хэрэгтэн үйлдсэн бол гурваас дээш зургаан сар хүртэл хугацаагаар баривчлах, эсхүл гурваас дээш таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

99 дүгээр зүйл. Бусдын бие махбодид хөнгөн гэмтэл санаатай учруулах

- 99.1. Бусдын бие махбодид хөнгөн гэмтэл санаатай учруулсан, өөрөөр хэлбэл эрүүл мэндийг нь түр хугацаагаар сарниулсан буюу хөдөлмөрийн чадварыг бага хэмжээгээр алдагдуулсан бол хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг таваас хорь дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл нэгээс гурван сар хүртэл хугацаагаар баривчлах ял шийтгэнэ.
- 99.2. Энэ хэргийг давтан буюу бүлэглэж үйлдсэн бол хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг тавин нэгээс нэг зуу дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, хоёр зуун тавин нэгээс гурван зуун тавин цаг хүртэл хугацаагаар албадан ажил хийлгэх, эсхүл гурваас дээш зургаан сар хүртэл хугацаагаар баривчлах ял шийтгэнэ.

100 дугаар зүйл. Тарчлаах

- 100.1. Байнга зодох буюу тарчлаах шинжтэй бусад үйлдэл хийсэн нь энэ хуулийн 96, 98 дугаар зүйлд заасан хор уршиг учруулаагүй бол гурваас дээш зургаан сар хүртэл хугацаагаар баривчлах, эсхүл хоёр жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

117 дугаар зүйл. Хүүхэд хаях, төөрүүлэх

- 117.1. Төрүүлсэн болон үрчлэн авсан хүүхдээ хаясан, төөрүүлсэн бол хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг тавин нэгээс хоёр зуун тавь дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, хоёр зуун тавин нэгээс гурван зуун цаг хүртэл хугацаагаар албадан ажил хийлгэх, эсхүл гурваас дээш зургаан сар хүртэл хугацаагаар баривчлах ял шийтгэнэ. /Энэ хэсэгт 2008 оны 02 дугаар сарын 01-ний өдрийн хуулиар нэмэлт оруулсан/
- 117.2. Энэ хэргийн улмаас хүүхдийн амь нас хохирсон, бусад хүнд хор уршиг учирсан бол таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

118 дугаар зүйл. Асран хамгаалах үүргээ урвуулах

- 118.1. Эцэг, эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигч хуулиар хүлээсэн асран хамгаалах үүргээ шүнахай зорилгоор урвуулан ашигласан, асран хамгаалж байгаа хүнээ хараа хяналтгүй байлгасан, шаардлагатай түслэмж үзүүлэлгүй орхисон бол хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг таваас тавь дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл нэгээс гурван сар хүртэл хугацаагаар баривчлах ял шийтгэнэ.

119 дүгээр зүйл. Сургуулийн өмнөх насны хүүхдийг халамжлах үүрэгт ажилдаа хайнга хандах

- 119.1. Сургуулийн өмнөх насны хүүхдийг халамжлах албан үүрэг бүхий этгээд уг үүрэгт ажилдаа хайнга хандсаны улмаас хохирогчийн бие махбодид хүндэвтэр, хүнд гэмтэл учруулсан нь албан тушаалын гэмт хэргийн шинжгүй бол тодорхой албан тушаал эрхлэх, үйл ажиллагаа явуулах эрхийг хоёр жил хүртэл хугацаагаар хасах буюу хасахгүйгээр хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг тавин нэгээс нэг зуун тавь дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл гурваас дээш зургаан сар хүртэл хугацаагаар баривчлах ял шийтгэнэ.
- 119.2. Энэ хэргийн улмаас хүүхдийн амь нас хохирсон бол тодорхой албан тушаал эрхлэх, үйл ажиллагаа явуулах эрхийг гурван жил хүртэл хугацаагаар хасч хоёроос таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

125 дугаар зүйл. Бэлгийн дүр хүслээ ёс бусаар хангах

- 125.1. Хүсэл зоригийнх нь эсрэг хүч хэрэглэж буюу хүч хэрэглэхээр заналхийлэх, бусдын биеэ хамгаалж чадахгүй байдлыг далимдуулан, түүнчлэн хохирогчийг тохуурхан доромжилж бэлгийн дүр хүслээ ёс бусаар хангасан бол хоёроос таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

126 дугаар зүйл. Хүчиндэх

- 126.1. Хохирогчид хүч хэрэглэж буюу хүч хэрэглэхээр заналхийлэх, эсхүл бусдын биеэ хамгаалж чадахгүй байдлыг далимдуулан хурьцал үйлдсэн бол таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.
- 126.2. Энэ хэргийг:

- 126.2.1. хохирогчийг тохуурхан даажигнаж, зовоон тарчлааж;
- 126.2.2. хүндэвтэр буюу хүнд гэмтэл учруулж;
- 126.2.3. давтан;
- 126.2.4. насанд хүрээгүй хүнийг;
- 126.2.5. албан тушаал, эд хөрөнгийн болон өөр байдлаар эрхшээлдээ байгаа хүнийг; / Энэ заалтыг 2008 оны 02 дугаар сарын 01-ний өдрийн хуулиар нэмсэн/
- 126.2.6. бүлэглэж буюу урьдчилан үгсэж тохиролцсон бүлэг үйлдсэн бол таваас дээш арван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ. /Энэ заалтын дугаарт 2008 оны 02 дугаар сарын 01-ний өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан/
- 126.3. Энэ хэргийг онц аюултай гэмт хэрэгтэн, зохион байгуулалттай бүлэг, гэмт бүлэглэл үйлдсэн, уг хэргийн улмаас хүний амь нас хохирсон, бусад хүнд хор үршиг учирсан, эсхүл бага насны, өөрөөр хэлбэл арван дөрвөн насанд хүрээгүй хүүхдийг хүчиндсэн бол арван таваас дээш хорин таван жил хүртэл хугацаагаар хорих, эсхүл цаазаар авах ял шийтгэнэ.

127 дугаар зүйл. Эмэгтэй хүнийг тулган шаардаж үр хөндүүлэх

- 127.1. Эмэгтэй хүнийг тулган шаардаж үр хөндүүлсэн бол хоёр зуун тавин нэгээс дөрвөн зуун цаг хүртэл хугацаагаар албадан ажил хийлгэх, гурваас зургаан сар хүртэл хугацаагаар баривчлах, хоёр жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

181 дүгээр зүйл. Танхайрах

- 181.1. Бусдыг илтэд үл хүндэтгэн хүч хэрэглэх буюу хүч хэрэглэхээр заналхийлж, нийгмийн хэв журмыг ноцтой зөрчсөн бол хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг тавин нэгээс нэг зуу дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, гурваас дээш зургаан сар хүртэл хугацаагаар баривчлах, эсхүл гурван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ. /Энэ хэсэгт 2008 оны 02 дугаар сарын 01-ний өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан/
- 181.2. Энэ хэргийг:
 - 181.2.1. догшин авирлаж;
 - 181.2.2. нийгмийн хэв журам хамгаалах үүргээ биелүүлж байгаа цагдаагийн ажилтан, төрийн болон олон нийтийн төлөөлөгч, танхайрсан үйлдлийг таслан зогсоох гэсэн иргэнийг эсэргүүцэж;
 - 181.2.3. урьд нь энэ хэрэгт шийтгүүлсэн этгээд;
 - 181.2.4. давтан;
 - 181.2.5. бүлэглэж үйлдсэн бол гурваас дээш таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.
- 181.3. Энэ хэргийг онц аюултай гэмт хэрэгтэн, түүнчлэн зэвсэг, зэвсгийн чанартай бусад зүйл хэрэглэж үйлдсэн бол таваас дээш найман жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

245 дугаар зүйл. Хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалт, шүүн таслах ажиллагаанд саад учруулах

- 245.1. Хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалт, шүүн таслах ажиллагаанд санаатайгаар саад учруулсан бол хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг таваас тавь дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, нэг зуугаас хоёр зуун цаг хүртэл хугацаагаар албадан ажил хийлгэх, эсхүл нэгээс гурван сар хүртэл хугацаагаар баривчлах ял шийтгэнэ.
- 245.2. Энэ хэргийг албан тушаалын байдлаа ашиглаж үйлдсэн бол тодорхой албан тушаал эрхлэх, үйл ажиллагаа явуулах эрхийг гурван жил хүртэл хугацаагаар хасах буюу хасахгүйгээр хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг тавин нэгээс хоёр зуун тавь дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, гурван зуугаас таван зуун цаг хүртэл хугацаагаар албадан ажил хийлгэх, гурваас дээш зургаан сар хүртэл хугацаагаар баривчлах, эсхүл гурван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

246 дугаар зүйл. Гэмт хэргийг үл мэдээлэх

- 246.1. Энэ хуулийн тусгай ангийн 87.2/Хүндрүүлэх нөхцөл байдалтайгаар төрийн нууц

задруулах/, 91/Хүнийг санаатай алах/, 96/Бусдын бие махбодид хүнд гэмтэл санаатай учруулах/, 108/Хүн хулгайлах/, 112/Хүнийг барьцаалах/, 126.2; 126.3/Хүндрүүлэх нөхцөл байдалтайгаар хүчиндэх/, 145.2; 145.3; 145.4/Хүндрүүлэх нөхцөл байдалтайгаар бусдын эд хөрөнгийг хулгайлах/, 146.2; 146.3; 146.4/Хүндрүүлэх нөхцөл байдалтайгаар бусдын эд хөрөнгийг булаах /, 148.2; 148.3; 148.4/Хүндрүүлэх нөхцөл байдалтайгаар бусдын эд хөрөнгийг залилан мэхлэх/, 150.2; 150.3/Хүндрүүлэх нөхцөл байдалтайгаар бусдын эд хөрөнгийг завших, үрэгдүүлэх /, 147/Бусдын эд хөрөнгийг дээрэмдэх/, 176/Мөнгөн тэмдэгт, үнэт цаасыг хуурамчаар үйлдэх, борлуулах/, 177/Зандалчлах/, 1781 /Терроризм/, 225/Агаарын хөлөг авч зугатаах/, 268.2; 269.2; 270.2/Хүндрүүлэх нөхцөл байдалтайгаар хээл хахууль авах, өгөх, зуучлах / -т заасан гэмт хэргийг үйлдэхээр бэлтгэж байгаа буюу үйлдсэнийг лавтай сайн мэдсэн атлаа зохих байгууллага, албан тушаалтанд мэдээлээгүй бол хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг таваас тавь дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл нэгээс гурван сар хүртэл хугацаагаар баривчлах ял шийтгэнэ./Энэ хэсэгт 2008 оны 02 дугаар сарын 01-ний өдрийн хуулиар нэмэлт, өөрчлөлт оруулсан/

246.2.Энэ хуулийн тусгай ангийн 79/Эх орноосоо үрвах/, 80/Тагнуул хийх/, 81/Төр, нийгмийн зүтгэлтний амь биед халдах/, 82/Төрийн эрх мэдлийг хууль бусаар авах хуйвалдаан зохион байгуулах/, 84/Хорлон сүйтгэх/, 85/Хорлон саатуулах/ дугаар зүйлд заасан гэмт хэргийг үйлдэхээр бэлтгэж байгаа буюу үйлдсэнийг лавтай сайн мэдсэн атлаа зохих байгууллага, албан тушаалтанд мэдээлээгүй бол гурван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

258 дугаар зүйл. Шүүхийн шийдвэрийг үл биелүүлэх

258.1.Хуулийн хүчин төгөлдөр болсон шүүхийн шийтгэх тогтоол, шийдвэр, магадлал, шүүхийн тогтоол, шүүгчийн захирамжийг санаатай биелүүлээгүй, эсхүл биелүүлэхэд нь зориуд саад учруулсан бол хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг таваас тавь дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, нэг зуугаас хоёр зуун тавин цаг хүртэл хугацаагаар албадан ажил хийлгэх, нэгээс гурван сар хүртэл хугацаагаар баривчлах ял шийтгэнэ./Энэ хэсэгт 2008 оны 02 дугаар сарын 01-ний өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан/

258.2.Шүүхийн шийдвэр биелүүлэхээс зайлсхийх зорилгоор хөрөнгийн мэдүүлгээ санаатай буруу гаргасан, эсхүл эд хөрөнгөө нуун дарагдуулсан, бусдад шилжүүлсэн бол хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг тавин нэгээс хоёр зуун тавь дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, хоёр зуун тавин нэгээс таван зуун цаг хүртэл хугацаагаар албадан ажил хийлгэх, гурваас дээш зургаан сар хүртэл хугацаагаар баривчлах, эсхүл хоёроос дээш дөрвөн жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

258.3.Энэ хэргийг гэмт хэрэгт урьд ял шийтгүүлсэн этгээд, зохион байгуулалттай бүлэг, гэмт бүлэглэл үйлдсэн бол гурваас дээш таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ. Тайлбар: Энэ зүйлд заасан гэмт хэрэгт сэжигтнээр тооцогдсон, яллагдагчаар татагдсан, ял шийтгэгдсэн этгээд шүүхийн шийдвэрийг биелүүлсэн бол эрүүгийн хариуцлагаас чөлөөлнө.

Эрүүгийн байцаан шийтгэх тухай хууль

25 дугаар зүйл. Хохирогч нь яллагдагч, шүүгдэгчтэй эвлэрснээр хэргийг хэрэгсэхгүй болгох

25.1.Яллагдагч, шүүгдэгч нь Эрүүгийн хуульд заасан хөнгөн гэмт хэргийг анх удаа үйлдсэн бөгөөд учруулсан хохирлоо бүрэн төлсөн, гэм хорыг арилгасан нөхцөлд хохирогч нь яллагдагч, шүүгдэгчтэй сайн дураараа эвлэрсэн бол хэргийг хэрэгсэхгүй болгоно./Энэ хэсгийг 2004 оны 5 дугаар сарын 14-ний өдрийн хуулиар өөрчлөн найруулсан//Энэ хэсгийг 2007 оны 08 дугаар сарын 09-ний өдрийн хуулиар өөрчлөн найруулсан/

25.2. Энэ хуулийн 25.1-д заасан хэргийн хохирогч нь яллагдагчийн эрхшээлд байгаагаас,

эсхүл бусад шалтгааны улмаас өөрийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалж чадахгүй тохиолдолд хэргийг хэрэгсэхгүй болгож болохгүй ба энэ тохиолдолд хэргийг шүүхэд шилжүүлж шүүх ердийн журмаар хянан шийдвэрлэнэ.

147 дугаар зүйл. Гэрч, хохирогчийг байцаах журам

147.4. Гэрч, хохирогч нь өөрийн болон гэр бүлийн гишүүд, эцэг, эх, үр хүүхдийнхээ эсрэг тэдний байдлыг хүндрүүлж болох тухай мэдүүлэг өгөхгүй байх эрхтэйг нь тайлбарлан өгөх бөгөөд энэ эрхээ эдлэхгүй гэвэл мэдүүлэг өгөхөөс татгалзах буюу зайлсхийх, санаатай худал мэдүүлэг өгвөл хариуцлага хүлээлгэх тухай сануулна.

156 дугаар зүйл. Шинжилгээ заавал хийлгэх

156.1. Дор дурдсан тохиолдолд шинжилгээ заавал хийлгэнэ :

156.1.1. гадны нөлөөллөөр буюу сэжигтэй байдлаар нас барсан бол түүний шалтгааныг тогтоох;

156.1.2. бие махбодид учирсан гэмтлийн зэрэг, шинж байдлыг тогтоох;

156.1.3. сэжигтэн, яллагдагч, шүүгдэгч хэргийнхээ үйлдлийг тайлбарлах, түүнийг хариуцах чадвартай эсэхэд эргэлзээ төрвөл тэдний сэтгэцийн байдлыг тодорхойлох;

156.1.4. гэрч, хохирогч нь хэрэгт ач холбогдол бүхий байдлыг бодитойгоор тусгаж, зөв мэдүүлэг өгөх чадвартай эсэхэд эргэлзээ төрвөл тэдний сэтгэцийн байдлыг тодорхойлох;

156.1.5. сэжигтэн, яллагдагч, шүүгдэгч, хохирогчийн насны тухай баримт бичиг байхгүй бөгөөд тэдний насыг тогтоох явдал хэрэгт ач холбогдолтой байвал;

156.1.6. онц хүнд гэмт хэргийн яллагдагчийн сэтгэцийн байдлыг тодорхойлох.

165 дугаар зүйл. Нэмэлт ба дахин шинжилгээ хийх

165.1. Нэмэлт ба дахин шинжилгээ хийлгэхэд Шүүхийн шинжилгээний тухай хуулийн 19, 20 дугаар зүйлд заасан үндэслэл, журмыг баримтална.

193 дугаар зүйл. Хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын ажиллагаанд хяналт тавих прокурорын бүрэн эрх

193.1. Эрүүгийн хэргийн хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын ажиллагаанд хууль хэрхэн биелж байгаад хяналт тавихдаа прокурор дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

193.1.1. эрүүгийн хэрэг үүсгэсэн нь хууль зүйн үндэслэлтэй эсэхийг хянаж үндэслэлгүйгээр эрүүгийн хэрэг үүсгэсэн гэж үзвэл тогтоолыг хүчингүй болгох;

193.1.2. гэмт хэргийн шинж тэмдгийг өөрөө илрүүлсэн бол эрүүгийн хэрэг үүсгэх шийдвэр гаргаж хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалт явуулах байгууллагад харьяаллын дагуу шилжүүлж шалгуулах;

193.1.3. гэмт хэргийн тухай гомдол, мэдээллийг хүлээн авах, бүртгэх, шалган шийдвэрлэх ажиллагаа хуулийн хүрээнд явагдаж байгаа эсэхийг хянах;

193.1.4. хэргийн оролцогч гомдол, хүсэлт гаргасан бол түүнийг хянан шийдвэрлэхийн тулд хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын шатанд байгаа хэргийг хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалт явуулах байгууллагаас татаж хянах, үүний үндсэн дээр байцаан шийтгэх тодорхой ажиллагаа явуулах даалгаврыг хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагчид өгч биелэлтэд хяналт тавих;

193.1.5. гэмт хэрэг, түүнийг үйлдсэн этгээдийг олж тогтоох зорилгоор хийгдэж байгаа гүйцэтгэх ажилд хууль тогтоомжоор олгосон бүрэн эрхийн хүрээнд хяналт тавих;

193.1.6. шаардлагатай гэж үзвэл хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагчаас байцаан шийтгэх тодорхой ажиллагаа явуулахад биечлэн оролцох;

193.1.7. энэ хуульд заасны дагуу мөрдөн шалгах ажиллагаа явуулах;

193.1.8. энэ хуульд заасан тохиолдолд хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагчаас явуулах байцаан шийтгэх тодорхой ажиллагааны зөвшөөрлийг өгөх;

193.1.9. хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын хугацааг сунгах;

193.1.10. сэжигтэн, яллагдагчийг хорьж мөрдөх, уг хугацааг сунгах саналыг шүүхэд тавих;

193.1.11. хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч, доод шатны прокурорыг татгалзан гаргах тухай хүсэлтийг шийдвэрлэх;

193.1.12. хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын ажиллагаа, хэрэг бүртгэгч, мөрдөн

- байцаагчийн ажиллагаа, шийдвэрийн талаар прокурорын байгууллагад гаргасан гомдлыг хянан шийдвэрлэх;
- 193.1.13. хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын явцад хуулийн шаардлагыг биелүүлэх талаар бичгээр заалт өгч хэргийг буцаах;
- 193.1.14. эрүүгийн хэргийг түдгэлзүүлэх, сэргээх, хэрэгсэхгүй болгох талаар гарсан хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагчийн саналыг шийдвэрлэх;
- 193.1.15. эрүүгийн хэрэг үндэслэлгүйгээр үүсгэсэн, нэгтгэсэн, тусгаарласан хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагчийн тогтоолыг хүчингүй болгож цаашид хэрхэхийг шийдвэрлэх;
- 193.1.16 энэ хуульд заасан тохиолдолд хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагчийн тогтоолыг батлах;
- 193.1.17. хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч, доод шатны прокурорын хууль бус шийдвэрийг хүчингүй болгох;
- 193.1.18. нэмэлт мөрдөн байцаалт хийлгэхээр тодорхой чиглэл өгөх, хэргийг хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагчид буцаах;
- 193.1.19. хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын ажиллагааны үед хууль зөрчсөн хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагчийг тухайн хэргийг цаашид мөрдүүлэхийг зогсоох;
- 193.1.20. хэргийг шүүхэд шилжүүлэх;
- 193.1.21. хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын болон хяналтын ажилд шаардлагатай мэдээ судалгаа, баримт бичгийг аль ч байгууллага, албан тушаалтнаас үнэ төлбөргүй гаргуулан авах, газар дээр нь танилцах, мэргэжлийн дүгнэлт магадлагаа гаргуулах;
- 193.1.22. хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын ажиллагаанд хуулийн заалт хэрхэн хэрэгжиж байгаад үнэлэлт, дүгнэлт өгөхийн тулд тэдгээрийн ажлыг бүхэлд нь буюу хэсэгчлэн шалгах, шаардлагатай хэрэг материалыг татаж хянах;
- 193.1.23. хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын хэвийн ажиллагааг хангах, уг ажиллагаанд илэрсэн нийтлэг зөрчлийг арилгуулах талаар хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалт явуулах байгууллагын захиргаанд шаардлага тавих;
- 193.1.24. хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалт явуулах байгууллагын захиргаанаас хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын ажиллагааны талаар гаргасан тушаал, шийдвэр хуульд нийцэж байгаа эсэхийг хянах, зөрчсөн тушаал шийдвэрт эсэргүүцэл бичих;
- 193.1.25. хэрэг шалгах харьяалал тогтоох;
- 193.1.26. эрүүгийн хэргийн хавтаст хэргийг архивт хадгалах;
- 193.1.27. энэ хуульд заасан бусад бүрэн эрх.

Иргэний хууль

492 дугаар зүйл. Бусдын хөрөнгийг үндэслэлгүйгээр олж авсан буюу эзэмшсэнээс үүсэх үүрэг

- 492.1. Бусдын өмнө хүлээсэн үүргээ гүйцэтгэхээр хэн нэгэн этгээдэд хөрөнгө шилжүүлсэн этгээд уг зүйлийг олж авсан этгээдээс дээрх хөрөнгөө дараахь тохиолдолд буцаан шаардах эрхтэй:
- 492.1.1. хөрөнгө олж авсан этгээд болон үүрэг гүйцэтгэгч этгээдийн хооронд үүрэг үүсээгүй, эсхүл үүрэг нь хожим дуусгавар болсон буюу хүчин төгөлдөр бус болсон;
- 492.1.2. үүрэг гүйцэтгүүлэгч шаардлага гаргаж болохооргүй үлэмж маргаантай.
- 492.2. Дараахь тохиолдолд бусдад шилжүүлсэн хөрөнгийг буцаан шаардаж болохгүй:
- 492.2.1. үүрэг гүйцэтгэгч үүргээ гүйцэтгэсэн явдал нь нийтээр хүлээн зөвшөөрсөн зан суртахууны хэм хэмжээнд нийцсэн;
- 492.2.2. шаардлага гаргах хөөн хэлэлцэх хугацаа өнгөрсөн;
- 492.2.3. хүчин төгөлдөр бус болсон үүргийн хувьд өмнө нь гүйцэтгэсэн үүрэг ёсоор шилжүүлсэн өр төлбөрийн гэрээг гүйцэтгэх үед хөрөнгөө буцаан шаардах шаардлага нь хуульд харшилж байвал;
- 492.2.4. хөөн хэлэлцэх хугацаа дууссаныг мэдэлгүйгээр нэг тал нөгөөдөө үүргийн гүйцэтгэл болгон хөрөнгө шилжүүлсэн.
- 492.3. Үүрэг гүйцэтгүүлэхээр бус харин тодорхой үйлдэл хийлгэх буюу үйлдэл хийхгүй

байхаар хэн нэгэн этгээдэд хөрөнгө шилжүүлсэн тохиолдолд нөгөө этгээдийн үйлдэл буюу эс үйлдэхүй хөрөнгө шилжүүлсэн этгээдийн хүсэл зоригт нийцэхгүй бол шилжүүлсэн зүйлээ буцаан шаардаж болно.

492.4.Дараахь тохиолдолд ийнхүү шилжүүлсэн хөрөнгөө буцаан шаардаж болохгүй:

492.4.1.анхнаасаа зорилгодоо хүрэх боломжгүй байсныг хөрөнгө шилжүүлсэн этгээд мэдэж байсан;

492.4.2.хөрөнгө шилжүүлсэн этгээд шударга бус хандаж нөгөө этгээдийнхээ үйлдэлд саад хийсэн.

492.5.Үүрэг гүйцэтгэхээр бус харин хүч хэрэглэсэн буюу заналхийлсэн үйлдлийн үндсэн дээр хэн нэгэн этгээд нөгөө этгээдэд хөрөнгө шилжүүлсэн бол хөрөнгө олж авсан этгээд тухайн хөрөнгийг өөрийн эзэмшилд байлгах эрхтэй байхаас бусад тохиолдолд хөрөнгө шилжүүлсэн этгээд нь түүнийг буцаан шаардах эрхтэй.

497 дугаар зүйл. Гэм хор учруулснаас хариуцлага хүлээх үндэслэл

497.1.Бусдын эрх, амь нас, эрүүл мэнд, нэр төр, алдар хүнд, ажил хэргийн нэр хүнд, эд хөрөнгөд хууль бусаар санаатай буюу болгоомжгүй үйлдэл /эс үйлдэхүй/-ээр гэм хор учруулсан этгээд уг гэм хорыг хариуцан арилгах үүрэгтэй.

497.2.Гэм хор учруулсан этгээд ийнхүү гэм хор учруулсан нь түүний буруугаас болоогүй гэдгийг нотолбол хуульд зааснаас бусад тохиолдолд гэм хор учруулсны хариуцлагаас чөлөөлөгдөнө.

497.3.Гэм хор учруулахад хэд хэдэн этгээд оролцсон бол тэдгээр нь уг гэм хорыг хамтран хариуцах бөгөөд энэ тохиолдолд шууд гэм хор учруулсан этгээд төдийгүй, түүнийг уруу татсан, дэмжин тусалсан, түүнчлэн гэм хор учруулсны үр дүнг санаатай ашигласан этгээд нэгэн адил хариуцлага хүлээнэ.

Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль

129 дүгээр зүйл. Гэр бүлийн холбогдолтой хэрэг хянан шийдвэрлэх урьдчилсан арга хэмжээ

129.1.Шүүгч шаардлагатай гэж үзвэл гэр бүлийн холбогдолтой хэрэг хянан шийдвэрлэхдээ дараахь арга хэмжээг урьдчилан авахаар захирамж гаргаж болно:

129.1.1.насанд хүрээгүй хүүхэд болон хөдөлмөрийн чадваргүй эцэг,эхийг тэжээн тэтгүүлэх;

129.1.2.насанд хүрээгүй хүүхдийг эцэг, эхийн хэн нэг дээр байлгах;

129.1.3.гэрлэгчдийг тусдаа амьдрахыг даалгах;

129.1.4.гэрлэгч хэн нэгийг тэжээн тэтгүүлэх;

129.1.5.орон сууц болон хамтран өмчлөх дундын өмч, үл хөдлөх эд хөрөнгийг өмчлөх эрхийг бусдад шилжүүлэх, худалдах, бэлэглэх, захиран зарцуулахыг хориглох;

129.1.6.шүүхийн зардлын зохих хувийг урьдчилгаа болгон төлүүлэх;

129.1.7.зохигчийг эвлэрэх талаар хугацаа заах.

Гэр бүлийн тухай хууль

3 дугаар зүйл. Хуулийн нэр томъё

3.1.2. “гэр бүл” гэж гэрлэлтийн үр дүнд буй болсон, эд хөрөнгийн бус амины болон эд хөрөнгийн эрх, үүргээр холбогдсон хамтын амьдрал бүхий гэр бүлийн гишүүдийг

3.1.8. “хүнд нөхцөлд байгаа хүүхэд” гэж Хүүхдийн эрхийг хамгаалах тухай хууль[3]-ийн 15 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт заасан хүүхдийг.

4 дүгээр зүйл. Гэрлэлт, гэр бүлийн харилцааны зарчим

4.4. Гэр бүл, эх нялхас, хүүхдийн ашиг сонирхлыг төр хамгаална.

5 дугаар зүйл. Гэр бүлийн эрхийг хамгаалах

5.1. Шүүх нь Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль[4]-д заасны дагуу гэр бүлийн эрхийг хамгаална.

5.2. Төрийн захиргааны болон нийгмийн халамжийн байгууллага нь энэ хуульд заасны дагуу гэр бүлийн эрхийг хамгаална

10 дугаар зүйл. Гэрлэгчдийн эрх, үүрэг

10.2. Гэрлэгчид нь гэр бүлээ төлөвлөх, оршин суух газар, эрхлэх ажил, мэргэжлээ чөлөөтэй сонгох, хуваарьт эд хөрөнгөтэй байх, дундаа хамтран өмчлөх эд хөрөнгөө эзэмших, ашиглах, захиран зарцуулах, материалын болон сэтгэл санааны хохирлоо бүрүүтай этгээдээс гаргуулах тэгш эрхтэй

10.3. Гэрлэгчид нь бие биедээ үнэнч байх, хүүхдээ өсгөн хүмүүжүүлэх, гэр бүлийн гишүүд нь бие биеэ халамжлах, хүндэтгэх, тэжээн тэтгэх, туслах, гэр бүлд шаардагдах эдийн засгийн нөхцөлийг бүрдүүлэх, хэн нэгнийхээ эрхийг зөрчихгүй, бие биеэ аливаа хэлбэрээр хүчирхийлэхгүй байх, үгийн бичиг хөтлөх үүргийг адил хүлээнэ.

12 дугаар зүйл. Гэрлэлт цуцлах журам

12.2. Эхнэр нь жирэмсэн буюу хүүхэд нь нэг нас хүрээгүй, эсхүл хариуцагч хүндээр өвчилсөн тохиолдолд гэрлэлтийг цуцлахыг хориглоно.

14 дүгээр зүйл. Гэрлэлтийг шүүхийн журмаар

14.2. Шүүх шаардлагатай гэж үзвэл хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг гурван сар хүртэл хугацаагаар түдгэлзүүлж, энэ хугацаанд гэрлэгчдийг эвлэрүүлэх бүх талын арга хэмжээ авна. Шүүх гэрлэгчдийг эвлэрүүлэхэд авах бүх талын арга хэмжээг эвлэрүүлэн зүүчлагчаар дамжуулан хэрэгжүүлнэ.

14.4. Гэрлэгчдийн хэн нэгний байнгын хүчирхийлэл, дарамтаас болж гэр бүлийн гишүүдийн амь нас, эрүүл мэнд болон хүүхдийн хүмүүжилд ноцтой хохирол учирч болзошгүй, эсхүл учирсан нь тогтоогдсон бол шүүх энэ хуулийн 14.2-т заасан эвлэрүүлэх арга хэмжээ авахгүйгээр гэрлэлтийг цуцална.

14.6. Гэрлэгчид энэ хуулийн 14.5-д заасны дагуу тохиролцоогүй бол хүүхдийн нас, эцэг, эхийн халамж, ахуйн нөхцөл, бололцоо, ёс суртахууны байдал, хүчирхийлэл үйлдсэн эсэхийг нь харгалзан хүүхдийг эцэг, эхийн хэн нэгний асрамжид үлдээх, тэтгэлгийн хэмжээг тогтоох, хамтран өмчлөх дундын эд хөрөнгийг хуваах асуудлыг шүүх шийдвэрлэнэ.

25 дугаар зүйл. Хүүхдийн эрх, ашиг сонирхлыг хамгаалах

25.4. Эцэг, эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигчийн болон хүүхдийн ашиг сонирхол хоорондоо зөрчилдөж байгаа нь тогтоогдсон бол сум, дүүргийн Засаг дарга хүүхдийн эрх, ашиг сонирхлыг хамгаалах төлөөлөгчийг томилж болно.

25.6. Энэ хуулийн 25.4, 25.5-д заасан хүүхдийн тухай мэдээллийг ясли, цэцэрлэг, ерөнхий боловсролын сургууль, эмнэлгийн байгууллагын холбогдох албан тушаалтан болон иргэн хүүхдийн оршин суугаа /оршин байгаа/ газрын сум, дүүргийн Засаг даргад өгөх үүрэгтэй

25.8. Сум, дүүргийн Засаг дарга энэ хуулийн 25.6, 25.7-д заасан хүүхдийн тухай мэдээллийг хүлээн авснаас хойш гурав хоногийн дотор хүүхдийн амьдралын нөхцөлийг судалж, эцэг, эх болон төрөл садангийн хүн байхгүй нь тогтоогдсон бол түүний эрх, ашиг сонирхлыг хамгаалах үүрэг хүлээнэ

25.9. Сум, дүүргийн Засаг дарга нь хүнд нөхцөлд байгаа хүүхдийг илрүүлж, бүртгэл хөтлөн, түүнийг гэр бүлдээ авч асран хүмүүжүүлэхээр хүсэлт гаргасан иргэнд шилжүүлж болно.

25.10. Хүүхдийг энэ хуулийн 25.9-д заасны дагуу шилжүүлэх боломжгүй бол сум, дүүргийн Засаг дарга нь асран хамгаалагч, харгалзан дэмжигч тогтоолгох, үрчлүүлэх, хүүхэд асран хүмүүжүүлэх байгууллагад шилжүүлэх асуудлыг шийдвэрлэнэ.

26 дугаар зүйл. Хүүхдээ хүмүүжүүлэх эрх, үүрэг

26.2. Эцэг, эх дараахь үүрэг хүлээнэ: [. . .]

26.2.4. хүүхдийн эрхийг хамгаалж, үүргээ биелүүлэхэд нь туслах.

26.3. Эцэг, эх нь хүүхдийн эрүүл мэнд, сэтгэхүй, ёс суртахууны хүмүүжилд хохирол учруулах, хүүхэддээ хэрцгий хандах, эцэг, эх байх эрхээ зүй бусаар ашиглахыг хориглоно.

26.9. Хүүхдийн эрх, ашиг сонирхлыг хохироосон эцэг, эх хууль тогтоомжид заасан хариуцлага хүлээж, энэ хуулийн 30.1-д заасан үйлдлийг хийж, хүүхдээ бага наснаас нь өсгөн хүмүүжүүлээгүй нь тогтоогдсон бол тухайн хүүхдийн эцэг, эхийн хувьд эдлэх эрхээ алдана.

28 дугаар зүйл. Эцэг, эх байх эрх хязгаарласнаас үүсэх үр дагавар

28.1. Эцэг, эх байх эрхээ хязгаарлуулсан хүн уг хүүхдийг биечлэн өсгөн хүмүүжүүлэх, төлөөлөх, хүүхэдтэй холбогдуулан хууль тогтоомжоор олгосон эрхээ алдана.

29 дүгээр зүйл. Эцэг, эх байх эрх хязгаарласныг хүчингүй болсонд тооцох

29.1. Эцэг, эх байх эрхээ урвуулан ашигласан /хүүхдээ хаях, санаатай төөрүүлэх, тарчлаан зовоох, худалдах, барьцаалах, биеийг нь үнэлэх, шунахай зорилгоор ашиглах, эрх зүйн зөрчилд татан оруулах зэргээр/, хүүхэдтэйгээ удаа дараа хэрцгий харьцсан, бэлгийн харьцаанд оруулахаар завдсан, оруулсан, сэтгэл санааны хүнд дарамтад байлгасан, хүүхдээ өсгөн хүмүүжүүлэх үүргээс санаатайгаар зайлсхийсэн, согтууруулах ундаа, мансууруулах бодис байнга хэрэглэдэг хүний эцэг, эх байх эрхийг шүүх хасаж болно.

33 дугаар зүйл. Хүүхдийн талаархи эцэг, эхийн эрхийг хамгаалах

33.1. Эцэг, эх нь хүүхдийг хууль бусаар авсан хүнээс хүүхдээ эргүүлж авахыг шаардах эрхтэй.

36 дугаар зүйл. Гэрлэгчид харилцан бие биеэ тэжээн тэтгэх үүрэг

36.2. Гэрлэгчдийн хэн нэг нь бие биеэ тэжээн тэтгэх үүргээсээ татгалзсан, эсхүл тэжээн тэтгэх тухай гэрээ байгуулаагүй бол түслалцаа шаардлагатай болсон нөхөр, эхнэр тэжээн тэтгүүлэхээр шүүхэд нэхэмжлэл гаргах эрхтэй.

37 дугаар зүйл. Гэрлэгчдийн тэжээн тэтгүүлэх эрх үргэлжлэх

37.1. Гэрлэгчдийн хэн нэг нь гэрлэлтээ цуцлуулах болон гэрлэлт хүчин төгөлдөр бүс болсонд тооцогдохоос өмнө, эсхүл гэрлэлтээ цуцлуулснаас хойш нэг жилийн дотор хөдөлмөрийн чадвараа бүрэн алдсан нь гэр бүлийн хүчирхийлэл болон гэрлэлт цуцлуулахаас өмнө бий болсон нөхцөл байдалтай шүүд холбоотой үүссэн, гурван нас хүрээгүй болон тахир дутуу хүүхдээ асарч байгаагийн улмаас хөдөлмөр эрхлээгүй буюу гэрлэлтээ цуцлуулах үед тэтгэвэр тогтоолгох насанд хүрсэн, эсхүл гэрлэлт цуцлуулахаас өмнө тэтгэвэрт гарсан бол салсан нөхөр буюу эхнэрээрээ тэжээн тэтгүүлэх эрхтэй.

Захиргааны хариуцлагын тухай хууль

21 дүгээр зүйл. Танхайрах

Гудамж, талбай, орон сууц, нийтийн тээвэр, үзвэр, үйлчилгээний болон олон нийтийн бусад газар хэрүүл маргаан, зодоон үүсгэсэн, бусдыг өдөөн хоргоосон, айлган сүрдүүлсэн, иргэдийн амгалан тайван байдал алдагдуулсан, олон нийтийг үл хүндэтгэсэн, үйлчилгээний болон дарааллын журам зөрчсөн бол 15000 хүртэл төгрөгөөр торгох, эсхүл 7-30 хоногийн хугацаагаар баривчлах шийтгэл ногдуулна. /Энэ зүйлд 1995 оны 4 дүгээр сарын 17-ны өдрийн хуулиар өөрчлөлт орсон/

22 дугаар зүйл. Согтуурах

Архидан согтуурч удаа дараа эрүүлжүүлэгдсэн бол 7-30 хоногийн хугацаагаар баривчлах шийтгэл ногдуулна. /Энэ зүйлийг 1994 оны 1 дүгээр сарын 10-ны өдрийн хуулиар хүчингүй болгоод 1995 оны 4 дүгээр сарын 17-ны өдрийн хуулиар нэмсэн/

Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хууль

7.3. Хууль зүйн сайд дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

- 7.3.1. төрийн захиргааны төв, нутгийн захиргааны болон шүүх, прокурор, хууль сахиулах бусад байгууллагаас гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх талаар зохиож байгаа ажлыг зохицуулах;
- 7.3.2. гэмт хэргээс урьдчилан сэргийлэх хууль тогтоомж, Засгийн газрын шийдвэрийн биелэлтэд эрх хэмжээнийхээ хүрээнд хяналт, шалгалт явуулах
- 7.3.3. шүүх, прокурорын байгууллагатай зөвшилцөн улсын хэмжээнд гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх талаар авах арга хэмжээний хөтөлбөр, төлөвлөгөөний төслийг боловсруулж Засгийн газарт оруулах
- 7.3.4. гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх талаар зөвлөмж гаргах
- 7.3.5. гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх асуудлаар гадаад улстай хамтын ажиллагааг хөгжүүлэх

7.3.6. гэмт хэргийн шалтгаан нөхцөлийг судлах эрдэм шинжилгээ, судалгааны ажлыг зохион байгуулах;

Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хууль

1 дүгээр зүйл.Хуулийн зорилт

1.1. Энэ хуулийн зорилт нь улс төр, эрх зүй, эдийн засаг, нийгэм, соёлын ба гэр бүлийн харилцаанд жендэрийн эрх тэгш байдлыг хангах нөхцөл бүрдүүлэх эрх зүйн үндсийг тодорхойлж, хэрэгжүүлэхтэй холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

2 дугаар зүйл.Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хууль тогтоомж

2.2. Монгол Улсын олон улсын гэрээнд энэ хуульд зааснаас өөрөөр заасан бол олон улсын гэрээний заалтыг дагаж мөрдөнө.

4 дүгээр зүйл.Хуулийн нэр томъёоны тодорхойлолт

4.1.8.“жендэрт суурилсан хүчирхийлэл” гэж жендэрээс үүдэлтэйгээр бусдад бие махбодийн, бэлгийн, сэтгэл санааны гэм хор, эдийн хохирол учруулсан, учруулж болзошгүй үйлдэл, эс үйлдэхүйг;

5 дугаар зүйл.Жендэрийн эрх тэгш байдлыг хангах үндсэн зарчим, бодлого

5.1.2.ялгаварлан гадуурхахгүй байх зарчим: эрэгтэй, эмэгтэй хүн бүр нас, хүйс, ажил, албан тушаал, үзэл бодол, гэрлэлтийн байдал, боловсролын ялгаа зэргийг үл харгалзан ялгаварлан гадуурхалт, хязгаарлалтгүйгээр хүний эрх, эрх чөлөөг эдлэх;

5.1.жендэрийн мэдээлэл хүртээмжтэй байх зарчим: хүйсээр ангилсан албан ёсны статистикийн болон бусад мэдээллийн ил тод, нээлттэй, хүртээмжтэй байдлыг хангах.

6 дугаар зүйл.Жендэрийн ялгаварлан гадуурхалтыг хориглох

6.2. Жендэрт суурилсан хүчирхийлэл, бэлгийн дарамт нь жендэрийн ялгаварлан гадуурхалтад хамаарна

6.3. Жендэрт суурилсан хүчирхийллээс урьдчилан сэргийлэх, түүнтэй тэмцэх, хохирогч, гэрчийн аюулгүй байдлыг хангах, эрхийг нь хамгаалах нөхцөл, журмыг хуулиар тогтооно.

7 дугаар зүйл.Эрэгтэй, эмэгтэй хүний тэгш эрхийг хангах тусгай арга хэмжээ

7.1. Энэ хуулийн 5.2-т заасан төрийн бодлогын хүрээнд эрэгтэй, эмэгтэй хүний нийгэм, гэр бүлийн харилцаанд үүссэн тэгш бус байдлыг арилгах, нөхөн үржихүйн эрүүл мэндийг хамгаалахад чиглэсэн тусгай арга хэмжээ хэрэгжүүлэх бөгөөд эдгээр тусгай арга хэмжээг ялгаварлан гадуурхалт гэж үзэхгүй.

18.3.Жендэрийн үндэсний хороо жендэрийн эрх тэгш байдлыг хангах талаар дараахь чиг үүргийг хэрэгжүүлнэ:

18.3.1.жендэрийн эрх тэгш байдлыг хангах бодлого, хөтөлбөр, тусгай арга хэмжээг боловсруулах, хэрэгжүүлэх, түүний биелэлтэд хяналт тавих ажлыг зохион байгуулах;

18.3.2.жендэрийн эрх тэгш байдлыг хангах бодлогыг хэрэгжүүлэх эдийн засаг, эрх зүйн баталгааг бүрдүүлэх, түүнийг боловсруулах ажлыг арга зүйн удирдлагаар хангах;

18.3.3.жендэрийн эрх тэгш байдлыг хангахтай холбоотой асуудлаар хууль тогтоомж, бодлого, хөтөлбөр болон олон улсын байгууллагаас гаргасан зөвлөмжийн хэрэгжилт, үр дүнтэй танилцах, зөвлөгөө өгөх;

18.3.4.жендэрийн эрх тэгш байдлыг хангахад шаардлагатай үндэсний чадавхийг төрийн байгууллагын болон нийгмийн хүрээнд бэхжүүлэхэд чиглэсэн бодлого, хөтөлбөр, төсөл, арга хэмжээг боловсруулах, хэрэгжүүлэх, түүний биелэлтэд хяналт тавих ажлыг зохион байгуулах;

18.3.5.энэ хуулийн 15.1.4.а-д заасан тайланг бэлтгэх ажлыг зохион байгуулах;

18.3.6.энэ хуулийн 15.1.4.в, 15.1.4.г-д заасан тайлангийн төсөлтэй танилцах, санал өгөх;

18.3.7.энэ хуулийн 18.3.15-д заасан тайлангийн төслийг хэлэлцэх, санал өгөх;

18.3.8.жендэрийн мэдээллийн сан бүрдүүлэх, нэгдсэн сүлжээ байгуулах, жендэрийн мэдээллийг хэрэглэгчид хүргэх ажлыг зохион байгуулах;

18.3.9.жендэрийн эрх тэгш байдлыг хангах, бэхжүүлэх, хамгаалахад олон нийтийн болон хувийн хэвшлийн байгууллага, иргэдийн оролцоог хангах;

- 18.3.10.жендэрийн эрх тэгш байдлыг хангах төрийн бодлого, хууль тогтоомжийг аж ахуйн нэгж, байгууллага, олон нийтэд таниулах, сурталчлах үйл ажиллагааг хэвлэл мэдээлэл, олон нийтийн болон хувийн хэвшлийн байгууллагатай хамтран зохион байгуулах, жендэрийн эрх тэгш байдлыг хангах ажлын үр дүнгийн тухай мэдээлэх;
- 18.3.11.жендэрийн салбар хороо, зөвлөлийн тайлан, мэдээллийг хэлэлцэж, дүгнэлт гаргах
- 18.3.12.жендэрийн эрх тэгш байдлыг хангах ажлаар үр дүнд хүрсэн аж ахуйн нэгж, байгууллага, иргэнийг шагнал, урамшилд тодорхойлох;
- 18.3.13.Жендэрийн үндэсний хороо, түүний ажлын албаны бүтэц, зохион байгуулалт, дүрмийг хэлэлцэж, батлуулах;
- 18.3.14.жендэрийн эрх тэгш байдлын тухай хууль тогтоомжийн хэрэгжилтийн төлөв байдлын талаар судалгаа, дүн шинжилгээ хийх ажлыг зохион байгуулах;
- 18.3.15.жендэрийн эрх тэгш байдлыг хангахтай холбогдсон хууль тогтоомж, бодлого, хөтөлбөрийн хэрэгжилтийн байдлын талаархи тайланг бэлтгэж Засгийн газарт оруулах;
- 18.3.16.жендэрийн эрх тэгш байдлыг хангах асуудлаар олон улсын байгууллага, гадаад улстай хийх хамтын ажиллагааг өргөжүүлэх.

23 дугаар зүйл. Жендэрийн эрх тэгш байдал зөрчигдсөн тухай гомдол гаргах

- 23.1. Энэ хуулийн 14 дүгээр зүйлээс бусад зүйл, заалтыг зөрчсөн нь Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комисст гомдол гаргах үндэслэл болно.

ХАВСРАЛТ Г.

Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуульд (2005 он) Миннесота дахь Хүний эрхийг хамгаалагчид байгууллагын зүгээс тусгасан санал зөвлөмж

Монгол Улс нь гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэн иргэдийнхээ эрх ашгийг хамгаалах зорилгоор Гэр Бүлийн Хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийг (ГБХТТХ) 2005 онд соёрхон батлан хуулийг хэрэгжүүлж байгаад Хүний Эрхийг Хамгаалагчид байгууллага (The Хүний Эрхийг Хамгаалагчид байгууллага for Human Rights цаашид Хүний Эрхийг Хамгаалагчид байгууллага гэнэ) талархал илэрхийлж байна. Уг хуулийг баталсан явдал нь CEDAW болон бусад олон улсын хүний эрхийн гэрээ хэлэлцээрээр хүлээсэн үүргээ Монголын Засгийн Газар биелүүлж буй чухал алхам юм. Уг үүрэгт Засгийн Газрын буруутай үйл ажиллагаанаас хувь хүний эрхийг хамгаалах нь төрийн үүрэгт хамаарах бөгөөд мөн хувийн хэвшлийн үйл ажиллагааны улмаас гарсан зөрчил, хүчирхийлэлээс хамгаалах арга хэмжээг авнах ба өөрөөр хэлбэл хүн бүрийг хүчирхийлэлээс ангид байлгах юм.

Хүний Эрхийг Хамгаалагчид байгууллага нь ГБХТТ хуулинд (**16 ба 17 дүгээр зүйл**) эрх хязгаарлах арга хэмжээ авах тухай заалт оруулсаныг тусгайлан сайшааж байна. Иргэний эрхийг хязгаарлах арга хэмжээ авах тухай шийдвэрийг хамгаалах шийдвэр гэж ойлгож болох бөгөөд энэ нь хохирогчийг гэр бүлийн хүчирхийлэл үйлдэгчээс хол байлгах хамгийн зөв арга хэмжээ мөн. Эрх хязгаарлах арга хэмжээ авах тухай заалт бол хүчирхийлэл үйлдэгчийн үйлдэлд хязгаарлалт хийх ач холбогдол бүхий заалт юм (**16 дугаар зүйл**). Зарим заалтын давуу талууд гэвэл хохирогчийн гомдлоор 24 цагийн дотор эрх хязгаарлах арга хэмжээ авахуулахыг даалгах (**17.2 дугаар зүйл**), давж заалдахаар гомдол гаргасан хэдий ч тухайн шийдвэрийг гүйцэтгэх ажиллагааг зогсоохгүй байх (**17.4 дугаар зүйл**) ба эрх хязгаарлах арга хэмжээ авах шийдвэр нь бусад эрүү, иргэн, захиргааны шалгах ажиллагаа явуулахад саад болохгүй (**17.5 дугаар зүйл**) гэсэн заалтыг хэлж байна. Тус хууль хэд хэдэн чухал заалт тусгаж өгсөн бөгөөд энэ нь хуулийн зохицуулалтанд хамрах хүрээг өргөн авч үзэх (**3 дугаар зүйл**) мөн төрийн эрх бүхийн байгууллагын үүрэг роль хариуцлага болон гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэхэд төрийн бүс байгууллагуудын үүрэг ролийг тодорхой болгон өгчээ (**7, 8, 9, 10, 11, 14 дугаар зүйл**).

ГБХТТ хуульд дээрхи сайшалтай хуулийн заалт байгаа хэдий ч гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн гол зорилтийг биелүүлэхийн тулд Монгол Улс нь бусад хуулиа сайжруулах, бэхжүүлэх мөн хохирогчийн аюулгүй байдлын хангах ба хүчирхийлэл үйлдэгчийн хариуцлагыг өндөрсгүүлэх явдал юм. Монгол Улсын хууль нь тэдгээр зорилтыг хэд хэдэн байдлаар илэрхийлэхээс гадна хамгийн наад зах нь дараах сайжруулалт хийх хэрэгтэй. Үүнд:

Иргэний журмаар

- Хохирогчийн мэдээлэл дээр үндэслэн шүүхэд хэрэг хянан хэлэлцэх боломжоор хангагдан эрх хязгаарлах арга хэмжээ авах тухай шийдвэргаргуулах ба аль нэг талын хүсэлтэнд үндэслэн уг хохирогчийн мэдүүлэг нь нэмэлт нотлох баримт болох хангалттай үндэслэл болгох
- Эрх хязгаарлах арга хэмжээ авах шийдвэрийг зөрчсөн тохиолдолд хүчирхийлэл үйлдэгч нь өөр ямар нэгэн нэмэлт зөрчилд холбоодоогүй ч Эрүүгийн зөрчил гэж үзэх
- Эрх хязгаарлах арга хэмжээ авах тухай шийдвэрийг сахин биелүүлэх, хэрэгжүүлэх бүрэн эрхийг хуульд тодорхой тусгаж өгөх.
- Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх үйл ажиллагаанд хүрэлцэхүйц нөөцөөр хангах

Эрүүгийн журмаар

- Гэр бүл дэх танхайрах асуудлыг бага хэмжээний гэмтэл хөхрөлт, зүсэлт түлэгдэл зэргийг гэмт хэрэг гэж Эрүүгийн Хууль болон Эрүүгийн Байцаан Шийтгэх Ажиллагааны Тухай Хуульд тооцуулах
- Удаа дараа халдлага хийсэн болон хамгаалах шийдвэрийг олон удаа зорчсөнбол нэмэгдүүлсэн ял шийтгэл ноогдуулах. Удаа дараа бага хэмжээний гэмтэл учирүүлсан тохиолдолд онц хүнд гэмт хэрэг гэж тооцуулах гэдгийг хуульд тусган оруулах
- Гэр бүлийн хүчирхийлэлтэй холбоотой хэргийг хууль сахиулах үүрэг хүлээсэн прокурорт даалгахыг тодорхой байдлаар хуульд оруулах
- Эрх хязгаарлах арга хэмжээ зөрчсөн гэмт хэрэгт холбогдон гэм бүрүү нь тогтоогдсон, эсхүл эрүүгийн гэмт хэргийн шинжийг агуулсан гэр бүлийн хүчирхийлэл үйлдэгчид гар бүү болон галт зэвсэг эзэмшихийг хориглох
- Хэрэв хохирогч болон түүний хүүхдүүдийн аюулгүй байдлыг хангах шаардлагатай гэж үзсэн тохиолдолд өөрийн саналаар эсхүл прокурорын хүсэлтээр эрүүгийн хэргийг хянан шалгах явцад хүчирхийлэл үйлдэгчийн эрхийг хязгаарлах арга хэмжээ авах тухай шийдвэрийг шүүхээс гаргуулах эрхийг хуулиар олгох

Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухайн хуульд тусгах тусгайлсан санал:

1дүгээр зүйл. Хуулийн зорилт

Хүний Эрхийг Хамгаалагчид байгууллага нь хохирогчдийн хүний эрхийг хамгаалах, хохирогчийн аюулгүйн байдлыг хангах, баталгаажуулах болон гэмт этгээд хийсэн үйлдэлдээ хариуцлага хүлээлгэх асуудлыг энэ зүйлд онцгойлон тусгасанд сайшаан үзсэн байна. Мөн түүнчлэн гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх, сэргийлэх үүргийг нийгэм дэх хэд хэдэн сабарууд хүлээн зөвшөөрсөнд хуулийн зорилтын ач холбогдол оршиж байна.

Здугаар зүйл. Хуулийн зохицуулалтад хамаарах этгээд

Хүний Эрхийг Хамгаалагчид байгууллага нь гэр бүлийн гишүүдийн тоонд хамаардаггүй, гэхдээ тухайн нөхцөлд хамт амьдарч байгаа хүмүүсийг ГБХТТ хуулийн хүрээнд хамгаалалтанд оруулахыг зөвлөж байна. Энэ хэсэгт тухайн гэр бүлийн харилцаанд татагдан орсон бүхий л талуудын тусгайлсан жагсаалт гарган тодорхой болгохыг энэ хэсэгт суулгаж өгөх хэрэгтэй. Гэр бүлийн хүчирхийлэлтэй холбоотой олон үйлдэл нь хамтын амьдралгүй харилцаатай талуудад тохиолддог юм. Энэ үүднээс уг заалтыг дараах байдлаар тодорхой ойлгомжтой болгох, тухайлбал *“Эхнэр нөхөр эсхүл эхнэр нөхөр байсан хүмүүс; эцэг эх болон хүүхдүүд;*

цусан төрлийн холбоотой хүмүүс; эхнэр нөхөр болсны үндсэн дээр садан төрөл болсон хүмүүс (эхнэр нөхрийн хадам тал); одоогийн нөхцөл байдалд хамтран амьдарч байгаа эсхүл өмнө нь хамтран амьдарч байсан хүмүүс; гэр бүлээ бүртгүүлсэн эсэх, урьд өмнө нь хамтран амьдарч байсан эсхүл хамтран амьдраагүй эсэхээс үл шалтгаалан дундын хүүхэдтэй хүмүүс; хэрэв эмэгтэй нь жирэмсэн ба эмэгтэй эрэгтэй хоёр гэр бүлээ батлуулсан, эсхүл ямар нэгэн байдлаар хамтран амьдарч байсан эсэхээс үл шалтгаалан тухайн эрэгтэйд хүүхдийн эцэг гэж сэжиглэгдэж байгаа этгээд; өмнө болон одоо үед романтик болон бэлгийн харилцаанд орж байсан хүмүүс” гэдгээр илэрхийлэгдэж болох юм.

5 дугаар зүйл. Хуулийн нэр томъёоны тодорхойлолт

5.1 “Гэр бүлийн хүчирхийлэл”-ийг маш өргөн хүрээнд тодорхойлжээ. Бие махбодийн хохирол, гэмтэл, эрэгтэй/эмэгтэй эсхүл гуравдагч талд учирч болзошгүй аюулын айдас, эсхүл эрүүл мэндийн асуудал болоод мөрдөн мөшгих, зовоох болон албадлагын арга хэрэглэн хянах зэрэг асуудлын хүрээнд тодорхойлолтоо хязгаарлаж байхыг хууль боловсруулагч нарт зөвлөж байна.(6.1 дугаар зүйлд тусгасан саналын хэсгээс харна уу).

6 дугаар зүйл. Гэр бүлийн хүчирхийллийн хэлбэр

6.1. Хүний Эрхийг Хамгаалагчид байгууллага нь уг хуулинд заасан гэр бүлийн хүчирхийлэлийн хэлбэр болох “сэтгэл санааны” болон “эдийн засгийн” гэснийг хасахыг зөвлөж байна. Бусад улс орны туршлагаас үзэхэд гэр бүлийн хүчирхийллийн хэлбэрийн тодорхойлолтонд сэтгэл санааны хүчирхийллийг тусгасан явдал нь сэтгэл санааны хүчирхийлэлийг нотлоход маш ээдрээтэй байдаг бөгөөд мөн хохирогчдод аюул учруулахүйц байдаг юм.Тэдгээр нэр томъёог гэр бүлийн хүчирхийллийн тодорхойлолтонд оруулснаар зарим тохиолдолд санаанд оромгүй үр дагавар гардаг бөгөөд энэ нь хүчирхийлэлд өртсөн хохирогчоос гэмт хэрэгтэн сэтгэл санааны болон эдийн засгийн хохиролыг нэхэмжлэх боломжийг бүрдүүлдэг байна.Тухайлбал, хүчирхийлэл үйлдэгч хэл амаар дайрч доромжилсон тул эхнэрийн бие махбодид гэмтэл учруулсан гэдэг үндэслэлээр өөрийн эхнэрийн эсрэг гомдол гаргадаг байна.Эсхүл уур уцаартай хүчирхийлэгч магадгүй өөрийн өмчлөлд байгаа өмчийг ашиглан эхнэрийнхээ эсрэг хамгаалах арга хэмжээ авах талаар эрэл хайгуул хайж болох юм.Ихэнх тохиолдолд энэхүү ажиллагааны үр дүнд хохирогчийг гэмт хэрэгтэнд ашигтайгаар баривчилах буюу саатуулдаг. Гэр бүлийн бүх гишүүдийн маргаан, зөрчилдөөн болон үл зөвшөөрлийг хуулийн оролцоотойгоор шийдвэрлэх нь тэр бүр зохимжгүй юм.

Хүний Эрхийг Хамгаалагчид байгууллага нь “гэр бүлийн хүчирхийлэл”-ийн хэлбэр болох сэтгэл санааны болон эдийн засгийн хүчирхийлэлийн оронд “**албадлагын аргаар хянах**” (өөрөөр хэлбэл бие махбодын болон бэлгийн хүчирхийлэл хэлбэрт нэмэлт болгон)гэсэн ойлголтыгоруулж ирэхийг хууль боловсруулагч нарт зөвлөж байна. Албадлагын аргаар хянах гэдгийг энэ хуулийн зорилтын хүрээнд “*хохирогчид аюултай үйлдэл эс үйлдэхүйгээр халдах, бэлгийн хүчирхийлэл, заналхийлэл, доромжлол, айлган сүрдүүлэлт, эсхүл бусдад гэм хор учруулах, шийтгэх эсхүл сүрдүүлэх зорилгоор хүч хэрэглэнэ. Хяналт гэж хохирогчийг сүрдүүлэх ба/эсхүл бусдаас дэмжлэг туслалцаа авах эх сурвалж боломжоос тусгаарлан өөрийн хувийн ашиг сонирхолд нийцүүлэн тэдгээрийн нөөц бололцоог, чадавхийг мөлжихийн тулд зугтах боломж, эсрэг үйлдэл хийх, бие даан амьдрах байдлыг үгүй болгон тэдгээрийн өдөр тутмын амьдрал, зан байдлыг удирдаж байх хууль бус үйлдлийг хамруулна*”.

Хүний Эрхийг Хамгаалагчид байгууллага тус хуульд хууль боловсруулагч нар гэр бүлийн хүчирхийлэллийн бүрэлдэхүүнд **бэлгийн хүчирхийллийн** асуудлыг оруулж, түүнийг хүлээн зөвшөөрч байгаад сайшаан үзжээ.Бид энэ хэсэгт нэмэлт болгон “Энэ хуулийн хүрээнд гэрлэгсдийн бэлгийн хүчирхийлэл гэдэг хариуцлагын доор гэрлэлт эсхүл өмнөх болон одоогийн харилцааг хамаарахгүй байх”гэдэг үгийг нэмхийг зөвлөж байна.

Цаашид хууль боловсруулагч нарт зөвлөхөд **бие махбодын хүчирхийлэллийн** тодорхойлолтонд бие махбодын гэм хор, гэмтэл, эсхүл халдлага эсхүл энэ сүрдүүлгийн улмаас үүссэн аюул, гэм хорыг тодорхой болгох.Тодорхойлолтонд мөн даган мөшгих болон заналхийллийг тухай тусгаж өгөх ёстой.

7 дугаар зүйл. Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх талаархи төрийн байгууллагын бүрэн эрх

7.1.1. Хүний Эрхийг Хамгаалагчид байгууллага нь гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэхэд “бодлого, хөтөлбөрийг баталж, хэрэгжүүлэх” үүргийг бүрэн тодорхойлохыг хууль боловсруулагч нарт зөвлөж байна.Тодорхойлолтонд бодлого хөтөлбөрийг баталж хэрэгжүүлэх үйл ажиллагаа, гарах үр дүн болон яам, яамдын хариуцлагыг тодорхой болгох. Мөн бодлого хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд шаардагдах төсөв, санхүүжилтийг тусгаж өгнө. Энэ нь хуулийн биелэлтийн хангах, хууль сахиулагч нарт чиглэсэн сургалт, хохирогчдод зориулсан нийгмийн үйлчилгээ, хамгаалах байр, мөн олон нийтийн мэдлэгийг дээшлүүлэх зохион байгуулалттай үйл ажиллагаа, бодлого хөтөлбөр үр дүнтэй эсэхэд мониторинг хийх зэрэг үйл ажиллагааг санхүүжилсэн байна.Үр дүнтэй бодлого хөтөлбөрийг бий болгоход хуульд цаг хугацааны асуудлыг тусгайлан тусгаж өгөх шаардлагатай.

9 дүгээр зүйл. Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх талаархи цагдаагийн байгууллагын үүрэг

9.1.3. Энэ хэсэгт цагдаагийн ажилтан хүчирхийлэл үйлдэгчид “Захиргааны болон эрүүгийн шийтгэл ноогдуулж болох тухай [нэмэлт болгон тодруулсан байна]” сануулга өгөхийг зөвшөөрсөн байна.Сануулга өгч байгаа явдал нь хүчирхийлэл үйлдэгчид гэр бүлийн хүчийрхийллийн асуудалд тэвчээртэй хандаж байх гэсэн мессэж өгөх ёсгүй эсхүл энэ нь хүчирхийлэл үйлдэгчид хийсэн хэргээ ухамсарлах, хариуцлага бий болгохгүй.Хүний Эрхийг Хамгаалагчид байгууллагын зүгээс энэ хэсгийг хүчингүй болгох эсхүл хэрэв цагдаагийн ажилтан тухайн гэмт хэргийн гэрч болоогүй хэдий ч гэмт хэрэг гарсан тухай нотлох баримт байгаа тохиолдолд цагдаагийн ажилтан хүчирхийлэл үйлдэгчийг албадан саатуулах эсхүл хорих арга хэмжээ авах тухай бүрэн эрхийг цагдаагийн ажилтанд олгохыг зөвлөж байна.

9.1.4.Энэ хэсэг нь шаардлагатай тохиолдолд хохирогчийг эмнэлэгт, эсхүл хамгаалах байранд хүргэх, боломжтой бол төрөл, садангын хүний нь түр хамгаалалтад өгөх гэсэн байна.Хохирогчийг гэр орноос холдуулахын оронд хүчирхийлэл үйлдэгчийг албадан сатуулах эсхүл хорих арга хэмжээ авах хохирогчийн эрүүл мэнд, биеийн нөхцөлд үндэслэн эмнэлэгт хэвтүүлэх шаардлагатай бол цагдаагийн ажилтан үүнийн хангах тухай хуульд тусгаж өгөх нь зүйтэй.Хамгаалах байр эсхүл төрөл, садангийн хүний асран хамгаалалтад өгөхөөр бол энэ нь зөвхөн хохирогчийн хүсэлтэд үндэслэгдсэн байх ёстой.

9.1.5.“Шаардлагатай гэж үзвэл” гэсэн үг нь цагдаагийн ажилтанд албадан сатуулах, баривчлах бүрэн эрхийг хэт их өгч байгаа бөгөөд үүнийг хасах. Харин цагдаагийн ажилтан хүчирхийлэл үйлдэгчийг захиргааны болон эрүүгийн хуульд заасны дагуу албадан саатуулах бүрэн эрхийг зөвшөөрөх.Онол ёсоор бол цагдаагийн ажилтан нотлох баримт дээр тулгуурлан цагдан хорих ажиллагаа хийх бүрэн эрхтэй юм.Энэ нь нотлох баримт дээр тулгуурлах стандартад нь хүчирхийлэл үйлдэгч мансуурсан эсхүл хэвийн тайван байдалтай байгаа эсэхээс үл хамааран хүчирхийлэл гарч цагдаа гэрчлэх боломжгүй ч хүчирхийлэл үйлдсэн нотолгоо дээр үндэслэн цагдаагийн ажилтан гэр бүлийн хүчирхийллийн сэжигтэнийг баривчлах болон албадан саатуулах тогтоол үйлдэхийг зөвшөөрөх явдал юм. .

9.1.6. Хүний Эрхийг Хамгаалагчид байгууллага согтууруулах ундаа хэтрүүлэн хэрэглэсэн этгээдийг эрүүлжүүлэх байранд хүргэх энэ заалтыг хүчингүй болгохыг зөвлөж байна. Учир нь согтууруулах ундаа бол гэр бүлийн хүчирхийлэл гарах нөхцөл биш бөгөөд хамгийн эхний ээлжинд цагдаагийн ажилтан хүчирхийллийн эрсдэлийг тогтоох явдал юм.Архи, согтууруулах ундаа хэт их хэрэглэх нь хоёрдогч асуудал гэж үзэх хэрэгтэй бөгөөд энэ нь хохирогчийн аюулгүй байдлыг баталгаажуулах мөн хүчирхийлэл үйлдэгчид хэрэг хариуцах хариуцлагыг бий болгоно.

9.1.8. Энэ хэсэгт хүчирхийлэл үйлдэгчийн эрхийг хязгаарлах арга хэмжээ авахуулах тухай хүсэлтийг эрх бүхий байгууллага, албан тушаалтанд гаргах асуудлыг тусгасан байна. Энэ асуудал чухал хэдий ч цагдаагийн ажилтан хохирогчдод эрх хязгаарлах эрхийн шийдвэрт хүргэхэд өргөдөл гарган туслалцаа үзүүлэх асуудлыг хуульд тусгах нь чухал. Харин хохирогч эрх хязгаарлах эрхийн шийдвэрийг өөрт нь үлдээнэ.

10 дугаар зүйл. Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх талаархи нийгмийн ажилтны үүрэг

10.1.2. Энэ хэсэг нь нийгмийн ажилтанд хүчирхийлэл үйлдэгч уруу чиглэсэн албадан сургалтыг хийхийг даалгасан байна. Бид тэрхүү сургалтыг зохион байгуулахдаа хохирогчдод үйлчилгээ үзүүлэх сангийн санхүүжилтийг зарцуулахгүй байхыг энэ хуульд тодорхой тусгаж өгөхийн зөвлөж байна. Тэрхүү хязгаарлагдмал нөөц нь нэн тэргүүнд хохирогчдод үйлчилгээ үзүүлэхээр чиглэсэн байх ёстой.

11 дүгээр зүйл. Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх, урьдчилан сэргийлэхэд төрийн бүс байгууллагын оролцоо

Хүний Эрхийг Хамгаалагчид байгууллага нь гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх, урьдчилан сэргийлэхэд төрийн бүс байгууллагын үүргийг Монгол Улсын Засгийн Газар нь хүлээн зөвшөөрч байгаа явдлыг сайшаан үзэж байна. Засгийн газар нь тэдгээр байгууллагуудад үр дүнтэйүйл ажиллагаагаа эрхлэн явуулахад хүрэлцэхүйц төсөв санхүүжилтийг баталгаажуулах ёстой.

12 дугаар зүйл. Итгэмжлэгдсэн төлөөлөгч

Хүний Эрхийг Хамгаалагчид байгууллага нь гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх бодлогыг тогтоох үйл ажиллагаанд түршлага бүхий төрийн бүс байгууллагыг оролцуулах, тэдгээрийн үйл ажиллагааг Монголын Засгийн Газар хүлээн зөвшөөрч байгаад талархаж байна.

13 дугаар зүйл. Гэр бүлийн хүчирхийллийн тухай мэдээлэл

13.1. Энэхэсэгт цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуулийн багш, эмнэлгийн мэргэжилтэн нар гэр бүлийн хүчирхийлэл үйлдэгдсэн, эсхүл үйлдэгдэж болзошгүй байгаа нь илэрхий болсон тохиолдлыг цагдаагийн байгууллага, болон нутгийн захиргааны байгууллагад мэдээлэх үүргийг тусгаж өгсөн байна. Гэр бүлийн хүчирхийлэлтэй холбоотойгоор үйлчилгээ үзүүлдэг ажилтнууд гэр бүлийн хүчирхийлэлийн мэдээллийн мэдээлэх шаардлагагүй харин зөвхөн оюун ухааны хөгжлийн бэрхшээлтэй эсхүл насанд хүрээгүй хүүхдэд бие мах бодийн хүчирхийлэлд өртсөн өөрөөр хэлбэл эмзэг хохирогчтой тохиолдолд заавал мэдээлэх үүргийг энэ хуульд тусгаж өгөхийг бид зөвлөж байна. Заавал мэдээлэх үүрэг нь хохирогчдод аюул учруулах асуудлыг ихсэж болгох талтай юм. Үүнээс гадна, эмч болон бусад үйлчилгээ үзүүлэгч нар сэжиг бүхий гэр бүлийн хүчирхийллийн талаар мэдээлэл өгөх, тайлагнах юм бол хохирогч хэрэгцээт үйлчилгээг авахгүй байх зэрэг асуудал гарч магадгүй юм. Өөрөөр хэлбэл, үйлчилгээ үзүүлж буй ажилтнууд хохирогчид мэдээлэл өгөх, эсхүл бүрэн үйлчилгээ, туслалцаа авах тухай мэдээллээр ханган хохирогчид сонгох эрхийг энэ хуулиар чиглүүлэн өгөх ёстой.

14 дүгээр зүйл. Гэр бүлийн хүчирхийллийг таслан зогсоох талаархи сум, багийн Засаг даргын үүрэг

14.1.1. Энэ хэсэг нь хохирогчийн аюулгүй байдлыг хангах зорилгоор хүчирхийлэл үйлдэгчийг захиргааны байранд дуудан ирүүлж, шаардлага тавих бөгөөд уг хуулийн 9.1.3 сануулга өгөх арга хэмжээ авахтай адил байна. Хууль нь гэр бүлийн хүчирхийлэлд холбогдсон хүчирхийлэл үйлдэгчид шаардлага тавихаас илүү албадан саатуулах арга хэмжээ авахуулхаар тусгасан байх ёстой.

14.1.2. Энэ хэсэг нь “хохирогчийн байгаа гэр, орон байрны аюулгүй байдлыг хангах арга хэмжээ авах”, эсхүл “боломжтой бол хохирогчийг төрөл, садангийн хүний нь түр хамгаалалтад өгөх” асуудал засаг даргын үүрэгт хамаарна гэсэн байна. Энэ нь тус хуулийн 9.1.4 зүйлд санал болгон оруулж ирснээр хамгаалах байр эсхүл төрөл, садангийн хүний асран хамгаалалтад шилжүүлэх бол зөвхөн хохирогчийн хүсэлт, сонголт дээр үндэслэгдсэн байх ёстой.

15 дугаар зүйл.Хохирогчийг хамгаалах арга, түүний нууцыг задруулахгүй байх талаар бусад этгээдийн хүлээх үүрэг

Хүний Эрхийг Хамгаалагчид байгууллага нь хохирогч хамгаалах байранд байгаа эсэхээс үл хамааран хамгаалах байрны байршил, болон хохирогчийн хувийн нууцад хамаарах мэдээллийг тус хуулийн 15.3.болон 15.4. заалтаар хамгаалан баталгаажуулсанд Монгол Улсын Засгийн Газрыг сайшааж байна.

16 дугаар зүйл. Хүчирхийлэл үйлдэгчийн эрхийг хязгаарлах арга хэмжээ

Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн амин гол зүрх нь хүчирхийлэл үйлдэгчийн эрхийг хязгаарлах арга хэмжээ авах тухай заалт уг хуулийн 16 болон 17 дугаар зүйлд тусгажээ. Хүний Эрхийг Хамгаалагчид байгууллага нь уг хуулийн заалтыг соёрхон баталсанд Монгол Улсад баяр хүргэн тус хуулийн заалтыг сайжруулан бэхжүүлэх хэд хэдэн арга байдаг талаарх дурьджээ.

16.1.1.Хүчирхийлэл үйлдэгчийн эрхийг хязгаарлах арга хэмжээ авах тухай “хүсэлт” (цаашид “даалгах”) нь тусдаа амьдрахыг даалгах арга хэмжээний оронд хүчирхийлэл үйлдэгчийг гэр орон, орон байрыг орхин явуулахыг даалгах.Үүний оронд хүчирхийлэл үйлдэгчийг орхин явуулахыг даалгах биш харин хүчирхийлэл үйлдэгчийг тухайн гэр орон, орон байрыг орхин явах арга хэмжээг авахыг шаардах. Хэрэв хүчирхийлэл үйлдэгч орхин явах арга хэмжээг биелүүлээгүй тохиолдолд албадлагын журмаар орхин явуулах арга хэмжээ авсан байна.

16.1.2. Энэ хэсэг бол хамгаалах байранд, эсхүл хохирогчтой уулзах болон уулзахаар оролдохыг хориглосон заалт юм.Үүнийг хохирогч болон үр хүүхдүүдээс (бусад хамаарах хүмүүст) оршин суугаа газар болон хамгаалах байрнаас хүчирхийлэл үйлдэгчийгхол байлгах гэдгээр илүү дэлгэрүүлэх ёстой.Энэ хуулийн заалт хохирогч болон түүний хүүхдүүдийн амьдарч буй хамгаалах байр болон бусад газар, байршил хаягийг нууцлах гэдгээр бэхжүүлж өгөхийн бид зөвлөж байна. Хуулийн 16.1.5. болон 16.1.6.дүгээр зүйлийн хэсэгт зааснаар хүчирхийлэл үйлдэгч нар зан үйлд нөлөөлөх албадан сургалтад хамруулах, шаардлагатай гэж үзвэл согтуурах, мансуурах донтой өвчтэй этгээдийг албадан эмчилгээ хийлгүүлэх үүрэгтэй.Хуулийн 10.1.2 тусгасан саналын адил уг сургалтыг зохион байгуулахдаа хохирогчдод үйлчилгээ үзүүлдэг санхүүжилтийн төсвөөс зарцуулахгүй байхыг энэ хуульд тодорхой тусгаж өгөхийн зөвлөж байна.Үүнээс гадна шүүгч хүчирхийлэл үйлдэгчийн эрхийг хязгаарлах арга хэмжээг доорх байдлаар өргөжүүлэх. Үүнд:

- Хохирогч болон түүний хамаатан, садан төрөл болон өөр бусад холбоотой хүмүүст цаашид хүчирхийлэл учруулахгүйн тулд хүчирхийлэл үйлдэгчийн эрхийг хязгаарлах
- Хүчирхийлэл үйлдэгч бусад гуравдагч этгээдээр дамжуулах хохирогчтой уулзалт төлөвлөх эсхүл хохирогчтой холбоо тогтоохыг хориглох
- Хүчирхийлэл үйлдэгчээс бие даан тусдаа амьдрах санхүүгийн дэмжлэг олгох хуулийн заалт оруулах
- Хүчирхийлэл үйлдэгчид хүүхэддээ түр зуурын санхүүгийн дэмжлэг үзүүлэх тухай даалгах

Хязгаарлагдмал нөөцтэй тохиолдолд хохирогчдод үйлчилгээ үзүүлэх нь нэн тэргүүнд тавигдсан байх ёстой юм.

17 дугаар зүйл. Хүчирхийлэл үйлдэгчийн эрхийг хязгаарлах арга хэмжээ авах тухай шүүхийн шийдвэр

17.1. Энэ хэсэг бол хохирогчийн гомдол, цагдаагийн байгууллагын ажилтны, эсхүл өмгөөлөгч, итгэмжлэгдсэн төлөөлөгчийн хүсэлтийн дагуу хүчирхийлэл үйлдэгчийн эрхийг хязгаарлах арга хэмжээ авах тухай шийдвэрийг шүүхээс гаргахыг зөвшөөрсөн байна.Эрдсдэл өндөртэй эмзэг хохирогчдоос бусад тохиолдолд хохирогчийн зөвшөөрлөөр эрх хязгаарлах арга хэмжээ авч байхаар хуульчилах ёстой.Мөн энэ заалт нь тодорхой нотлох баримтыг үндэслэн эрх хязгаарлах арга хэмжээ авна. Хүний Эрхийг Хамгаалагчид байгууллага нь шүүх эрх хязгаарлах арга хэмжээ авах тухай шүүхийн шийдвэр нь хохирогчийн хүчирхийлэл гарсан гэсэн энэ

мэдээг үндэслэн арга хэмжээ авч байхыг зөвлөж байна. Талууд шүүх хуралдааныг хойшлуулах тухай хүсэлт гаргах, уг хугацаанд нотлох баримт цуглуулан танилцуулах боломжийг хуулиар олгосон байх ёстой.

Цагдаагийн байгууллагын ажилтны, эсхүл өмгөөлөгч, итгэмжлэгдсэн төлөөлөгчийн хүсэлтээр хязгаарлагдахгүй мөн хохирогч өөрөө хүсэлт гаргаж байхаар энэ хуульд зохицуулалт хийх.

17.2. Хохирогчийн гомдол хүлээн авснаас хойш 24-цагийн дотор эрх хязгаарлах арга хэмжээ авах тухай шийдвэр гаргахыг хуулчилсанд Монгол Улсад баяр хүргэж байна. 24-цагийн дотор эрх хязгаарлах арга хэмжээ авч байхыг даалгаж байвал уг хууль илүү бат бөх болно.

17.3. Хүчирхийлэл үйлдэгчийн эрхийг хязгаарлах арга хэмжээг тухайн нөхцөл байдалд нь тохируулж нэг жил хүртэл хугацаагаар авч болохоор энэ хэсэгт заасан. Хүний Эрхийг Хамгаалагчид байгууллага нь эрх хязгаарлах арга хэмжээг илүү урт хугацаатай болгох (Жишээлбэл АНУ-ын Миннесота мужийн хуулинд хамгаалалтын арга хэмжээ авах хугацаа хоёр жил хүртэлх байдаг бөгөөд “хэрэв шаардлагатай нөхцөлд шүүх түүнээс урт хугацааг тогтоож өгнө”) мөн ямар нэгэн хүчирхийлэл үйлдээгүй ч гэсэн хохирогчийн хүсэлтээр нэг жилээр сунгаж болдог байна. Хэрэв гэр бүлийн хүчирхийлэл давтан үйлдэгдсэн бол эсхүл эрх хязгаарлах арга хэмжээг давтан зөрчсөн бол хохирогчид аюулын эрсдэл ихэссэн бол эрх хязгаарлах арга хэмжээ авах тухай шийдвэр урт байнгын байх ёстой. Тухайлбал, Миннесоты мужийн хуулинд хэрэв хүчирхийлэл үйлдэгч гурав буюу түүнээс дээш гэр бүлийн хүчирхийлэл үйлдсэн эсхүл гурав буюу түүнээс дээш эрх хязгаарлах арга хэмжээ авах тухай шийдвэр зөрчсөн бол хүчирхийлэл үйлдэгчийн эрхийг 50-жилийн хугацаатай эрхийг хязгаарлах арга хэмжээ авах шийдвэр гаргаж болдог байна. Харин эрх хязгаарлах арга хэмжээ авах тухай шийдвэрийг дуусгавар болгох үндэслэл бол хохирогчид ямар нэгэн аюул эрсдэл байхгүй гэдгийг тодорхой нотлох баримтын үндсэн дээр шүүх шийдвэрлэнэ.

17.4. Хүний Эрхийг Хамгаалагчид байгууллага нь давж заалдах гомдол гаргасан явдал тухайн эрх хязгаарлах арга хэмжээ авах шийдвэрийг гүйцэтгэх ажиллагааг зогсоох үндэслэл болохгүй гэдэг заалтыг сайшаан үзэж байна. 17.5. Хүний Эрхийг Хамгаалагчид байгууллага эрх хязгаарлах арга хэмжээ авах шийдвэр нь гэр бүлийн хүчирхийлэл үйлдэгдсэн талаар захиргааны зөрчлийг хянан шалгах ажиллагаа явуулах, эсхүл эрүүгийн хэрэг үүсгэн шалгах болон иргэний хэрэг хянан шийдвэрлэхэд саад болохгүй гэдэг заалтын мөн сайшаж байна.

17.6. Энэ заалт удаа дараа хэрцгий хандсан, заналхийлсэн, хүч хэрэглэсэн; хүчээр бэлгийн харьцаанд оруулсан, бусдаас тусгаарлах зэрэг зарим хүндрүүлэх нөхцөл байдлыг нарийвчлан тогтоожээ. Гэхдээ эдгээр нөхцөл байдал хэрхэн эрх хязгаарлах арга хэмжээ авах тухай шийдвэрт нөлөөлөлдөг талаарх тодорхойлоогүй байна. Бид эдгээр нөлөөллийг тодруулах зорилгоор хуульд нэмэлт өөрчлөлт оруулна уу гэсэн санал зөвлөж байна.

19 дүгээр зүйл. Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль тогтоомж зөрчигчид хүлээлгэх хариуцлага

19.1 Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль бусад хуулиудтай хэрхэн нийцэж байгаа талаарх судалгаа хийх, ингэснээр ГБХТТ хуулийг бэхжүүлэх боломжтой юм. Тухайлбал, эрх хязгаарлах арга хэмжээ авах тухай шийдвэрийг зөрчсөн үйлдэл нь Эрүүгийн Хуулийн 258 дугаарзүйл ангиар шийтгүүлэн хариуцлага ноогдуулах бол уг хуулийн заалтыг гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуульд хавсралт болгон нэмж оруулах.

**ХАВСРАЛТ Д:
НӨХЦӨЛ БАЙДЛЫН ҮНЭЛГЭЭНИЙ МАЯГТ**



МОНГОЛ
УЛСЫН
ЕРӨНХИЙ
МЭДЭЭЛЭЛ

Нийгмийн хамгаалалт хөдөлмөрийн
сайн, Хууль зүй, дотоод хэргийн сайдын
2009 оны 12 дугаар сарын 17-ны өдрийн
108/122 тоот хамтарсан тушаалын
1 дүгээр хавсралт

ГЭР БҮЛИЙН ХҮЧИРХИЙЛЭЛТИЙН
ЭРСДЭЛИЙН НӨХЦӨЛ БАЙДЛЫГ ТОДОРХОЙЛОХ ҮНЭЛГЭЭНИЙ МАЯГТ

УХА.0069

А. БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ТУХАЙ ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

1. Үйлчилгээ үзүүлж буй байгууллагын нэр:
2. Бүртгэлийн дугаар No
3. Үнэлгээ хийсэн он сар өдөр
4. Үнэлгээ хийсэн нийгмийн ажилтны овог, нэр
5. Үнэлгээ хийсэн газар
 - ☐ Үйлчилгээ үзүүлж буй байгууллага
 - ☐ Үйлчлүүлэгчийн гэр
 - ☐ Хамгаалах байр
 - ☐ Бусад
6. Үнэлгээний ерөнхий дүн (Энэ хэсгийг үнэлгээний эцэст бөглөнө)
 - ☐ Үйлчлүүлэгчийн аюулгүй байдлыг нэн даруй хангахад туслах (хамгаалах байртай холбох, хувийн аюулгүйн төлөвлөгөө зохиох)
 - ☐ Үйлчлүүлэгчийн аюулгүй байдлыг нэн даруй хангах хууль эрх зүйн туслалцаатай холбох (хуулийн зөвлөгөө өгөх, цагдаагийн байгууллагын хойшлуулашгүй ажиллагааг хийх, аюулгүй байдлаа хангахад нь туслалцаа үзүүлэх, шинжээчийн дүгнэлт гаргах, итгэмжлэгдсэн төлөөлөгч буюу өмгөөлөгч сонгоход нь туслах гэх мэт)
 - ☐ Байгууллагын нийгмийн ажлын үйлчилгээнд хамруулах
 - ☐ Орон нутгийн нийгмийн үйлчилгээний бусад байгууллагатай холбох
7. Үйлчлүүлэгчид аюул учрах эрсдэлийн түвшин (Энэ хэсгийг үнэлгээний эцэст бөглөнө)
 - ☐ Үйлчлүүлэгчид аюул учрах эрсдэл өндөр
 - ☐ Үйлчлүүлэгчид аюул учрах эрсдэл дунд зэрэг
 - ☐ Үйлчлүүлэгчид аюул учрах эрсдэл бага
8. Үнэлгээний ерөнхий дүгнэлт (Нөхцөл байдлын үнэлгээнд тулгуурласан шинжээчийн дүгнэлт, санал зөвлөмжийн гол агуулгыг энэ хэсэгт тусгана. Харин үнэлгээний явцад илэрсэн гэр бүлийн хүчирхийлэлтэй холбогдох бүхий л нотолгоо баримт бүхий мэдээллийг энэхүү нөхцөл байдлын үнэлгээний үндсэн бүлэгт буюу дараах хуудсанд дэлгэрэнгүй тусгах болно)

.....

.....

.....

.....

.....

.....

.....

.....

Нөхцөл байдлын үнэлгээг хамтран хийсэн ажилтны албан тушаал
..... Гарын үсэг овог, нэр /...../
..... он сар өдөр

Б. ХОХИРОГЧ БА ХҮЧИРХИЙЛЭЛ ҮЙЛДЭГЧИЙН ТУХАЙ ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

Б.1 Хохирогчийн тухай мэдээлэл	Б.2 Хүчирхийлэл үйлдэгчийн тухай мэдээлэл
Овог: Нэр:..... Хүйс:..... Төрсөн он сар өдөр:..... Оршин суугаа хаяг: Холбоо барих утас:	Овог: Нэр:..... Хүйс:..... Төрсөн он сар өдөр:..... Оршин суугаа хаяг: Холбоо барих утас:
Ам бүлийн байдал:	Ам бүлийн байдал:
Хөдөлмөр эрхлэлтийн байдал:	Хөдөлмөр эрхлэлтийн байдал:
Амьдарч буй байр/ орон сууц/ гэрийн байршил ба нөхцөл:	Амьдарч буй байр/ орон сууц/ гэрийн байршил ба нөхцөл:
Хохирогчийн тодорхойлсон түүнд тулгарч буй асуудал, бэрхшээлүүд	Хүчирхийлэл үйлдэгч хохирогчид тулгарч буй асуудалтай ямар холбоотой болох
Хохирогчийн тухай болон түүнд тулгарч буй асуудлыг сонсох явцад хийсэн нийгмийн ажилтны ажиглалт тэмдэглэл	Хохирогч хүчирхийлэл үйлдэгчийн тухай мэдээлэх явцад хийсэн нийгмийн ажилтны ажиглалт тэмдэглэл

В. ХАМТАРСАН БАГИЙН ҮЗҮҮЛСЭН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ТЭМДЭГЛЭЛ

/Энэ хэсгийг үнэлгээний эцэст хамтарсан багаар ажилласан тэмдэглэгээг хийлгэж хавсаргана/

1. Цагдаагийн хэсгийн байцаагчийн нэр, холбогдох утас

Дүгнэлт, санал

.....

.....

.....

.....

.....

.....

Гарын үсэг он сар ...өдөр

2. Өрхийн эмнэлэгийн ахлагчийн нэр, холбогдох утас

Дүгнэлт, санал

.....

.....

.....

.....

.....

.....

.....

.....

.....

.....

.....

.....

.....

.....

.....

.....

.....

.....

.....

.....

.....

.....

.....

.....

.....

.....

.....

.....

.....

.....

.....

.....

.....

.....

Г. ХҮЧИРХИЙЛЭЛТЭЙ ГЭР БҮЛИЙН ХАРИЛЦААНЫ ТҮҮХ

1. Хамт амьдарч эхэлсэн буюу гэр бүл болсон он..... (сар)
2. Хамт амьдарсан хугацаа.....
3. Хүчирхийлэл эхэлсэн он (сар)
4. Хүчирхийлэл ямар хэлбэрээр эхэлсэн ба одоо ямар хэлбэрийн хүчирхийлэл үйлдэгддэг (биеийн хүчний, сэтгэл санааны, бэлгийн, эдийн засгийн, хавсарсан)
.....
.....
.....
5. Хүчирхийллийн хэлбэр, давтамж хэрхэн өөрчлөгдсөн
.....
.....
6. Хүчирхийлэл ямар давтамжтай явагддаг (нэг хүчирхийлэлээс дараагийн хүчирхийлэл болох хооронд ямар хугацаа өнгөрдөг)
.....
.....
7. Хамгийн сүүлд хэзээ хүчирхийлэл болсон
8. Хүчирхийлэл яаж илэрдэг (хэрүүл маргаан, дарамт, хараат байдал, айдас түгшүүр, зодоон, эрх мэдлийн тэнцвэргүй байдал гэх мэт)
.....
.....
.....
9. Хүчирхийлэл болохын өмнө ба болсны дараа хохирогчид ямар сэтгэгдэл, мэдрэмж төрж байсан
.....
.....
10. Хүчирхийллийг таслан зогсоох ба урьдчилан сэргийлэх талаар ямар нэг байгууллагад хандаж байсан эсэх, хэрэв тийм бол ямар байгууллагын үйлчилгээ авч байсан
.....
.....
11. Хүчирхийлэлтэй гэр бүлийн харилцааны түүхийг сонсох явцад хийсэн нийгмийн ажилтны ажиглалт, тэмдэглэл
.....
.....
.....

**Д. ГЭР БҮЛИЙН ХҮЧИРХИЙЛЛИЙН ХОХИРОГЧИД АЮУЛ УЧРУУЛАХ
ЭРСДЛИЙН ТҮВШИНГ ҮНЭЛЭХ НЬ**

I. Хүчирхийлэл үйлдэгчийн зан үйлтэй холбоотой эрсдлүүд

1. Гэр бүлийн хүчирхийлэл даамжирч, хүчирхийлэл үйлдэх давтамж ойртсон эсэх

☐ Тийм

☐ Үгүй

Хэрэв тийм бол хүчирхийлэл хэрхэн даамжирч, давтамж нь ямар хугацаатай ойртсон тухай тодруулан бичнэ үү

.....

2. Хүчирхийлэл үйлдэгч нь гаднын биет, хутаг мэс болон галт зэвсэг хэрэглэдэг эсэх

☐ Тийм

☐ Үгүй

Хэрэв тийм бол ямар гаднын биет, хутаг мэс болон галт зэвсэг хэрэглэдэг тухай тодруулан бичнэ үү

.....

3. Хүчирхийлэл үйлдэгч бэлгийн хүчирхийлэл ба бусад бэлгийн шинжтэй үйлдлийг хохирогч хүсээгүй байхад үйлддэг эсэх

☐ Тийм

☐ Үгүй

4. Хүчирхийллийн улмаас хохирогчийн бие махбодь, эрхтэн системийн үйл ажиллагаанд өөрчлөлт ба гэмтэл гарсан эсэх

☐ Тийм

☐ Үгүй

Хэрэв тийм бол ямар эрхтэн системийн үйл ажиллагаанд өөрчлөлт, гэмтэл учирсан эсэхийг тодруулан бичнэ үү

.....

5. Хохирогч сэтгэл санааны байнгын дарамт, шахалтанд байдаг эсэх

☐ Тийм

☐ Үгүй

Хэрэв тийм бол энэ дарамт шахалт нь хохирогчийн ажил амьдралд нь ямар нөлөө үзүүлдэг тухай тодруулан бичнэ үү

.....

6. Хүчирхийлэл үйлдэгч хүүхдийн эсрэг хүчирхийлэл үйлддэг эсэх

☐ Тийм

☐ Үгүй

Хэрэв тийм бол хүүхдийн эсрэг ямар хэлбэрийн хүчирхийллийг хэрхэн үйлддэг тухай тодруулан бичнэ үү

.....

7. Хүчирхийлэл үйлдэгч хохирогчийн хөдөлмөр эрхлэлт, эдийн засгийн бие даасан байдалд нөлөөлдөг эсэх

☐ Тийм

☐ Үгүй

Хэрэв тийм бол хохирогчийн хөдөлмөр эрхлэлт, эдийн засгийн бие даасан байдал хэрхэн нөлөөлдөг тухай тодруулан бичнэ үү

.....

8. Хүчирхийлэл үйлдэгч хохирогчийг нийгмээс тусгаарлаж, бусадтай холбоотой байхад нь саад болдог эсэх

☐ Тийм

☐ Үгүй

Хэрэв тийм бол нийгмээс хэрхэн тусгаарлаж, бусадтай холбоотой байхад нь яаж саад болдог тухай тодруулан бичнэ үү

.....

9. Хүчирхийлэл үйлдэгч хохирогчийг ямар нэг шалтгаанаар айлган сүрдүүлж, баривчлуулна гэж заналхийлдэг эсэх

☐ Тийм

☐ Үгүй

Хэрэв тийм бол ямар шалтгаанаар хохирогчийг айлган сүрдүүлж, баривчлуулна гэж заналхийлдэг тухай тодруулан бичнэ үү

.....

II. Нийгмийн орчны эрсдлүүд

1. Хохирогч санхүүгийн асуудалтай байнга тулгардаг эсэх

☐ Тийм

☐ Үгүй

Хэрэв тийм бол санхүүгийн ямар асуудалтай тулгардаг талаар тодруулан бичнэ үү.

.....

2. Хохирогч хүчирхийлэл гарсан үед нэн даруй хүчний байгууллагын болон нийгмийн халамж, хамгааллын үйлчилгээ авах боломжгүй газар амьдардаг эсэх

☐ Тийм

☐ Үгүй

Хэрэв тийм бол хохирогч хаана амьдардаг, ямар шалтгаанаар үйлчилгээ нэн даруй авах боломжгүй тухай тодруулан бичнэ үү.

.....

3. Хохирогч ямар нэг архаг хууч өвчтэй эсвэл хөгжлийн бэрхшээлтэй эсэх

☐ Тийм

☐ Үгүй

Хэрэв тийм бол ямар өвчтэй эсвэл ямар хэлбэрийн хөгжлийн бэрхшээлтэй тухай тодруулан бичнэ үү.

.....

4. Хохирогчийн хэрэгцээнд нийцсэн тусламж, үйлчилгээг орон нутгийн нийгмийн халамж, хамгаалал, нийгмийн үйлчилгээний байгууллагаас үзүүлэх боломжгүй

☐ Тийм

☐ Үгүй

Хэрэв тийм бол ямар шалтгаанаар орон нутгийн нийгмийн үйлчилгээний байгууллагууд хохирогчийн хэрэгцээнд нийцсэн үйлчилгээг үзүүлэх боломжгүй талаар тодруулан бичнэ үү.

.....

5. Хүчирхийлэлтэй гэр бүлийн харилцааг гэр бүлийн бусад гишүүд, ах дүү, хөрш, орон нутгийнхан хэвийн гэж үздэг эсэх

☐ Тийм

☐ Үгүй

6. Хохирогч ямар нэг шалтгаанаар (нас, хүйс, гарал үүсэл, боловсрол, эрхэлж буй ажил, эрүүл мэндийн байдал, шашин шүтлэг, бэлгийн чиг хандлага зэрэг шалтгаанаар) ялгаварлан гадуурхагддаг эсэх.

☐ Тийм

☐ Үгүй

Хэрэв тийм бол хохирогчийг ямар шалтгаанаар бусдаас ялгаварлан гадуурхдаг тухай тодруулан бичнэ үү.

.....

III. Хохирогчийг алах магадлал бүхий эрсдлүүд

1. Хүчирхийлэл үйлдэгч өөрийгөө болон эхнэр эсвэл хамтран амьдрагч, үр хүүхдээ ална гэж заналхийлдэг эсэх

☐ Тийм

☐ Үгүй

1. Хүчирхийлэл үйлдэгч нь хохирогчийг өмчилж, өөрөөс нь салбал түүнийг ална гэж заналхийлдэг, мөн энэ бодолдоо итгэлтэй зан үйл гаргадаг эсэх

☐ Тийм

☐ Үгүй

2. Хүчирхийлэл үйлдэгч ямар нэг галт зэвсэг эзэмшдэг эсвэл хэрэглэнэ гэж өмнө нь заналхийлж байсан эсэх

☐ Тийм

☐ Үгүй

3. Хохирогч хүчирхийлэл үйлдэгчээс зугтаахад түүнийг мөрдөн мөшгиж, хохирогчийг гэртээ харихгүй бол ална айлган заналхийлдаг эсэх

☐ Тийм

☐ Үгүй

4. Хүчирхийлэл үйлдэгч хохирогчийг олохын тулд хүүхдээ холбоо тогтоох хэрэгсэл болгон ашигладаг эсвэл хэн нэгнийг барьцаалж ална гэж заналхийлдаг эсэх

☐ Тийм

☐ Үгүй

Е. НИЙГМИЙН АЖИЛТАН-ШИНЖЭЭЧИЙН ДҮГНЭЛТ

1. Үйлчилгээ үзүүлсэн байгууллага ба ажилтны тухай ерөнхий мэдээлэл

1. Үйлчилгээ үзүүлсэн байгууллагын нэр:

2. Байгууллагын хаяг

3. Үнэлгээ хийсэнон сар өдөр

4. Үнэлгээ хийсэн ажилтны овог нэр

5. Үнэлгээ хийхэд байлцсан ажилтны овог нэр, албан тушаал.....

2. Хохирогч ба хүчирхийлэл үйлдэгчийн тухай ерөнхий мэдээлэл

3. Хүчирхийлэлтэй гэр бүлийн харилцааны түүх

4. Гэр бүлийн хүчирхийллийн хохирогчид аюул учруулах эрсдлүүд

5. Хохирогчид аюул учруулах эрсдлийн түвшинг үнэлсэн дүн

6. Хохирогчийг хамгаалах, нөхөн сэргээх, хүчирхийллээс урьдчилан сэргийлэх чиглэлээр авсан арга хэмжээ

7. Нийгмийн ажилтны ерөнхий дүгнэлт ба санал зөвлөмж

Нийгмийн ажилтан – шинжээчийн гарын үсэг он сар өдөр

ХОХИРОГЧИД АЮУЛ УЧРУУЛАХ ЭРСДЛИЙН ТҮВШИНГ ҮНЭЛЭХ АРГАЧЛАЛ

Тийм гэсэн хариулт тус бүр 1 оноо, харин үгүй гэсэн хариулт тус бүр 0 оноо гэж тооцогдоно.

1. Хохирогчид аюул учруулах эрсдлийн харьцангуй бага түвшин

- Хүчирхийлэл үйлдэгчийн зан үйлтэй холбоотой эрсдлүүд дангаараа 0-4 оноо болсон ЭСВЭЛ
- Нийгмийн орчны эрсдлүүд дангаараа 0-3 оноо болсон тохиолдолд хохирогчид учруулах аюулын эрсдлийн түвшин харьцангуй бага гэж үнэлнэ.

Онцгой тохиолдол: Гэр бүлийн хүчирхийлэл даамжирсан, хүчирхийлэл үйлдэгч гадны биет тухайлбал хутга мэс, галт зэвсэг хэрэглэдэг, мөн хүчирхийллийн улмаас хохирогчийн эрхтэн системийн үйл ажиллагаа алдагдсан буюу бие махбодид хүнд гэмтэл учирсан нь нотлогдсон тохиолдолд хохирогчид учруулах аюулын эрсдлийн түвшинг аюул багатай гэж үзэхгүй. Энэ тохиолдолд бусад эрсдлийн хүчин зүйлсийн үзүүлэх дан ба хавсарсан нөлөөллийг нарийвчлан судлаж, гэр бүлийн хүчирхийллийн даамжирсан нөхцөл байдлыг аюул учруулж болох дунд зэрэг буюу түүнээс өндөр эрсдэл байж болох тодорхойлно.

Хариу авах арга хэмжээ: Хохирогчийн шийдвэрийг нэн түрүүнд харгалзан үзэх ба нийгмийн хамгаалал, халамж, эрүүл мэндийн үйлчилгээг санал болгоно. Нийгмийн ажилтан болон хамтарсан багийн бусад гишүүд хохирогч өөрийн аюулгүй байдлаа хангах төлөвлөгөө боловсруулахад нь тусална. Нөгөө талаас орон нутгийн нийгмийн үйлчилгээний байгууллагын ажилтнууд гэр бүлийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэх арга хэмжээний төлөвлөгөө гаргаж хүчирхийллээс хамгаалах, урьдчилан сэргийлэх үйлчилгээнд хамрагдах боломжоор хангана (ХЭҮТ 2006 n.d).

2. Хохирогчид аюул учруулах эрсдлийн дунд зэргийн түвшин

- Хүчирхийлэл үйлдэгчийн зан үйлтэй холбоотой эрсдлүүд ба нийгмийн орчны эрсдлүүдийн нийлбэр оноо 5-11 болсон тохиолдолд хохирогчид учруулах аюулын түвшинг дунд зэрэг гэж үнэлнэ.


Онцгой тохиолдол: Гэр бүлийн хүчирхийлэл даамжирсан, хүчирхийлэл үйлдэгч гаднын биет буюу галт зэвсэг хэрэглэдэг, хохирогч нэн даруй хүчний байгууллагын буюу нийгмийн хамгаалал, эрүүл мэндийн үйлчилгээ авах боломжгүй, эсвэл архаг хууч өвчтэй буюу хөгжлийн бэрхшээлтэйн улмаас хүчирхийлэл үйлдэгчээс хамааралтай гэдэг нь тогтоогдсон тохиолдолд хохирогчид учруулах аюулын түвшинг дунд зэрэг гэж үзэхгүй. Энэ тохиолдолд хохирогчид учруулах аюулын эрсдлийн түвшинг өндөр гэж үзэн бусад хавсарсан нөлөөллийг нарийвчлан судлах шаардлагатай.

Хариу авах арга хэмжээ: Хохирогчийн хүсэлтийг харгалзан гэрт нь буцаах буюу хүчирхийлэл үйлдэгчтэй хамт байх шийдвэрийг нь хүндэтгэж үзэх хэдий ч орон нутгийн цагдаагийн байгууллага ба нийгмийн үйлчилгээний байгууллагын ажилтнууд хохирогчийн нөхцөл байдлыг хяналтандаа авах арга хэмжээ авна (ХЭҮТ 2006 n.d). Нөгөө талаас ах дүү, төрөл садан болон хөршийн хамгаалалтыг санал болгоно. Нийгмийн ажилтан болон хамтарсан багийн бусад гишүүд хохирогч өөрийн аюулгүй байдлаа хангах төлөвлөгөө боловсруулахад нь тусална.

3. Хохирогчид аюул учруулах эрсдлийн өндөр түвшин

- Хүчирхийлэл үйлдэгчийн зан үйлтэй холбоотой эрсдлүүд нь нийгмийн орчны эрсдлүүд ба хохирогчийг алах магадлал бүхий эрсдлүүдийн аль нэгэнтэй хавсарсан
ЭСВЭЛ
- Гурван бүлгийн эрсдлүүд хавсарсан хэлбэрээр зэрэг илэрсэн тохиолдолд тэдгээрийн нийлбэр оноо нь 12 буюу түүнээс их болсон тохиолдолд хохирогчид учруулах аюулын эрсдлийн түвшин өндөр буюу аюултай гэж үнэлнэ.

Хариу авах арга хэмжээ: Энэ тохиолдолд хохирогчийг шууд хөндлөнгийн хамгаалалтанд авах ба хүчирхийлэл үйлдэгчид шүүхээр эрх хязгаарлах арга хэмжээ авахуулах хүсэлтийг гаргана. Мөн хохирогчийн хүсэлтийг харгалзан хуулийн байгууллагаар шийдвэрлэх асуудлуудыг тогтооно. Хохирогчийг нэн даруй хамгаалах арга хэмжээг төлөвлөж холбогдох нийгмийн хамгаалал, халамж, эрүүл мэндийн байгууллагуудтай холбон зуучлана (ХЭҮТ n.d).



**ЦАГДААГИЙН АЖИЛТНУД ХОХИРОГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ ЭРХ ХЯЗГААРЛАХ
АРГА ХЭМЖЭЭ АВАХУУЛАХ ХҮСЭЛТ ГАРГАХ ЗАГВАР**

..... дүүрэг/ сумын шүүхэд хүсэлт гаргах нь:

..... он сар ...ны өдөр

Улаанбаатар хот

..... албан тушаалтай овогтой би
ГБХТТХ- ийн 9-р зүйлийн 9.1.8 -д заасны дагуу хүлээсэн үүргийнхээ хүрээнд
дараах хүсэлтийг гаргаж байна.

..... дүүргийн..... оршин суудаг
..... овогтой нь өөрийн
/хүчирхийлэл үйлдэгч хохирогчтой ямар хамааралтай болохыг бичнэ./ болох
..... овогтой ны эсрэг үйлдсэн /үйлдэж болзошгүй, удаа
дараа үйлдэж буй/ гэр бүлийн хүчирхийлэл хэргийн талаар шалгахад

1.
.....
.....
/бие махбодийн хүчирхийлэл/
2.
.....
.....
/сэтгэл санааны хүчирхийлэл /
3.
.....
.....
/эдийн засгийн хүчирхийлэл/
4.
.....
.....
/бэлгийн хүчирхийлэл /

зэрэг хүчирхийлэл үйлдсэн /үйлдэж болзошгүй, удаа дараа үйлдэж буй/
хохирогчид

хохирол учруулсан, цаашид

.....цаашид ..
..... хохирол учруулж болзошгүй
байна.

Хүчирхийллийн нөхцөл байдлыг үнэлж:

1. Хүчирхийлэл дахин давтагдах магадлалтай
2. Хүчирхийллийн болзошгүй эрсдлийн түвшинг
 - А. Аюултай ба эрсдлийн түвшин өндөр
 - Б. Дунд зэргийн аюултай ба эрсдлийн түвшин дунд зэрэг
 - В. Аюул багатай ба эрсдлийн түвшин бага зэрэг

байна гэж дүгнэлээ.

Иймд хохирогчийн аюулгүй байдлыг хангахын тулд овогтой ..
.....нд Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн 16-р
зүйлийн 16.1-д заасны дагуу

зэрэг эрх хязгаарлах арга хэмжээг /Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн
16.1-д заасан арга хэмжээнээс шаардлагатайг сонгон бичнэ/ болон мөн хуулийн
16.1.5-д заасан зан үйлд нөлөөлөх албадан сургалтанд хамруулах эрх хязгаарлах
арга хэмжээтэй хамтруулан хугацаагаар ногдуулах
шаардлагатай гэж үзэж байна.

Хүсэлтэнд хороо /сумын нийгмийн ажилтан
овогтой-тэй хамтран тогтоосон нөхцөл байдлын үнэлгээ
болон хуудас материал хавсаргав. .

Хүсэлт гаргасан
байгууллага /албан тушаал / овогтой /нэр/
..... гарын үсэг

Хүний Эрхийг Хамгаалагчид

Эмэгтэйчүүдийн хүний эрхийн цуврал тайлан-хэвлэлт

- Бүгд Найрамдах Молдав улсын Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн хэрэгжилт, 2012 он
- Хорват улсын Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн хэрэгжилт, 2012 он
- Миннесота мужийн, бэлгийн мөлжлөгтэй тэмцэх хэрэгцээ үнэлгээ, 2008 он
- Тажикстан улс, Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн хэрэгжилт, 2008 он
- Болгарь улсын Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн хэрэгжилт, Хүний эрхийн тайлан, 2008 он
- Аюулгүй, амар амгаланд хүрэх харгуй: Хүчирхийлэлд өртсөн эмэгтэйчүүд, 2008 он
- Гүрж улс, Гэр бүлийн хүчирхийлэл ба хүүхдийн эсрэг хүчирхийлэл: Гүрж улсын Гэр бүлийн хүчирхийлэл ба хүүхдийн эсрэг хүчирхийллийн хуулийн өнөөгийн нөхцөл байдал, практик, НҮБ-ын улс орны багт хүргэх зөвлөмж, 2006 он
- Хүний эрхийн тайлан 2004 он, Дүрвэгч, цагаач эмэгтэйчүүдийн гэр бүлийн хүчирхийлэлд Засгийн газраас анхаарал хандуулж буй нөхцөл байдал
- Польш улс дахь гэр бүлийн хүчирхийлэл, 2002 он
- Польш улс, ажлын байранд дахь ялгаварлан гадуурхалт ба бэлгийн дарамт, 2002 он
- Армени улс дахь гэр бүлийн хүчирхийлэл, 2000 он
- Молдав улс дахь гэр бүлийн хүчирхийлэл, 2000 он
- Украин улс дахь гэр бүлийн хүчирхийлэл, 2000 он
- Укбекстан улс дахь гэр бүлийн хүчирхийлэл, 2000 он
- Эмэгтэйчүүдийн худалдаалах гэмт хэрэг: Молдав, Украин улс, 2000 он
- Ажлын байранд дахь хүйсийн ялгаварлан гадуурхалт ба бэлгийн дарамт, Болгарь улс, 1999
- Непал улс дахь гэр бүлийн хүчирхийлэл, 1998 он
- Макдони улс дахь гэр бүлийн хүчирхийлэл, 1998 он
- Албани улс дахь гэр бүлийн хүчирхийлэл, 1996 он

Эдгээр тайлангуудыг www.theadvocatesforhumanrights.org сайтаас авах боломжтой

Хүний эрхийг хамгаалагчид нь АНУ-д сайн дурынхан, судлаачид, боловсрол олгогчид, хүний эрхийг хамгаалагчидийн оролцоотой олон улсад хүрч ажиллах улс орноо сонгож ажилладаг.

